ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

ХУУЛЬ ЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, ОНОЛ, ПРАКТИКИЙН СЭТГҮҮЛ

2006 №4 (15)

ЭНЭ ДУГААРТ:

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойд

Монголын төр, тусгаар тогтнолын түүхэн замнал
(Үндсэн хуулийн цэцийн гишүүн **П.Очирбат**) 4-9
Өрнөдийн шашин номлогчдын Монголчуудтай холбогдох нь
(МУИС-ийн Нийгмийн ухааны сургуулийн дэргэдэх Түүхийн судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор **Т.Төмөрхүлэг**) 10-12

Хууль зүйн алба үүсгэн байгуулагдсаны 85 жилийн ойд

Хууль зүй, дотоод хэргийн сайдын мэндчилгээ.. 13
Монголын Улсын Хууль зүйн албаны үүсэл, хөгжил, түүхэн замнал
(Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах мэргэжилтэн **Б.Цэвээн**) 14-28
Тэнхимийн багшаас төрийн сайдаар өргөмжлөгдсөн нь
(ХЗҮТ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор **Б.Чимид**) 29-32
Эрх зүйн салбарт хийх шинэтгэлийг эрчимжүүлэхэд хүчин зүтгэсэн
(ХЗҮТ-ийн захирал, гавьяат хуульч, академич **Ж.Амарсанаа**) 33-34
Улаанбаатар хотод 10 гаруйхан өмгөөлөгч байлаа
(Хууль зүйн тэргүүний ажилтан ***Д.Тогтохжаргал***) *35-37*

Төрийн байгуулалтын хууль тогтоомж

Армен Улсын Үндсэн хуулийн шүүхийн онцлог
(Үндсэн хуулийн цэцийн ажилтан **Б.Лхагвасүрэн**) 38-40
Мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрх буюу нууцын тухай эрх
(ХЗДХЯ-ны мэргэжилтэн **Ш.Үнэнтөгс**) 41-44
Ард түмэн төрийн хэрэгт шууд оролцох эрх буюу ард нийтийн санал асуулга
(Отгонтэнгэр их сургуулийн багш **С.Эрдэнэболор**) 45-49

Шүүх эрх мэдэл

Шүүхийн менежментийг боловсронгуй болгох үзэл баримтлал
(Нийслэлийн шүүхийн Тамгын хэлтсийн дарга **Н.Дагва**) 50-53
Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагааны төлөвшил
(Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн **О.Зандраа**) 53-55
Шүүх эрх мэдлийн тухайд
(Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн нарийн бичгийн дарга, хууль зүйн магистр **Ц.Баярмаа**) 56-57

Криминологи

Ял эдэлж буй хэрэгтний бусдад учруулсан хохирлыг төлүүлэх ажиллагаа
(ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих тасгийн хяналт шалгалтын байцаагч, ахлах дэслэгч Ч.Өнөрцэцэг) 58-60

Прокурорын хяналт

Гэр бүлийн хүчирхийлэл: Хорих ял ба эмэгтэйчүүд
(Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор, докторант **Ц.Мөнхбат**) 61-62

Иргэний хууль тогтоомж

Хөдөлмөрийн гэрээ цуцалсан маргаан шийдвэрлэх зарим асуудал
(Отгонтэнгэр Их сургуулийн дэд захирал, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор **Л.Баасан**) 63-65
Санхүүгийн түрээс, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал
(Улсын дээд шүүхийн шүүгч **А.Доржготов**) 66-73
Ажлын байран дахь бэлгийн дарамтлалын эсрэг хууль тогтоомжийн хэрэгцээ
(ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, Отгонтэнгэр их сургуулийн багш **Д.Эрдэнэчимэг**, Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал **Ц.Алтанцэцэг**) 74-77
Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын зарим конвенцийн хэрэгжилтийн талаар цухас авч үзэх нь
(ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний дэд ажилтан **С.Ганцэцэг**) 78-80
Аккредитивийн төлбөр тооцоо, түүнийг хэрэгжүүлэх журам
(Хуульч **Г.Батчимэг**) 81-85
Иргэний хуулийн тайлбар
(Цуврал) 86-90

Олон улсын эрх зүй, харьцуулсан эрх зүй

Олон улсын эрүүгийн шүүх ба Үндсэн хуулийн асуудал
(ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрхлэгч **М.Мөнхбат**) 91-93
Олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн хэрэглэх нь
(ГХЯ-ны Гэрээ, эрх зүйн газрын захирал, хууль зүйн шинжлэх ухааны доктор **Б.Алтангэрэл**) 94-96
Олон улсын гэрээг үндэсний шүүхэд хэрэглэх асуудалд
(ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан **Б.Гүнбилэг**) 97-101
Олон улсын эрх зүйн зохицуулалтад Монгол Улсын оролцоог өргөтгөх нь
(ГХЯ-ны Гэрээ, эрх зүйн газрын зөвлөх, олон улсын эрх зүйч **Г.Сэсээр**) 102-103
Хятад улсын газрын эрхийн дүрмийн одоогийн байдал хийгээд шинэчлэлийн асуудал
(Хятад улсын Өвөрмонголын их сургуулийн Хууль судлалын дээд сургуулийн дэд профессор **Хайтан**) 104-107

Эрх зүйн үйлчилгээ

Үндэсний эрх зүйн тогтолцоонд нотариатын эзлэх байр суурийг тодорхойлох асуудалд
(Баянгол дүүргийн нотариатч, хууль зүйн магистр **Ч.Баянжаргал**) 108-110
Даатгалын хэлцэл
(МӨХ-ны гишүүн, өмгөөлөгч **Ч.Уянга**) 111-114
Эрх зүйн иж бүрэн үйлчилгээний цогцолбор
(Хуульч **Б.Цогнэм**) 115

CONTENT:

Occasion of the 800th anniversary of the foundation of the Mongolian Statehood

Historical path of the Mongolia's Statehood and Independence
(**P.Ochirbat,** Member of the Constitutional court)..... 4-9
Relation of Western religion propangandiss with Mongolians
(PhD **T.Tomorhuleg,** NUM, Historical study institution of Social science faculty, researcher,) 10-12

Occasion of the 85th anniversary of foundation of the Justice service

Greeting of the Minister of Justice and Home affairs 13
Foundation and developement of the Justice service of Mongolia and its historic path
(**B.Tseveen,** Junior specialist, Ministry of Justice and Home affairs) 14-28
The teacher became the Minister
(**B.Chimed,** Scientist secretary of NL, ScD, Prof.)..... 29-32
Dedication of commetment to the strengthening of Legal reform
(**J.Amarsanaa,** Head of NLC, Academician,)..... 33-34
There was only over 10 advocates in Ulaanbaatar
(**D.Togtohjargal,** Leader of Justice) 35-37

State organization legislation

Characteristics of Armenian Constitutional court
(**B.Lkhagvasuren,** Officer of the Constitutional court's department)..... 38-40
Legal basis for obtaining8 dissemination and acquiring information
(**Sh.Unentogs,** Specialist of the Ministry of the Justice and Home affairs) 41-44
Direct participation of people in referendum State activities
(**S.Erdenebolor,** Teacher, Otgontenger University, Law school) 45-49

Judicial power

Concepts on developing court management
(**N.Dagva,** Head of the Metropolitan court's administrative department) 50-53
Formation of Administrative court trial
(**O.Zandraa,** Judge of Supreme court) 54-55
About Jurisdiction
(**Ts.Bayarmaa,** Secretary of the Metropolitan Administrative court, MA) 56-57

Criminology

Procedures of compensation criminal; injury in execution process of punishment
(**Ch.Unurtsetseg,** Inspection officer, General Authority for Implementing court decisions) 58-60

Prosecutors monitoring

Family voilence: Imprisonment and women
(**Ts.Munhbat,** State General Prosecutor'soffice, Supervising prosecutor, PhD candidate) 61-62

Private law legislation

Issues on resolving disputes of labour cantract dissolution
(**L.Baasan,** Vice director of the Otgontenger University, ScD, professor) 63-65
Leasing and issues in legal regulation
(Judge of the Supreme court **A.Dorjgotov**) 66-73
Necessity of legislation against sexual harassment
(**D.Erdenechimeg,** Teacher of the Otgontenger University, researcher of the NLC, **Ts.Altantsetseg,** Director of the Law school, Otgontenger University,) 74-77
In working place of Mongolian international treaties of ILO
(**S.Gantsetseg,** Researcher of the NLC) 78-80
Accreditive payment and procedure of its implementation
(**G.Batchimeg,** Lawyer) 81-85
Civil law commentary *86-90*

International law, comparative law

International criminal court and Constitutional issues
(LL.M.int **M.Monhbat,** Head of International law sector, NLC, .) 91-93
Using on consumate international treaties with national legislation
(ScD **B.Altangerel,** Director of Counsel of Treaty and Legal office, Ministry of Foriegn affairs) 94-96
Issues on using international treaties in national court (international practice, precedents)
(**B.Gunbileg,** Research fellow of NLC) 97-101
Expansion of Mongolian involvement in International regulation
(**G.Seseer,** International lawyer, Counsel of Treaty and Legal office, Ministry of Foriegn affairs) 102-103
Present state of Chinese land charter, renovation issues
(Vice professor **Khaitan,** Teacher of the Chinese Inner Mongolia University, Law school)..... 104-107

Legal service

Issues on determining role of notary in the national legal system
(MA **Ch.Bayanjargal,** Notary) 108-110
Insurance agreement
(**Ch. Uyanga,** Member of Mongolian Advocate Association, Advocate) 111-114
Complexe of legal services
(**B.Tsognyam,** Lawyer) 115

ХУУЛЬ ЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГ www.legal.mn

Сэтгүүлийн зөвлөлийн гишүүд:

Ц.Бат-Орших *Сэтгүүлийн зөвлөлийн ерөнхий эрхлэгч*

Гишүүд:

Л.Бямбаа	- Улсын дээд шүүхийн шүүгч
Гарри Лэдбэттэр	- АНУ-ын ОУХА-ийн ШЭМШХ-ийн удирдагч
Н.Дагва	- Нийслэлийн шүүхийн Тамгын хэлтсийн дарга
М.Дангаасүрэн	- Улсын дээд шүүхийн судалгааны төвийн захирал
А.Доржготов	- Улсын дээд шүүхийн шүүгч
Л.Заяа	- ГТХАН-ийн ХСДСТ-ийн удирдагч
Э.Лхагвасүрэн	- Үндсэн хуулийн цэцийн ажилтан
Д.Мөнхгэрэл	- ХЗДХЯ-ны газрын дарга
Д.Наранчимэг	- Отгонтэнгэр Их сургуулийн захирал
А.Оюунчимэг	- Монголын нотариатчдын танхимын ерөнхийлөгч
Б.Пүрэвням	- Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч
Т.Уранцэцэг	- Сонгинохайрхан дүүргийн шүүгч
Ш.Үнэнтөгс	- ХЗДХЯ-ны мэргэжилтэн
Б.Цэрэнбалтав	- Улсын ерөнхий прокурорын орлогч
Б.Чимид	- ХЗҮТ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор
А.Энхжав	- Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн дарга

Дугаарыг эрхэлсэн: Б.Дашдулам

Сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга

Эрхлэн гаргагч: Хууль зүйн үндэсний төв

Редакцын хаяг: Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг, Сүхбаатарын талбай-7

Утас: 315736 Факс: 315736

Вэб сайт: www.legalcenter.mn

И-мэйл: magazine_info@legalcenter.mn

Улсын бүртгэлийн дугаар: 279

Ямар ч нөхцөлд Монгол Улс эрх чөлөө, тусгаар тогтолоо хамгаалсаар, бидний монголчууд хүн төрөлхтний хөгжил дэвшлээс төдийлөн хоцролгүй өөрийн гэсэн давтагдашгүй дархлалтай нүүдлийн иргэншлээ хадгалсаар өнөөг хүрлээ.

Улс үндэстэнд хамгийн үнэт зүйл нь эрх чөлөө, тусгаар тогтнол байдгийг өнгөрсөн түүхийн сургамжаас бид юу юунаас илүү ойлгож мэдлээ. Бид тусгаар тогтнолын олон сорилт шалгуурыг даван туулаа.

АНУ, Англи, ЗХУ гурван их гүрний Ялтын бага хурал БНМАУ-ын тусгаар тогтносон бүрэн эрхийг 1945 онд байгаа байдлаар нь хүлээн зөвшөөрөх, Хятад улсаар хүлээн зөвшөөрүүлэхдээ ЗХУ Японд дайн зарлаж, ялах явдлыг нөхцөл болгон тавьжээ. Уг тохиролцооны дагуу ЗХУ 1945 оны 8 дугаар сарын 9-нд Японд дайн зарласны маргааш БНМАУ Японд дайн зарлаж Зөвлөлтийн армитай хамтран тулалдсан билээ. Японд ийнхүү дайн зарласан нь 1936, 1939 онд Халхын голд хийсэн Японы түрэмгийллийн хариу ч биш. Япон улсыг дайтан эзлэх гэсэн түрэмгийлэл ч биш, Дэлхийн хоёрдугаар дайны Ази Номхон далайн бүс нутаг дахь голомтыг дарахад Монгол Улс өөрийн цэргийн хүчээр их ялалтын үйл хэрэгт хувь нэмрээ оруулж, БНМАУ бол тусгаар тогтносон, энхийг эрхэмлэгч улс гэдгээ дэлхийн олон нийтэд батлан харуулах гэж монголын эх орончид халуун амь, бүлээн цусаа урсгаж энэ дайнд оролцсон хэрэг юм.

1945 оны 9 дүгээр сарын 2-нд Япон бууж өгсөн тухай актад гарын үсэг зурсан хэдий ч Монгол Улсын тусгаар тогтнолын баталгаа үүгээр бас дууссангүй.

Монголын ард түмэн өөрийн улсын тусгаар тогтнолыг бүх нийтийн санал хураалтаар нотолбол тусгаар тогтнолыг зөвшөөрнө гэсэн Хятадын давхар барьцаалалт цаана нь бас байв. Ингээд 1945 оны 10 дугаар сарын 20-нд Монголын ард түмэн бүгдээрээ өөрсдийгөө тусгаар тогтносон бүрэн эрхт БНМАУ-ын иргэн гэдгээ батлан саналаа өгснөөр Монгол Улсыг өөрийн бүрэлдэхүүн хэсэг хэмээн зүтгэсээр ирсэн Хятадын Гоминданы Засгийн газар, БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч, 1946 оны 2 дугаар сарын 13-ны өдөр дипломат харилцаа тогтоох протоколд гарын үсэг зурсан байна. Энэ өдрөөс хойш асар удалгүй гуравхан жилийн дараа 1949 онд Хятадад Ардын хувьсгал ялж БНХАУ байгуулагдсан явдал БНМАУ-ын тусгаар тогтнолыг бэхжүүлэхэд таатай нөхцөл бүрдүүлсэн юм.

БНМАУ-ын Засгийн газар 1949 оны 10 дугаар сарын 6-нд БНХАУ-ыг хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоосноор сайн хөршийн найрсаг харилцааны суурь тавигдаж, улмаар 1960 онд Монгол - Хятадын найрамдал, харилцан туслах тухай гэрээ, 1962 онд БНМАУ ба БНХАУ-ын хилийн гэрээ тус тус байгуулагдаж тусгаар тогтнолоо харилцан хүндэтгэж, энх тайвнаар зэрэгцэн оршиж буй билээ.

Дайны хүнд үеийг амжилттай туулсан Монгол-Зөвлөлтийн харилцаа 1946 онд БНМАУ ба ЗСБНХУ-ын хооронд байгуулагдсан найрамдал, харилцан туслах тухай гэрээ болон эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийн үндсэн дээр бүх талаар өргөжин хөгжив.

Ингэж манай улс хөрш хоёр их гүрэнтэйгээ тэгш эрхт найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлж, улсын хил хязгаарыг батлан тогтоох, тус орны тусгаар тогтнол, төрийн бүрэн эрхт байдлыг улс хоорондын харилцааны эрх зүйн болон нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байх зарчмын дагуу харилцан баталгаажуулж, улс орноо хөгжүүлэх нийгэм-эдийн засгийн зорилтыг шийдвэрлэж байна.

Энэ зууны эхэнд төрийн тусгаар тогтнолоо сэргээж эв хамтын замаар 70 жил замнан хөгжсөн хийгээд 1990-ээд оноос ардчилал, шинэчлэлийн замд орж төрийн ардчиллыг эдийн засгийн ардчилалтай хослуулсан хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх шинэ замд орлоо.

Өнөөгийн энэхүү шинэчлэлийг бид өмнөх түүхэн замналаас салгаж үзэх аргагүй юм. Өнгөрсөн түүхээсээ салангид шинэчлэл гэж байх учиргүй. Үүний нэгэн адил манай улсын сүүлийн үеийн түүхийг Монголын тулгар төр үүссэнээс хойшхи 800 жилийн түүхээс салгах учир бас байхгүй, Улс үндэстнээ соёл иргэншилтэй нь амьдрах арга ухаантай нь үеэс үед уламжлан хөгжүүлж ирсэн монгол төрийн арга ухаан ширгэшгүй юм.

"Их Засаг" цаазтай, нэгдсэн Монгол Улсын төрийн төр ёсыг алдагдуулснаас XYII зууны үед Монголын нэгдсэн төр задарч Өвөрмонголын цахрын хаант улс, Ар Монгол дахь Халхын ханлиг, Баруун Монголын Дөрвөн Ойрадын холбоо хэмээх гурван бага улс болж нэгдмэл байдлаа алдсаны харгайгаар 1634 онд Өвөрмонгол Манжид эзлэгджээ. Монгол аймгуудын хамгийн ахуултай дайсан гэгдэж байсан Зүрчидийн Алтан улсын суурин дээр үүсч хүчирхэгжсэн Манж Чин улсад эзлэгдэх ахуул Монгол төрийн өмнө тулгарсан үед монголчууд 1691 онд манжийн хааны ивээлд сайн дураараа дагаар орох уян хатан бодлого явуулж байжээ. Ингэснээр улс орноо бүтнээр нь, хүн ардаа цэврээр нь, мал сүргээ удмаар нь авч үлдсэн төдийгүй бусдад эзлэгдэх ахуулаас Манж нараар 200 гаруй жил хамгаалуулж чадсан нь ирт сэлэм, их цэргээс ч илүү хүчтэй төрийн мэргэн бодлого байжээ. Энэ бодлого 1691 оны Долнуурын чуулганаас 1891 он хүртэл 200 жил баримталсан "Хязгаарын цаазлах" хуульд тусчээ. Үүнийг батлах баримт олон бий. Заримаас дурдахад: Монгол Манжид дагаар орсноос хойш 18 жилийн дараа "Халх журам" хэмээх Монгол хуулийг зохион бүтээж 1709 оны шороон үхэр жилийн зуны дунд сарын хорин наймны өдөр Түшээт хан тэргүүтэй бүх ноёд, сайд хэлэлцсэн байна. Манжийн хааны ивээлд байсан Монгол Улс өөрийн энэхүү хуулийг 100 шахам жил даган мөрдсөн нь Энх-Амгалан хаанаас "Шинэ дагасан Халх нарыг тэдний хууль ёсоор болтугай" гэж зарлиг буулгасан болон 1789 онд манж нар Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйн бичгийг зохион гаргаж дагаж шийтгүүлэх болсноос хойш ч "Халх журам" урьдын адил мөрдөгдсөөр байснаас мэдэж болно. Энэ нь

"Шавь яамны дүрэм"-ийн нэгэн зүйлд "Аймаг, хошуу холилдсон хэргийг цом монгол цаазны бичгийн ёсоор шийтгэсүгэй" гэж бичсэнийг үзэхэд батлагдана. "Өөрийнхөө хуультай бусдын сүмд залардаггүй" гэдэг. Монгол Улс манжийн ивээлд байхдаа "Халх журам"-тайгаа л байжээ. Энэ нь тус улс тусгаар тогтнолоо алдан устаж манжид эзлэгдээгүйг нотлох том баримт мөн. Бэлэг тэмдгийн чанартай хаан, харьяалал тэр цагт төдийгүй эдүгээ үед ч энэ ертөнцөд байсаар байна. Тухайлбал, өнөөдөр Австрали улсын эзэн хаан нь англиин хатан хаан II Елизавет шүү дээ. Тэглээ гээд Австрали улсыг тусгаар улс биш гэж дэлхийн тавцанд хэн ч хэлдэггүй, НҮБ-ын гишүүн бие даасан орон билээ.

"Доминион" гэж Британийн эзэнт улсын мэдэлд байсан өөрийгөө захирдаг улс орнуудыг хэлдэг байв. Доминион нь Британийн титэмд үнэнч байхаа илэрхийлж Британийн хамтын нийгэмлэгийн орнуудын байгууллагад сайн дурааараа элсэн орсон орнууд гэж тодорхойлсон байдаг. Олон улсын харилцааны хувьд доминионууд нь бие даасан улс, субъект гэж тооцогддог. Доминион нь эрх тэгш бус аль нэг өөр этгээдэд захирагдах гэсэн утга агуулж байсан учраас 1947 оноос хойш "доминион" гэдэг хэллэгийг хэрэглэхээ больж, оронд нь "хамтын нийгэмлэгийн гишүүн орон" гэдэг нэр томъёог хэрэглэдэг болжээ. Энэ бүхнээс үзэхэд Монгол Улс 1691-1911 онд харьцангуй бие даасан байдлаа хадгалсан Манж Чин улсын нэг ёсны доминион байсан гэж үзэж болох юм.

Өөр хоорондоо хүчийг үрж өрөөлийн эрхшээлд орсон олон монголчуудаа Халх, Ойрадын хаад, ноёд, хутагт хувилгаад, төр шашны зүтгэлтнүүд нэгэн шашны номын хүрээнд нийлүүлэн нэгтгэж, тэрхүү оюун санааны нэгдлээр дамжуулж улс гэр, шавь олныг тэгшитгэн засах номч мэргэн ухаанаар улс үндэстнээ авран хамгаалж чадсан явдал Монгол Улс 1911 онд эзэн хааныг өргөмжлөн залж төрийн тусгаар тогтнолоо сэргээн тунхаглах эрх зүйн үндэс болсон байна.

Түүхч эрдэмтэд монголчууд төрийн 2000 гаруй жилийн түүхэн уламжлалтайг нотолсон билээ.Төр ёсныхоо өнө эртний өв уламжлалд тулгуурлан эдүгээгээс 800 жилийн тэртээ, билгийн улирлын дөрөвдүгээр жарны улаан барс жилийн зуны эхэн сарын шинийн 16-ны тэргэл өдөр буюу аргын 1206 оны 5 дугаар сарын 25-нд Чингис хаан Онон мөрний эхэнд есөн хөлт цагаан сүлд тугаа босгож Монгол ноёдын Их хурилдайг зарлан чуулж, Төв Азийн эсгий туургатныг нэгтгэн захирсан Монголын үндэсний тулгар төр Их Монгол Улс байгуулсныг тунхаглан зарласан юм.

Ийнхүү дорно зүг Их Хянганы нуруунаас өрнийн Тэнгэр уул хүртэл, умардын Саяаны уулс, Байгал нууруас Түмэн газрын урт цагаан хэрэм хүртэлх өргөн уудам нутаг дээр Их Монгол хэмээх Азийн хүчирхэг нэгэн хаант улс мандан гарч ирсэн билээ.

Эртний монгол нутагт Хүннү, Сянби, Ниргун, Түрэг, Уйгар, Кидан гэх зэрэг янз бүрийн нэр, төртэй овог, аймгууд түүхийн тавцанд ээлжлэн гарч байсан бол одоогоос яг 800 жилийн тэртээ бүх Монгол угсаатныг нэгтгэн зангидсан жинхэнэ Монгол үндэстний хүчирхэг төр улс бүрэлдэн тогтжээ.

Тухайн нийгмийн бартаат амьдрал дотроос түүхийн тавцанд тодрон гарсан эзэн Чингис хаантай, хатуу засаг хуультай, нэгэн туг сүлдтэй, өөрийн гэсэн гадаад бодлоготой, нэгдмэл эдийн засагтай, цомхон бөгөөд хүчирхэг цэрэгтэй, өвөрмөц үндэсний соёл иргэншилтэй, нэгдмэл монгол хэл, монгол бичиг үсэгтэй, хэний ч эрхшээлд биш, шинэ төлөвшсөн монгол үндэстний хүчирхэг улс тийнхүү байгуулагдсан нь тухайн үед монголын нийгэмд гарсан үнэхээрийн гарамгай их үйл явдал мөнөөс мөн байлаа.

Эзэн Чингис хаан Монгол туургатнаа нэгтгэн Их Монгол Улс байгуулсныгаа тайлбарлаж өгүүлэхдээ: "Мөнх тэнгэр мөхөс миний биеийг зарлигдан түмэн иргэдийг захируулахаар соёрхов. Тал нутагт одоо болтол ямар ч эмх журамгүй учраас ийм зэрэгт хүрсэн ажээ. Үр хүүхэд нь эцэг, эхийн үгийг авахгүй, дүү нар нь ахаа дагахгүй, эр нь эхнэртээ итгэхгүй, эхнэр нь эрийнхээ үгийг даахгүй, дагагсад нь ахлагчаа хүндэтгэхгүй, ноёд нь ард албатынхаа дотор үүрэг гүйцэтгэхгүй, баячууд нь ядуучуудаа тэтгэхгүй, газар сайгүй сэтгэл тайван суухыг бодохгүй, бидний омог аймаг, төрөл угсаатны дэг журам бүр алдагдаж, сүр сүлдгүй болоход хүрч буй. Эдүгээ хүрсэн газар болгонд дурааараа авирласан хүмүүн олон. Худалч, хулгайч, урвагчид, дээрэмчид хүртэл бий болжээ. Иймээс миний бие ард олныхоо хүсэл захиасыг даган энэхүү мөчид хатуу төв чанга жам ёсоор тэд нарыг засч нэгтгэн энх амгалан зол жаргалыг энэ нутагтаа хүртээн тогтоохыг чармайх ёстой" гэсэн байна.

Дундад зууны үеийн түүх бичлэгийн гайхамшигт дурсгал болох "Монголын нууц товчоонд" өгүүлснээр:

Шүлсээр ундлаж
Шүдний махаар хооллож
Магнайн хөлс уланд хүртэл
Улны хөлс магнайд гартал

зовон зүдэж байгуулсан төр улсаа юу юунаас илүү хайрлан хамгаалж явахын утга учрыг Их эзэн Чингис хаан

"Алд бие минь алжааваас
алжаатугай
Аху төр минь бүү алдартугай
Бүтэн бие минь зовбоос
зовтугай
Бүрэн улс минь бүү
сандартугай"

гэсэн энэ гайхамшигт сургаал үгээ хойч үеийнхэндээ гэрээс болгон үлдээжээ.

XIII зууны эхэн үед дэлхий дахинаа ялангуяа, Ази тивийн хүчирхэг их гүрнүүдтэй эн зэрэгцэн гарч ирсэн Их Монгол Улсын тулгар төр гадныг улс орны анхаарлыг ихэд татаж, тэдний зүгээс халдлага довтолгоо, айлган сүрдүүлэлт, булаан эзлэх санаархлын аль алинтай нь тулгарч байсан байна. Иймээс хил залгаа харь улс орны зүгээс учрах аюул заналыг хөндийрүүлэн зайлуулж, хил хязгаараа энх амгалан болгох нь Чингис хааны тэргүүн зорилгын нэг болж байжээ. Чингис хаан Монгол угсаатныг нэгтгэн нэгэн жолоонд оруулан захирахдаа улс

орноо хүчирхэг болгох, гаднын довтолгооноос сэргийлэх, тусгаар тогтнолоо хамгаалах нь монголын нийгмийн хөгжлийн амин чухал зүйл гэж үзэж байжээ.

Нөгөө талаас дотооддоо нэгдэж чадаагүй тархай бутархай байсан бусад улс орныг нэгдмэл улс болоход нь байлдан дагуулал нөлөөлдөг байжээ. Загалмайтны дайнд монголчуудын туслалцааг хүсч байсан, байлдааныг найрамдлаар солих талаар 1253, 1289, 1305 онуудад Францын IX Людвиг хаан, Гоо Филипп хаан, Монголын Их хаан Мөнх, Их хаан Аргун, Их хаан Өлзийт нарын захидлууд үүнийг гэрчилнэ.

Өөр хоорондоо өрсөлдөн тэмцэлдсэн Оросын 18 вант улс Алтан ордын ивээлд 238 жил байж нэгдсэн хүчирхэг Оросын эзэнт улс байгуулагджээ. Энэ хугацаанд Алтан Ордны улс Оросын вант улсуудыг түрэмгийлэн эзэлж байсан гэвэл түүхэн үнэн байдалд бүрэн нийцэхгүй. Чингэх шаардлага, бололцоо ч монголчуудад байгаагүй. Хэрэв түрэмгийлэн эзэлж байсан бол Алтан Ордны улс Оросын вант улсуудыг гадны довтолгооноос юунд хамгаалж, ивээлдээ байлгаж байх билээ.

Хоорондоо тэмцэлдэн задран бутарч байсан Хятад орныг монголчууд төвхнүүлж нэгдсэн Хятад улсын суурийг тавилцаж, Дундад Азид Газан хааны гэж алдаршсан шинэчлэлтийг хийж байсныг түүх тэмдэглэн үлдээжээ.

Чингисийн байлдан дагууллын үр дүнд Умард Хятадын төв хэсгээс өмнөд Сибирийн нутаг хүртэл, Манж-зүрчидээс Каспийн тэнгисийн хоорондох олон улс орон Монголын эзэнт гүрний захиргаанд багтан орсон байв. Түүний үр ач нар нь газар нутгийг улам ихээр тэлж өргөжүүлэн Ази Европыг дамнасан их эзэнт гүрэн байгуулав.

Аливаа байлдан дагуулал нь улс түмнүүдэд гай гамшиг авч ирдэг бөгөөд тэдний урагшлах хөгжилд саад тотгор болдгийг түүх гэрчилнэ. Түүний бас нэг үр дагавар бол үндэстэн хоорондын зөрчил тэмцлийг эв нэгдлээр сольж, улс үндэстэн үүсч төвхнөхөд эергээр нөлөөлдгийг ч түүх харуулж байна. Монголын байлдан дагуулал ч мөн тийм сөрөг, эерэг үр дагавартай байсныг хэлэх хэрэгтэй. Гашуун сургамжаар монголчууд бид бахархахгүй. Тийм харш сөрөг үзэгдэл бүхний нарийн утга учир, үр нөлөөг орчин үеийн соёлт хүн төрөлхтөн бодитойгоор үнэлж цэгнэх болжээ. Чингисийн байлдан дагууллыг зөвхөн хараар дүрсэлж гүтгэх болсон түүхээс үзэхэд Анкарын Тамплер нар монголчуудаас урваж, 1260 онд Айн Жалудын дэргэд ялагдсанаа цагаатгах гэж татарын тухай хар домог тараажээ.

Эл домогт "Монгол гэдэг чинь татаар, татаар гэдэг чинь доод тивээс гарч ирсэн зэрлэг тамын элч нар. Тэд олзлогсдыг тамлана. Амьтай бүхнийг хүйс тэмтэрч байшин барилга, цэцэрлэг тариаланг үнсэн товрог болгоно" гэсэн чалчаа яриа католик мөргөлт нийт Европ, нийт христосын ертөнц даяар тарж, хүн ардын оюуныг хордуулан, зүрх сэтгэлийг цэвдэгшүүлсэн юм. Энэ нь "хар үхэл" гэдэг тахлаас дутуугүй хор хүргэсэн "хар домог" мөн гэж их эрдэмтэн Лев Николаевич Гумилев бичжээ.

Эцэст нь Францын ард түмнийг эрээ цээргүй мэхэлж байсан тэрхүү Тамплер нарыг 1307 онд Францын эзэн хаан Гоо Филигатийн зарлигаар нэг шөнийн дотор баривчилж заримыг нь Парист шатааж, бусдыг нь гянданд хорьсон байна.

Тэгтэл Гоо Филигатийн бүх дайсан Тамплер нарыг хамгаалж, тэдний хийж байсныг зөвтгөж, тэдний санаа бодол, түүний дотор татаар бол тамын төрөлхтөн гэсэн хар домгийг өргөн сурталчлах болсон байна.

Энэ талаар эрдэмтэн Л.Гумилев бичихдээ: "Тодорхой зорилго бүхий гүтгэлэг гэдэг дийлдэшгүй зэвсэг мөн. Ганцхан хуурташ байгаа хүн нь цаад сэдвийг нь маш муу мэддэг байх учиртай. Тэгвэл тэр хүн хичнээн тэнэг биш байлаа ч чухам яасан ийсний учрыг олохгүй. XIY-XY зуунд Дорнод Азийн газар зүйг маш муу мэддэг, түүхийг нь бол онхи мэддэггүй байсан тул илчлэгдэнэ гэж айх юмгүй дурарааа худал бурж болж байжээ. Чингэж тамын хорлогчин татаарын тухай "хар домог" Европоор таржээ" гэсэн байдаг.

Эртний түүхийн энэ гажуудлыг эдүгээ цагийн соёлт ертөнц үнэн зөвөөр нь үнэлдэг болж байна. Монголчууд эзэн хааныхаа алдар гавьяаг хүндлэн дээдлэж ирсэн уламжлалаа сэргээж байна.

Монголыг Их Монгол, эзэнт гүрэн болтол нь мандуулж чадсан тулгар төр нь дорно дахины нийгмийн тогтолцооны үндэс, түүний хөгжлийн уг сурвалж болсон арга билгийн чанарыг зөвхөн сөргөлдүүлэх бус нэгдмэл чанараар авч үзсэнд оршино. Өөрөөр хэлбэл, засаглалыг нэг хүний гарт төвлөрүүлэн, авах гээх ёсны уян хатан бодлого явуулж байжээ.

Тулгар төр байгуулагдсан 1206 он бол монгол угсаатны хөгжлийн өгсөлт дэвшлийн үе, төвөөс зугтахаасаа төвд тэмүүлэх хүч нь давамгайлж байсан болохоор ардчиллыг аль болохоор хөгжүүлэхэд нэн тохиромжтой төдийгүй, шаардлагатай тийм үе байв. Чингис хаан энэ байдлыг харгалзан нэг хүний засаглалыг ардчилалтай хослуулж байсны баримт нь түүнд зөвлөх эрхтэй

"Сэцдийн зөвлөл", "Их хурилдай" гэсэн өнөөгийнхөөр бол парламентын хоёр ч хэлбэрийн засаглал ажиллаж байсан явдал юм. Улс төрийн ийм боловсронгуй тогтолцоо бүр Хүннүгийн үеэс уламжлалтай байсан нь хүчтэй төр бүрэлдэн тогтох шимтэй хөрс болжээ.

Чингис хаан тулгамдсан асуудлаар "Сэцдийн зөвлөл"-д хандаж тэдний санал зөвлөгөөг нь сонсдог байжээ. "Их хурилдай" гэдэг нь хаан, хаан хөвгүүд, төрөл төрөгсөд, том ноёд, тэр үеийн бусад албан тушаалтнууд оролцож хааныг сонгох, байлдах, найрамдах зэрэг цаг үеийн онцгой чухал хэргийг хэлэлцэн шийддэг байсан нь өнөө үед ч төрийн асуудлыг шийдвэрлэнэ гэдэг нь төрийн хэрэгт оролцогч хүнээс өндөр боловсрол, мэдлэг, улс төрийн зөв сэтгэлгээ, холын хараа, стратеги, тактикийн ухааныг хослуулах чадвар зэрэг улс төрийн нарийн мэргэжил, мэдлэг шаардаж байгааг харахад тухайн үедээ туйлын зөв байсан хэрэг юм.

Монголын эзэнт гүрний төр нь хууль буюу диктатурын, зөрчлийг бий болгогч талуудыг харилцан бие биед нь шингээн шүтэн

барилдуулсан Чингисийн билиг сургаал болон бөөгийн шашинтай байсан нь дэлхийн олон төр, улсын арга буюу дагах зүй тогтол байлаа.

Чингис хаан ард иргэдээ зэрэг дэвийн тогтолцоонд оруулж, дээдсээ хүндэлж, шүтэн захирагдах зарчмаар нийгмийнхээ харилцааг зохион байгуулжээ. Хүннүгээс уламжлалтай аравтын тогтолцоо нь зэрэг дэвийн тогтолцооны үндсэн нэгж болж байв. Чингис хаан хүн амын нийт давхрагыг аравт, зуут, мянгатын захирагч ноёдууд, хишигтнүүд, есөн өрлөг, шадар сайдууд, төрийн заргач, ерөнхий сайд, хаан гэсэн 11 зэрэг дэвээр ангилахдаа авьяас чадвар, байгуулсан гавьяа, улс үндэстний хэрэгт оруулсан хувь нэмэр зэргээр нь хувааж, тус тусын эрх үүргийг хуульчлан тогтоож өгсөн байна. Зэрэг дэвийн дэг нь нийгэмд захирах, захирагдах тогтолцоог бий болгож, эмх цэгц, зохион байгуулалттай байлгах чухал нөхцөл болж байжээ.

Хүндлэн захирагдах ёс нь харалган сохроор, бишрэн шүтэх юм уу албадлагаар бий болсон журам огтхон ч биш бөгөөд хүмүүсийн нийгэмд гүйцэтгэх эрх, үүргийн диалектик чанарт тулгуурлан гарсан, хүн нийгмийн ухамсарт ёс суртахууны нэг эрхэм чанар юм.

Чингис хаан засаг захиргааныхаа зохицуулалт өөрчлөлтийг хийж дууссаны дараа улс орныхоо эдийн засгийг түргэн хугацаанд өөд татах ажлын эхлэлийг тавьсан юм. Чингис, Өгөөдэй зэрэг их хаадын үед Монгол Улсын эдийн засаг ихэд тогтворжин хөгжжээ. Тэд мал өсгөх, зэр зэвсэг, эдлэл хэрэглэлээ хийх гар үйлдвэр хөгжүүлэх, хот суурин барих, газар тариалантай болох, өртөө алба байгуулах, худаг гаргаж усжуулах, гааль, татвар тогтоох, худалдааны зам харилцааг өргөжүүлэх зэрэг эдийн засгийн өргөн шинэтгэл хийжээ.

Чингис хаан Их Монгол Улсыг байгуулсны дараа ард олныхоо гавьяа зүтгэлийг үнэлэн "Аливаа зовиур зүдүүр ба аюул түгшүүрийг үл хайхран эрэлхэг баатар, хатан зориг гарган намайг тойрон нэгдэж баяр зовлонг хамтаар эдэлж, эрхэм дээд үр бүтээл болж бүрдсэн их улсын дээд иргэд минь ертөнц дээр амьдарч буй олон улсын дотор хамгийн агуу их улсын ард болно. Аливаа аюул түгшүүрийн дунд боловч миний чармайсан зорилтыг биелэх болтол энэхүү улсын ард иргэд нар хамгийн их үнэнч шударгаа үзүүлсэн юм..." гэж хэлсэн байна. Энэ утгаар авч үзвэл "Төр нь ард түмнээ түшдэг, халамжилдаг, ард олон нь төрөө хамгаалдаг, дээдэлдэг" ёсон бат оршиж байж сая улс орны аливаа ажил үйлс өөдрөг бөгөөд урагштай байхын үндэс болдог ажээ.

Хожим Хубилай хаан эзэнт гүрний нэрийг сольж Их Монгол Улсыг Их Юан улс гэж нэрлээд эзэнт гүрний нийслэлийг Хархорум хотоос Бээжинд шилжүүлсэн юм. Гэсэн ч Юан гүрний үед Монгол орон бол түүний эзэн улс, гол цөм нь болж байжээ. Хархорум хот их Юан гүрний хувьд дэд нийслэлийн эрх хэмжээтэй болж, Монголын өөрийнх нь улс төр, эдийн засаг, соёлын төв хэвээр хадгалагдаж байсан билээ.

Тухайн цагт монгол хаад Бээжингийн орд харшид сууж, тэндээс улс гүрнээ удирдаж байсан хэдий ч монголын ард түмэн төрөлх монгол нутагтаа мал сүргээ адгуулан амьдарсаар байсан юм.

1368 онд Юан улсын төр өөртөө эзлэгдсэн Хятадын ард түмний бослого тэмцэлд цохигдон унахад түүний хаад, ноёд өөрийн цэргийн хамт эргэж Монголдоо ирээд дахин Хархорумд төвлөн нийсэллэсэн байна.

Эзэн Чингисийн үүсгэн байгуулсан Монголын төрийг түүний алтан ургийн 37 хаан XYII зууны дунд үеийг хүртэл үе залгамжлан барьсан түүхтэй билээ.

Нэгэн үед тэнгэрийн хаяа шиг алсад байсан XXI зуунд бид туулсан замынхаа тоймыг эргэж санахад ийм байгаа бөгөөд товчилж хэлэхэд: нэгдүгээрт, Монголчууд хүн төрөлхтний соёл иргэншлийн хөгжилд их түлхэц өгч, төрт ёсны 2200 гаруй жилийн түүхийг бүтээж, Монголын тулгар төрийг үндэслэн байгуулж, нандигнан хадгалсаар 800 жилийнх нь ойг эдүгээ ёслол төгөлдөр тэмдэглэж байна.

Хоёрт, орчин үеийн нийгмийн хөгжлийн огцом түргэн өөрчлөлтөөс хоцорч үлдэх, сөрж зогсохын аль аль нь Монгол Улсын үндэсний эрх ашигт харшлах болно.

Гуравт, Монгол Улс олон улсын хамтын нийгэмлэгийн бүрэн эрхт гишүүнийхээ хувьд аюулгүй байдлаа улс төр, дипломатын аргаар баталгаажуулж, өөрийн давуу талыг ашиглан бүс нутгийн эдийн засгийн интеграцид орон зайгаа олж эзлэх явдал чухал байна.

Чухам ингэж гэмээ нь бидний юу санасан бүхэн сэтгэлчлэн бүтэх болно.



Өрнөдийн шашин номлогчдын Монголчуудтай холбогдох нь*

МУИС-ийн Нийгмийн ухааны сургуулийн дэргэдэх Түүхийн судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан,
доктор /Ph.D/ Т.Төмөрхүлэг

Христ шашин монгол язгуурын улс түмэнд гагцхүү XIII зуунаас бус, бүр өмнөх үеэс нэвтэрч эхлэсний жишээ гэвэл VIII зууны эцэс, IX зууны эхээр Нестор мөргөлтний номын багш Тимоте /Timothee/ Каспийн тэнгисийн эрэг орчимд нүүдэллэн очсон Хүн гүрний нэг тасархай монгол, түрэг угсааныханд евангиль судрын номлолоо түгээхээр санваартнуудыг илгээж байсан баримтыг[1] дурдаж болно. Хожим, нестор шашны урсгал Төв Ази, Хятад хүртэл дэлгэрсэн түүхтэй. Монголын эзэнт гүрэнд багтсан хэд хэдэн ханлиг нестор шашинтай байсныг бид түүхээс мэдэх билээ. Рубрук Францын ванд өргөсөн айлтгалдаа Монголын нестор шашинтнуудын талаар нэлээд тодорхой бичсэн. Аргун хааны элч Раббан Соума 1287 онд Ромын кардиналуудад " эдүгээ олон монгол хүн христ шашинтан болсон, тэд тал нутагтаа өөрийн гэсэн сүм дуганатай" гэж мэдэгдэж байв. Гэвч монгол нутагт Нестор шашинтай холбогдох эд өлгийн зүйл хараахан олдоогүй. Монголчуудын ярианы хэлэнд "ёдрын ганц мод" гэдэг хэллэг одоо ч байдаг нь христосын шашинтнуудыг үхэхэд булшных нь толгойд загалмайн дүрстэй мод хатгадаг ёс заншлаас үүдэн энэ үг гарсан хэрэг болов уу гэж таамаглахаас өөр үүнтэй холбогдуулан хэлэх зүйл алга.

Чингис хаан болон түүнийг залгамжлагчдын үеэс францискан, доминикан урсгалын төлөөлөгчид болох санваартнууд Монголд зугуухан орж ирсэн юм. Үүнд, Хархорумд христийн сүм байсан, Өрнөдийн олон христ шашинтнууд энэ хотод амьдарч байсныг Рубрукийн номоос бид мэдэж байгаа. Түүхийн сурвалж бичгүүдийг мөшгөн үзвэл монголчууд уг шашинд хэрээслүүлсэн тохиолдол нэлээд буй. Ноёд, эзэн хаад хүртэл христ шашинд орж байсан гэж ярьдаг боловч энэ нь улс төрийн бодлоготой цаагууруаа уялдаж байжээ гэж үзэх бас нэг шалтгаан бий. Энэ ч учраас тухайн үед Мусульман шашинтнуудын эсрэг Өрнөдийн ноёд, вангуудтай холбоотон болохыг эрэлхийлж, тэдний сэтгэл санааг татахын үүднээс өөрсдийнхөө эздийг загалмайлуулсан, христийг шүтдэг хэмээн ярьдаг байсан монгол элч нарын үгийг тэр бүр итгэхэд хэцүү гэж үзэх үндэслэлтэй.

Ер нь Өрнөдийн шашин номлогчдын үйл ажиллагаа Ил хаадын улс, Алтан ордны улс, мөн Цагаадайн улст ч сүрхий идэвхтэй байсан ч Монголын Эзэнт гүрний нийслэлээ болгосон Бээжинд XIV зуунд католик сүм үүсч харьцангуй цэцэглэн хөгжсөн түүх бидний сонирхлыг илүүтэй татах учиртай юм. Үүнд, Ромын пап IV Николасын 1289 онд Их хааны дэргэд илгээсэн Жан де Монт Корвино бол Бээжинд католик сүмийг цогцолгосон сартваахь билээ. Монт Корвино 1293 онд Ханбалик хотноо хүрэлцэн очсон бөгөөд эсэргэн жилийн эхээр, Хувилай хааныг бие барсны дараа дөнгөж хаан ширээнд залраад байсан Төмөр-Өлзийт түүнийг хүлээн авч уулзсан байна. Монт Корвино дотроо тэдий л итгэлгүйгээр эзэн хааныг христийн шашинд орохыг ятгасан боловч "хаан хэдийгээр Христ мөргөлтнүүдэд талтай ханддаг авч дүрс тахиг шашиндаа /Буддагийн шашин/ гүнзгий итгэлтэй юм"[2] гэж тэмдэглэн үлдээжээ. Төмөр-Өлзийт хаан түүнд өөрийнхөө хүссэнээр шашнаа номлож сүм байгуулах эрх олгожээ.

Гэвч Монт Корвинод саад бэрхшээл учирсан нь түүнд атаархсан нестор мөргөлтнүүд түүнийг засаг төрийн дээд эрхтнүүдэд зүйл бүрээр гүтгэн муулж, ажилд нь хориг саад учруулахыг хамаг байдгаараа оролджээ. Гэвч Монт Корвино Төмөр-Өлзийт хааны хүргэн онгуд овгийн Коргүзийг католик шашинд оруулж түүгээр дамжуулан бүх онгуд овгийнхныг өөрийн шашинд хамруулахыг хичээж байжээ. Түүний сацуу Монт Корвино Шинэ Гэрээс болон Псомыг[3] монгол хэлээр орчуулах, шинэ сүм цогцолгох ажилд оржээ. Тэр санваартан Ханбалигт 6000 орчим хүнийг загалмайлсан гэх бөгөөд ихэнх нь монгол, түрэг, алэнчууд байжээ. Жан де Монт Корвино 1328-1333 оны хооронд наснаас нөгчсөн бололтой. Дараагийн их хамба нь хурдан томилогдоогүй. Ямар ч атугай Ромын папын явуулсан Жан де Мариноли 1342-1346 онд Бээжингийн сүмийн их хамбаар ажиллаж байсан мэдээтэй. Дараагийн хамбынх нь талаар тодорхой зүйлгүй байна.

Монголын эзэнт гүрний үед Өрнөдийн шашин номлогчдын заримыг улс төрийн зорилгоор гадаад улсад элчээр зарах явдал байсан. Үүнд, Ил хаан Аргун бээр дээр нэр гарсан Раббан Соума гэгчийг Европт илгээсэн сириак хэлээрх баримт XIX зууны эцэст Азербайжанаас олдсон билээ. Раббан Соума 1225 онд Бээжинд төржээ. Тэр нестор мөргөлт гэлэн хожим /1281 онд/ Дорнодын сүмийн их хамба / III Яахбаллаха Мар хэмээх цол гуншинтай/ болсон Маркос гэдэг хүнтэй хамт Иерусалемд очиж мөргөл хийхээр Ираныг дайрч явжээ. 1275 онд

* Улаанбаатар хотноо 2006 оны 8 дугаар сарын 8-аас 12-ны өдөр зохиогдсон Олон улсын Монголч эрдэмтний IX их хуралд тавьсан илтгэл

[1] R.-E. Huc, Souvenirs d'un voyage dans la Tartarie, Paris, 1962, p.500.

[2] Jean-Paul Roux, Histoire de l'Empire Mongol, Paris, 1993, p.468.

[3] Псом нь католик сүмийн ёслолын болон мөргөлийн дуулал болно. Нийтдээ 151 дуураас бүрддэг. Хебре хэлнээс анх грек, дараа нь латин хэлээр, нэлээд хожим /18 дугаар зуунд/ франц хэлээр орчуулсан байна.

тэднийг Месопотами буюу Дорнодын сүмийн хамгийн чухаг төвд ирэхэд Персийн монголчууд болон Египет, Сирийн мусульман мамлюкуудын хоорондын дайсагналцлаас шалтгаалж Иерусалем орох зам хаагдаад аяллаа зогсоохоос өөр аргагүйд хүрчээ. Аргун хаан 1287 онд Европт буюу Ромын пап, Англи, Францын ван нар руу хоёр дахь элчээ явуулахаар шийдэж Раббан Соумаг сонгосон байна. Аргун түүнийг тийнхүү элчээр зарсан учир гэвэл Сири, Палестиныг байлдан дагуулахад Европын улсууд эрхбиш Христ шашинтайн улмаас өөрт нь туслах байх гэж бодсон хэрэг. Ромын пап хийгээд Франц, Английн вангууд Раббан Соумаг аятай таатай хүлээн авч өмнө нь Аргуны анхны элч төлөөлөгчид амласан шигээ үг дамжуулсан боловч хэлсэндээ хүрсэнгүй. Чингэхээр Раббан Соумагийн зорьсон хэрэг ч талаар өнгөрсөн хэрэг. Гийом де Рубрук ч Хархорумд дипломат элчийн үүрэгтэй ирснийг түүний Вандаа өргөсөн айлтгалаас нь үзэхэд тов тодорхой. Чингэхдээ шашнаар халхавчилсан элч асан.

1368 онд Мин улс үүссэн цагаас хятадууд "харийн" гэж үзсэн бүх юмнаас ангижран түгжигдэж, өмнөх үед нь Монголчуудын баримталсан "хүлцэмж"-ийн байр суурь хятадын үндэстний тэмүүллээр солигдон алга болсон билээ. Чингээд Хятадад католик сүмийн үйл ажил унтарчээ.

Манж Чин улсын үед, ялангуяа Кансигийн хаанчлалын үед Европоос очсон иезуйтүүд хааны ордонд зохих байр суурьтай байсан гэж түүхэнд гардгийг бид мэднэ. Христ шашинт гэлэн нарын зарим нь хааны ордонд одон орны судлал буюу зурхайг эрхэлж байсан бол зарим нь их буу үйлдвэрлэхэд нь тусалж байсан гэдэг. Зарим нь улс төрийн яриа хэлэлцээнд ч оролцож байжээ. Үүнд, Жербиллон (франц), Перейра (португаль) гэдэг хоёр гэлэн 1689 оны Нэрчүүгийн хэлэлцээнд орчуулагч хэлмэрчээр ажилласан баримтыг дурдаж болно. Хаант Орос, Манж гүрний энэ хэлэлцээнд оросууд нь манж, хятад хэл мэддэггүй, манж нар нь орос хэл мэддэггүйн шалтгаанаар энэ хоёр санваартан манж, хятад, латин хэлээр орчуулж хэлмэрчлэх үүрэг хүлээжээ. Нэрчүүгийн хэлэлцээний тухай Жербиллон, Перейра хоёрын хөтлөсөн өдрийн тэмдэглэлийг түүхийн ховор баримт гэж үзэх хэрэгтэй бөгөөд Нэрчүүгийн хэлэлцээр XVII зууны Монголын түүхтэй холбогдож буй болохоор бидний сонирхлыг бүр ч татах учиртай. Бас Жербиллон гэлэн Энх-Амгалан хааныг 1691 онд Долнуурт хүрэлцэн ирэхэд нь дагалдаж явсан байна. Өндөр гэгээн Занабазар, Түшээт хан Чахундорж хоёрын Кансид бараалхахыг нүдээр харснаа, мөн Өндөр гэгээний гаднах дүр төрхийг болон тэр гэгээнтний Монголын улс төрийн амьдралд мэдэгдэхүйц үүрэг гүйцэтгэж байсныг Европын тэр гэлэн товч төдий боловч тэмдэглэн үлдээсэн нь олзуурхууштай, түүхийн хувьд бол үнэ цэнэтэйд тооцогдоно гэж үзэж болох байх аа.

XVIII, XIX зуунд болон XX зууны эхээр Халх болон өвөрлөгчдийн нутгаар зорчсон европ санваартнуудын гол зорилго бол шашнаа шууд номлохдоо биш, харин түүнийгээ нэвтрүүлэх ямар арга зам, үүд хаалга хэр байна вэ гэдгийг танин мэдэхэд оршиж байсан онцлогтой гэж хэлж болно. Үүний тулд Монголчуудын түүх, сэтгэх арга, нийгмийн амьдрал, угсаатны зүй, хэл, үндэсний шашин номлол, зан заншил хийгээд ахуй амьдрал, байгаль цаг уур, амьтан, ургамлыг хүртэл илүүтэй сонирхож судлан аян замын тэмдэглэлдээ нүдээр харсан, чихээр сонссон юмс үзэгдэл, уулзаж ярилцсан хүмүүсийн яриа, ажиглалт зэргээ дэлгэрэнгүй бичсэн нь эдүгээ монгол судлалд ч тус нэмэртэй бүтээл туурвил болжээ. Үүнд, 1844-1845 онд Өвөрмонголын нутгаар аялсан монгол хэлтэй, франц гэлэн Р.Е.Хюкийн "Татаарт аялсан дурсамж" ном нь ардын ёс заншил, угсаатны зүй, соёлын үүднээс төдийгүй Манж Чин улсын дотор багтсан Монгол-Хятад үндэстэн хоорондын аж ахуйн харилцааны тухайд нэн сонирхолтой, чухамхүү судалгаанд нөхвөр болохуйц чансаатай бүтээл юм. Хюк гэлэн XIII, XIV зууны Монголын түүх хийгээд монголчууд Ази, Европын аж ахуйн болон соёлын хэлхээ холбоог сэргээхэд чамгүй хувь нэмэр оруулсныг бодит жишээгээр өгүүлсэн эсээг уг бүтээлийнхээ нэг бүлэгт бичсэн юм. Үүнийг бичигчийн үзэж байгаагаар, өгүүлэгдэн буй үеийн Монголын түүхийн талаар Европт анх удаа хамгийн шударга үнэлгээг одоогоос 150 гаруй жилийн өмнө франц гэлэн Хюк авгай гаргасан шиг байна[1].

XIX зууны хоёрдугаар хагаст Бээжинд сууж байсан Английн харьяат, протестант шашин түгээгч Жеймс Мор монгол хэл сурч Халх нутгаар олонтаа аялж судалгаа хийсний дүнд "Монголчуудын дунд" (Among the Mongols) гэдэг онц сонирхолтой ном бичсэнийг 1888 онд Лондон хотноо хэвлэн гаргажээ. Энэ ном тухайн үедээ утга зохиолын ертөнцөд шуугиан дэгдээсэн учир гэвэл ганц өгүүлэмжийн чадалдаа бус (түүний найруулах эрдмийг Даниел Дефогийнхтой зүйрлэдэг байжээ), өрнөдийн уншигчдад Монголчуудын өдөр тутмын амьдрал, зан заншил, сэтгэх арга, мухар сүсэг, шашин шүтлэгийг яруу сайхан дүрслэн бичсэнд байгаа юм. Зохиогч өгүүлэхдээ, "Христосийн шашин монголчуудад илүүц зүйл мэт санагддаг" гээд "Монголчууд Буддагийн шашныг хийсвэр номлолоороо ч, далай мэт арвин бичиг судраараа ч, зан үйлийн сэтгэл булаам шинж чанараараа ч, аль дивангарын их түүхээрээ ч, уудам их орон зайд тархсанаараа ч, амьд бурхадын ид шидээрээ ч, төрөлх нутагт нь үлэмж үүрэг гүйцэтгэдгээрээ ч гайхамшигтай тогтолцоо"[2] хэмээн үздэг гэжээ. Чингээд Жеймс Мор Христосын шашныг Монголд нэвтрэх хөрс суурь үгүй гэж дүгнэжээ. Зохиогч номдоо, Монголчуудын дунд түгээмэл байдаг өвчнийг тоочиж зүсэн бүрийн өвчний үүсэх учир шалтгааныг гаргасан нь одоогийн бидэнд ч мэдэхэд илүүдэхгүй болов уу. Тухайлбал, Монголд хавар салхи айхтар тавьдаг учраас хүний хууч өвчин хөдөлж,

1 R.E. Huc, Souvenirs d'un voyage dans la Tartarie, Paris, 1962, pp.460-505.

2 Revue Anda, 33-34, avril - juillet 1999, Bulletin trimestriel d'information de l'Association Anda, <<L'Allié>> sur la Mongolie et les régions voisines, Paris

ялангуяа настайчууд чухамхүү хаврын улиралд нөгөө ертөнцөд ихэвчлэн талийдгийг ажигласан байх жишээтэй.

Энэ илтгэлд тэр бүрийг тоочих аргагүй. Тэгэхдээ, Сэлэнгийн зүүн хойд этгээдэд хорь буриадын нутагт 1818-1840 онд бүтэн хорин хоёр жил суусан Англий харьяат, шашин түгээгч Суан, Броун нар Буриадын бөөгийн талаар судалгаа хийж бөөгийн зан үйл, бөөлөх ажиллагааг амьд мэт нарийн тодорхой бичсэн нь манай угсаатны судлаачдад сонин байж болох юм[1]. Түүнчлэн 1923 оны намар франц санваартан, их жуулчин, палеонтологич Пиер Тейлар де Шардин Ордос нутгаар хэсүүчлэн аян замын сонирхолтой тэмдэглэл[2] бичиж үлдээжээ. Тэр хүний аялсан газрын гуравны нэг нь Ази тив байсан юм.

Зарим гэлэн нь монгол судлалыг хөгжүүлэхэд гавъяат үйлс бүтээсэн. Үүнд, Ордос нутагт 17 жил сууж монголчуудын түүх, хэл, бичгийн болон аман зохиолын талаар далайцтай судалгаа хийн жинтэй бүтээл зохиол туурвисан бельги гарвалтай Мостерт авгайг нэрлүүштэй байнам. Тэр хүний бүтээл олон талтай бөгөөд Монголын түүхтэй холбогдох сурвалж бичгүүдийн судалгаа нь, тухайлбал, Монголын нууц товчооны уг эхийн гурван орчуулгыг харьцуулж хийсэн шинжилгээний ажил болон Ил хаан Аргун, Өлзийт нараас 1289, 1305 онд Гоо Филиппт илгээсэн захидлуудын талаархи буурьтай судалгаа нь өдгөө ч ач холбогдлоо гээгээгүй байна.

Эдгээр баримтаас үзвэл Өрнөдөөс Монгол нутагт ирж байсан Христос шашны ном түгээгчид эрдэм сурлагатай хүмүүс байжээ. Гэхдээ Хятад, Монголд богино хугацаагаар зорчсон зарим жуулчин гэлэнгүүдийн тэмдэглэл зэрэгт түүхийн тухайд өнгөцхөн хандсан, шашны хувьд гэнэн маягаар бичсэн болон Төв Азийн нүүдэлчдийг хооронд нь хольж хутгасан зэрэг зүйл бишгүй тааралддагийг хэлэхээс өөр аргагүй. Үүнтэй холбогдуулан өгүүлэхэд XVIII зууны үеийн Францын их сэтгэгчид Монголчуудын талаар зохиөл бүтээлдээ тусгахдаа Алс дорнод руу жуулчилсан шашин номлогчдын тэмдэглэл, ном зэрэгт л дулдуйдаж байжээ. Жишээлбэл, тухайн үеийн эрдэмтэн, улс төрийн зүтгэлтэн Белли гэгч Вольтерт Монголчуудын талаар мэдээлэл өгч байсан баримт буй. Энэ нь лав жуулчин гэлэнгүүдийн ном бүтээл байсан нь гарцаагүй. Вольтер "Улс үндэстний зан заншлын эсээ"-дээ цаг уур, засаглалын хэлбэр, шашин гурав хүний оюун бодолд нөлөөлдөг гэсэн онол дэвшүүлээд, "Туркуудын эзэнт гүрнээ байгуулсан Траст ч, тэдний эрт урьдын цагт гарсан Татар оронд ч манайхны оршдог энэ Европын хэсгийнхний зан заншлын хийгээд суу залийн шинж тэмдэг аль нь ч үгүй"[3] гэж бичсэн юм.

Түүнчлэн тэр үеийн их сэтгэгч, эвлэрэнгүй үзэлтэн, барон Шарль Луй Монтескьюе "Хуулийн амин сүнс" хэмээх зохиолдоо Евроазийн улс түмний талаар нэлээд дэлгэрэнгүй өгүүлсэн байна. Тухайлбал, анчин гөрөөчдийн овог аймгийг зэрлэгт тооцоод малчин улс түмнийг бүдүүлэгт оруулжээ. Зохиогч бээр Жан де Плано Карпиний тэмдэглэлийг үндэслэн "Чингис хааны монголчууд эд өлгийн соёлын хувьд их хоцрогдсон учраас хуульд амархан захирагддаг" гэсэн дүгнэлт хийжээ. Цааш нь өгүүлэхдээ, мөн л Плано де Карпиний бичсэнчлэн, "Татарууд өвөр хоорондоо их эвтэй, хүнлэг хирнээ [бусдыг] эзлэн түрэмгийлэхдээ маш догшин ширүүн"[4] гэжээ. Уг зохиолд "цаг агаарын онол" гэсэн томъёолол бий. Сайхь онолоор, "халуун уур амьсгалтай орны хүмүүсийн идэвхгүй үлбэгэр зан нь өөрсдийг нь ихэнхдээ боол болгодог бол хүйтэн газрын улс түмний зориг хатуужил нь эрх чөлөөтэй золгуулдаг" гэжээ. Гэтэл Монтескье "Монголчуудыг ташууураар засагладаг" гэсэн нь мөнөөх онолтой нь зөрчилддөг юм. Монголын тухай зохиогчийн ойлголт бүрхэгдүү байсан нь эрт цагаас Хятадаар явж байсан иезуитууд нарын манжуудыг өөлж муулах өнгө аясаар бичсэн ном бичиг, өнгөц ажиглалтад тулгуурласных гэж үзэлтэй. Тэр иезуитууд Сибирийн олон улс түмэн, манж, монголчуудыг нарийвчлан ялгахгүй, тэднийг ерөнхийд нь татарууд гэж нэрлэн хооронд нь хольж хутгадаг асан. Монтескье бүтээл туурвилдаа санваартан Плано де Карпини, Гийом де Рубрук нарын илтгэл айлтгалаас гадна Хятадаар явсан гэлэн Дю Халдын бичсэн Чин улсын тухай тэмдэглэл (1735), мөн шашин түгээгч Пети де ла Круагийн Их Чингисийн түүх (1711) гэсэн бичиг зэргийг ашигласныг дурдалтай[5].

Ерөнхийдөө Христосын шашин түгээгч нарын аян замын илтгэл айлтгал, бичсэн ном туурвил нь Өрнөдөд монголчуудын тухай шинэ мэдээг аваачиж, улмаар түүх, соёлын судлагаанд нөхөөр болох олон зүйл агуулснаараа монгол судлалд мэдэгдэхүйц нэмэр хандив оруулжээ. Тэдний бүтээлд, орчин үеийн шинжлэх ухааны сэтгэлгийн үүднээс шүүмжлэлтэй хандах зүйл нэлээд байх нь ч мэдээж хэрэг. Гагцхүү тэдний бүтээсэн ном бичгийг орчуулж, олон судлаачдын хүртээл болгох ажил хүлээгдэж байна.



1 Charles R. Bawden, <<Chamanisme et lamaïsme en Mongolie eptentrionale>>, Études mongoles et sibériennes, ' 18, 1987.(Citations extraites de Quarterly Chronicle of transactions of the London Missionary Society, 1825 et 1829)
2 Pierre Teilhard de Chardin, Lettres de voyages (1923-1955), Paris, Grasset, 1956.
3 Voltaire, « Essai sur les moeurs et l'esprit des nations », Paris, Editions sociales, 1975, p.300.
4 Montesquieu, De l'esprit des lois, I, Gallimard, Paris, 1995, p. 544.
5 Denis Sinor, Montesquieu et le monde altaïque, Etudes mongoles et sibériennes, cahier 27, Paris, 1997, pp.51-57.



МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсад Хууль зүйн алба үүсч байгуулагдсаны 85 жилийн ойг тохиолдуулан эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх үйлсэд хүчин зүтгэж ирсэн үе үеийн ахмад буурлууд, тэдний нэр төртэй үйл хэргийг өвлөн авч урагшлуулан хөгжүүлж яваа өдгөө цагийн хуульчид, тус салбарын нийт хамт олон, ажиллагсад Та бүхэндээ чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Хууль зүйн албаны шинэ үеийн түүхийн хуудсыг манай ахмад үе 1921 онд үндэсний ардчилсан хувьсгал ялж, ард олон бүрэн эрхтэй болсон үеэс эхэлдэг хэмээн үзэж энэ он тооллоор тэгш ойн баяруудыг тэмдэглэж ирсэн билээ. Өнгөрсөн он жилүүдэд манай салбар өөрөөсөө шүүх, прокурор, өмгөөлөл, нотариат, хууль зүйн сургуулиуд зэрэг олон салбар институтуудийг төрүүлж гаргасан юм.

Хууль зүйн албаны түүх нь угтаа Монголын төрт ёс, төрийн институт, эрх зүйн сэтгэлгээ, соёлын өөрчлөлт, хөгжлийн түүх бөгөөд өнөөдөр хувийн өмчийн эрхийг баталгаажуулсан олон хэвшил бүхий эдийн засагтай, ардчилсан Үндсэн хуульт ёсыг тогтоосон, эрх зүйт ёсыг хэвшүүлэхийг зорьсон, дэлхий дахинд танигдан хүлээн зөвшөөрөгдсөн тусгаар улс болжээ. Энэ бүхэн Монголын Хууль зүйн алба, түүнд үеийн үед зүтгэж ирсэн, өнөө ч хүч оюунаа зориулж байгаа хуульчид, ажилтнуудын хүч хөдөлмөр идэвх зүтгэлтэй салшгүй холбоотой юм.

Орчин үеийн Хууль зүйн алба нь эрх зүйт ёсыг хэвшүүлэх, эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, нийгмийн хэв журам, ард иргэдийн аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангах, нийгмийн шударга ёсыг бэхжүүлэх үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

Хууль зүйн албаны өмнө цаашид ч ард иргэд, улс эх орныхоо өмнө хийх ажлууд их байна. Хууль зүйн мэргэжилтэй боловсон хүчнийг чадваржуулах, хуулийг боловсруулахаас эхлээд хэрэгжилтийг зохион байгуулах хүртэлх бүх үе шатанд буй хийдэл, дутагдлыг арилгах, эрх зүйн ухамсрыг төлөвшүүлэх, орчин үеийн хууль зүйн шинжлэх ухааны ололт, шинэ санааг нэвтрүүлэх, нийгмийн аливаа үзэгдэл, үйл явцад эрх зүйт ёсны үүднээс ханддаг хандлагыг дэлгэрүүлэх зэрэг олон ажлыг энд дурдаж болно.

Хууль зүйн албаны байгууллага бол юун түрүүн хүний эрхийн байгууллага байх учиртай. Хүн хүнээ хүндэтгэсэн, хүн бүр өөрийн үйлдэл, үйл ажиллагаагаа хүний эрх, эрх чөлөөг дээдлэх үзэл санаанд нийцүүлж чадсан газарт л хууль ёс жинхэнэ ёсоор засагладаг.

Эдгээр зорилго, зорилтуудыг бид хамтын хүчээр шийдвэрлэж чадна гэдэгт итгэж байгаагаа илэрхийлэхийн хамт Та бүхэнд Хууль зүйн албаны 85 жилийн ойн баярын мэндчилгээг хүргэж, амжилт бүтээл, цог хийморийг бэлгэдэн хүсье.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД Д.ОДБАЯР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН АЛБАНЫ ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ТҮҮХЭН ЗАМНАЛЫН ҮЕ ШАТ

Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах мэргэжилтэн
Б.Цэвээн



Нэг. Түүхийн товч зурвас

1. 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын ачаар Ар монгол Манжийн 200 гаруй жилийн хүнд бэрх дарлалаас чөлөөлөгдсөн. Цагаагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн 9 буюу 1911 оны 12 дугаар сарын 29-ний Баасан гаригт Жибзундамба хутагтыг Монгол Улсын шашин төрийг хослон барьсан хаан ширээнд өргөмжлөн залах ёслол Их хүрээнд болж олноо өргөгдсөн Монгол Улсыг байгуулсныг албан ёсоор тунхагласан нь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний анхны том амжилт байлаа.

Богд гэгээн 5 яам бүхий Засгийн газрыг байгуулж, Ерөнхий сайд бөгөөд Дотоод яамны сайдаар Цэрэнчимэд даа ламыг, Гадаад хэргийн сайдаар Чин ван Ханддоржийг, Цэргийн яамны сайдаар далай ван Гомбосүрэнг, Сангийн яамны сайдаар түшээт ван Чагдаржавыг, Шүүх яамны сайдаар Намсрай гүн нарыг тус тус томилжээ.

Засгийн газар улсын хууль, дүрмийг боловсруулж тогтоохыг чухалд үзэж өөрийн улсын хуулийг боловсруулан баталж гаргатал хуучин хуулийн зарим зүйлийг түр хэрэглэх зөвшөөрлийг Монгол Улсын хаан 1911 оны эцсээр Шүүх яамны саналын дагуу олгож байжээ.

Олноо өргөгдсөний 5 дугаар оны 6 дугаар сард Монгол Улсын хууль зохиолгох 16 хүний бүрэлдэхүүнтэй комисс байгуулж, тэрхүү комисс нь богино хугацаанд "Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг"-ийг 65 дэвтрээр бэлтгэж, 1918 онд улсын доод, дээд хурлаар нэг нэг дэвтрээр нь хэлэлцүүлж, эцэст нь хааны зарлигаар батламжлуулж хэвлэсэн байна. Мөн энэ үед тухайн цагийн дэлхийн боловсон олон улсын жишээгээр улсынхаа хуулийг зохиох оролдлого хийж байв. Монгол Улсын ерөнхийлөн захирах сайд, Сайн ноён хан Намнансүрэнгийн шийдвэрээр эрдэмтэн Ж.Цэвээн Үндсэн хуулийн төслийг зохиож байжээ.

2. Монгол Улсын тусгаар тогтнол удаан үргэлжилсэнгүй. 1915 оны 5 дугаар сард Хиагтад Дундад иргэн улс, Орос, Монгол гурван этгээдийн бага хурал дуусч хоёр их гүрний тусламжаар Монголд туйлын ашиггүй, гарын үсэг зурсан өдрөөс журамлан дагах гэрээ байгуулснаар Монголын тусгаар тогтнолыг цуцалж, түүний төв болж байгаа Ар Монголыг Дундад иргэн улсын харьяанд нэрийн төдий автономит эрхтэй байлгах болов. Улмаар Бадамдорж тэргүүтэй хятадын талыг баримталсан хуучин эрх баригчид Их Хүрээ дэх Дундат иргэн улсын сайд Чэнь-И-тэй үгсэж Ар Монголын автономитыг устгаж, оросын хувьсгалаас хятадаар эх орноо хамгаалуулах талаар тус улсын Ерөнхийлөгчид өргөх бичиг барьсан явдал манай тусгаар тогтнолыг сүйрүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлэв. Үүнийг далимдуулан Хятадын Ерөнхийлөгч 1919 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Ар Монголын автономыг хүчингүй болгосон тухай зарлиг гаргаж, тус улсын Засгийн газрын эрхийг барьж байсан аньфугийн бүлэг өөрийн удирдагчдын нэг болох генерал Сюй-Шу-Чженийг мөн оны 12 дугаар сард нийслэл хүрээ рүү явуулснаар Монголын автономит засгийг шууд цэргийн хүчээр устгах төлөвлөгөөг хэрэгжүүлсэн юм. Хятад цэргийн эрх баригчид Манлайбаатар Дамдинсүрэн, Хатанбаатар Магсаржав нарыг дэмжигчдийнх нь хамт 1920 оны 9 дүгээр сарын 10, 11-нд, Богд хаан Жибзундамба хутагт болон түүний шадар бараа бологчдыг 1920 оны 10 дугаар сарын 26-нд тус тус баривчлан хорьсон байна. Иймхүү Монгол Улсын төрийн байгууламжийн тогтолцоо үндсэндээ 1919 оны 11 дүгээр сард Дундат иргэн улсын цэргийн эрхтнүүд гадаад Монголын автономитыг устгах хүртэл үйлчилж байгаад үйл ажиллагаагаа зогсоосон болно.

3. Монголын эх орончид цэрэг элсүүлэн эрх чөлөөний хөдөлгөөнд иргэдийг татан оролцуулж, оросын цагаантантай хүч хавсран нийслэл Хүрээг чөлөөлж, Ар Монголын автономит эрхийг сэргээж, Богд Жибзундамба хутагтыг суллан 1921 оны 2 дугаар сарын 22-нд хаан ширээнд дахин өргөмжлөх, дотоод 5 яамыг байгуулах, тэдгээрийн тэргүүн, дэд сайд, жанжин нарыг томилох, хятадын түрэмгийлэгчдийг бут цохиход идэвхтэй хүчин зүтгэсэн хүмүүсийг хөхиүлэн шагнах зэрэг ёслол үйлдсэн явдал үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний 2 дахь том амжилт байлаа.

Хэдийгээр хууль зүйн албаны төв байгууллагыг нэг жил 3 сар завсарласны дараа дахин байгуулсан ч олноо өргөгдсөн Монгол Улсаас автономит эрхтэй Ар Монголын үед ажиллаж байсан, 1911 оны Шүүх яамаар хууль зүйн албаны байгууллагын үүсэл хөгжлийн эх суурийг төлөвлүүлэх явдал шинжилгээ судалгааны талаас ч, залгамж чанарын хувьд ч нэлээд ул суурьтай хандах асуудал

болов уу гэж үзээд энэ хугацааны үйл ажиллагааг түүхийн зурвас гэж нэрлэсэн болно.

Гэхдээ манай Гадаад хэргийн яамныхан Монгол Улсын дипломат албаны 95 жилийн ой, Сангийн яамныхан Монгол Улсын санхүүгийн албаны 95 жилийн ой гэж ярьж, бичиж байгааг эрдэмтэн хуульчид маань анхааралдаа авч, хууль зүйн албаны үүсэл хөгжлийн асуудлын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй хариу өгнө гэдэгт найдаж байна.

Хоёр. Хууль зүйн албаны үүсэл хөгжлийн талаар

Тус улсын хууль зүйн албаны байгууллагууд ардын хувьсгалын анхны өдрүүдээс өнөөг хүртэлх 85 жилд төр, засгаас хууль зүйн салбарт дэвшүүлсэн зорилтыг тууштай хэрэгжүүлж, улс орныхоо хөгжлийн хурдац, түүхэн үе шат бүрийн зорилгод зохицон хөгжиж, үүрэг хариуцлага нь өсөн нэмэгдсээр ирсэн билээ.

1. Хууль зүйн алба үүсэн бэхжсэн бүх үйл явц нь ардын засаг, төрийн аппаратын үүсэл, хөгжил, түүний үр бүтээлт асар их үйл ажиллагааны өсөлт бэхжилтийн яруу алдарт замналын нэгэн хэсэг мөн.

Монгол Улсын хууль зүйн албаны анхны систем нь 1921 оны 7 дугаар сард байгуулагдсан Монгол Ардын Засгийн Шүүх явдлын яам, 1923-1924 оны эхээр байгуулагдсан олон аймаг, хошууны захиргааны зарга шийтгэх хэлтсүүдээс анхлан бүрдэж, жинхэнэ ардчилсан зарчмуудад үндэслэн үйл ажлаа эхэлсэн түүхтэй. Эдгээр байгуулага нь 1920-иод оны эцэс буюу шүүх, прокурорын байгууллагыг тусгайлан байгуулах хүртэл хувьсгалт шүүн таслах, засан хүмүүжүүлэх, гэрээ бичиг гэрчлэн батлах, энэ салбарт хууль, дүрэм боловсруулах, сурталчлах, хууль ёсны биелэлтэд төрийн хяналт тавих зэрэг эдүгээ үеийн хэд хэдэн төрлийн байгууллагын ажлыг бүхэлд нь эрхэлсэн нэгдмэл систем болж байлаа.

Улсын анхдугаар Их Хурлаас баталсан БНМАУ-ын Үндсэн хуулиар монголын нийгэм-төрийн байгууллын үндэс тулгуурыг бэхжүүлэн, хөдөлмөрчин ард түмний эрх чөлөөг илтгэн тунхагласан нь манай орны амьдралыг тууштай ардчилж, түүний эрх зүйн үндсийг язгуураар нь өөрчлөн бэхжүүлэх хэтийн төлөвийг нээсэн билээ.

Энэ үеэс Шүүх яам, түүний харьяа газрууд Улсын Их Хурал, Ардын засгийн газрын байнгын удирдлагын дор төрийн бусад байгууллага, хөдөлмөрчин олны идэвх оролцоотойгоор шинэ тутам төлөвшиж буй хувьсгалт хууль ёсыг цаашид бэхжүүлэх нөр их ажлыг зохион явуулжээ. Юуны өмнө засаг, төрийн дээд байгууллагуудаас батлан тогтоосон хууль, дүрмийг улс даяар дагаж биелүүлэхэд чиглэсэн нийгэм-улс төрийн бусад ажлын зэрэгцээ БНМАУ-ын Үндсэн хуулийн үзэл санааны дагуу хууль зүйн салбарт феодалын хууль цаазны үлдэгдлийг үүрд устган эрх зүйн шинэ нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх, түүнийг сахин хамгаалагч ардчилсан шүүх, прокурорын газруудыг үүсгэн төлөвшүүлэх зэрэг арга хэмжээг зохион байгуулжээ.

1925-1930 онд БНМАУ-ын "Шүүх цаазны бичиг" (Эрүүгийн хууль), "Монгол улсын шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх тухай хууль", иргэн, гэр бүл, биеийн хүчин үнэлэгчдийн зэрэг төрөлжсөн томоохон хууль болон тэдгээрийн дагуу олон тооны дүрэм, зааврыг гаргажээ.

Ардын төрийн хууль, дүрмийг олны сонорт хүргэж, түүнийг эрхэмлэн биелүүлэх үзэл дадлыг хөдөлмөрчдөд төлөвшүүлэх явдал хувьсгалын ардчилсан шатнаа шинэ хууль ёсыг тогтоон бэхжүүлэх түвэгтэй зорилтын нэг байсан. Хууль зүйн албаны байгууллагууд нь ардын засгийн хууль дүрмийг олшруулан аймаг, хошуудад хүргүүлж, орон нутгийн засаг захиргаа, хуулийн байгууллага, хөдөлмөрчдийн хурлаар дамжуулан хүн амд өргөнөөр мэдээлэх, аймаг, хотын төвд хууль судлах дугуйлан байгуулж хичээллүүлэх зэргээр засаг, төрийн эрх зүйн бодлогыг олон түмний дотор дэлгэрүүлж, тэдний ухамсар, хүмүүжлийг төлөвшүүлэх олон хэлбэрийн ажил зохиож байв. Тэдгээрийн дотор байгууллагын удирдах ажилтан, бусад ажиллагсад, иргэдийн чухал хэрэгцээ болсон хууль зүйн ном хэвлэлийн ажил мэдэгдэхүйц суурь эзэлж ирсэн юм. БНМАУ-ын Шүүх яам 1927 оноос уг ажлыг төвлөрүүлэн эрхэлж 1940 он хүртэл (1926 оноос Засгийн газрын эрхэлж байсан) "Засгийн газрын албаны сэтгүүл", "Улсын бага хурал, Засгийн газрын хууль, тогтоолуудыг эмхтгэж хавсруулсан сэтгүүл"-ийн хэдэн арван дэвтрээс гадна хөдөлмөрчдөд зориулсан сэдэвчилсэн эмхтгэл, тайлбар ном зохиол, түүнчлэн 1927 оноос эхлэн "Хувьсгалт хууль ёсны төлөө" сэтгүүл гаргаж төр, хууль зүйн асуудлыг нийтэлж байсан зэрэг нь хууль зүйн соёлыг түгээж, хөдөлмөрчдийн улс төр, эрх зүйн ухамсрыг дээшлүүлэхэд тус нөлөө үзүүлсэн нь дамжиггүй.

Хууль хамгаалах болон эрх зүйн ажлыг нэгэн зэрэг эрхэлж байсан төрийн захиргааны төв, орон нутгийн аппаратаас 1926 онд хувьсгалт шүүхийн, 1930 онд прокурорын байгууллага салбарлан үүсч цаашдаа тус тусын систем болж бэхжсэн байна. Түүнчлэн Шүүх яам, түүний орон нутгийн байгууллагын харьяанд байсан засан хүмүүжүүлэх газруудыг 1936 онд удирдлагын өөр системд шилжүүлж, Монголын өмгөөлөгчдийн байгууллагыг "Шүүх таслах явдлын тухайд тусламж үзүүлэх бүлгэм" нэртэйгээр 1928 онд үүсгэн байгуулж, улмаар тус яаманд харьяалуулжээ. Энэхүү өөрчлөлтийн дараа хууль зүйн албаны байгууллага нь орон нутгийн шүүх болон хууль хамгаалах бусад зарим байгууллагыг удирдан зохицуулах гол үүрэгтэй болсон.

Түүний дагуу холбогдох хууль дүрэм, тэдгээрийг хэрэглэх арга зүйн олон асуудлыг шинэчлэн боловсруулж орон нутгийн шүүх, ялангуяа сум, хорооны захиргаадын энэ талын ажилтай танилцах, шалгаж зааварлах, аймаг, хот, тусгай шүүхийн дарга, прокуроруудын нэгдсэн зөвлөгөөн, семинар зохион байгуулах зэргээр тэдгээрээс захиргаа, эрүү, иргэний хэргийг зөв шийдвэрлэж хуулийн нэгдсэн бодлогыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг сайжруулахад багагүй чармайлт тавьж ажилласан байна.

Хуучин төрийн хууль цаазыг халж, хувьсгалын ололт, хөдөлмөрчин ард түмний ашиг сонирхлыг тууштай хамгаалж, эрх зүйн шинэ соёлыг түгээн дэлгэрүүлсэн нь хувьсгалын ардчилсан шатан дахь хууль зүйн албаны байгууллагын үйл ажиллагааны гол үр дүн мөн.

2. 1940 онд Улсын 8 дугаар Их хурлаас баталсан БНМАУ-ын хоёр дахь Үндсэн хуулиар шүүх, прокурорын байгууллагыг биеэ даасан систем болгож бэхжүүлсэн юм.

Энэ бүхэнтэй уялдаж хууль зүйн албаны байгууллага 1940-1960-аад он хүртэл орон нутгийн шүүх, өмгөөлөгчдийн болон нотариатын байгууллагыг зохион байгуулалтын талаар удирдах, АДХ-ын Гүйцэтгэх захиргаадаас нотариатын үйлчилгээ хийхэд нь туслах, эдгээр салбарт дагаж мөрдөх хууль, эрх зүйн бусад актын төсөл боловсруулах, мэргэжилтэй боловсон хүчнийг төвлөрсөн журмаар бэлтгэж хуваарилах, давтан сургах, хүн амын дотор хууль сурталчлах, иргэд байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлсэн байна.

1940-1950-иад онд орон нутагт ардын хэсгийн шүүхүүдийг шинээр байгуулах, аймаг, хотын шүүхийг өргөтгөн бэхжүүлэх, улмаар нийт шүүхийг ардчилсан сонгуулийн шинэ системийн дагуу өөрчлөн байгуулах ажлыг зохион байгуулахын зэрэгцээ БНМАУ-ын Эрүүгийн хууль (1941), Иргэний хууль (1952), Эрүү, Иргэний байцаан шийтгэх хууль (1949, 1952), Шүүхийн зохион байгуулалтын хууль (1949, 1958) зэрэг төрөлжсөн бусад хуулийг манай орны хөгжлийн тухайн үеийн түвшинд нийцүүлж шинэчлэн боловсруулж батлуулсан байна.

Улс оронд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх ажлын хэмжээ мэдэгдэхүйц нэмэгдэж, энэ үйлсэд хууль зүйн албаны байгууллага өөрийн хувь нэмрийг оруулж иржээ. 1940-өөд оноос ЗХУ-д хууль зүйн мэргэжилтнийг бэлтгэхийн зэрэгцээгээр Шүүх яамны дэргэд хууль цаазны түр курсийг хичээллүүлж, 1950 онд жилийн курс, 1956 онд дунд сургууль болгон өргөтгөсний дээр 1960 оноос МУИС-д хууль зүйн салбарыг нээж улмаар өргөжүүлэн ажиллуулсны үр дүнд өнгөрсөн хугацаанд нийтдээ дээд, дунд мэргэжилтэй 3000 шахам хуульчийг бэлтгэн гаргажээ. Мэргэжилтэй боловсон хүчний эгнээ өсч, тэдний боловсролын түвшин нэмэгдсэн нь хууль тогтоомжийг боловсронгуй болгох, эрх зүйн шинжлэх ухааны мэдлэгийг дэлгэрүүлэх, хөдөлмөрчдийн эрх зүйн соёлын хэмжээг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг сайжруулахад чухал ач холбогдол үзүүлжээ. Энэ үед Шүүх яам, түүний харьяа байгууллагуудаас хууль дүрэм тайлбарлан таниулах, сурталчлах ажлын хэмжээ өсч, арга хэлбэр нь сайжирсны дээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил хууль хамгаалах байгууллагын үйл ажиллагааны гол чиг үүргийн нэг болж ирсэн байна.

Өмгөөллийн болон нотариатын байгууллагаас ард иргэд, албан байгууллагад үзүүлэх эрх зүйн туслалцааг өргөтгөн сайжруулахад анхаарч Монголын өмгөөлөгчдийн коллегийг өргөтгөн 1956 оноос орон нутагт мэргэшсэн өмгөөлөгчдийг бий болгож, цаашдаа Хууль зүйн зөвлөгөө өгөх газрууд байгуулан үүргийг нь нэмэгдүүлсэн байна.

Энэ үед хууль зүйн албаны байгууллагын үйл ажиллагаанд гарсан шинэ чухал ололт бол БНМАУ-ын гадаад харилцаа өргөжин хөгжсөнтэй уялдан бусад улс оронтой харилцах эрх зүйн хамтын ажиллагаанд дагаж мөрдөх олон улсын гэрээ, хэлэлцээрийн төсөл боловсруулах, уг гэрээ, хэлэлцээрээр БНМАУ-ын хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж, зохицуулах асуудлыг эрхлэх болсон явдал юм. Манай орон 1958 онд ЗХУ-тай эрүү, иргэн, гэр бүлийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг анх байгуулснаас хойш социалист бусад хэд хэдэн оронтой ийм харилцааг тогтоосон нь тус яамны гадаад харилцааг цаашид хөгжүүлэхэд зохих хувь нэмэр оруулсан юм.

3. БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1959 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 52 дугаар зарлигаар БНМАУ-ын Шүүх яамыг татан буулгасан явдлыг цаг үеийн зайлшгүй шаардлага байв уу, аль эсвэл нам, төрөөс 1960-1970-аад онд захиргааны орон тоо цомхотгон аривлан хэмнэх зорилт дэвшүүлж ажилласны урьдчилсан нөхцөл болов уу гэдгийг таахад төвөгтэй юм. Яагаад гэвэл энэ шийдвэр гараад 2 сар 23 хоног өнгөрсний дараа БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1959 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 210 дугаар тогтоолоор тус улсын хууль, хуульчилсан баримтуудыг боловсруулах, тэдгээрийг системчлэх, ангилах үүрэгтэй Хууль цаазны хороог 9 орон тоотойгоор Сайд нарын Зөвлөлд байгуулсан байна. Түүнээс нэлээд хойно Сайд нарын Зөвлөлийн 1959 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 437 дугаар тогтоолоор Хууль цаазны хорооны дүрэм, мөн хорооны бүрэлдэхүүнийг баталсан байна.

Эдгээр баримт бичгийг гаргасан хугацаанаас нь үзэхэд Шүүх яамыг ямар ч бэлтгэлгүйгээр татан буулгасны дараа Хууль цаазны хороог зохих ёсоор нь байгуулж ажиллуулахад бараг бүтэн гурван улирлын хугацаа зарцуулсан байдал ажиглагдаж байна.

Төр, засгаас хууль тогтоомжийг боловсронгуй болгох, шүүн таслах ажлын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор хууль зүйн албаны салбарыг удирдах байгууллагын системд зарчмын өөрчлөлт оруулж 1960 оноос эхлэн шүүхүүдийг удирдах үүргийг Улсын дээд шүүхийн тэргүүлэгчдэд шилжүүлсэн бөгөөд хууль боловсруулах, системчлэх ажлыг тэр үед шинээр байгуулсан Сайд нарын Зөвлөлийн Хууль цаазны хороонд эрхлүүлсэн байна.

Сайд нарын Зөвлөлийн Хууль цаазны хорооны хамгийн чухал нэр хүндтэй ажлын нэг нь 1960 оны Үндсэн хууль юм. Энэ тухай манай гавьяат хуульч С.Жалан-Аажав гуай дурдатгалдаа: "1960 оны Үндсэн хуулийн анхны эхийг Үндсэн хуулийн комиссын даалгавраар боловсруулах өндөр хариуцлагатай нөр их ажлыг хийж гүйцэтгээд Үндсэн хуулийн улсын комиссын дарга Ю.Цэдэнбалд өргөн барьсан юм. Үндсэн хуулийн төслийг боловсруулах ажилд Ю.Цэдэнбал дарга 2 сар шахам өдөр шөнөгүй ажиллаад уг төслийн чанар, агуулга,

хэл найруулгыг улам сайжруулж байсныг тэмдэглэх хэрэгтэй. Миний бие Хууль цаазны хорооны даргын хувьд Ю.Цэдэнбалтай хамтран сууж, өөрийн хэр чинээгээр тус нэмэр болохыг хичээж байлаа. Хууль цаазны хорооноос эрхлэн боловсруулсан энэхүү төслийг Үндсэн хуулийн комисс хүлээн аваад түүнд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж эцэслэн боловсруулаад бүх ард түмнээр хэлэлцүүлж, улмаар Ардын Их Хурлын чуулганаар батлуулж байсан билээ" гэж тэмдэглэсэн байна.

Хууль цаазны хороо Монгол Улсын хууль тогтоомжийн бүх актуудыг системчлэх, төрөлжүүлэх ажлыг анх хийж эхэлсэн. Төр, засгаас 1960 он хүртэлх хугацаанд нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралын бүх салбараар гаргасан хууль, эрх зүйн актуудыг системчилж, ангилан ялгаж, төрөлжүүлээд тусгай эмхтгэл болгон хэвлүүлж байсан юм. Энэ бол 50 шахам жилийн дотор гарсан олон арван мянган актуудыг эрж олох, судлах, системчлэн төрөлжүүлэх, хэвлүүлэх их ажил байсныг хэлэх хэрэгтэй.

Түүнчлэн Хууль цаазны хороо нь хууль тогтоох байгууллагаас батлаж гаргах хуулиудын төслүүдийг боловсруулахаас гадна Сайд нарын Зөвлөлөөр батлагдаж гарах бүх тогтоол, журам, зааврууд хууль зүйн үүднээс хянан үзэж зөвшөөрөл (виз) өгөх үүргийг гүйцэтгэж байсан юм. Хууль цаазны хорооны визгүйгээр нэг ч тогтоол, зааврыг Сайд нарын Зөвлөлд оруулдаггүй хатуу журам дагаж мөрдөж байв. Энэ бол Үндсэн хууль ба бусад хуулийг зөрчихгүй, хуулийг дээдлэн үзэж түүнийг нарийн чанд дагаж мөрдөж байх үзэл баримтлалтай бүрэн нийцэж байсан юм.

Тэр үеийн нам, төр, засгийн бүх байгууллага хуулийг сайн сурталчлах явдал нь түүнийг хэрэгжүүлэх нэг гол нөхцөл гэж үзэж уг ажлыг нарийн төлөвлөгөө, зохион байгуулалттайгаар хийж гүйцэтгэдэг байсан юм. Энэ чухал ажилд Хууль цаазны хороо гол үүрэгтэй оролцож байсны тодорхой баримт жишээ бол хууль тогтоомжийг сурталчилсан сэтгүүл гаргахын зэрэгцээ Монгол Улсын бүх хууль тогтоомжийн актыг системчлэн төрөлжүүлж салбар, салбараар нь хэвлэн нийтэлж нийтийн хүртээл болгож байсан явдал юм.

Төрийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хууль ёсыг бэхжүүлэх талаар нам, засгаас авсан олон талт арга хэмжээний ачаар хууль зүйн албаны болон хууль хамгаалах байгууллагууд өргөжин бэхжиж тус орны эдийн засаг, нийгэм соёл, улс төрийн байгуулалтыг хөгжүүлэх үйлст тэдгээрийн гүйцэтгэсэн үүрэг, үр нөлөө үзэмж дээшилсэн нь энэ шатны хөгжлийн гол үр дүн мөн.

Гурав. Хууль зүйн албаны систем бүрэлдэн тогтсон нь

1970 оноос хойш манай хууль зүйн албаны байгууллага улс ардын аж ахуйн эрх зүйн ажлыг эрхлэх гол чиглэлээр өөрчлөгдөн хөгжиж, ажлын хүрээ нь улам олон талтай болж ирлээ. 1972 онд Шүүх яамыг шинэчлэн байгуулж, түүнд хууль тогтоомжийн төсөл боловсруулах зэрэг уламжлалт үүрэг дээр нь улс ардын аж ахуйн эрх зүйн болон хөдөлмөрчдийн хууль зүйн хүмүүжлийн ажлыг аргачилсан удирдлагаар хангах, нотариат, өмгөөлөх, иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн ажлыг зохион байгуулах үүргийг нэмж хариуцуулсан байна.

Шүүх яам байгуулагдсантай холбогдуулан БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1972 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 473 дугаар тогтоолоор Сайд нарын Зөвлөлийн Хууль цаазны хороог 1973 оны 1 дүгээр сарын 1-ээс татан буулгасан болно.

Шинэчлэн байгуулагдсан Шүүх яам зарчмын шинж чанартай, хэтийн төлөвийг агуулсан үндсэн дөрвөн зорилтыг багцаар нь боловсруулж шийдвэрлүүлсэн нь одоо ч гэсэн ач холбогдлоо алдаагүй байна.

Нэгдэх үндсэн зорилт нь улс ардын аж ахуйн хууль зүйн албаны байгууллагын нэгдсэн тогтолцоо бий болгож, үйл ажиллагааг нь жигдрүүлэн эрчимжүүлэх явдал байв. Төр, засгаас хууль зүйн албаны зохион байгуулалтыг улс ардын аж ахуйн удирдлагын бүтцэд зохицуулан өргөтгөж үйл ажиллагааг нь идэвхжүүлэх арга хэмжээ авч ирсэн. Ялангуяа МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1979 оны 9, Сайд нарын Зөвлөлийн мөн оны 101 дүгээр тогтоолоор улс ардын аж ахуйн эрх зүйн ажлын байдалд дүн шинжилгээ хийж, түүнийг цаашид сайжруулах арга зам, хууль зүйн албаны байгууллагуудын гол зорилт, зарчим, журмыг нэгтгэн тодорхойлсон нь тус албаны хөгжилд чухал ач холбогдолтой боллоо.

Эдгээр шийдвэрийн дагуу 1979, 1980 онд аймаг, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, аж ахуйн гол гол салбарын яам, зарим төв байгууллагад хуулийн хэлтэс, тасаг байгуулж, томоохон үйлдвэрийн газруудад хуулийн зөвлөх бий болгож ажиллуулав. Түүний үр дүнд улс ардын аж ахуйн зонхилох салбаруудад хууль зүйн албаны аппаратын зохистой үндэс тавигдлаа. Ийнхүү улс ардын аж ахуйн хууль зүйн алба нь салбарын хууль зүйн алба (яам, улсын хороо, тусгай газар, үйлдвэрийн хуулийн хэлтэс, тасаг, хуулийн зөвлөх), нутаг дэвсгэрийн хууль зүйн алба (аймаг, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны Хуулийн хэлтэс), хууль зүйн албаны аргачилсан удирдлагын байгууллага (Шүүх яам) гэсэн гурван хэсгээс үндсэндээ бүрдэл болж, өөрсдийн үүргээ зохих ёсоор гүйцэтгэж ирсэн юм. Тухайлбал, яам, улсын хороо, тусгай газар, аймаг хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаадад шинэ тутам байгуулагдсан хуулийн хэлтэс, тасаг, хуулийн зөвлөх нь хууль тогтоомжийн системчилсэн бүртгэл-лавламжийн фондыг бүрдүүлж удирдлагад байнга үйлчлэх; дагаж мөрдөж байгаа хуулиар иргэд, байгууллагад лавлагаа, зөвлөгөө өгч эрх зүйн үйлчилгээ үзүүлэх; төрийн өмчийн хадгалалт, ажлын чанарт үзлэг, шалгалт явуулах; аж ахуйн гэрээ, гомдлын шаардлагын ажлыг зохион байгуулах; эрх зүйн сургалт, сурталчилгааг өргөтгөн тогтмолжуулах; гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэхэд чиглэсэн системтэй ажлыг төлөвлөгөөтэй зохиож, тодорхой үр дүнд хүрч эрх зүйн ажлын ач холбогдлыг салбарын хэмжээнд ч, нутаг дэвсгэрийн хэмжээнд ч ойлгуулж чадсан юм.

Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сурталчилгаа, мэдээлэл сурталчилгааны үндэсний төв

Хоёрдахь үндсэн зорилт нь хууль тогтоомжийг боловсронгуй болгох арга замыг боловсруулж шийдвэрлүүлэх явдал байлаа. МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1982 оны "Хууль тогтоомжийг боловсронгуй болгох зарим арга хэмжээний тухай" хавсарсан 1 дүгээр тогтоол, "БНМАУ-ын хүчин төгөлдөр хууль тогтоомжийн системчилсэн бүрэн эмхтгэл бэлтгэж хэвлүүлэх тухай" хавсарсан 2 дугаар тогтоол тус тус гарч, эдгээрээс улбаалан хууль тогтоомжийг боловсронгуй болгох 5 жилийн төлөвлөгөөг БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн мөн оны 7/52 дугаар тогтоолоор батална билээ. Дээд байгууллагаас батлан гаргасан эдгээр шийдвэрүүд нь:

1/ 1921-1981 онд гарсан хууль, зарлиг, тогтоол, дүрэм, заавар болон олон улсын гэрээг нийтэд нь бүртгэж, бүртгэл-лавламжийн улс, салбар, орон нутгийн сан бүрдүүлэх;
2/ тэдгээрийг хянан үзэж цаг үеийн шаардлагаас хоцорсон, давхардаж зөрчилдсөн эрх зүйн акт, заалтыг хүчингүй болгох;
3/ янз бүрийн цаг үед гарсан нэг төрлийн олон арван эрх зүйн актыг төрөлжүүлэн нэгтгэх замаар боловсронгуй болгож хэрэглэхэд дөт болгох;
4/ "БНМАУ-ын хүчин төгөлдөр хууль тогтоомжийн системчилсэн бүрэн эмхтгэл" бэлтгэж Улсын комиссоор хянуулан албан ажлын хэрэгцээнд зориулж хэвлэн нийтлэх зэрэг цогцолбор арга хэмжээг урт хугацаагаар тогтоож бүх яам, улсын хороо, тусгай газар, аймаг, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаадын энэ талаар гүйцэтгэх үүргийг тодорхойлж өгсөн.

Энэ зорилтыг хэрэгжүүлсний үр дүнд хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулах, салбарын эрх зүйн актыг цэгцэлж боловсронгуй болгох ажил жигдэрч, нийгмийн ихэнх харилцааг гол төлөв элдэв дүрэм, журмаар зохицуулдаг буруу хандлага аяндаа өөрчлөгдөж ирсэн юм.

Гуравдахь үндсэн зорилт нь иргэдийн эрх зүйн хүмүүжлийн ажлыг улсын хэмжээний удирдлага, зохицуулалтын шинэ тогтолцоонд оруулж хэвшүүлэх явдал байсан юм. 1974 онд АИХ-ын 8 дахь удаагийн сонгуулийн 3 дугаар чуулганаар "Хөдөлмөрчдийн хууль эрхийн хүмүүжлийг дээшлүүлэх тухай" хэлэлцэж тодорхой шийдвэр гаргасан бол АИХ-ын Тэргүүлэгчдийн 1979 оны "Хөдөлмөрчдийн хууль зүйн хүмүүжлийн ажлыг цаашид сайжруулах арга хэмжээний тухай" тогтоол гарсан.

Энэ тогтоолын дагуу уг ажлыг улсын хэмжээнд зохицуулж арга зүйн удирдлагаар хангахад туслах үүрэг бүхий "Хууль зүйн хүмүүжлийн ажлын зохицуулалт арга зүйн зөвлөл"-ийг байгуулж, түүнийг чиглүүлж удирдах үүргийг Шүүх яамны сайдад даалгасан билээ. Ийнхүү хөдөлмөрчдийн эрх зүйн хүмүүжлийн ажлыг яам, улсын хороо, тусгай газрууд салбартаа, орон нутгийн засаг захиргаа нутаг дэвсгэртээ эрхлэн зохиож үр дүнг өөрсдөө хариуцах болж, харин уг ажлын аргачилсан удирдлага Шүүх яаманд төвлөрсөн билээ.

Дөрөвдэх үндсэн зорилт нь хууль зүйн албаны төв, орон нутгийн байгууллагыг мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлж, тэдний ажлын арга барил, ур чадварыг дэс дараатай дээшлүүлэх явдал байлаа. Юуны өмнө хууль зүйн албанд ажиллах мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд ихээхэн анхаарал хандуулсан. ЗХУ-д хуулийн мэргэжлээр суралцдаг оюутны тоог нэмэгдүүлж, 1980 оноос МУИС-ийн НУФ-д аж ахуйн эрх зүйчийн анги, Хууль цаазны дунд сургуульд хууль зүйн албаны болон архив, бичиг хэргийн анги тус тус шинээр нээж хэдэн жилийн дотор хууль зүйн албаны системийн байгууллагыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах боломжтой болсон юм. Дараа нь хууль зүйн албаны ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд анхаарч, энэ асуудлаар ЗХУ-ын Шүүх яамтай хамтын ажиллагааны тухай хэлэлцээр байгуулсан. Хэлэлцээрийн дагуу аймаг, хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргааны Хуулийн хэлтэс, шүүхийн ажилтнуудыг ЗХУ-ын Шүүх яамны дэргэдэх Бүх холбоотын хууль зүйн албаны удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх институтэд 1980 оноос эхлэн 15 хүнийг 45 хоногийн хугацаагаар сургаж мэргэжлийг нь дээшлүүлэх, ажлын арга барил, туршлага судлуулах арга хэмжээг хэд хэдэн удаа дэс дараатай авч хэрэгжүүлсэн нь хууль зүйн албаны төв, орон нутгийн байгууллагын ажил жигдэрч тогтмолжиход ихээхэн нөлөө үзүүлсэн. 1984 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн "Хууль зүйн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх зарим арга хэмжээний тухай" тогтоол гарсан нь гадаад, дотоодын их, дээд сургуульд хууль зүйн чиглэлээр оюутан сургах, Хууль цаазны дунд сургуулийг бэхжүүлж сургалтын болон элсэлтийн чанарыг сайжруулах асуудлыг тухайн үедээ шийдвэрлэсэн чухал арга хэмжээ болсон юм.

Түүнчлэн өмгөөлөх, нотариатын байгууллагыг бэхжүүлэх, эрх зүйн үйлчилгээг нь өргөжүүлэхэд анхаарал тавьж ирснээр аймаг, хотын Хууль зүйн зөвлөгөө өгөх газраас гэрээгээр үйлчилдэг байгууллагуудын тоо 2 дахин нэмэгдэн 400 гаруй болж санхүү, аж ахуй, боловсон хүчний хувьд бэхжсэний зэрэгцээ Улаанбаатар хотод орлогоороо зарлагаа нөхдөг Улсын нотариатын контор байгуулж ажиллуулав. Энэ бүхэн нь өмгөөлөх, нотариатын байгууллагын нэр хүнд өсч, ажил үйлс нь тогтмолжин чанаржиж байгааг илтгэх нэгэн үзүүлэлт байв.

Ийнхүү шинэчлэгдэн байгуулагдсан Шүүх яам улс ардын аж ахуйн хууль зүйн албаны нэгдсэн систем бий болгон бэхжүүлж, түүний үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөж, хууль тогтоомжийг эмхлэн цэгцлэж, хууль зүйн сургалт, сурталчилгааны хэлбэр, агуулгыг тогтоож чадсанаар нам, төр, түүний байгууллагуудаас хуульд хандах зарчим, үүрэг хариуцлага, арга технологи, сэтгэл зүйн хувьд огцом эргэлт хийх, хуулийн бодлогыг хөгжлийн шинэ үе рүү нь чиглүүлэх их ажлын гарааны суурь тавигдсан юм.

Дөрөв. Хууль зүйн алба ардчилсан хөдөлгөөний жилүүдэд

Хууль зүйн албаны төв, хөдөөгийн байгууллагын хөгжилд ардчилсан хөдөлгөөний жилүүд онцгой байр суурь эзэлдэг. Монгол Улсын түүхэнд тодорхой ул мөр үлдээсэн энэ 10 жилд хууль зүйн албаны бүтэц, зохион байгуулалт ч, үйл ажиллагааны чиглэл, эрх хэмжээ ч ихээхэн өөрчлөгдсөн билээ.

I. Хууль зүйн албаны байгууллагын бүтэц, түүний үйл ажиллагаа

1. Хууль зүйн албаны аргачилсан удирдлагын байгууллага болох Шүүх яамны бүтэц, зохион байгуулалт цаг үеийн аяс, нийгмийн хөгжил даган тодорхой хэмжээгээр өөрчлөгдөж янз бүрийн нэр, үүрэг, бүтэцтэй ажиллаж ирлээ. Тухайлбал 1921 оноос Шүүх явдлын яам, 1958 оноос Сайд нарын Зөвлөлийн Хууль цаазны хороо, 1972 оноос Шүүх яам, 1989 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн АИХ-ын Тэргүүлэгчдийн 16 дугаар зарлигаар Шүүх яамыг татан буулгаж, мөн өдрийн 17 дугаар зарлигаар Хууль зүй, арбитрын яам байгуулсан. Тус яамыг 1990 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар татан буулгаж, Засгийн газрын мөн оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 42 дугаар тогтоолоор Хууль зүйн яамны цалингийн санг баталсан байна. Түүнчлэн Хууль зүйн яамны бүтцийг Засгийн газрын 1992 оны 12, 1994 оны 24, 1996 оны 182, 1997 оны 151, 2000 оны 21 дүгээр тогтоолоор тус тус өөрчлөн боловсронгуй болгож байсан. Харин Засгийн газрын 2000 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 131 дүгээр тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн яам болгон өөрчлөн зохион байгуулсан.

Түүнээс гадна 1993 онд баталсан "Засгийн газрын тухай" Монгол улсын хуулийн 20 дугаар зүйлд зааснаар Хууль зүйн яамны эрхлэн гүйцэтгэж байсан үндсэн үүрэг дээр улсын архив, шүүхийн шийдвэр биелүүлэх, гал түймэртэй тэмцэх асуудал, иргэний харьяалал, цагаачлалын асуудал, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон төрийн бус байгууллагын бүртгэл, төрөөс сүм хийдтэй харилцах асуудал, шүүхийн байгууллагын зохион байгуулалт, санхүү, материал техникийн хангамж, үйлчилгээ, Засгийн газраас шүүх, прокурорын байгууллагатай харилцах асуудал, цагдаа, мөрдөн байцаах, нийгмийн дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал зэргийг нэмж хариуцуулсан юм. 2000 оны 8 дугаар сарын 3-нд "Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Монгол Улсын хуульд зааснаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд дээрх үүргээс гадна улсын хил хамгаалалтын асуудлыг шинээр хариуцуулсан болно.

2. Хууль зүйн албаны орон нутгийн байгууллага ч тухайн цаг үеэ даган бүтэц, зохион байгуулалтын хувьд өөрчлөгдөж байсан юм. Тухайлбал Сайд нарын Зөвлөлийн 1989 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 52 дугаар тогтоолоор аймаг, хотод Хууль зүй, арбитрын хэлтэс байгуулж, Засгийн газрын 1992 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 24 дүгээр тогтоолоор аймгийн дээрх хэлтсийг Хууль зүйн хэлтэс, мөн өдрийн 25 дугаар тогтоолоор нийслэлийн дээрх хэлтсийг Засаг даргын дэргэдэх Хууль зүйн газар болгон өөрчилсөн билээ.

Харин Засгийн газрын 1993 оны 64, 65 дугаар тогтоолоор аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоохдоо аймгуудын Хууль зүйн хэлтэс, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хууль зүйн газрыг тус тус татан буулгаж, хууль зүйн албыг орон нутгийн байгууллагагүй болгосон байна. Хэдийгээр бүтцийг нь өөрчилсөн ч Хууль зүйн яам тус албаны үүргийг орон нутагт ямар албан тушаалтан хэрхэн гүйцэтгэх талаар тодорхой зөвлөмж боловсруулж 1996 онд аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсний гадна 1998 онд Хууль зүйн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын "Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга бөгөөд Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргад ажил хариуцуулах тухай" 262 дугаар тушаал, захирамжаар хууль зүйн албаны үүргийг гүйцэтгэх 3-4 төрийн албан хаагчийн орон тоон дээр мэргэжлийн хуульчид ажиллуулах чиглэл өгч байсан болно. Тэр ёсоор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хууль зүйн албаны ажлыг цаг үеийн шаардлагын дагуу тодорхой албан тушаалтанд хавсруулан гүйцэтгүүлсэн энэхүү арга хэмжээ нь дайвар үүргийн хэлбэрээр үйлчилж бүх нийтийн эрх зүйн ухамсрыг төлөвшүүлэх, иргэдэд эрх зүйн соёлыг эзэмшүүлэх, хууль тогтоомж тайлбарлан таниулах, сургалт сурталчилгаа зохион байгуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилтыг хангахад бодит үр дүнгээ өгөхгүй байгаа нь орон нутгийн ажлыг шалгаж зааварлах явцад тодорхой ажиглагдаж байлаа.

Иймээс Хууль зүй, дотоод хэргийн яамны орон нутгийн байгууллага болох аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийг байгуулах асуудал нь нийгэм, улс төр, эрх зүйн шинэчлэл, хууль хэрэгжүүлэхтэй холбоотой, зохион байгуулалтын шинжтэй, зайлшгүй авах ёстой арга хэмжээ байсныг үндэслэн Засгийн газарт 2000 оны 10 дугаар сард энэ талаар асуудал боловсруулж оруулсан юм.

Засгийн газрын 2000 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 181 дүгээр тогтоолоор аймгийн Засаг даргын Тамгын газарт, 11 дүгээр сарын 29-ний өдрийн 185 дугаар тогтоолоор нийслэлийн Засаг даргын Тамгын газарт Хууль зүйн хэлтсийг тус тус байгуулсан бөгөөд аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар дээрх тогтоолуудыг үндэслэн Хууль зүйн хэлтэс байгуулах, боловсон хүчнээр бэхжүүлэх асуудлыг богино хугацаанд шуурхай шийдвэрлэсэн. Ер нь аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга, мэргэжилтнээр гол төлөв өмнө нь хуулийн хэлтэст ажиллаж байгаагүй хүмүүс шинээр томилогдсон учраас ажлыг нь зөв эхлүүлэх, цаашид улам жигдрүүлэх, үр дүнг нь дээшлүүлэх асуудалд яамны зүгээс багагүй анхаарал төвлөрүүлж семинар, сургалт зохион байгуулах, гарын авлагаар хангах, ажлыг нь шалгаж заавар, зөвлөгөө өгөх зэргээр ажилласан байна.

3. Хууль зүй, дотоод хэргийн яам гэсэн одоогийн энэ бүтэц нь хууль зүйн албыг бэхжүүлэх, эрх зүйн шинэтгэлийг эрчимжүүлэх, дотоодын дэг журмыг сайжруулах нэгдсэн зохион байгуулалтаар Засгийн газрын түвшинд ажиллах боломжийг бүрдүүлж байна.

БНМАУ-ын Ардын Их Хурал улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгосон Монгол Улсын дөрөв дэх Үндсэн хуулийг баталж 1992 оны хоёрдугаар сарын 12-ны өдрөөс дагаж мөрдүүлсэн билээ.

Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн агуулга, зарчим, эдийн засаг, нийгмийн харилцааны шинэчлэл, өөрчлөлтийн бодлогод нийцүүлэн хууль зүйн албаны байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж, "Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"-ийн дагуу хууль боловсруулах, боловсронгуй болгоход үндсэн ажлаа чиглүүлж ирлээ. Иймхүү Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн 10 жилийн хугацаанд хууль боловсруулах ажилд түлхүү анхаарч ажилласнаар Улсын Их Хурал 2000 оныг дуусталхи хугацаанд 885 хууль батлан гаргасан бөгөөд үүний 259 нь бие даасан хууль, 417 нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль, 123 нь олон улсын гэрээ соёрхон батлсан хууль, 86 нь хууль хүчингүй болгосон эрх зүйн акт байлаа.

Монгол Улсад эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйлсэд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг, Ханнс-Зайделийн сан, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг зэрэг олон улсын хамтын ажиллагааны байгууллагууд тодорхой тусламж, дэмжлэг үзүүлж ирснийг тэмдэглэхэд таатай байна. Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг нь Монгол Улсын иргэний эрх зүйн салбарт, Ханнс-Зайделийн сан нь нийтийн болон эрүүгийн эрх зүйн салбарт дэмжлэг туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх хэлбэрээр төсөл хэрэгжүүлж байна. Эдгээр байгууллагын идэвхтэй оролцоотойгоор эх газрын эрх зүйн тогтолцоотой харьцуулан судалж, мэргэжлийн зөвлөгөө өгч боловсруулсан Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан хэлэлцэх хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль, Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслүүдийг УИХ-ын 2001 оны намрын чуулганаар хэлэлцэж эхэлсэн билээ.

4. Хуулийн сургалт, сурталчилгааг төв, орон нутагт зохиож ирсэн өмнөх туршлагадаа түшиглэн хууль тогтоомжийн сурталчилгааг гол төлөв радио, телевиз, сонин зэрэг иргэдэд хүртээмжтэй сувгуудыг ашиглан явуулж ирсэн байна.

Хууль зүйн албаны байгууллагууд сүүлийн жилүүдэд хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, тайлбарлан таниулах ажлын тодорхой сүлжээ бий болгох, сурталчилгааг энгийн, ойлгомжтой, сонирхолтой, хүртээмжтэй арга хэлбэрээр зохион байгуулах зорилт тавьж иргэд, түүний дотор оюутан, залуучуудын эрх зүйн мэдлэг, идэвхийг дээшлүүлэхэд түлхүү анхаарч ажиллав. Энэ ажлын хүрээнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Албан бус сургалтын талаар авах арга хэмжээний төлөвлөгөө, хэвлэлээр сурталчлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус тус боловсруулан хэрэгжүүлж ажилласан нь хөдөлмөрчдийн таашаал хүлээж байсан болно. Жишээ нь: Монголын радиогийн "Хууль таны амьдралд", "Соёмбо", FM-107-гийн "Шинэ товчоо" зэрэг радиогийн хууль зүйн тайлбарт нэвтрүүлэг, Монголын үндэсний телевизийн "Хуулийн цаг", "Дэвжээ", MN-25-ын "Дэнс" зэрэг телевизийн зохиомжит нэвтрүүлгийг долоо хоногийн тодорхой өдөр, цагуудад явуулж иргэд түүнийг тогтмол сонсч, үзэж хэвшээд байна.

Монголын үндэсний телевиз, радиогоор хууль тогтоомжийг сурталчлахын зэрэгцээ оюутан, залуучуудын илүүтэйгээр сонирхон сонсдог FM радиогоор хууль тогтоомжийг сурталчлах ажлыг тус яам, Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран зохион байгуулж, Гэр бүлийн тухай шинэ хуулиас сэдэвлэсэн радио зохиомжоор бэлтгэсэн цуврал зохиомжийг FM-107 радиогоор сар бүр нэвтрүүлж байна.

"Зууны мэдээ" сонинтой гэрээ байгуулан сар бүр нүүр бэлтгэн яам, агентлагуудын үйл ажиллагааг сурталчлах, хууль тогтоомжийн тодорхой зүйл, заалтыг тайлбарлах зэрэг асуудлыг тусган гаргаж байна.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй хамтран "Архидан согтуурахтай тэмцэх тухай", "Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай", Сонгуулийн ерөнхий хороо, Хуульчдыг давтан сургах төвтэй хамтран "Улсын Их Хурлын сонгуулийн тухай", Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтран "Тэтгэврийн шинэчлэл шинэ зуунд" зэрэг сэдвээр төрөлжсөн сургалт зохион байгуулж төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах арга барилаа улам боловсронгуй болгож ирсэн.

5. Тус яам Төрийн бус багууллагын тухай, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай, Дундын өмчлөлийн орон сууцны тухай, Өмгөөллийн тухай хууль, Засгийн газрын зохих шийдвэрийн дагуу төрийн бус болон шашны байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хууль зүйн товчоо, үйлдвэрчний эвлэл, сууц өмчлөгчдийн холбооны улсын бүртгэлийн ажлыг эрхэлж ирэв. 2000 оны байдлаар төрийн бус байгууллага 2302, үйлдвэрчний эвлэлийн байгууллага 1410, шашны байгууллага 202, хууль зүйн товчоо 54, сууц өмчлөгчдийн холбоо 481, сонин 1077, сэтгүүл 229, студи 118-ыг тус тус бүртгэжээ.

6. Хүний эрхийг хангах эрх зүйн үйлчилгээг иргэдэд ойртуулах шаардлагын үүднээс нэлээд арга хэмжээ авсан байна. Тухайлбал 1994 онд Өмгөөллийн тухай, 1997 онд Нотариатын тухай хуулийг тус тус УИХ-аар батлан гаргаж иргэд,

байгууллагад үзүүлэх эрх зүйн үйлчилгээг хуулиар баталгаажуулсан билээ. Эдгээр хуулийн хүрээнд өмгөөлөл, төлөөлөлд оролцох, зөвлөгөө өгөх, нотариатын төрөл бүрийн үйлдлээр бичиг баримт гэрчлэх зэргээр иргэд, байгууллагад үзүүлэх эрх зүйн үйлчилгээ сүүлийн жилүүдэд улам өсөн нэмэгдэж байна. Энэ үйлчилгээний чанар, соёлч байдлыг дээшлүүлэх, хөдөлмөрчдийг чирэгдэлгүй хөнгөн шуурхай үйлчлэх талаар өмгөөлөх, нотариатын байгууллагууд нэлээд анхаарал хандуулж ирсэн болно.

7. Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн төслийг хэлэлцүүлж батлуулснаар Хүний эрхийн асуудлыг үндэсний хэмжээнд хариуцан зохион байгуулах байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндэс бүрдэж, улмаар Монгол Улсын хүний эрхийн үндэсний комисс байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна. Түүнээс гадна "Монголд хүний эрхийг хангах төсөл"-ийн шугамаар "Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр" боловсруулах бэлтгэл ажил хийгдсэн. Энэ бүхний үр дүнд Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн: "Хүний эрхийн үндэсний байгууллага бий болгож, хүний эрхийн чиглэлээр нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид Монгол Улсын хууль тогтоомжийг нийцүүлэх арга хэмжээ авна" гэсэн зорилт хэрэгжиж байна.

II. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар

Сүүлийн 10-аад жилд шүүх эрх мэдлийг төлөвшүүлэх, хүний эрхийг хангах, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, хуульчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр НҮБ болон бусад олон улсын байгууллагын шугамаар томоохон төслүүдийг хэрэгжүүлж байна.

1. Монгол Улсад шүүх эрх мэдлийг төлөвшүүлэх нь Хууль зүйн яамны чухал зорилт байсан юм. 1972 онд Шүүх яамыг шинэчлэн байгуулахдаа шүүхийн зохион байгуулалтыг тус яаманд хариуцуулахаар бүтцийг нь баталсан боловч хэрэгжихгүй 20-иод жилийн нүүр үзжээ. Ардчилсан шинэ Үндсэн хуулиар шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах чиг үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөлд хариуцуулсан юм.

Шүүхийн тухай хуулийн дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийг 1996 оны 10 дугаар сараас Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн толгойлж, ажлын алба нь Хууль зүйн сайдын дэргэд ажиллах болсон. Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүхийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг сонгон шалгаруулах, эрх ашгийг нь хамгаалах, шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангах үүргийг хэрэгжүүлж ирсэн. Энэ хугацаанд Шүүхийн ерөнхий зөвлөл хот, хөдөөгийн шүүхийн байгууллагыг мэдлэг чадвартай, дадлага туршлагатай хуульчдаар бэхжүүлэхэд нэлээд анхаарч ажилласан болно. Ер нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн хүчин чармайлтын үр дүнд Монгол Улсын шүүхийн боловсон хүчний мэргэжил дээшлүүлэх, шүүгчдийн давтан сургах төвтэй болж, төвлөрсөн суурин газруудын шүүхүүд орчин үеийн техник хэрэгслээр хангагдан мэдээллийн автомат сүлжээг ашиглаж, шүүхийн ажлын нөхцөл шинэ түвшинд гарч, шүүхийн автомашины парк шинэчлэгдэж чадлаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргаар Хууль зүй, дотоод хэргийн сайд байх нь зөв, буруу гэж маргадаг, зарим нь энэ асуудлыг улс төржүүлэх хандлага ажиглагддаг юм. УИХ-аас 2002 онд шинэчлэн баталсан Шүүхийн тухай хуулийн 61.4 дэх хэсэгт "Ерөнхий зөвлөлийн дарга нь Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч байна" гэж зааснаар тухайн асуудал эцэслэн шийдвэрлэгдсэн. Гадаадын эрдэмтэн хуульчид ч ийм санал бодолтой байдаг юм билээ. Жишээ нь: АНУ-ын Техас мужийн Уислэн их сургуулийн Хуулийн дээд сургуулийн профессор Жо Спурлок "Хууль зүйн мэдээ" сонин (2006 оны №20)-д өгсөн ярилцлагадаа: "Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын албыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тусгаарлаж гүйцэтгэх засаглалын хүрээнээс гаргасан нь чухал алхам болсон... Шүүхийн тогтолцоог зөв голдрилд нь оруулахад асуудлын гол нь байгаа юм. Одоо Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга чинь Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч болсон шүү дээ. Ингэснээрээ шүүхийн төлөө ажиллах ёстой байгууллага зохих газраа ирж байгаа юм" гэсэн байна.

УИХ 2000 оны 5 дугаар сард шүүхийн байгууллагын хэтийн болон ойрын ирээдүйн зорилго, зорилтыг иж бүрнээр тодорхойлсон стратегийн баримт бичиг болох "Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө"-г баталсан. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газарт туслах зорилгоор АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагаас "Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр"-ийг санхүүжүүлж байгаа бөгөөд төслийг АНУ-ын Муж улсуудын шүүхийн үндэсний төв хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд шүүхийн болон шүүн таслах ажиллагааны менежментийг боловсронгуй болгох, мэргэшил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах, хуульчдыг сонгон шалгаруулах тогтолцоо бий болгоход туслах, хуульчдын ёс зүй, сахилга хариуцлагыг тооцох механизм бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, эрх мэдлийн харьяалал, үүрэг хариуцлагыг тодорхойлох талаар зөвлөмж гаргах зэргээр Монгол Улсын холбогдох байгууллагуудтай зөвшилцөж ажиллаж байна.

2. Цагдаагийн байгууллага 1996 оноос Монгол Улсын Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын тохируулагч агентлаг болж 1993 онд батлагдсан Цагдаагийн байгууллагын тухай хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Цагдаагийн байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн удирдан зохион байгуулах; гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах,

урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх; иргэдийн амар амгалан байдлыг хангаж тэдэнд цагдаагийн үйлчилгээг шуурхай хүргэх; алба хаагчийн сахилга хариуцлага, мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвар, харилцааны соёлыг сайжруулж ёс зүйг төлөвшүүлэх талаар багагүй анхаарч ажилласан.

Цаашид цагдаагийн байгууллага гэмт хэргийг халуун мөрөөр нь шуурхай илрүүлэх, албадын ажлын уялдааг сайжруулах, мэргэжлийн удирдлагаар хангах, албаны шуурхай бэлэн байдлыг дээшлүүлэх, машин техник, харилцаа холбооны хүч чадлыг нэмэгдүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлэх шаардлагатай байна.

3. Цагдаагийн ерөнхий газрын харьяанд байсан Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв 1996 оноос Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болон өргөжиж Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа төвлөрүүлэх арга хэмжээ авсан нь иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдалд дэвшил гарч иргэдэд үзүүлэх үйлчилгээ улам өргөжлөө.

Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв нь Монгол Улсын иргэний паспортыг иргэний үнэмлэхээр солих, үндэсний иргэний гадаад паспорт болон иргэний бүх төрлийн гэрчилгээ олгох, иргэний гэр бүлийн байдал, шилжих хөдөлгөөн, хүн амын автоматжуулсан төв регистрийг эрхлэн хөтлөх, өөрт байгаа мэдээллийн сан, архиваас байгууллага, иргэдэд лавлагаа, магадлагаа өгөх ажлыг улсын хэмжээнд удирдах зохицуулж ирсэн.

4. Гадаад харилцаа өргөжихийн хэрээр гаднаас ирэгсдийн тоо эрс өсч, тэд хууль тогтоомж зөрчих явдал газар авсан, манай улсын харьяат болох, харьяатаас гарах, цагаачлах явдал ихэссэн тул гадаадын иргэдийн нэгдсэн бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоо бий болгох асуудлыг боловсруулан 2000 онд "Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай", "Харьяатын тухай", "Иргэний бүртгэлийн тухай" хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг УИХ-аар шийдвэрлүүлж, Засгийн газрын 2001 оны 71 дүгээр тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд "Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба"-ыг шинээр байгуулж дүрмийг нь батлуулж мөрдүүлэв.

Энэ албыг бий болгох асуудлыг улсын төсөвт ямар нэг хүндрэл учруулалгүй шийдвэрлэсэн бөгөөд харин ч уг алба байгуулагдсанаасаа хойш багагүй мөнгийг улсын төсөвт оруулж ирлээ. Дээрх арга хэмжээ нь олон улсын жишигт нийцсэн гадаадынхны талархлыг хүлээсэн ажил болж, манай улсын нутаг дэвсгэр дээр ямар ч хяналтгүй явдаг байсан гадаадынхны хөдөлгөөнийг тодорхой дэгт оруулах нөхцөлийг бүрдүүлсэн.

5. Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагыг шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага болгон өөрчлөн зохион байгуулж, 1996 онд "Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай" хуулийг батлуулж зохион байгуулалт, эрх зүйн үндсийг бий болгосон бөгөөд одоо үүнийг улам төгөлдөржүүлэх асуудалд анхаарлаа төвлөрүүлэн ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хорих ангийн ахуй нөхцөл, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх; хорих ангид ялтны эрхийг хангах; эрүүл мэндийг хамгаалах, өвчлөл, ялангуяа сүрьеэ өвчнийг багасгах; нас барах, оргох явдлыг бууруулах; тэдний жингийн алдагдал, тураал гаргахгүй байх; шүүхийн шийдвэрийн бодит биелэлтийн хувь, хэмжээг нэмэгдүүлэх; шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн үндэслэл, зохицуулалтыг шинэчлэн боловсронгуй болгох зорилтуудыг дэвшүүлэн түүнийг биелүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлж ирлээ.

6. 2000 оны 8 дугаар сард Засгийн газрын тухай хуулиар улсын хил хамгаалалтыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд оруулсан нь нийгмийн дэг журмыг бэхжүүлэх ажлыг сайжруулах, тэр тутмаа хил хамгаалалтыг чангатгах, Монгол Улсын Үндсэн хуульд заасан хилийн халдашгүй дархан байдлыг хангахад чухал алхам болсон юм. Хил хамгаалах байгууллага нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд улсын хил хамгаалалтыг боловсронгуй болгох, хилийн цэргийн бие даасан тогтолцоог бүрдүүлэх, холбоо, техник хангамж, уналгыг үе шаттайгаар сайжруулах, улсын хил хамгаалалтад орон нутгийн байгууллага, иргэдийг өргөнөөр татан оролцуулах, офицер, ахлагч нарын ахуй хангамж, нийгмийн баталгааг сайжруулах зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

7. НАХЯ-ны бүрэлдэхүүнд байсан Улсын архивын албыг хүн амд ил тод нээлттэй, ойр дөт байлгах зорилгоор Үндэсний архивын газар болгон өөрчлөн зохион байгуулж, 1996 оноос Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн эрх хэмжээтэйгээр ажиллуулж, улмаар ажлын шинэ байртай болголоо. 1998 онд Архивын тухай хуулийг УИХ-аар батлуулснаар тухайн байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүллээ.

Үндэсний төв архивын сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлт, агуулга баяжиж чанар, тоо хэмжээний хувьд жил бүр өргөжиж байна. Төрийн архивын сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлтэд түүх-эрдэм шинжилгээний ач холбогдолтой, хосгүй үнэт болон үнэт баримт материалыг олж илрүүлэх талаар ахиц гарсан нь сан хөмрөгийн баримтын агуулга, ач холбогдлыг улам өргөж өгсөн. 2000 оноос хойш Үндэсний төв архивын сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлт бараг цоо шинээр хийгдсэн чухал ач холбогдолтой ажил болж, архивын баримтын хадгалалтын хуулбар хувийг орчин үеийн техник хэрэгсэл ашиглан үйлдэж байна.

8. Хуулийн байгууллагад ажиллагсдын болон чөлөөнд гарсан ахмадуудын нийгмийн асуудал манай төр, засгийн анхаарлын төвд ямагт байсан, одоо ч байсаар байна. Үүний нэг тод илрэл нь

Засгийн газрын 2000 оны 13 дугаар тогтоолоор Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий газрын эмнэлгийг Хууль зүйн яамны харьяа Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг болгон өөрчлөн зохион байгуулсан явдал юм.

9. Үндсэн хуульд заасан иргэдийн хувийн өмчийн эрхийг баталгаажуулах зорилгоор үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тогтолцоог Монгол Улсад анх удаа бий болголоо. 1997 онд Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль батлагдсанаар тус улсын нутаг дэвсгэрт байгаа төрийн болон орон нутгийн нийтийн зориулалттай өмчид хамаарахаас бусад үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэх, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг баталгаажуулахтай холбогдсон харилцааг зохицуулах үүрэг бүхий үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллагын зохион байгуулалт, эрх зүйн үндэс бий болсон юм.

Засгийн газрын 1997 онд гаргасан шийдвэрийн дагуу Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар, орон нутаг дахь товчоод зохион байгуулагдаж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар үйл ажиллагаагаа явуулж эхэлснээр манай оронд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөлийг баталгаажуулах явдал бодит биелэлээ оллоо.

Уг байгууллага "Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Газрын харилцаа, геодези, зураг зүйн газарт харьяалагдаж байгаад Засгийн газрын 2006 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 201 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар болж өөрчлөгдсөн.

10. 1999 онд Галын аюулгүй байдлын хууль батлагдсанаар Гал түймэртэй тэмцэх байгууллагыг харьяаллын хувьд Цагдаагийн ерөнхий газрын үндсэн бүтцээс гарган Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээн дэх Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болгон зохион байгуулж хот суурин болон ой, хээрийн гал түймрийг унтраах, хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулах чиг үүрэгтэйгээр ажиллуулсан.

Тус газрын харьяаллыг Улсын Их Хурлын 2003 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 32 дугаар тогтоолоор өөрчилж Засгийн газрын тохируулагч агентлаг-Гамшгаас хамгаалах ерөнхий газар (одоо Онцгой байдлын ерөнхий газар)-т нэгтгэсэн.

11. Монгол Улс ардчилал, зах зээлийн харилцаанд шилжиж эхэлснээр оюуны өмчийг хувийн өмч гэдгийг хүлээн зөвшөөрч, энэ үндсэн дээр оюуны өмчийн эрхийн хамгаалалтын шинэ системийг бүрэлдүүлэн тогтоох зорилгоор Засгийн газрын шийдвэрээр Зохиогчийн эрхийн газар, Патентийн газруудыг нэгтгэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Оюуны өмчийн газрыг шинээр зохион байгуулсан билээ.

Одоо тус газар Улсын Их Хурлын 2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай" 14 дүгээр тогтоолын дагуу Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжсэн.

Тав. Хууль зүйн алба – XXI зууны эхлэлт

Хууль зүйн албаны эрхлэх асуудлын хүрээ жил ирэх тутам өргөжин тэлж, нийгмийн цаг үеийн шаардлага, хөгжлийн хэтийн төлөв нь соёлт ертөнцөд нэгэнт бий болсон жам ёсны тэр хэмжээнд улам ойртох зорилготойгоор XXI зуунтай золголоо. Хууль зүйн албаны байгууллага шинэ зууны эхний жилүүдэд дараахь үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд анхаарлаа төвлөрүүлэн ажиллаж байна.

Нэгдүгээр үндсэн зорилт бол хууль зүйн албаны үйл ажиллагааг сайжруулах, улам боловсронгуй болгох, ур нөлөөг нь дээшлүүлэх явдал юм.

Энэ зорилтын хүрээнд эхний ээлжинд хууль тогтоомжийг боловсронгуй болгоход анхаарч бизнесийн таатай орчин бүрдүүлэх, эдийн засаг, аж ахуй эрхлэгчдийг дэмжих, хүний эрхийг хангах төрийн байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг төгөлдөржүүлэх, шүүх эрх мэдлийн шинэтгэл болон төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хянах, түүнд гомдол гаргах чиглэлээр Монгол Улсын хууль тогтоомжийг шинэчлэх, боловсронгуй болгох, шинээр боловсруулах ажлыг шинэ зууны эхний 5 жилд хийж гүйцэтгэлээ.

1. Иргэн, эдийн засаг, аж ахуй эрхлэгчдийг дэмжих чиглэлээр олон хууль тогтоомжийг шинэчлэх, боловсронгуй болгох арга хэмжээ авлаа. Тухайлбал, шинэчлэн батлагдсан Иргэний хуулиар өмчлөх эрх олж авах аргуудыг шинээр зохицуулж, өмчлөгчийн эрхийн хамгаалалтын баталгааг сайжруулж, түүнийг зөвхөн хуульд заасан үндэслэлээр хязгаарлах зарчмыг тогтоож, өмчлөгчийн хувьд төр, иргэн, хуулийн этгээд эрх тэгш байх үндсийг боловсронгуй болгож, төр нь эдийн засаг болон иргэний эрх зүйн харилцаанд давуу эрхтэй байсныг өөрчилж, эдийн засгийн үндэс нь болдог гэрээний харилцаанд төрийн зохицуулалт, гэрээний эрх чөлөөний зарчмыг оновчтой хослуулж чадсан юм. Иргэний хуулийг хэрэглэж эхэлсэнтэй холбоотойгоор түүнд тусгагдсан шинэ зохицуулалт, зарчмын хэрэгжилтийг хангах зорилгоор эдийн засаг, аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой 30 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Шинэчлэн батлагдсан Иргэний хуулийн зарчимтай уялдуулах зорилгоор Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийг боловсруулан батлуулсан. Энэ хууль батлагдсаны дүнд иргэд өөрийн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг бүртгүүлэх, түүнтэй холбоотой бусад эрхийн бүртгэл болох үл хөдлөх эд хөрөнгөө барьцаалах, түрээслэх, бусдын газар дээр барилга байгууламж барих эрхийн болон өмчлөх эрхийн шилжилт, хөдөлгөөн зэрэг бүртгэлийг олон байгууллагын хаалгыг татаж, олон шат дамжлагыг дамжиж, цаг хугацаа алддаг байсныг өөрчлөн

эдгээр бүртгэлийг нэг байгууллагаар хийлгэх болсон.

Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжих, тэдэнд төрөөс өгдөг зөвшөөрлийн шат дамжлага, давхардлыг багасгах, уг зөвшөөрлийн тоог үе шаттайгаар цөөрүүлэх зорилгоор Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг анх удаа боловсруулан батлуулсан. Энэ хууль батлагдсаны үр дүнд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох асуудлыг олон төрлийн хууль тогтоомж болон журам, дүрмээр зохицуулж байсныг цэгцэлсэн. Уг хуулийн дагуу аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид давхардсан тоогоор 650 орчим тусгай зөвшөөрөл олгодог байсныг цөөрүүлж 83 болгосон. Энэ хуультай уялдуулан 33 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Хуулийн этгээд байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүнийг үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт орсныг улсын бүртгэлд бүртгэх, хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг шинээр боловсруулан батлуулсан.

Аливаа иргэн, хуулийн этгээд, гадаадын иргэн иргэний эрх зүйн шинжтэй маргаанаа шүүхийн олон шат дамжлагыг дамжихгүй, цаг хугацаа, зардал мөнгөө хэмнэх сонирхолтой байдаг тул шүүхийн бус журмаар шийдвэрлүүлэхээр түр арбитр байгуулах, эсхүл байнгын арбитраар шийдвэрлүүлж болох шинэ зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн зохицуулсан Арбитрын тухай хуулийг боловсруулж батлуулсан юм.

Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийг шинэчлэн боловсруулж батлуулсан. Уг хуулиар үйлдвэрлэгч болон үйлчилгээ эрхлэгчид хамтран барааны тэмдгийн мэдүүлэг гаргах, түүнийг бүртгэх, гэрчилгээ олгох шинэ зохицуулалтыг тодорхойлсон.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай, Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийг дагалдаж гарах 16 хуулийн хамт батлууллаа.

Мөн түүнчлэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Автозамын тухай, Харилцаа холбооны тухай, Газрын тухай зэрэг 30 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлуулан мөрдүүлсэн болно.

2. Хүний эрхийг хангах, хууль сахиулах байгууллагын зохион байгуулалт, шүүх эрх мэдлийн байгууллагын шинэтгэлийн чиглэлээр нэлээд хууль боловсруулаа.

Хүний эрхийг хангахад чиглэсэн бие даасан үйл ажиллагаа явуулдаг Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хууль баталсан нь хүний эрхийг хангах талаар хийсэн томоохон шинэтгэлийн нэг юм. Уг хуулийн дагуу Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөг нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн зөрчсөн гэж үзвэл Монгол Улсын иргэн дангаар буюу хамтарч энэ хуульд заасны дагуу Комисст гомдол гаргах эрхтэй болсон. Түүнчлэн хүний эрхийн орон нутгийн болон үндэсний хэмжээний байгууллагуудыг төлөвшүүлэн бэхжүүлэх, хүний эрхийг хангах шат дараатай, цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор Хүний эрхийн үндэсний хөтөлбөрийг УИХ-ын тогтоолоор 2003 онд батлуулсан.

Нийгмийн хэв журам хамгаалах, түүнийг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг цагдаагийн байгууллагын хяналтад авч, эмнэлгийн үйлчилгээ үзүүлж, албадан эрүүлжүүлэхтэй холбогдсон харилцааг өмнө нь журмаар зохицуулж байсныг хүний эрхийг хангах, олон улсын хүний эрхийн конвенцүүдтэй нийцүүлэн Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийг батлуулсан.

Хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангах, төрөөс иргэдийн өмнө хүлээх хариуцлагыг өндөржүүлэх хууль зүйн нэг чухал баталгаа болдог хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын зөв тогтолцоог бий болгох, хууль сахиулах байгууллага, шүүх эрх мэдлийг зөв төлөвшүүлэхэд чиглэсэн багц арга хэмжээг хэрэгжүүлж ирлээ. Тухайлбал, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын зохион байгуулалтыг боловсронгуй болгох, чирэгдэл, дамжлага багатай бүтэц бий болгох, тэдний нийгмийн баталгааг хангахтай холбогдуулан Шүүхийн тухай, Прокурорын байгууллагын тухай, Өмгөөллийн тухай хуулиудыг шинэчлэн боловсруулж, Цагдаагийн байгууллагын тухай, Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулав.

1960 оны Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу хуучин үзэл суртал, зарчмын хүрээнд өмнөх нийгмийн харилцааг гэмт халдлагаас хамгаалахад чиглэгдэж 1986 онд баталсан Эрүүгийн хуулийг шинэчлэн боловсруулж батлуулсан. Уг хуулиар 1992 онд баталсан Үндсэн хуульд тусгагдсан шинэ зарчим, манай улсын нийгэм, эдийн засгийн шинэлэг нөхцөл байдалтай холбоотойгоор гэмт хэргийн нөхцөл байдал, шинж чанарын өөрчлөлтийг харгалзан эрүүгийн эрх зүйн бодлогыг шинээр тодорхойлсон. Шинэчлэн баталсан Эрүүгийн хуулийн зохицуулалтаар дамжуулан хүний эрхийг баталгаатай хамгаалах, нэгэнт гэмт халдлагад өртсөн хохирогчийн хөндөгдсөн эрхийг сэргээх буюу түүнд учирсан хохирлыг арилгах боломжийг бүрдүүлж чадсан. Түүнчлэн гэмт хэрэгт ногдуулах ялын төрлийг олон сонголттой байхаар өөрчилж баривчлах, албадан ажил хийлгэх ял шинээр бий болгон, торгох ялыг инфляцийн нөлөөнд автахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй харьцуулан тогтоохоор хуульчилсан.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хувьд албадан саатуулах, цагдан хорих зөвшөөрлийг прокурор өгдөг байсныг олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд заасан гол зарчмыг үндэслэн шүүгч өгдөг байхаар өөрчилсний дээр хорьж мөрдөх хугацааг богиносгосон. Түүнчлэн сэжигтнийг баривчлах үндэслэл, журмыг тодорхой болгож, сэжигтнээр хавтгайруулан тооцож, баривчилж байсан хуучин практикийг таслан зогсоож хөнгөн, хүндэвтэр хэрэгт явуулах байцаан

шийтгэх ажиллагааг хэрэг бүртгэлт, харин хүнд, онц хүнд хэрэгт явуулах ажиллагааг мөрдөн байцаалт гэсэн ойлголтод шинээр хамааруулан тусгасан төдийгүй яллах, өмгөөлөх, шүүн таслах чиг үүрэг нь тус тусдаа байх зохицуулалтыг шинэчлэж оруулсан.

Иргэн, хуулийн этгээд шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын талаар хаана гомдол гаргаж болох, ямар байгууллага ийм үйл ажиллагаа эрхлэхийг зохицуулаагүйгээс шалтгаалан 1990 онд батална Иргэн, хуулийн этгээд шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах журмын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байсан. Энэ зохицуулалтыг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлоо нөхөн төлүүлэх, сэтгэл санааны үр дагаврааарилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших хийгээд бусад эрхээ нөхөн сэргээлгэхээр шүүхэд гомдол гаргаж болох талаар тусгасан. Түүнчлэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч хуульд захирагдаж ажиллах, хуулийг гажуудуулахгүй байх заалт оруулж, хэрэв уг заалтыг зөрчвөл тэдгээрт хариуцлага тооцохоор хуульчилсан. Үүнтэй нийцүүлэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор гэмт хэрэгт холбогдсон бол түүнд мөрдөн байцаалт явуулах үүрэгтэй мөрдөн байцаах албыг прокурорын байгууллагын дэргэд байгуулсан.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль шинэчлэн батлагдсаны үр дүнд уг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэтгэлзэх зарчмыг бүх шатанд жигд баримталж, энэ ажиллагааны явцад хүний эрхийг дээдлэн хангаж, аливаа чирэгдэл, хүнд суртлыг арилган, шүүхийн ачаллыг оновчтой хуваарилж, шат шатны шүүхийн эрх, үүргүүдийг нарийсгах, иргэний шүүхэд гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг давж заалдах, хянуулах эрхийг өргөтгөсөн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэр гүйцэтгэлийн салбарын шинэчлэлийг гүнзгийрүүлэх, зах зээл хөгжсөн орны жишигт ойртуулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд аль болох өөрийгөө санхүүжүүлэх зарчмыг тогтоох, төрийн албан хаагч - шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны хариуцлага, сахилгыг дээшлүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ авснаар шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа шуурхай, үр ашигтай, зардлаа нөхөх боломжтой болж, шүүхийн шийдвэрийн биелэлтийг бодитой дээшлүүлж, хүний зөрчигдсөн эрхийг бүрэн утгаар сэргээх, өр, авлагыг барагдуулах системийг бий болгох зэрэг зарчмуудыг тогтоож чадсан гэж үзэж байна. Энэ хуулийн хэрэгжилтийн хүрээнд Засгийн газрын 2 тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар 20 гаруй дүрэм, журам батлагдан мөрдөгдөж байна.

Мөн Хувийн хамгаалалтын тухай хуулийн төслийг боловсруулж батлуулсан бөгөөд энэ хууль батлагдсанаар хувь хүн өөрийн амь бие, эрүүл мэндээ хувийн хамгаалалтын байгууллагаар хамгаалуулах үйл ажиллагааны эрх зүйн үндэс, уг байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих боломж тус тус бүрдсэн юм.

3. Төрийн байгууллагын хүнд суртлыг арилгах, төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хянах, түүнд гомдол гаргах чиглэлээр зарим хуулийг шинээр болон шинэчлэн боловсруулж батлуулсан.

Төрийн байгууллага, албан тушаалтан хууль тогтоомжоор тогтоосон өөрийн шийдвэрлэх асуудлын хүрээг нийтэд хандаж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлах, улмаар иргэд амаар гаргах өргөдөл, гомдлоо радио, телевизээр явуулж буй шууд нэвтрүүлгээр болон утсаар төрийн байгууллага, албан тушаалтанд гаргаж болохоор Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргах өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж батлуулаа.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг шинээр боловсруулж батлуулсан. Энэ хуулийн үндсэн зорилго нь засаг захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус ажиллагаа, дур зоргоор аашлах явдлаас хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг нь сэргээн тогтоох, эрх зүйн шударга дэг журмыг дэмжихэд оршино. Эл зорилгыг хэрэгжүүлснээр шүүхийн ардчилсан шинэтгэлийн томоохон алхам болох юм. Түүнчлэн төрийн ба нутгийн засаг захиргааны үйл ажиллагааг хууль ёсны, үр нөлөөтэй байлгахад таатай нөлөө үзүүлэх, удирдлагын зөв тогтолцооны эрх зүйн зохистой нөхцөл бүрдүүлэхэд энэ хууль ихээхэн үүрэг гүйцэтгэх болно.

4. Эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааны чиглэлээр нэлээд шинэлэг ажил хийж байна. Тухайлбал:

1/ Хууль зүй, дотоод хэргийн яам, Дэлхийн банкнаас хэрэгжүүлж байгаа "Шүүх, эрх зүйн шинэчлэлт" төслийн шугамаар "Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сүлжээ" байгуулсан. Нэгдсэн сүлжээний хүрээнд Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, Шүүхийн мэдээллийн нэгдсэн системийн программ хангамж, вэб сайтыг боловсруулаа. Энэхүү нэгдсэн сүлжээний зорилго нь байгууллага, иргэдэд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн актын талаархи мэдээллийг хайх, хүлээн авах, түгээх боломжийг хангах, шүүхийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд таниулах явдал юм.

Эрх зүйн мэдээллийн санд дараахь эрх зүйн актууд орсон. Үүнд:

- Монгол Улсын хууль;
- Улсын Их Хурлын тогтоол;
- Монгол Улсын олон улсын гэрээ;
- Ерөнхийлөгчийн зарлиг;
- Үндсэн хуулийн цэцийн шийдвэр;
- Улсын дээд шүүхийн тогтоол;
- Засгийн газрын тогтоол;
- Сайдын тушаал;
- Засгийн газрын агентлагийн даргын шийдвэр;

- УИХ-аас томилогддог байгууллагуудын дарга, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр;
- Аймаг, нийслэлийн ИТХ-ын шийдвэр;
- Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж.

Шүүхийн мэдээллийн санд дараахь мэдээллүүд орсон. Үүнд:
- Улсын дээд шүүхийн тайлбар;
- Шүүхийн тогтолцоо;
- Шүүхийн ерөнхий зөвлөл;
- Шүүхийн статистик мэдээ;
- Хэргийн бүртгэл;
- Шүүхийн судалгааны төв;
- Шүүхийн менежмент;
- Шүүхийн танилцуулга.

Эрх зүйн мэдээллийн системд шилэн кабелиар холбогдсон байгууллагууд www.legalsystem.mn хаягаар, бусад байгууллага, олон нийт интернэтийн www.legalinfo.mn хаягаар, шүүхийн мэдээллийн системд интернэтийн www.judgeinfo.mn хаягаар тус тус хандаж шаардлагатай мэдээллээ авах бүрэн боломжтой.

2/ Хууль зүйн албаны ажилтнуудаас иргэд, байгууллагад эрх зүйн актын талаар лавлагаа, мэдээлэл өгөх нэг чухал эх сурвалж нь хууль тогтоомжийн бүртгэл – лавламжийн сан, цахим сан байдаг. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн мэдэлд байгаа хууль тогтоомжийн бүртгэл – лавламжийн сангийн бүрдүүлэлт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт харилцан адилгүй байдаг боловч хууль тогтоомжид орсон өөрчлөлт, хөдөлгөөнийг цаг тухайд нь хийж байвал ямар ч нөхцөлд ашиглах бүрэн боломжтойгоороо цахим сангаас давуу талтай.

Хууль зүйн мэдээллийн цахим санд байгаа 4000 гаруй эрх зүйн актыг он дараалсан байдлаар, түүнчлэн актын нэр, дугаараар нь хайж, интернэтээс болон хуулийн байгууллагуудын нэгдсэн вэб сайтаас мэдээлэл авах боломжоор иргэд 2001 оноос хангагдсан билээ.

Цахим санг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас нэгдсэн журмаар аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст өгсөн боловч өөрчлөлт, хөдөлгөөн хийсэн материалыг яамнаас цаг тухайд нь авдаггүй, аймагтаа интернэтийн сүлжээнд холбогдоогүй, тухайн аймагт байгаа компьютерийн хүчин чадал муу зэрэг шалтгаанаар бүрэн гүйцэд ашиглаж чадахгүй байгааг цаашид өөрчлөх шаардлагатай байна.

3/ Ард иргэдэд хуулийг боломжийн хэрээр ойлгомжтой, сонирхолтой, хүртээмжтэй байдлаар шуурхай хүргэж сурталчлах, мэдээлэх ажлыг өмнөх жилүүдийн арга барил, туршлагадаа тулгуурлан улам баяжуулах замаар зохион байгуулж ирлээ. Улсын Их Хурлаас хуулиудыг баталсан даруйд тэдгээрээс олон түмэнд түгээмэл хэрэглэгдэх, нийтлэг ач холбогдолтой хуулиудыг түлхүү сурталчлахыг чухалчлан ажилласан болно. Хууль сурталчлах ажлыг олон нийтэд хүргэж хуулийг тэдэнд ойлгуулах, тайлбарлан таниулахдаа бид мэдээллийн хэрэгслийг илүү түшиж, хамтран ажиллаж ирсэн бөгөөд үзэгч, сонсогчдын дийлэнх болох залуучуудын хүсэл, сонирхолд нийцүүлэх үүднээс мэдээллийн чөлөөт сувгаар дамжуулан энэ ажлыг гүйцэтгэж ирлээ. Хуулийг олон түмэнд үр нөлөөтэйгээр хүргэх, сурталчлан таниулах чиглэлийн ажлыг сайжруулах, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр явуулах үүднээс Засгийн газрын бус болон эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран хэд хэдэн удаа нийгмийн тандах судалгааг хийж ажилдаа ашиглаж байна. Хууль тогтоомжийг сурталчлах зориулалт бүхий "Хуулийн цаг", "Дэнс", "Дэвжээ" нэвтрүүлгүүд нь олны танил болсон бөгөөд радио, телевиз, сонин, хэвлэлээр явуулсан эрх зүйн сурталчилгааны багтаамж өмнөх жилүүдтэй харьцуулахад 3 дахин нэмэгджээ.

Засгийн газрын 2002 оны 121 дүгээр тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэд байгуулагдсан Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв (Хууль зүйн үндэсний төв гэж товчлон ярьж, бичиж хэвшсэн)-тэй хамтран он дараалсан 10 боть, салбарын үйл ажиллагааг зохицуулсан 20 гаруй хуулийн эмхтгэлийг тус тус хэвлэн иргэдийн гарт хүргээд байна. Үүний зэрэгцээ иргэдийн байнга асууж, лавлаж байдаг зарим хуулиуд тухайлбал, нийгмийн даатгалын, халамжийн, боловсролын, газрын, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай зэрэг хуулиудаас асуулт – хариулт хэлбэрээр хялбаршуулан боловсруулсан номыг авсаархан хэмжээтэй, олон тоогоор хэвлүүлж иргэдэд, түүний дотор хөдөө нутгийн алслагдсан баг, сумдад амьдарч байгаа хүмүүст байнга хүргүүлж байна.

4/ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2004 оны 45 дугаар тушаалаар баталсан "Эрх зүйн албан бус сургалтын хөтөлбөр"-ийг орон нутагт хэрэгжүүлэх, уг сургалтыг хэрхэн зохион байгуулах талаар манай яам Нээлттэй нийгэм форумтай хамтран аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтнуудад удаа дараа сургалт явуулж, холбогдох гарын авлагаар хангаж ажилласан.

Ийнхүү Хууль зүй, дотоод хэргийн яам Нээлттэй нийгэм форумын санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Эрх зүйн мэдээлэл, үйлчилгээг орон нутагт хэрэгжүүлэх нь" төслийн хүрээнд Хууль зүйн хэлтсүүд жил бүр аймгийнхаа 2-3 суманд "Эрх зүйн хөтөч" номын тодорхой бүлгээс сонголт хийх замаар сургалт зохион байгуулж хэвшээд байна.

Хоёрдугаар үндсэн зорилт бол хууль зүйн албаны байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, боловсон хүчний мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагыг дээшлүүлэх явдал юм.

1. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэс нь Хууль зүй, дотоод хэргийн яамны анхан шатны нэгж болохын хувьд тухайн Хурлын нутаг дэвсгэрийн хэмжээнд дараахь чиглэлийн асуудлыг эрхлэн хариуцах үүрэгтэй. Үүнд:
1) Хууль тогтоомжийн системчлэл, мэдээллийн ажлыг эрхэлнэ;
2) Нутгийн захиргааны байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлнэ;

3) Сум, дүүргийн хууль зүйн албаны ажлыг удирдан чиглүүлнэ;
4) Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна;
5) Орон нутгийн хэмжээнд хуулийн хэрэгжилтийн байдлыг шалгаж зааварлана;
6) Иргэний болон иргэний гэр бүлийн бүртгэл, мэдээллийн асуудал эрхэлнэ;
7) Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулна;
8) Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагийн орон нутгийн байгууллагуудын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт – шинжилгээ, үнэлгээ хийх асуудлыг эрхэлнэ;
9) Нийгмийн дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулна;
10) Аймаг, нийслэлийн Засаг даргаас шүүх, прокурор, нотариат, өмгөөлөх байгууллагатай харилцах асуудлыг төлөөлөн явуулна.

Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсүүдийн эрх зүйн ажлын хагас, бүтэн жилийн тайлан, мэдээнээс үзэхэд дээрх үүргээ шаардлагын хэмжээнд хүртэл биелүүлж чадахгүй байгаа байдал ажиглагддаг. Яагаад гэвэл, сонгуулийн үр дүнгээр албан тушаалд шинээр томилогдсон Засаг дарга нар багаа бүрдүүлэх нэрийн дор Тамгын газрын дарга, хэлтсүүдийн дарга, тэр ч бүү хэл мэргэжилтнүүдийг халж, сольж өөрчилдгөөс ийнхүү ажил цалгардах явдал газар авч байна. Жишээ нь, хууль зүйн албаны 80 жилийн ойг тэмдэглэхэд оролцож байсан Хууль зүйн хэлтсийн 22 даргын 86.4 хувь нь өнөөдрийн байдлаар өөрчлөгдсөн байна.

2. Салбарын хууль зүйн албыг яаралтай бэхжүүлж, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх шаардлага зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн хандлагаас урган гарч байна. Ихэнх яам, агентлагуудад мэргэжлийн хуульч, хууль зүйн албаны аппарат ховор байна, байгаа заримыг нь зохих ёсоор ажиллуулж мэдлэг, чадварыг нь ашиглаж чадахгүй байна. Иймд ойрын ирээдүйд бүх яам, агентлаг, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, улсын үйлдвэрийн газарт хууль зүйн албаны зохих бүтэц бий болгох, тухайлбал, хуулийн хэлтэс, тасаг, зөвлөх ажиллуулах зайлшгүй шаардлага тавигдаж байна. Энэ бүхнээс улбаалан салбарын хууль зүйн албыг чадварлаг хуульчдаар бэхжүүлэх, тэнд ажиллаж байгаа хуульчдын мэргэжлийг дээшлүүлэх асуудлыг зохицуулсан эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх явдал чухал гэж үзэж байна.

3. Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг сурталчлах, тайлбарлан таниулах, иргэдэд энэ асуудлаар лавлагаа, мэдээлэл өгөх, тэдэнд зориулсан хууль зүйн сургалт зохион байгуулах, байгууллагын даргын батлан гаргах шийдвэрийн төслийг хууль зүйд нийцүүлэх, иргэд, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зэрэг бүхий л ажилд хууль зүйн албаны ажилтан (хуулийн хэлтэс, тасгийн дарга, хуулийн зөвлөх)-ууд оролцдогоос үзэхэд тэдний эрхлэх асуудлын цар хүрээ хичнээн өргөн, хариуцлага хичнээн өндөр байгааг харуулж байна.

Төрөөс хуульч боловсон хүчний талаар баримтлах бодлогыг нэгдмэл болгох, эрх зүйн чиглэлээр төгсөгчид, сонгон шалгаруулалтад оролцогчдын мэргэжлийн мэдлэг, чадварыг нэг түвшинд шалгаж, үнэлж дүгнэх, шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, нотариат, өмгөөллийн байгууллагад ажиллах хуульчдын чанарыг сайжруулах, түүнчлэн өндөр мэдлэг боловсролтой, мэргэшсэн хуульчдыг бэлтгэх нөхцөлийг бүрдүүлж, зах зээлийн бодит өрсөлдөөнийг бий болгох зорилгоор Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуулийг шинээр боловсруулан батлууллаа. Улсын Их Хурлаас 2003 онд батлан гаргасан энэ хуулийн дагуу төрийн болон хувийн хэвшлийн олон их, дээд сургуулийг төгссөн хуульчдын дунд сонгон шалгаруулалтыг 3 дахь удаагаа зохион байгууллаа. Шалгалтын дүнгээс үзэхэд шалгалтад оролцсон хүмүүсийн 20 орчим хувь нь тэнцэж байгаа явдал хуулийн сургуулиудын сургалтын чанарыг илтгэх нэг үзүүлэлт даруй мөн. Шалгалтын зорилго нь шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудыг чадварлаг хуульчдаар бэхжүүлэх, мэдлэг боловсролтой нөөц хүчнээр хангахад оршино. Хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн хүн өмгөөлөгч, нотариатч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн мэргэшлийн шалгаруулалтын шалгалтад өрсөлдөх, хууль зүйн албаны байгууллагад мэргэшлийн дагуу ажилд орох эрх нь нээгдэж байгаа хэрэг мөн. Цаашдаа жил бүр олон зүүн хуульчдыг бэлтгэн гаргаж, дээд боловсролтой ажилгүйчүүдийн эгнээг нэмэгдүүлж байгаа буруу зуршлыг халахын тулд сонгон шалгаруулалтад оролцсон хүмүүсийн үзүүлсэн амжилтыг төгссөн сургууль тус бүрээр нь нийтэд мэдээлэх шаардлагатай байна. Ингэснээр мэдлэг чадвартай боловсон хүчин бэлтгэдэг сургуулиуд сургалтаа улам сайжруулах, хангалтгүй мэдлэгтэй боловсон хүчин бэлтгэдэг сургуулиуд сургалтынхаа арга барилыг өөрчилж, цаг үеийн шаардлагад нийцэж ажиллах, эсхүл чанаргүй сургалт явуулж иргэдийг хохироодог дутагдалдаа дүгнэлт хийж үйл ажиллагаагаа зогсоох нөхцөлийг бүрдүүлж өгөх болно.

4. Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх ажлын хүрээнд нэгэн шинэ байгууллага нэмэгдсэн нь Шүүхийн шинжилгээний үндэсний төв билээ. УИХ-ын 1998 оны 18 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын эрх зүйн шинэтгэл хөтөлбөр"-ийн 44 дүгээр заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 63 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн яамны харьяа Шүүх эмнэлгийн магадлах төв, Сангийн сайдын дэргэдэх Шүүх-нягтлан бодох бүртгэлийн магадлах товчоо, Цагдаагийн ерөнхий газрын Шинжилгээний хүрээлэнг нэгтгэж

Шүүхийн шинжилгээний үндэсний төв байгуулсан юм.

Ийнхүү хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх, прокурор болон хууль сахиулах бусад байгууллагатай ажлын нягт уялдаа холбоотой криминалистик, шүүх-эмнэлэг, шүүх-нягтлан бодох бүртгэл зэрэг магадлан шинжилгээний байгууллагуудыг нэгтгэснээр олон газарт янз бүрээр хэрэглэж байгаа шинжилгээний төрөл бүрийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж төвлөрч ашиглалт нь сайжрах, үйлчилгээг чанартай, хөнгөн шуурхай болгох, шинжлэх ухааны орчин үеийн ололт, шинэ технологи, арга барилыг шинжилгээний хүнд хүчир, нарийн чимхлүүр ажилд нэвтрүүлэх таатай нөхцөл бүрдэж байгаа билээ.

Гуравдугаар үндсэн зорилт бол хууль зүйн албаны байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг улам өргөжүүлж шинэ шатанд гаргах явдал юм.

1. Хууль зүй, дотоод хэргийн яамны гадаад харилцаа, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах нь өнөөгийн бодит шаардлага болж байна. Юуны өмнө, 1992-2000 онуудад Хууль зүйн яамнаас бусад улсын ижил төрлийн яамтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээг эргэн харж баталсан, тохирсон зүйлээ ажил болгож хэрэгжүүлэх, шаардлагатай заримыг нь шинэчлэн боловсронгуй болгож мөрдөх талаар анхаарч ажилласан. Тухайлбал, түс яам өнгөрсөн хугацаанд ОХУ, ХБНГУ, БНХАУ, БНСУ, Япон улс, БНТУ-ын Хууль зүйн яам, Дотоод хэргийн яам, тэдгээрийн харьяа хууль сахиулах байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлж, улмаар Япон улсын Хууль зүйн яам, Тайланд улсын Цагдаагийн байгууллага, БНТУ-ын Дотоод хэргийн яамтай албан ёсны харилцаа тогтоолоо.

Харилцан айлчлалын үеэр яамд хоорондын хамтын ажиллагааны 4 гэрээ, хэлэлцээр, 10 хамтран ажиллах хөтөлбөрийг байгуулсан. Эдгээр баримт бичгийн үр дүнд Монгол Улсын цагдаа, иргэний бүртгэл, шүүхийн шийдвэр гүйцэтгэх зэрэг байгууллагууд гадаад орны ижил төрлийн байгууллагуудтай туршлага солилцох, боловсон хүчин сургах, мэргэжил дээшлүүлэх, техникийн туслалцаа авах зэргээр хамтран ажиллаж байна.

2. ОХУ, БНХАУ-ын хил залгаа аймаг, мужтай хамтран ажиллах боломж бүрдүүлэх нь чухал гэж үзэж байна. Ялангуяа, ОХУ, БНХАУ-ын хил залгаа аймгуудын Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэс тэдгээр улсуудын аймаг, мужийн хууль зүйн албаны байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах замаар хамтын ажиллагааны зүйн орчин бий болгох асуудалд тухайн аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар санаачлага гаргаж ажиллавал зохих үр дүнд хүрнэ гэж үзэж байна.

3. Хууль зүйн албаны ажилтнуудыг гадаадад суралцуулах, мэргэшлийг нь дээшлүүлэх, туршлага судлуулах нь яамны анхаарлын төвд байх ёстой. Энэ чиглэлээр өмнө нь хэрэгжүүлж байсан практиктаа тулгуурлан хууль зүйн албаны төв, орон нутгийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилтнуудыг ОХУ-ын Хууль зүйн яамны шугамаар Оросын эрх зүйн академид богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах, эсхүл ОХУ болон Зарим Бүгд найрамдах улсын хууль зүйн албаны ажлын шинэ арга барил, туршлага судлуулах зэргээр тэдний идэвх санаачлагыг өрнүүлэх, үр чадварыг нь сайжруулах чиглэлээр яамны удирдлага тодорхой ажил зохиож хэрэгжүүлнэ гэдэгт итгэл төгс байна.

Хууль зүйн албаны төв, орон нутгийн байгууллага, хамт олны өмнө Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн үзэл санаа, зарчмыг мөрдлөг болгон Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр, Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн дагуу хууль тогтоомжийг улам боловсронгуй болгох, хууль ёсыг эрхэмлэн сахиж, чанд биелүүлэх, нийгмийн дэг журмыг хаа сайгүй бэхжүүлэх, сахилга хариуцлагыг бүх түвшинд дээшлүүлэх, архидан согтуурахтай эргэлт бүцалтгүй тэмцэх талаар илүү өргөн дэлайцтай, их эрч хүчтэй ажиллах шаардлага тавигдаж байна. Бид энэ өндөр шаардлагыг эмх цэгцтэй, дэг журамтай, зохион байгуулалттай, хариуцлагын өндөр ухамсар, мэдрэмжтэй байж ханган биелүүлж чадах болно.

Хууль зүйн алба анх байгуулагдсан үеэс эдүгээ үеийг хүртэл туулж өнгөрүүлсэн түүхэн замнал нь бүхэлдээ улс орныг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсан, оруулсаар байгаагийн тод илэрхийлэл болж байна. Энэ их үйлсийг бүтээхэд бие сэтгэл, оюуны чадавхиа дайчилсан ахмад үеийнхэндээ, хууль зүйн албанд ажиллагсаддаа, тэдний ар тал нь болсон гэр бүлийнхэнд гүн талархлаа илэрхийлж эрүүл энх, аз жаргал, ажлын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

Тэнхимийн багшаас төрийн сайдаар өргөмжлөгдсөн нь



ХЗҮТ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор Б.Чимид

Өмнөх нийгмийн тогтолцооны үед сайдын алба сүрдмээр том алба байлаа. Одоо шиг төрийн эрх мэдэл ёстой л өмч гэдэг шиг бүгд төрийнх, Засгийн газар нь "баг"-аар ажилладаггүй, ажлын хувь заяаг сайд дангаараа "хар толгойгоороо" дангаар хариуцдаг байсан цаг. Тийм болохоор сайд мөнгөний мэдэл багатай ч, удирдан чиглүүлэх эрх, нэр хүндийн засгаараа төр салбартаа "хаан" байв. Тэгээд ч хэн хүн сайд болно гэж ярих нь байтугай, зүүдэлдэг ч үгүй байсан гэдэг.

Б.Чимид багшийг 1978 оны хавар Намын Төв Хорооны Боловсон хүчний хэлтсийн эрхлэгч дуудсанаар хууль зүйн практик алба Шүүх яамтай амьдралынхаа хэдэн жилийг холбох эхлэлийг тавьсан гэдэг. Түүний сайдын албанаа өргөмжлөгдсөн нь сонин түүхтэй. Үүнийг Б.Чимидийн ярьснаар дор сийрүүлье.

1978 оны хавар Намын Төв Хорооны Боловсон хүчний хэлтсийн эрхлэгч дуудаж байна гэлээ. Очлоо. Төрийн (тэр үед "Засгийн газрын") ордны баруун жигүүрийн гуравдугаар давхарт Б.Ламжав гуайн өрөөд ортол мөн Төв Хорооны Ерөнхий хэлтсийн эрхлэгч Ц.Намсрай тэр хоёр ярилцаад сууж байна. Мэнд усаа мэдэлцээд надад ямар нэг тодорхой юм ч хэлсэнгүй. Ер нь Ламжав гуай ховорхон дуугардаг хүн. Бичгийн цаас нэг ширхгийг өгөөд:

-Социалист өмч хамгаалах талаар намаас дэвшүүлсэн лоозонгийн тухай оросоор бич гэлээ. Тэр хавар Төв Хорооны бүгд хурлаас "Хүн бүр бага балчраасаа эхлэн туйлын аж ахуйч, арвич хямгач, социалист өмчийн эс ширхэг бүрийг алхам тутамдаа нүдлэн хамгаалагч, хөдөлмөрийг бишрэн шүтэгч байх ёстой" гэсэн лоозон дэвшүүлээд нэг их удаагүй байлаа. Уг лоозон хэрэгжүүлэх ажил орон даяар ид өрнөж, нэгдэл нь малаа им тамга, нас зүсээр дансалж, улсын байгууллагууд барилга байшингаас эхлээд машин техник, сандал ширээгээ хүртэл будаг шохой, зэс, гуулиар дугаарлан хүн хүнд хариуцуулж, данслах зэргээр их давалгаа эхэлсэн үе. Улс төрийн утга өөр ч гэсэн юмыг "эзэнтэй" болгох, бусдын бүтээснийг хайрлан хямгадах талаараа чухал арга хэмжээ байсан юм шүү. Багш бид хичээл номондоо заавал хэлж, тайлбарлаж, бас бичиж нийтлүүлдэг, оюутан нартаа оросоор цээжлүүлж, шалгадаг боллоо. Тийм болохоор Улсын их сургуулийн салбар эрх зүйн тэнхмийн эрхлэгч хүний чинь толгой дотор тэр лоозон монгол, оросоороо өрөөтэй байлгүй яах вэ дээ. Өмч энэ тэрийн тухай товч оршил дурдаад "каждый сызмальства..." гэхчилэн лоозонг оросоор үгчлэн биччихээд сууж байв. Гэтэл Төрийн ордонд норм мэт тараадаг шилэн аягатай байхуу авч ирсэн бүсгүй цайгаа цалигуулаад нөгөө лоозон бичсэн цаасыг норгож орхив. Би ихэд сандарч билээ. Хуулбарлах гэж цаас гуйтал "хэрэггүй" гээд хоёр дарга тэр чигээр нь авч үлдээд намайг "явж болно" гэлээ. Баларсан юм боллоо гэж бодсон. Тэгээд л таг чиг болсон. Ингээд 10 дугаар сарын 4-ний орой ажил тарахын өмнөхөн хичээл заагаад зогсож байтал мөнөөх Б.Ламжав гуайн өрөөнд гэсэн гэнэтийн дуудлага ирлээ. Яваад очлоо. Орлоо. Суугаагүй байтал "За хоёулаа явна аа" гээд босоод алхчихав. Дагаад гартал С.Жалан-Аажав даргын үүдний өрөөнд оруулж орхиод цааш орчихов. Хэдэн хормын дараа хонх дуугарч туслах нь орсноо эргэж цухуйгаад "Та ор" гэж байна. Яваад орлоо. Мэндлэлцээд суу, суу гэхээр нь хурлын ширээний өнцөгт суутал,

-Наашил. Таныг ... гээд нэг л албархаг эхэлж байна. Уг нь бидэнд Үндсэн хуулийн хичээл заасан, бас бичих боловсруулахад хааяа дайчилдаг тул бие биеэ мэдэх л дээ. Би ч их хүндэлнэ. Бас их цэрвэнэ.

-Таныг Шүүх яамны сайдаар томилох саналыг оруулсан. Маргааш өглөө 9 цагт бэлэн бай. Улс төрийн Товчооны хуралд оруулна гэлээ. Чи чадах уу, за юу энэ тэр гэж ч асуусан үгүй. Маргааш 9 цагт ир гэсэн. Би ер нь юм хэлж амжилгүй гарав. Маргааш өглөө нь эртлэн "биеэ засаад..." гэдэг шиг үс зүсээ янзлаад явж очлоо. Төрийн ордны зүүн жигүүр дөрвөн давхрын хуралдааны танхимын үүдний өрөөнд 9.30 цаг орчимд хүлээж суулаа. Удсан ч үгүй хурал эхэлж намайг оруулав. Товчоо бүрэн сууж байна. Улс төрийн Товчооны гишүүн С.Жалан-Аажав гуай товч үг хэлж, танилцуулж батлуулах санал тавьсан санагдана. Ю.Цэдэнбал гуай "Чи чинь оросоор ..." гээд эхлэхэд нь нөгөө цай асгасан цаас санагдаад эвгүй оргиод явчихлаа. Гэтэл "... сүрхий бичсэн байдаг шүү. Их сургуульд сурсан уу" гэхчилэн яриад "За баталъя.

Сайн ажиллана шүү" гэсэн утгатай цөөн үг захиж хэлсэн. Гарах гэтэл намайг суу гэв. Төдөлгүй элчин сайд байгаад чөлөөлөгдсөн Х.Дамдин[1] гуайг оруулж ирлээ. Түүнийг Шүүх яамны Гэр бүл, нотариатын хэлтсийн даргаар ажилла гээд шууд л баталчихдаг байгаа. Үнэнийг хэлэхэд намайг оюутан байхад Улсын дээд шүүхийн дарга, бидний улсын шалгалт дээр сууж байсан их хүн миний үгэнд орох болов уу, яах бол гэсэн шүү юм бодогдож билээ. Ерөнхий маань Х.Дамдин гуайг сайн мэддэг нь ойлгомжтой харагдав гэхчилэн хүүрнэжээ.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1978 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 236 дугаар зарлиг гарч, БНМАУ-ын Шүүх яамны сайдаар Бяраагийн Чимид томилогдсон юм. Ийнхүү тэрээр 1959 онд татан буугдсан Шүүх яам Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1972 оны 12 дугаар сарын 7-ны 247 дугаар зарлигаар сэргээн байгуулагдсаны дараах хоёр дахь сайд нь болон очжээ.

Буйг нь эвлүүлж, байхгүйг бүтээсэн нь

Тэр үеийн Шүүх яам одоогийн Иргэний хамгаалалтын газар байрлаж байгаа байрын дөрөвдүгээр давхрын хэдхэн өрөөнд элбэг багтаж байв. Ердөө 3-8 хүнтэй Хууль боловсруулах, системчлэх хэлтэс, Гэр бүл, нотариатын хэлтэс, Эрхийн үйлчилгээ, өмгөөллийн хэлтэс, Гадаад харилцааны гэсэн дөрвөн хэлтэстэй, сайдаас сахиулаа хүртэл 35 ажилтантай. Тэдгээрийн бараг тал нь дотоод ажил, санхүү, аж ахуйн үйлчилгээ эрхэлсэн тасгийн 14 орон тоо, гэр бүлийн архивч нэг, сайд, орлогч сайд зэргийг хасчихвал яамны үндсэн чиг үүргийг эрхлэн хэрэгжүүлдэг шуурхай ажлын бүрэлдэхүүн нь 16 хүн, түүний дөрөв нь хэлтсийн дарга, нэг нь орчуулагч, тав нь ахлах, тав нь ердийн мэргэжилтэн, яамны тэр жилийн зардлын төсөв 507 000 төгрөг байжээ.

Харьяа газар гээд одоогийнх шиг том том агентлагууд байсангүй. 1978-1979 оны хичээлийн жилийн байдлаар 14 багш, найман ажилчин, өдөр, оройн хоёр салбарын 263 оюутантай Хууль цаазны дунд сургууль, найман орон тоотой Тэргүүлэгчид, аймаг, хотын 21 зөвлөгөө өгөх газар, Налайх, Зүүнхараа, Тосонцэнгэлд салбартай Монголын өмгөөлөгчдийн коллеги хоёр л байв. Энэ үед аймаг, хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргаанд гэр бүлийн байдлын бүртгэл, нотариатын үйлчилгээг сум, хороо, орон нутгийн хот, районы гүйцэтгэх захиргааны нарийн бичгийн дарга эрхэлдэг байсан бөгөөд тэдгээрийг нэгтгэн "Гэр бүл, нотариатын товчоо" болгон зохион байгуулсан аж.

Хамт олон, хань нөхөд хажуугаас туших тулгуур билээ

1970-аад оны эцэс гэхэд Шүүх яамны юуны түрүүнд хэрэгжүүлэхээр анхаарсан асуудал бол аж ахуйн хууль зүйн албаны тогтолцоо бий болгох зорилт байжээ. 1970-аад оны эцэс хүртэл тийм дагнасан албаны тогтолцоо байсангүй. Зарим нэг яаманд ганц зөвлөгч, хавсарсан орон тоо байсныг эс тооцвол зөвхөн өмгөөлөгчид үйлдвэр, байгууллагад гэрээний үндсэнд зөвлөгөө өгч, туслалцаа үзүүлдэг. Түүнийгээ эрх зүйн үйлчилгээ хэмээн томъёолдог байжээ. Гэтэл цаг үеийн хэрэгцээ өсч, шинэ өндөр шаардлага гарч ирсээр байв.

Б.Чимидийн сайдаар ажилласан жилүүд социализм зах зухаасаа хөдөлгөөнд орсон үе байлаа. Хөгжлийн зогсонги байдлаас гарахын тулд үйлдвэрлэлийн удирдлагыг ардчилах, захиргааны аргыг хязгаарлаж, эдийн засгийн аргыг өргөн хэрэглэх, үүний тулд "төлөвлөлт, урамшууллын шинэ систем" нэвтрүүлэх, үйлдвэрийн газруудын эрхийг өргөтгөж, бие даасан байдлыг нь дээшлүүлэх, төвлөрсөн удирдлагын үүргийг аж ахуйн нэгдлүүдэд шилжүүлэх гээд тэр үедээ хатуу төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг эрх биш либеральчлах гэсэн оролдлого нам, төрийн бодлогод шинэ хандлага болон нэвтэрч байсан цаг. Дур үзэмж, намын байгууллагын тогтоол, даргын даалгавар, ам зангаагаар биш Засгийн газраас баталсан нийтлэг дүрэм, цаашлаад төрийн хуулиар аж ахуйн харилцааг зохицуулах шаардлага тулж ирээд байлаа. Үүнд хууль зүйн мэргэшсэн алба, үйлчилгээ илт дутаж байгааг мэргэжлийн хүмүүс арай л эрт мэдэрч, нийгмийн ухамсарт нэвтрүүлэхийг хичээж байжээ.

Энэ асуудлыг шийдвэрлэхэд Шүүх яамны удирдлага аппаратынхаа хүчийг дайчилж, эрх зүй, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, цалин хөлс, байршил, санхүү, боловсон хүчин, сургалт гэх зэрэг тал бүрээс нь боловсруулцгаасан юм. Эцэст нь олон яам, газраас санал авч, төслөө МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлд өргөн мэдүүлжээ. Энэ ажилд гурван сар гаруй хугацаа зарцуулан, 1979 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр "Улс ардын аж ахуйд хууль зүйн албыг бэхжүүлэн, эрх зүйн ажлыг сайжруулах арга хэмжээний тухай" МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн хавсарсан 9 дүгээр тогтоол гарч, тус албаны үндсэн зорилтыг тодорхойлон, аж ахуйн гол гол яам, тусгай газар, нийт аймаг, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд хуулийн хэлтэс, зарим яаманд тасаг байгуулах, үйлдвэр, аж ахуйн газарт ажлын хэмжээ, онцлогийг харгалзан хуулийн зөвлөгчийн орон тоо бий болгох, энэхүү шинэ албаны ажлын аргачилсан удирдлагыг Шүүх яаманд төвлөрүүлэх болжээ.

Тухайн үеийн Шүүх яамны хүч тавин оролдсон хоёр дахь зүйл нь хууль тогтоомжийг боловсронгуй болгох арга замыг боловсруулж, хэтийн чанартай зарчмын шийдэлд хүргэсэн явдал юм. Социалист агуулгынхаа хувьд өнөөгийнхөөс өөр юмаа гэхэд нам, төр, түүний байгууллагуудаас хуульд хандах зарчим, үүрэг, хариуцлага, арга технологи, сэтгэл зүйн хувьд урсгал ажлын бус, зөвхөн үзэл суртлын ~~бус~~, харин хууль тогтоомжийн бодлогод огцом эргэлт хийх, хөгжлийн шинэ үе рүү чиглүүлсэн их ажлын болсон МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1982 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн "Хууль тогтоомжийг боловсронгуй болгох зарим арга хэмжээний тухай" хавсарсан нэгдүгээр тогтоол; "БНМАУ-ын хүчин төгөлдөр хууль тогтоомжийн системчилсэн бүрэн эмхтгэл бэлтгэж хэвлүүлэх тухай" хавсарсан хоёрдугаар тогтоол гарсан юм. Удаахан нь хууль тогтоомжийг боловсронгуй болгох таван жилийн төлөвлөгөөг БНМАУ-ын Ардын Их Хурлын

[1]Монгол Улсын гавьяат хуульч

Тэргүүлэгчид, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн хавсарсан мөн оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 7/52 дугаар тогтоолоор баталжээ. Ингэзд төлөвлөгөөнд тусгагдаагүй, "урьд нэгэнт журамлагдсан", "хэт жижгэрсэн" асуудлаар хуулийн төсөл боловсруулах ажлыг зогсоох, хууль тогтоомжийн тогтвортой байдлыг хангах арга замуудыг тодорхойлж, салбарын хуулийг тухайн яам, тусгай газрууд Шүүх яамны арга зүйн удирдлага туслалцаатайгаар салбар дундын чанартайг нь Шүүх яам толгойлон боловсруулж байх хөдөлмөрийн хуваарь тогтоосон нь зарчмын шинэ шийдлүүд байсан бөгөөд одоо ч уламжлал болохуйц зүйл юм.

Хүн амын эрх зүйн хүмүүжлийн асуудал Шүүх яамны нэлээд зүг чигээ олсон ажил байсан бөгөөд түүнийг өргөсгөн улсын хэмжээний удирдлага, зохицуулалтын шинэ тогтолцоонд оруулахыг оролдсон билээ гэж тухайн үеийн сайд асан Б.Чимид дурсаж байна. тэр үед нийт аймаг, хотоос 40 багш Улаанбаатарт ирүүлж сургалтад хамруулан, тэднээр багшлуулан бүх аймагт 400 гаруй сургуулийн багш нарыг семинарлах, гарын авлага гаргах зэргээр ажилласан нь нэлээд үр дүнгээ өгч байсан юм. Ялангуяа ерөнхий боловсролын сургуулиуд эрх зүйн кабинет байгуулж, түүнд төвлөрүүлэн цөөнгүй ажил зохиодог арга, туршлага дэлгэрч байжээ.

Гэвч боловсролын гаднах хүрээнд, ялангуяа албан хаагчдын эрх зүйн сургалт, хүмүүжлийн ажил ахицтай байж чадахгүй л байв. Энэ нь тэр цагт нам, аж ахуй, соёлын салбарын удирдлагын хүрээнд Төв Хорооны тогтоол л гэхээс хууль нэг их ойшоож үздэггүй байсантай холбоотой ч байж магад.

Ийнхүү Б.Чимидийг сайдаар очиход дөрвөн хэлтэстэй, 35 ажилтантай байсан энэ яам өргөжин, Хууль зүйн албаны хэлтэс, Хууль боловсруулах, системчлэх хэлтэс, Эрх зүйн хүмүүжил, өмгөөллийн хэлтэс, Гэр бүл, нотариатын хэлтэс, Олон улсын эрх зүй, хамтын ажиллагааны хэлтэс, Санхүү, аж ахуйн, Захиргааны тасаг гэсэн долоон нэгжтэй болон өргөжижээ.

Гадаад түншээ дурсахуй

Социалист орнууд, юуны өмнө Эдийн засгийн харилца туслалцах зөвлөлийн орнуудын хооронд эрх зүйн хамтын ажиллагааг хөгжүүлэх, хууль журмаа уялдуулах асуудал гадаад улс төрийн бодлогод чухал суурь эзэлж байв. Шүүх яам Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн эрх зүйн хамтын ажиллагааны монголын хэсгийн үүргийг эрхлэн гүйцэтгэх тул энэ ажилд Гадаад харилцааны хэлтэс их цаг зардаг байжээ. Мөн Монгол-Зөвлөлтийн хооронд 1956 онд байгуулсантай адил бусад оронтой эрх зүйн туслалцааны гэрээ байгуулах, биелэлтэд нь хяналт тавьж зохицуулах ажлыг ч эрхэлж байв. Түвэгтэй асуудал ч гарч байлаа. Манай харчуудаас гадаадын бүсгүйчүүд хүүхдийн тэтгэлэг Шүүх яамаар дамжуулан нэхнэ шүү дээ. Тийм ч олон биш, гэхдээ л түвэгтэй, бүтэх, бүтэхгүй, эзэн нь олдох, олдохгүй, үйл үзнэ гээч. Харчуудаа гэж харийн бүсгүйчүүлийг баярлуулж нэг, гомдоож нэг явдаг улс даа гэж сайд асан Б.Чимид өгүүлж байна.

ЗХУ-ын Шүүх яамны урилгаар 1979 оны 4 дүгээр сард хийсэн айлчлал ихээхэн үр дүнтэй болсон юм. энэ үеэр ЗХУ-ын Шүүх яамтай шууд хамтын ажиллагааны тухай, хоёр улсын хууль тогтоомжийг ойртуулан уялдуулах тухай асуудлаар хэлэлцээ хийж, 4 дүгээр сарын 15-ны өдөр Монголын талаас Б.Чимид, Зөвлөлтийн талаас Шүүх яамны нэгдүгээр орлогч сайд А.Я.Сухарев нар хэлэлцээр болон хууль ойртуулах хөтөлбөр-протоколд гарын үсэг зуржээ.

Харилцан мэдээлэл, төлөөлөгч солилцох, мэргэжилтэн илгээж туслах, монголын хууль зүйн албаны ажилтнуудыг ЗХУ-д сургах, хэд хэдэн чухал хуулийг уялдуулж, бодлого зохицуулах гэх мэт үүрэг хүлээцгээсэн нь тэр жилээсээ эхлэн ажил хэрэг болж эхэлсэн гэдэг. Шүүх яамны гадаад үйл ажиллагааг идэвхжүүлэхэд уг ажлыг эрхэлсэн нэгдүгээр орлогч сайд (дараа нь сайдаар томилогдсон) О.Жамбалдорж, хэлтсийн дарга Д.Сүрэнжав, дараа нь залгамжилсан Б.Өнөбаатар нар их үүрэг гүйцэтгэснийг дурсахгүй байхын аргагүй юм.

Дуулбал дуу нэг, дуугарвал хүч нэг

Ахмад нь сургамжтай, залуус нь сурцтай байвал ажлын эрч хүч нэмэн, хамт олон зөв бүрэлддэг. Пүрэв сайдын үеэс яам ЗХУ-д нэр дээрээ оюутан сургаж эхэлсэн нь их тус болсон гэж Б.Чимид олзуурхах юм билээ. Шинэ алба үүрэгтэй холбогдож, төв, хөдөөд орон тоо өссөн зэргээс залгамжлагч, боловсон хүчнээ бүрдүүлэх талаар тус яам зохих бодлого баримталж байжээ. Тэр үед асуудал оруулж, МУИС-д "Аж ахуйн эрх зүйчимид анги" Хууль цаазны дунд сургуульд "Архив, бичиг хэргийн анги" тус тус нээх шийдвэр гаргуулж, аж ахуйн ангид эдийн засаг, инженер-техникийн мэргэжилтэй хүмүүсийг Шүүх яамны хяналт зөвлөмжөөр элсүүлж эхэлсэн нь бизнесийн эрх зүйн мэргэжилтнүүдийг бэлтгэхэд их үүрэг гүйцэтгэсэн юм. "Залуус бол оюун нь оргилж, хүч чадал буцалж байдаг, ирээдүйг зөгнөж шинэ юмыг амархан тусгаж эзэмшдэг, шаардлага даадаг хүмүүс. Тэдэнд найдаж, дэмжиж, аятайхан чиглүүлбэл "хүн хийж авч болно" гэдгийг цэрэг оюутны дотор олон жил хутгалдсан хэнбугай ч андахгүй. Багийн бичиг үсгийн багшаас их сургуулийн профессор хүртэл үргэлж залуустай өсөж өтөлж буй болохоор би тэдэнд л их найдаж, тулгуурлаж ирсэн хүн гэдгээрээ эрх биш бахархах эрхтэй болов уу. Одоо хөл нь гүйцэгүй ч хөөрөл баясал нь оюутантай хамт л явдаг юм. Өнөөгийн залууст "Араас чинь залуус айсуй. Тэдний уг таж аваад дэмжиж тулж өсгөөрэй. Тэд таныг зайлшгүй залгамжилна" гэдгийг захидаг" гэж Б.Чимид багш өгүүлнэ.

Энэ зарчмаар ч ажилдаа хандана. Ийм ч учраас Шүүх яам 1981, 1982 он гэхэд мэдэгдэхүйц залуужсан байлаа. Залуучууддаа Засгийн газрын хуулийн бодлогын гол төв байх "Шүүх яманд ороогүй нэг ч асуудал Засгийн газарт ордоггүй, Шүүх яамнаас оруулсан нэг ч асуудал хуулийн хувьд буруудаж буцахгүй байх ёстой" гэсэн шаардлагыг тавьдаг байсан. Энэ нь тэдэнд зарчимч, хатуу, аливаа зүйлийг эцэст нь тултал хийдэг болгож сургаад зогсоогүй, яамны ажил хийдэлгүй зөв явахад нэмэртэй болсон юм.

Тэгээд ч үүнийг амны уншлага болгож байсан тэд үнэндээ хууль боловсруулах ажилд гаршиж мэргэшсэн, дэрсхэн бойжсон боловсон хүчний "алтан сан" гэхэд хилсдэхгүй юм. Одоо ч гэсэн

академич Ж.Амарсанаа, хуульч Д.Сугар, А.Доржготов, Л.Хангай, Батхүү, Сүрэнжав, Бадамханд, Зина зэрэг мэдлэг, туршлагтай хуульчдыг сайтар дайчилж ажилламаар санагддаг. Хожим Б.Чимид Улсын Бага Хуралд байхдаа одоо ОХУ-д элчин сайд Л.Хангайн үзэж нягтлаагүй хуульд танилцаж гарын үсэг зурдаггүй байсан нь залхуурсных биш, харин хууль тогтоомжийн техникт гаршсан хүн гэдгийг мэддэгийнх байсан гэдэг.

Ийм олон залуус төрөн гарсан нь залуусыг дэргэдээ барьж нэг ширээнд сууж, бичиг баримтын төсөл дээр харилцан ярьж, бичиж боловсруулах, олшруулах, орон нутагт дагуулж явах зэргээр хамтран ажиллаж, уйгагүй дагалдуулж байсны үр дүн гэлтэй. Ажил их ч орон тоо цөөн, шинэ шинэ асуудал шийдвэрлэж байсан цаг тул их ч сууж ажилладаг байсан гэнэ. "Төлөвлөгөө төсөв гээд УТК, Сангийн яамны цонх гурван сар гэрэлтэй, төсөл гээд Шүүх яамны цонх 300 хоног гэрэлтэй" гэж хэлц гарсан гэдэг. Энэ талаар Б.Чимид гуай дурсахдаа "Ажил дээрээ үүр цайлгах нь онцгой үзэгдэл байгаагүй. Тэр үед конторынхныг чинь Хөдөлмөрийн хуулиар "тогтоосон цаггүй ажилтан" гэсэн ангилалд хамааруулна. Түүний дагуу долоо хоногт хоёр өдөр илүү цаг ажиллах журам тогтоож шахаж байв. Залуучууд, голдуу төслийнхөн сууна. Дагалдаад бусад нь сууна. "Сайд яваагүй юу" гээд л суугаад байдаг чимээтэй байдагсан. Тэгэхдээ хий хоосон дэмий суухгүй, ажлаа амжуулна. Зарим нь хааяа нэг шатардчихдаг байсныг ажигласан. Ядардаг л байсан байхдаа гэж одоо бодогдоно. Мөн ч захиргаадаж байж. Тэглээ гээд муудаагүй, гомдоогүй, сууж ажиллаж сурцгаасан гэж залуус ярих юм билээ" гэж билээ. Тэр үед яаж хичээж ажилладаг байсан талаар энд нэг жишээ дурдахад л хангалттай болов уу. ЗХУ-д хэвлүүлэх "БНМАУ-ын Үндсэн хууль ба хууль тогтоомжийн актууд" эмхтгэлийн өмнөх үгийг оросоор бичиж, маргааш өглөөний онгоцоор явуулах ажил гарчээ. Б.Чимид сайд Л.Хангай, Б.Өнөбаатар, Г.Зина, Пүрэвдулам гээд залуустай хамт үүр цайтал суужээ. Үүрээр 4 цаг орчим болж байхад хоёр залуу нь юм асуухад хариу дуугарахгүй юм гэнэ. Харсан чинь нүд нь мэлтийгээд харж байх хэрнээ унтчихсан, "сайдаас сүрдээд" зовхи нь анихгүй байсан юмсанж. Ингээд инээд ханиад болж сайд жаахан амар гэж "ершөөж" байсан гэнэ. Маргааш нь янзыг нь үзээд "дахиад сууцгаах уу" гэж "хэргийн эздээс" асуухад "тэгье" л гэцгээж. Тэгэхэд нь дотроо өрөвдсөн ч халаа харуулж, Б.Чимид сайд "За за. Та нар нэмэргүй, явж амар" гэсэн гэдэг. Ийм тохиолдол зөндөө л байсан гэнэ лээ.

Б.Чимид гуай "Бидэнд ажилд зүтгэж, аашлуулж, загнуулах өдөр байхад бас амарч цэнгэх, амьдралын баярт хийгээд гунигт мөчийг хамтдаа өнгөрөөх өдрүүд байсан" гэж өдгөө дурсаж байна.

Ахмад үеийн хийсэн нь арвин ч Б.Чимид сайд түүний хамтран ажиллагсдын ажиллаж байсан тэр жилүүдэд Шүүх яамны системийн хамт олны шийдвэрлэж эхэлсэн ажил өвөртөө тохирсон онцлоготой байв.

Тэд ажил үйлс нь өөдрөг байсан даа урамшиж, энэхүү албаны 60 жилийн ойг улс, орон нутгийн хэмжээнд угтан тэмдэглэх асуудал боловсруулж дээд засагт тавьснаар Төв Хорооны Улс төрийн Товчоо БНМАУ-д Хууль зүйн алба байгуулагдсаны 60 жилийн ойг 1981 оны 11 дүгээр сарын 20-нд тэмдэглэхийг зөвшөөрсөн тогтоолыг мөн оны 6 дугаар сард гаргажээ.

Хэдийгээр 1921 оны 7 дугаар сарын 10-ны өдөр Богд хаант төрийн яамдыг өөрчлөн байгуулсан Ардын засгийн анхны таван яамны нэг нь Шүүх явдлын яам байсан ч ажил төрлийн боломж, шаардлагаар 11 дүгээр сард тэмдэглэхээр шийдвэрлэсэн байна. Шүүх яам, аймаг, хотын болон бусад яам, улсын хороо, тусгай газар, үйлдвэр, албан газруудын албад, Монголын өмгөөлөгчдийн коллеги, хуулийн зөвлөгөө өгөх газрууд дор бүрнээ 60 жилийн ой угтсан ажлын төлөвлөгөө гаргаж, эрх зүйн бүх төрлийн үйлчилгээ, хүмүүжлийн ажлын далайц, үр дүнг дээшлүүлэх, түүхэн замнал, тухайн үеийн ажлаа дүгнэх, олон түмэнд тайлбарлаж, таниулах, суртал нэвтрүүлэг, сургалт хүмүүжлийн зэрэг олон зүйл ажлыг зохион байгуулжээ. 60 жилийн ойн өдрийг угтаж, төв, орон нутгийн удирдах ажилтны зөвлөлгөөн, хууль зүйн албаны ахмад ажилтан нарын уулзалт, радио-теле нэвтрүүлэг, хэвлэлийн бага хурал, онол-практикийн бага хурал зохион байгуулж, сонин, сэтгүүлд нийтлэл хэвлүүлэн, хуулийн хэлтсүүд танилцуулгаа хэвлүүлсэн нь одоо түүх болон үлдэж дээ.

60 жилийнхээ ойн босгонд Шүүх яам шүүхийн удирдах үүргээ халсан, энэ салбарын шинжтэй бус ч гэсэн улсын хэмжээнд нутаг дэвсгэрийн болон салбаруудын хууль зүйн албыг аргачилсан удирдлагаар хангах, эрх зүйн хүмүүжлийн ажлыг зохицуулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, эрх зүйн гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг тэр үедээ өмнө байгаагүй гэж болох чанарын ялгаа бүхий бусад томоохон чиг үүрэг, түүндээ тохирсон систем, бүтэц, орон тоо, ажилтан, бусад хүч бололцоотой, нэр хүнд бүхий алба болоод байлаа. Энэ бүхэн Б.Чимид, Шүүх яамны хамт олны амьдралд тохиосон баярт мөч төдий бус, хууль зүйн албаны үе үеийнхний ажил үйлсийн нэгэн ёсны тайлан, нийтийн үнэлгээ байсан юм.

"Хэдгэнэ шиг хий дүнгэнэн ганц ганцаар дүүлснээс зөгий шиг шаван бужигнаж, зогсоо зайгүй хийж бүтээх нь өөртөө ч, өрөөлд ч өгөөжтэй билээ. Бид тэгж л ажилчин зөгий шиг шургуу чимхлүүр ажиллаж байлаа. Тэгээд ч цөм өөдөлцгөөсөн. Яамны нэр хүнд өсөж, биднээс асуудаг, биднийг оролцуулдаг болсон. Сайд, дарга нар ч төслөө бариад ирдэг, эсвэл урьдаг, зөвлөлддөг, хамтардаг, бас дотночлон дэмждэг болсон. Энэ бол хамт олны маань хичээл зүтгэл, эвсэг ажиллагааны ач буян байлаа. Манай яам шиг шинэхэн, бас залуужсан яам тэр үед байгаагүй. Цөөн ахмад бид залуусаа хэр чадлаараа дэмжиж, эцэг шиг гаднаа хүрлийн дотроо хайрлан шахаж, үр бүтээлийг нь үнэлж, итгэл өгч ажилласан. Тэд мэргэжлээрээ амархан өсөж, өдгөө дөч хүрсэн эр, дөрвөө дарсан ат гэдэг шиг төрийн томчууд, өндөр мэргэжилтэн ах, эгч нар болцгоож. Зарим нь ач зээгээ энхрийлэн хөтөлж явна. Миний насныхан тэднээрээ бахархах эрхтэй... Тэд ч хальж одсон ахмадуудаа дурсах учиртай билээ" гэж буурал сайд дурсан сууна.

Д.Уянга

ЭРХ ЗҮЙН САЛБАРТ ХИЙХ ШИНЭТГЭЛИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХЭД ХҮЧИН ЗҮТГЭСЭН

Хууль зүйн албаны 85 жилийн ойг тохиолдуулан бяцхан тэмдэглэл тэрлүүлэх болсондоо баяртай байна. Энэ цөөхөн хуудсанд тэр бүр олон зүйл бичих боломжгүй учир миний ажиллаж байсан үед хамаарах зарим зүйлийг тоймлон гаргахыг хичээлээ.

Юуны өмнө хууль зүйн алба гэдэг үгийг Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн дараа шинээр томъёолон ойлгох шаардлагатайг хэлмээр байна. Энэ талаар одоохондоо ярьж хөөрсөн хүн миний санахад алга бололтой. Ямарч байсан Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх хүрээний ажил бүхэлдээ хууль зүйн алба биш гэдэг нь тодорхой байх аа. Миний бие 1981 онд Шүүх яамны сайд Б.Чимидийн саналаар Монгол Улсын Их Сургуулийн Нийгмийн ухааны факультетын орлогч декан, Төр эрх зүйн тэнхимийн багшийн ажлаа орхиж тус яаманд Хууль боловсруулах, системчлэх хэлтсийн даргаар ажиллаж эхэлсэн юм. Энэ үеэс төлөвлөлт, аж ахуйн механизмыг боловсронгуй болгох Засгийн газрын бодлогын хүрээнд Сайд нарын Зөвлөлийн болон яам, улсын хороо, тусгай газрын актыг цэгцлэх том ажлыг Шүүх яамнаас эрхлэн хийсэн юм. Энэ нь үндсэндээ Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг батлах үйл явцын угтал, урьдач нөхцөл болсон гэж хэлж болно. Энэ ажлын үр дүн болж хууль тогтоомжийн системчилсэн бүрэн эмхтгэлийг Шүүх яамнаас бэлтгэн гаргасан. Энэ үед буюу 1989 онд Шүүх яамыг Хууль зүй, арбитрын яам болгон өргөтгөн зохион байгуулсан юм. Энэ яаманд газрын даргаар ажиллаж байхдаа нэлээд тооны хуулийн төсөл дээр ажилласан юм. 1981 оноос хойш 10-аад жилд профессор Б.Чимид болон Х.Дамдин, Л.Рэнчин, Б.Жадамбаа,



ХЗҮТ-ийн захирал, гавьяат хуульч, академич Ж.Амарсанаа

О.Жамбалдорж, О.Амархүү, Д.Зундуй нарын арвин баялаг туршлагатай, эрдэм номтой хүмүүстэй ажилласан нь хожим төрд алба хаахад хэрэг болсныг бахархан санаж байна. 1990 онд Д.Бямбасүрэнгийн Засгийн газарт Хууль зүйн сайдаар, 1996 онд М.Энхсайханы Засгийн газарт Хууль зүйн сайдаар тус тус ажиллалаа. Түүнчлэн ажил үүргийн хуваарийн дагуу Шүүхийн ерөнхий зөвлелийн дарга, Өмч хувьчлалын комиссын гишүүн, Банкны өр барагдуулах комиссын дарга зэрэг албан үүргийг хашиж байлаа. Энэ бүх ажлын хүрээнд Хууль зүйн албанд хамаарах зохих ажлыг хийж байлаа.

1989 оноос БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль болон Монгол Улсын Үндсэн хуулийн төслийг боловсруулахад оролцлоо. 1990-ээд оноос зах зээлийн эдийн засгийн харилцааг төлөвшүүлэхэд чиглэсэн түрээсийн гэрээ, аж ахуйн нэгж, монополь, дампуурал, банкны зэрэг хуулийг батлан гаргахад хүчин зүтгэсний зэрэгцээ төрийн байгуулалтын үндсийг төлөвшүүлэх талаар гарсан хуулиудыг боловсруулахад бусадтай хамтран оролцож билээ. Ялангуяа бидний энэ үеийн үйл ажиллагааны нэг гол чиглэл бол эрх зүйн салбарт хийх шинэтгэлийг өрнүүлэх, эрчимжүүлэх явдал байлаа. 1998 онд УИХ-аас Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр батлагдсан явдал нь бид бүхний ажлын нэг үр дүн байсан юм.

Монгол Улсад шүүх эрх мэдлийг төлөвшүүлэх нь Хууль зүйн яамны чухал зорилт байсан юм. Энэ ч зорилго нь 1990-ээд оноос шүүхийн захиргааны үүргийг Хууль зүйн яам, улмаар Шүүхийн ерөнхий зөвлөл хэрэгжүүлэн шүүхийн материаллаг баазыг бэхжүүлэх талаар нэлээд ажил зохиогдсон. Наад зах нь л гэхэд Улсын дээд шүүх, 10-аад аймаг, нийслэл, дүүрэг, өмгөөлөх, нотариат, цагдаагийн зарим байгууллага бие даасан байртай болсон. Сүүлийн 10-аад жилд давхардсан тоогоор 300 орчим шүүгчийг дотоод, гадаадад богино хугацааны сургалтад хамруулсан. Түүнчлэн шүүгч, өмгөөлөгч, нотариатчийг Үндсэн хууль болон бусад хуулийн шаардлагын дагуу бүгдийг дээд боловсролтой болгох зорилтыг хэрэгжүүлсэн. Шүүгчийн үйл ажиллагааны талаар нэлээд журам гаргасны зэрэгцээ шүүгчийн ном зэрэг зарим баримт бичиг, гарын авлагыг төслийн шугамаар бэлдсэн нь шүүгчдэд тус дөхөм болсон нь дамжиггүй. Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагыг ял эдлүүлэх байгууллага, улмаар Шүүхийн шийдвэр биелүүлэх байгуулага болгон өөрчлөн зохион байгуулсан нь шүүх эрх мэдлийн шинэ тогтолцоонд шилжсэний нотолгоо болсон юм. Үүний адил Цагдан сэргийлэх байгууллагыг Цагдаагийн байгууллага болгон

өөрчлөн зохион байгуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тухайлсан хуулийн үндсэн дээр хэрэгжүүлэх болов. Хүний эрхийг хангах эрх зүйн үйлчилгээг иргэдэд ойртуулах шаардлагын үүднээс өмгөөлөх, нотариатын байгууллагыг нэг ёсондоо цоо шинээр зохион байгуулж, үйл ажиллагааг нь зүгшрүүлэхэд чиглэсэн өргөн хүрээтэй арга хэмжээ авсан. Үндсэн хуульд заасан иргэдийн хувийн өмчийн эрхийг баталгаажуулах зорилгоор үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тогтолцоог Монгол Улсад анх удаа бий болгосон. Патент, зохиогчийн эрхийн байгууллагыг бүтцийн хувьд өөрчилж Оюуны өмчийн газрыг байгуулан оюуны өмчийн талаар хэд хэдэн олон улсын гэрээнд нэгдэж орсон. Сүүлийн 10-аад жилд шүүх эрх мэдлийг төлөвшүүлэх, хүний эрхийг хангах, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, хуульчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр НҮБ, Дэлхийн банк, Ханнс-Зайделийн сан, Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг, Азийн сан, Азийн хөгжлийн банк, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн шугамаар томоохон төслүүд амжилттай хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж байна. НАХЯ-ны бүрэлдэхүүнд байсан Улсын архивын албыг хүн амд ил тод, нээлттэй, ойр дөт байлгах зорилгоор Үндэсний архивын газар болгон өөрчлөн зохион байгуулж, шинэ байртай болгож, бие даасан хуулийг нь УИХ-аас батлуулж өгсөн. Мөн Гал түймэртэй тэмцэх албыг Цагдаагийн байгууллагын бүтцээс гаргаж, үйл ажиллагааны хуулийн үндсийг нь тогтоож өгсөн. Дээр дурдсан бүх ажил нь хууль зүйн албаны байгууллагад миний ажиллаж байсан үед болсон гэдгийг онцлон хэлж байна. Өөрөөр хэлбэл энэ бүхнийг би гардан хийсэн гэдэг утгаар биш, дээрх том зорилтууд хэрэгжиж байх үед би ажиллаж байсан, зарим талаар оролцож байсан тухайн үеийн гэрч гэдгийг хэлэх гэсэн юм.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

Хууль зүйн салбарын шинэ гавьяат



Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн болон төрийн бус байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажилласан хүмүүсийг 11 дүгээр сарын 24-ний өдөр улсын цол, одон медалиар шагнасныг гардууллаа.

Эдгээрээс хууль зүйн салбарт Хууль зүйн үндэсний төвийн захирал, академич Ж.Амарсанаад Монгол Улсын гавьяат хуульч цолоор, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн хэлтсийн дарга Л.Гаваасүрэн, ШШГЕГ-ын тасгийн дарга, хурандаа Р.Нацагдорж, тус газрын тасгийн дарга, хурандаа Х.Оюунгэрэл нарыг Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор, ШШГЕГ-ын дарга, хурандаа Д.Батжаргал, ШШГЕГ-ын Гадна хамгаалалтын албаны дарга, хурандаа Д.Ганбат, Улсын мөрдөн байцаах газрын мөрдөн байцаагч, цагдаагийн хурандаа Н.Зоригт нарыг Цэргийн гавьяаны одонгоор, Хөдөлмөрийн хүндэт медалиар Цагдан хорих 461 дүгээр ангийн Ерөнхий эмч Д.Хишигдолгор, Цэргийн хүндэт медалиар Хан-Уул дүүргийн замын цагдаагийн тасгийн зохицуулагч цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Д.Баатарсүрэн, ШШГЕГ-ын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Я.Гаанжуур зэрэг хүмүүсийг шагнасан байна.

Д.Уянга

Д.Тогтохжаргал:

Улаанбаатар хотод 10 гаруйхан өмгөөлөгч байлаа



- Юуны өмнө Та хууль зүйн салбарт хөл тавьсан үеэсээ дурсвал...?

- 1959 онд болсон орон нутгийн сонгуулиар сумын депутат болж улмаар сумын АДХ-ын гүйцэтгэх захиргааны нарийн бичгийн даргаар сонгогдсон үеэс л хуульч болох зам минь эхэлсэн гэж хэлж болно. Сумын нарийн бичгийн даргын оролцохгүй ажил гэж бараг байдаггүй, иргэний, цэргийн хоёр талын ажил эрхэлдэг тухайлбал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх, гэр бүл, нотариатын ажлыг хийж гүйцэтгэдэг байлаа. Тийм ч учраас хууль тогтоомжийг уншиж, судлаж мэдэх явдал энэ тэргүүнд шаардагдаж, Үндсэн хууль, бусад дүрэм журмыг өөрийн хэмжээ, боломжийн дагуу уншиж, тэмдэглэл хөтөлдөг байлаа. Энэ маань дараа хууль цаазны дунд сургуульд элсэн суралцахад их хэрэг болсон.

Хууль цаазны дунд сургуулиа төгсөөд Улсын дээд шүүхэд хуваарилагдан ажиллаж байгаад өөрийн хүсэлтээр өмгөөлөгч боллоо. Ажиллахын хажуугаар МУИС-ийн хууль зүйн ангид оройгоор суралцаж 1972 онд төгссөн. Өмгөөлөх коллегийн даргаар жил шахам ажилласаны дараа Шүүх яамыг дахин байгуулахад тус яамны Эрхийн үйлчилгээ, өмгөөллийн хэлтэст ахлах мэргэжилтнээр томилогдон ажилласан. 1974 оны 10 дугаар сард яамны дотоод бүтцэд өөрчлөлт, сэлгээ хийж манай хэлтсийн дарга Д.Сэвжиддоржийг Хууль боловсруулах, системчлэх хэлтсийн даргаар, намайг Эрхийн үйлчилгээ, өмгөөллийн хэлтсийн даргаар томилож, энэ хэлтсийн маань нэр хэд хэд өөрчлөгдсөн боловч уг хэлтсийнхээ даргын албыг 1990 он хүртэл 16 жил тасралтгүй хашсан. Одоо Чингэлтэй дүүргийн Ахмадын хорооны даргын ажлыг хашиж байна.

- Та Хууль зүйн албанд 40 гаран жил зүтгэсэн ахмад хуульчийн хувьд энэ албаны үүсэл, хөгжлийн талаар хуучилах зүйл их байгаа байх?

- Хууль зүйн албаны үүсэл гэвэл 1921 онд Ардын хувьсгал ялсны дараа ардын засгийн газарт 5 яам байгуулагдсны нэг нь шүүх яам байсан бөгөөд тус яам хууль зүйн албаны эхний үүргийг гүйцэтгэж байсны дотор тус яаманд шүүх, прокурор, хорих, цагдаагийн байгууллагууд харьяалагдаж байсан.

Шүүх яамны нэг томоохон үүрэг бол хууль тогтоомжийг боловсронгуй болгох, түүнийг улс, орон нутгийн байгууллагад хэрэгжүүлэх, суртал нэвтрүүлэг хийх, хуулиа сурталчилах үүргийг гүйцэтгэж байсан.

1959 онд шүүх яамыг татаж буулгаж, Сайд нарын зөвлөлд хууль цаазны хороо байгуулсан. Хууль цаазны хороо байгуулснаар шүүх яамны үүргийг 2 хэсэгт хувааж, хуулийг боловсронгуй болгох, хууль сурталчлах албыг хууль цаазны хороонд харьяалуулж, нотариат, өмгөөлөх албыг дээд шүүхэд үлдээжээ. 1960 оны шинэ Үндсэн хууль батлагдаж, улс ардын аж ахуйд холбоотой олон хуулиуд батлагдан мөрдөгдөж, төлөвлөлт эдийн засгийн шинэ шинэ системд нэвтэрч эхэлсэнтэй холбогдон хууль зүйн албаны шинэ систем шаардлагатай болж байгааг эрдэмтэд, практикийн ажилтнууд ярих болов. Улс орон даяар шинэчлэл өөрчлөлт бий болж, 1970-аад оны эхээр улс ардын аж ахуйн хууль зүйн алба гэдэг шинэ систем байгуулах хэрэгтэй юм гэж үзсэн.

Тэр үед миний бие өмгөөлөх байгууллагад ажиллаж байсан учир өмгөөлөгчдийн эрхэлж байсан ажлын нэгэн хэсэг нь үйлдвэр, албан газар, байгууллагад хууль зүйн зөвлөгөө өгөх ажил байсан болохоор бидний анхаарлыг ихэд татаж байлаа.

1970 оны сүүлээр гэнэтхэн хуулийн байгууллагын нэгдсэн цуглааныг дээд шүүх дээр зохион байгуулж, намын төв хорооны захиргааны хэлтсийн дарга байсан генерал Батаа, Улсын дээд шүүхийн дарга, улсын прокурор, хууль цаазны дарга байсан Хорхой нар цуглан Монгол Улсад улс ардын аж ахуйн хууль зүйн алба гэж байгуулах болсон тухай мэдэгдсэн, ингэж л хууль зүйн алба улс ардын аж ахуйд систем болон байгуулагдсан юм.

Хууль зүйн албаны шинэ систем нь байгуулагдахдаа 2 үндсэн чиглэлээр, тухайлбал, яам тусгай газруудад салбарын удирдлагын хэлбэрээр хуулийн хэлтэс, тасгууд, аймаг, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны байгууллагад хуулийн хэлтсүүд байгуулагдав. Энэ албаны гол үүрэг нь хууль тогтоомжийг боловсронгуй болгох, системчлэх, иргэдэд сурталчлах таниулах, хөдөлмөрчдын эрх зүйн хүмүүжлийн ажлыг шинэ шатанд гаргах зэрэг байсны дотор эрх зүйн сургалт, суртал нэвтрүүлгийн ажил шинэ арга хэлбэрээр зохион байгуулагдан хэрэгжиж эхэлсэн билээ. Эрх зүйн сургалт гэдэг маань шинэ хуулиараа янз бүрийн мэргэжил, албаны

хүмүүст хууль зүйн мэдлэг олгох сургалтыг ардын их сургуулийн хэлбэрээр зохион байгуулж байсан. Зарим нь энэ үед нам, эвлэлийн улс төрийн сургуулиудаар сургалтын хэлбэрээр явагдаж байлаа. Мөн ерөнхий боловсролын сургууль д энэ чиглэлээр хичээл ч орж байсан. Иргэдийн дунд хөдөлмөрчдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх ардын их сургууль байгуулагдаж ажиллаж байсан.

- Тэр үед хамтран зүтгэж байсан хүмүүсээ дурсаач...?

- Улс ардын аж ахуйд хууль зүйн алба байгуулах ажлыг эхэн үедээ эрхлэж байсан хэлтэс голлон эрхэлж байсан юм. Энэ хэлтэст маань Б.Цэвээн, О.Огнон, Р.Жамьянчойжил, Б.Бадамханд, Р.Гүнжилдорж, Т.Сэнгэдорж, Д.Мөнхтуяа, Д.Завуд, Ц.Барадий, Б.Цэрэнпүрэв гээд боловсролтой, ажилсаг олон залуус дараалан ажиллаж байлаа. Манай хэлтсийн



хууль зүйн алба эрхэлсэн мэргэжилтэн Баатарын Цэвээн хууль зүйн албаны анхан шатны боловсруулалтын ажлыг эрхэлж, хууль зүйн албаны асуудлыг судалж боловсруулах, түүний тогтолцоо, үүрэг хариуцлагыг зөв тодорхойлох талаар их үүрэг гүйцэтгэсэн. Б.Цэвээн маань одоо ч яамандаа ажиллаж байна. Ер нь хууль зүйн алба нь эдийн засгийн албыг хөгжүүлэх тал дээр уялдаж гарч ирсэн. Тухайн үед улс ардын аж ахуйд төлөвлөлт, урамшууллын систем гэж нэвтэрч байсан. Энэ системийн эрх зүйн орчинг бүрдүүлэх, тухайлбал, аж ахуйн үйл ажиллагааг боловсронгуй болгох асуудлыг хууль зүйн алба голлон гүйцэтгэж байсан. Ялангуяа, сахилга дэг журмыг бэхжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль ёсыг иргэд, албан байгууллагад мөрдүүлэх, сахиулах, нэг журамд оруулж, боловсронгуй болгох ажлыг эрхлэж байлаа.

Хууль зүйн албыг байгуулж, хууль зүйн албаны үүрэг, зорилгыг олон нийтэд таниулах сургалт, семинар явуулж байсан. Хамгийн анхны сургалтад оролцож байсан хүмүүсийн зураг энд байна. Одоо харахад томоохон алба хашиж байсан хүмүүс энэ сургалтад хамрагдаж байсан байна. Жишээлбэл, Сэлэнгэ аймгийн хуулийн хэлтсийн дарга Д.Сугар, одоо Төрийн өмчийн хорооны даргын алба хашиж байна. Увс аймгийн хуулийн хэлтсийн дарга байсан Ө.Аюурзана, одоо Ерөнхийлөгчийн Тамгын газарт ажиллаж байна. Завхан аймгийн хуулийн хэлтсийн дарга байсан Загдаа ШШГЕГ-т хэлтсийн дарга, хурандаа цолтой, Төв аймгийн хуулийн хэлтсийн дарга байсан А.Доржготов УДШ-д шүүгчээр тус тус ажиллаж байна. Яам, тусгай газарт байгуулагдсан хуулийн хэлтэст ажиллах хуулийн мэргэжлийн, хууль зүйн албаны ажлыг мэддэг боловсон хүчин олон байгаагүй. Тийм учраас энэ ажлыг удирдаад явуулах хэлтсийн дарга нарыг Шүүх яамны удирдлагаас зохих газруудад санал болгосноор газар газар томилж байсан. Жишээ нь, гэхэд ХЗЯ-нд ажиллаж байсан хэлтсийн дарга Д.Минжүүрийг Худалдаа бэлтгэлийн яамны хууль зүйн хэлтсийн даргаар, хууль зүйн дээд боловсролтой Н.Лувсанжавыг Ардын хяналтын хорооны хууль зүйн хэлтсийн даргаар (одоо УИХ-ын Тамгын газрын дарга байгаа) томилж байсан.

Хууль зүйн албаны асуудлыг эхлэн боловсруулах ажлыг шинээр байгуулагдсан Шүүх яамны сайд



Донойн Пүрэв удирдан зохион байгуулж байсан бөгөөд Д.Пүрэв сайдыг элчингээр явсаны дараа Улсын их сургуулийн багш Бяраагийн Чимид сайдаар томилогдон ирж, энэ албыг жинхэнэ ёсоор байгуулах, яамыг өөд нь татах гол ажлыг хийсэн дээ. Бид, манай эрдэмтэд тэгэхэд хууль зүйн албыг байгуулахад олон талын судалгаа, гадаад орнуудын туршлагыг сонин хэвлэл, газар дээрээс судалж, манай улс ардын аж ахуйд хэрхэн буух вэ гэдэг дээр дүн шинжилгээ хийх хэрэгтэй байсан. Энэ бүгдийг нэгтгээд намын төв хороо, сайд нарын зөвлөлийн тогтоолын төсөл боловсруулах асуудлыг ХЗЯ дээр боловсруулж байсан. Энэ бүх ажлыг тэр үед сайд байсан одоо Монгол Улсын гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид гуай удирдаж байсан юм. Б.Чимид багш өөрийн уйгагүй шаргуу хөдөлмөр, их зүтгэл, мэдлэг, дадлагатай хүн учраас хууль зүйн албыг зөв чиглүүлж, үндсийг нь зөв тавьсан билээ.

Миний бие одоо эргэж бодоход энэ албыг манай томоохон нэртэй хүмүүс босгожээ хэмээн бахархаж байдаг аа. Тухайлбал, Хууль боловсруулах, системчлэх хэлтсийн даргаар эдүгээ академич Ж.Амарсанаа, Гэр бүл, нотариатын

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nji.gov.mn

хэлтсийн дарга байгаад дараа нь орлогч сайд гавьяат хуульч Хорлоогийн Дамдин мөн хууль зүйн яамны 1 дүгээр орлогч сайд асан гавьяат хуульч Осорын Амархүү, Л.Рэнчин, Шүүх яам байгуулагдахад хэлтсийн дарга байгаад орлогч сайд, 1 дүгээр орлогч сайд, жинхэнэ сайдаар ажиллаж байсан хууль зүйн ухааны доктор, профессор О.Жамбалдорж одоо Их засаг их сургуульд багшилж байгаа. Доктор, профессор Т.Сэнгэдорж нарын олон хүнийг нэрлэн хэлж болох юм. Би хууль зүйн албанд болон өмгөөлөгчдийн байгууллагад олон сайхан нөхдийн хамт, тэднээсээ сурч, бас тэднийхээ зорилгыг удирдсан болож ажилласан тухайгаа хууль зүйн албаны 80 жилийн ойд зориулан гаргасан "Дурдатгал, дурсамж, танилцуулга" болон Өмгөөлөх байгууллагын 75 жилийн ойд зориулан гаргасан "Үе үеийн өмгөөлөгчид" номд дурсан бичсэн бий. Одоо би өөрийнхөө амьдралыг эргэн дурсаж "Миний туулсан амьдрал" хэмээх ном бичин хэвлүүлж байгаа бөгөөд түүндээ ч бас дурсан бичсэн.

- Таныг ахмад өмгөөлөгчийн хувьд өмгөөлөгчийн холбооны үүсэл хөгжил, хууль зүйн албанд өмгөөллийн байгууллагын эзлэх байр суурийн талаар тодруулах гэсэн юм?

- Өмгөөллийн байгууллага нь 1928 онд байгуулагдсан, хууль зүйн ахмад байгууллагын нэг шүү дээ. Өмгөөлөгчид бол хоёр үндсэн ажилтай хүмүүс байсан одоо ч тийм л байгаа. Нэг нь эрүү, иргэний хэрэгт өмгөөлөгчөөр оролцоно. Нөгөө нь үйлдвэр, албан байгууллагад хуулийн зөвлөхөөр ажиллана. Манай улсад 1962 онд хуулийн зөвлөх гэрээгээр авч ажиллуулсан анхны байгууллага бол улсын банк, одоогийн Монгол банк байлаа. Дараа нь Геологийн удирдах газар, үйлдвэр хоршооллын болон худалдааны байгууллагууд байсан юм. 1964, 1965 онд энэ ажил өргөжин хөгжиж, хөдөө, орон нутаг аймгуудад хуулийн зөвлөх гэрээгээр авч ажиллуулж эхэлсэн. Ялангуяа үйлдвэр худалдаа, тээврийн байгууллагууд хуулийн зөвлөх олноор авч ажиллуулж байсан.

Хууль зүйн алба үүсэж байгуулагдахад өмгөөлөгч гол фронтын дайчид байсан. Их ч ажил гүйцэтгэсэн дээ.

- Өмгөөллийн байгууллагад анх хэдэн өмгөөлөгчидтэй байв?

Хотод 10 гаруй хүн байсан. Хөдөө, орон нутагт хууль зүйн зөвлөгөө өгөх газарт эхэндээ 1 хүн, дараагаар нь 2-3 хүн ажиллаж байсан. Одоо ч өмгөөлөгчид олон болж улсын хэмжээгээр 1100 гаруй өмгөөлөгч ажиллаж байгаа гэсэн.

- Анх хуульчдыг хэрхэн бэлтгэж байсан бэ? Шүүгч, өмгөөлөгч, прокурорыг хэрхэн сонгон шалгаруулж ажиллуулж байсан бол...?

- Эхэн үедээ манай хуульчид эрүү, иргэний хуулиар голлон мэргэшиж, төгсч ирдэг, тэр чиглэлээр ажилладаг байлаа. 1970-аад онд МУИС-ийн хууль зүйн сургуульд анх аж ахуйн хуульчдын ангийг нээж, жинхэнэ улс ардын аж ахуй дахь хууль зүйн албанд ажиллах мэргэшсэн хуульчдийг бэлтгэж эхэлсэн. Тэд нар маань ч үйлдвэр, аж ахуйн нэгжид хуулийн зөвлөхөөр ажиллаж, хууль зүйн албыг амьдралд хэрэгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан билээ. Мөн хууль зүйн дунд сургуульд ч аж ахуйн хуульчдыг бэлтгэж байсан. Хуучнаар ЗХУ-д суралцаж байсан.

Шүүгч, прокурор, өмгөөлөгч нарыг сонгон шалгаруулах ажил 1990-ээд оны сүүлчээс эхэлсэн байх. Бидний үед хууль зүйн дээд, дунд боловсролтой, түүнчлэн дээд боловсрол, мэргэжилгүй ч гэсэн зохих дадлага туршлагатай хүмүүсийг шүүгч, прокуророор ажиллуулж байсан. Өмгөөлөгчийн хувьд хууль хууль зүйн дунд сургуулийг төгсөөд өмгөөлөгчөөр ажиллаж байсан үе ч бий дээ.

- Хууль зүйн алба одоо 85 жилийн түүхтэй. Хөгжлийнхээ ямар түвшинд явж байна гэж боддог вэ?

- Өөрийн хувийн бодлоо хэлэхэд хууль зүйн алба их хөгжиж ээ. Ялангуяа, бизнесийн салбарт чухал үүргэтэй алба шүү дээ. Тухайлбал, гэрээ хэлцлийг хууль тогтоомжийн дагуу хийж боловсруулах, түүнийг мөрдөх, аж ахуйн үйл ажиллагааг хуулийн дагуу гүйцэтгэх, байгаль, экологитой холбогдох асуудалд ч хууль зүйн алба чухал үүрэг гүйцэтгэж байна. Гэхдээ сэтгэл дундуур зүйл ч их байна. Олон олон хууль батлагдан гарсан хэдий ч хуулийг мэддэг, хэрэгжүүлдэг байгууллага, ажилтан, иргэд цөөн байна. Байгууллага, аж ахуйн нэгжид бие даасан хуулийн хэлтэс байгуулан ажиллуулвал их үр дүнтэй байх болов уу гэж боддог. Мөн хууль тогтоомжийг сурталчлах, таниулах ажил муу хийгдэж байх шиг боддог. Хууль тогтоомжийг сурталчлахдаа сургалтын замаар, хэвлэл мэдээллээр гээд олон арга замаар иргэдэд хүргэх, мэдээлэх, таниулах хэрэгтэй. Тэгж мэдүүлж, таниулсны дараа хэрэгжүүлэхийг шаардаж болно. Ер нь хууль баталдаг, хэрэгжүүлдэг субъектууд л хуулийг мэдэж байгаагаас биш жинхэнэ амьдрал дээр хуулийг мэддэг, хэрэглэдэг үйл ажиллагаа тун ховор байх шиг санагддаг.

Хууль зүйн албатай хамт явдаг алба бол гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэгч байгууллага юм. Манайхан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хуулийн байгууллагуудын хүрээнд, цагдаа, хүчний байгууллагын хийх ажил мэтээр өрөөсгөл ойлгодог бололтой. Амьдрал дээр ажиглаж байхад хэлбэржсэн ажлууд голыг нь эзлээд байхаас биш жинхэнэ тэмцэл, хүн бүхний ажил амьдралтай холбосон зүйл ховор байна. 1970-1980-аад онд ураг төрлийн дунд гэмт хэрэг гарах явдлаас сэргийлэх ажил явдаг байсан. Энэ ажил бүр орхигдсон.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл одоо ХЗДХЯ-нд харьяалагдан ажиллаж байна. Энэ алба зөвхөн хууль зүйн яаманд төвлөрөх биш, улс орны хэмжээнд үйл ажиллагаагаа өргөн далайцтай , хүчтэй явуулдаг, удирдлагын дээд төвшингөөс, яам, агентлаг орон нутагт хүрч ажиллах хэмжээнд байхаар шинэ шатанд гаргаж тавиасай гэж хүсч байдаг юм.

Ярилцсан: Ц.Ариунжаргал



Армен Улсын Үндсэн хуулийн шүүхийн онцлог

Үндсэн хуулийн шүүхийг байгуулах дэг журам

Армены Үндсэн хуулийн шүүх нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн нэгэн адил 9 гишүүнээс бүрдэх бөгөөд тэдгээрийн тавыг Үндэсний хуралдаанаас, дөрвийг ерөнхийлөгчөөс тус тус санал болгож, улмаар Үндэсний хуралдаанаар томилдог. Нийт гишүүдийн 50 хувь буюу түүнээс дээш тооны бүрэлдэхүүн томилогдсон тохиолдолд Үндсэн хуулийн шүүхийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж, тус шүүхийг эмхлэн байгуулагдсанд тооцдог байна.

Үндсэн хуулийн шүүхийн гишүүн, түүнд тавих шаардлага

Армены Үндсэн хуулийн шүүх /цаашид ҮХШ гэх/-ийн гишүүн нь хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, төрийн болон эрдэм шинжилгээний байгууллагад ажиллах хугацаандаа ажлын дадлага туршлага хуримтлуулсан, ёс суртахууны өндөр соёлтой, армен хэлтэй, 35 нас хүрсэн Армен улсын иргэн байна. ҮХШ-ийн гишүүн нь өөрийн бүрэн эрхийн хугацаанд эрдэм шинжилгээ, сургалт, судалгаа, сурган хүмүүжүүлэх ажлаас бусад ямар нэгэн албан тушаалыг давхар эрхлэхийг хориглоно. Мөн тэрбээр ҮХШ-ийн гишүүнээр томилогдсоны дараа улс төрийн аль нэг нам, эвслийн гишүүн бол түүнээсээ түдгэлзэж өөрийн бүрэн эрхийн хугацаанд улс төрийн аливаа үйл ажиллагаа эрхлэх, түүнд ямар нэг хэлбэрээр оролцохыг хориглоно.

ҮХШ-ийн гишүүн нь албан тушаалдаа томилогдмогцоо Үндэсний хуралдаан дээр тангараг өргөдөг бөгөөд уг тангараг өргөх ёслолын ажиллагаанд БНУлсын ерөнхийлөгч уригдан оролцдог байна.

ҮХШ-ийн гишүүд маргаан хянан



Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын ажилтан Э.Лхагвасүрэн

шийдвэрлэх ажиллагаанд адил тэгш эрхтэй оролцохоос гадна хэнээс ч хараат бус байж, зөвхөн Үндсэн хуульд захирагдана. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ҮХШ-ийн гишүүдэд хөндлөнгөөс ямар нэг байдлаар нөлөөлөхийг хуулиар хориглодог.

ҮХШ-ийн гишүүн нь 70 нас хүртлээ өөрийн албан үүргээ хэрэгжүүлэх боломжтой бөгөөд түүний бүрэн эрхийг гагцхүү хуульд заасны дагуу зогсооно.

ҮХШ-ийн гишүүнийг ҮХШ-ийн зөвшөөрөлгүйгээр нэгжих, албадан саатуулах, баривчлах, эд зүйлийг нь хураан авахыг хориглоно. Мөн ҮХШ-ийн гишүүнийг эрүүгийн хариуцлагад татах /гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт үйлдлийн нотлох баримт хангалттай байгаагаас бусад/ тохиолдолд түүнийг томилсон байгууллагын зөвшөөрлийг авах ёстой. ҮХШ-ийн гишүүнийг баривчлах, мөрдөн мөшгих тохиолдолд энэ тухай холбогдох байгууллага болон ҮХШ-ийн даргад нэн даруй мэдэгдэнэ.

ҮХШ-ийн гишүүнийг зөвхөн Армены Ерөнхий прокурорын зөвшөөрлөөр баривчлах буюу цагдан хорьдог.

ҮХШ-ийн дарга, түүний орлогч, эрх хэмжээ

ҮХШ-ийн үйл ажиллагааг ҮХШ-ийн дарга зохион байгуулж удирдах бөгөөд түүний эзгүйд орлогч, орлогчийн эзгүйд ҮХШ-ийн даргын тушаалаар томилогдсон аль нэг гишүүн хэрэгжүүлнэ. ҮХШ-ийн дарга нь:

- ҮХШ-ийн үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангах;
- Хуралдааны бүрэлдэхүүнийг томилох;
- ҮХШ-ийн гишүүд, ажилтнуудын ажил, үүргийг хуваарилах, үүрэг даалгавар өгөх, биелэлтэд хяналт тавих;
- Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хуралдаан товлох, хуралдаан даргалах, хэлэлцэх асуудлыг танилцуулах, оролцогчдод дэг журмыг сануулах зэрэг процессийн эрхийг хэрэгжүүлнэ;
- Удирдлагын хүрээнд ҮХШ-ийг төлөөлөн бусад байгууллага, албан тушаалтантай харилцах;
- Хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

ҮХШ-ийн бүрэн эрх, үйл ажиллагааны үндсэн зарчим

Одоо мөрдөж байгаа Үндсэн хуульд заасны дагуу ҮХШ дараах бүрэн эрхийг эдэлнэ. Үүнд:

1. Хууль тогтоомж, Үндэсний хурлын тогтоол, заавар, түүнчлэн Ерөнхийлөгчийн захирамж Үндсэн хууль зөрчсөн эсэх;
2. Олон Улсын гэрээг батлагдахаас өмнө Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэх;
3. Ерөнхийлөгч болон Үндэсний хуралдааны гишүүдийг сонгох бүх нийтийн санал хураалтын үр дүнтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх;

4. Ерөнхийлөгчийг албан тушаалаас огцруулах үндэслэлийн талаар дүгнэлт гаргах;
5. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг биелүүлэх боломжтой эсэх талаар дүгнэлт гаргах;
6. ҮХШ-ийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, түүнийг эрүүгийн хариуцлагад татах эсэх талаар дүгнэлт гаргаж "тогтоол гаргах";
7. Хуульд заасны дагуу улс төрийн намын үйл ажиллагааг зогсоох эсэх талаар шийдвэр гаргах.

Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны үндсэн зарчим нь бие даасан, ил тод, тасралтгүй, эрх тэгш, асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэх зарчмууд юм.

ҮХШ-ийн материаллаг хангамж, баталгаа

Үндсэн хуулийн шүүх нь улсын төсвөөс санхүүжих бөгөөд Засгийн газар ҮХШ-ийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор тусгай байр болон шаардагдах бусад хангамжийг бүрдүүлэх үүрэгтэй.

ҮХШ-д хандах эрх бүхий субъект

1. Ерөнхийлөгч;
2. Үндэсний хурал /нийт депутатуудын 15-аас багагүй гишүүд/;
3. Ерөнхийлөгчид нэр дэвшигчид болон Үндэсний хуралдааны гишүүнд нэр дэвшигч тухайн сонгуулийн үр дүнтэй холбоотой асуудлаар;
4. Засгийн газар;
5. Иргэд.

Өргөдлийг урьдчилан авч хэлэлцэх

ҮХШ-ээр хэлэлцэх өргөдлийг Нарийн бичгийн дарга бүртгэж авсаны дараа ҮХШ-ийн даргад танилцуулна. ҮХШ-ийн дарга тухайн өргөдлийг шалгах гишүүнд хуваарилах бөгөөд өргөдөлд тусгагдсан асуудал буюу өргөдлийн шаардлага нь ҮХШ-д илтэд харьяалагдахгүй бол буцаана.

ҮХШ-ийн гишүүн ийнхүү илтэд харьяалагдахгүй байх үндэслэл тогтоогдохгүй бол өргөдлийг урьдчилан хянан шалгасны дараа ҮХШ-ийн даргад танилцуулна. ҮХШ-ийн дарга тухайн маргааныг хянан шийдвэрлэх хуралдааны тов болон бүрэлдэхүүнийг тогтооно.

Хэрвээ өргөдөлд тусгагдсан асуудал нь ҮХШ-ийн харьяаллын маргаан биш, түүнчлэн өргөдөл гаргагч нь ҮХШ-д хандах эрхгүй бол хэргийг хянан шийдвэрлэхээс татгалзана. Мөн өргөдөл гаргагч маргааныг ҮХШ-ийн хуралдаанаар авч хэлэлцэхээс өмнөх аль ч шатанд өргөдлийн шаардлагаасаа татгалзах эрхтэй.

ҮХШ-ийн хэрэг хянан шийдвэрлэх ерөнхий дэг журам

ҮХШ маргааныг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэх бөгөөд хуралдаанд ҮХШ-ийн олонхи гишүүд оролцвол маргааныг шийдвэрлэх бүрэлдэхүүнтэйд тооцно. ҮХШ-ийн хуралдааныг ҮХШ-ийн дарга эсхүл түүний даалгасан гишүүн удирдан явуулна. Маргааныг урьдчилан шалгасан гишүүн маргааны талаар дэлгэрэнгүй илтгэл тавина.

ҮХШ-ийн гишүүд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хуралдаанд авч хэлэлцэж буй маргаантай холбогдолтой цугларсан баримт сэлтгэн танилцах, хэлэлцэж буй асуудлаар асуулт тавих тайлбар авах зэрэг эрхтэйгээс гадна хуралдааны бэлтгэл ажиллагааны талаар ҮХШ-ийн даргын өгсөн үүргийг биелүүлэх, хуралдаан болон санал асуултад оролцох, хаалттай хуралдаанаар хэлэлцсэн болон зөвлөлдөх тасалгааны санал хураалтын нууцыг чандлан сахих, өргөсөн тангарагтаа үнэнч байх зэрэг үүрэгтэй.

Шүүхэд төлөөлөх эрх, процессийн эрх, үүрэг

Талууд Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд биечлэн эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөө томилох байдлаар оролцоно. Маргааны талууд хэргийн материалтай танилцах, шаардлагатай бол тэмдэглэл хийх, нэмэлт нотлох баримт гаргаж өгөх, маргааны талаар өөрийн байр сууриа илэрхийлэх, шүүх бүрэлдэхүүнээс татгалзах, өргөдлийн шаардлагаасаа татгалзах, нэхэмжлэгч хариуцагчид асуулт тавих, хариулт авах зэрэг процессийн эрхтэй.

Мөн талууд ҮХШ-ийн дуудсанаар хүрэлцэн ирэх, хариу тайлбар өгөх, асуултад хариу өгөх, шүүхэд хуурамч нотлох баримт гаргахгүй байх, ҮХШ-д хэрэг хянан шийдвэрлэх дэг журамд захирагдах үүрэгтэй.

Маргаан хянан шийдвэрлэх хуралдааны дэг

Хуралдаан даргалагч шүүх хуралдаан нээснийг мэдэгдэж, хянан шийдэх маргааны гол агуулгыг танилцуулж, оролцогч талууд болон сонирхогч этгээдэд тэдгээрийн эрх, үүргийг тайлбарлана. Илтгэгч гишүүн илтгэл тавьсны дараа ҮХШ-ийн гишүүд илтгэгч болон талуудад асуулт тавина. Хуралдаан даргалагч талуудад хянан шийдвэрлэж буй хэргийн талаар тайлбар өгөх баримт нотлогоо гаргахыг санал болгоно. ҮХШ талуудын тайлбарыг бүхэлд нь сонсоно. Талуудын тайлбарын дараа тэдгээрт ҮХШ-ийн гишүүд асуулт тавьж болно.

Мэтгэлцээний шат явагдаж улмаар ҮХШ-ийн гишүүд зөвлөлдөх тасалгаанд маргааны талаархи өөрийн санал бодол, нотлох баримтад үнэлэлт өгч үүнтэй холбоотой шийдвэр гаргана.

ҮХШ-ийн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг ҮХШ-ийн нарийн бичгийн дарга хөтөлнө. Тэмдэглэлд хуралдаан даргалагч, хуралдааны нарийн бичгийн дарга гарын үсгээ зурна. Талууд хуралдааны тэмдэглэлтэй танилцан өөрсдийн санал бодлыг илэрхийлж тэмдэглэлд хавсаргах эрхтэй.

Шинжээчийн дүгнэлт, түүний эрх, үүрэг

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч нэг чухал субъект нь шинжээч байдаг. ҮХШ-д шинжээчээр оролцож буй этгээд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар зохих мэдлэгтэй, тусгай мэргэшлийн хүн байх ёстой. Шинжээч шүүх хуралдаанд дүгнэлт гаргахын өмнө ҮХШ-ийн дарга түүнд дүгнэлтийг илт хууль бус гаргах, дүгнэлт гаргахаас санаатайгаар

зайлсхийсэн зэрэг тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар урьдчилан сануулна. Шинжээчийн дүгнэлтийг зөвхөн бичгэн хэлбэрээр гаргана.

Шинжээч маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах эрхтэй. Тухайлбал, ҮХШ-ийн зөвшөөрөлтэйгөөр хэргийн материалтай танилцах, ҮХШ-ийн зөвшөөрөлтэйгөөр талуудад болон гэрчүүдэд асуулт тавих, мэргэжлийн бус асуудлаар дүгнэлт гаргахаас татгалзах гэх мэт. Шинжээч гаргасан дүгнэлттэйгээ холбоотой асуудлаар шүүх бүрэлдэхүүн болон оролцогч талуудын тавьсан асуултад хариулах үүрэгтэй.

Хэргийг хэрэгсэхгүй болгох

ҮХШ-д маргаантай байгаа акт, тэдгээрийн холбогдох зүйл, заалт нь хуралдаанд бэлтгэх шатанд буюу хуралдааны явцад маргаан хянан шийдвэрлэгдэхээс өмнө хүчингүй болох, эсхүл холбогдох нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд тухайн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгсэхгүй болгоно.

ҮХШ-ээр хэрэг хянан шийдвэрлэх зарим онцлог

1. Хууль тогтоомж, Үндэсний хуралдааны тогтоол, Ерөнхийлөгчийн захирамж зааврууд, Засгийн газрын шийдвэр зэрэг ҮХШ-ийн хянан хэлэлцэх маргаантай холбогдсон асуудлаар ҮХШ-д Ерөнхийлөгч, Үндэсний хурлын гишүүдийн 1/3-ээс багагүй тооны гишүүд хандаж болно.

ҮХШ өргөдөлд дурдсан асуудалтай холбоотойгоор түүнд тусгасан эрх зүйн актын болон эсвэл зөрчигдсөн гэж үзэж буй Үндсэн хуулийн зүйл, заалтыг тэдгээрийн нийцлийг дараах үндэслэлийг баримталж тайлбарлана.

- эрх зүйн актын хэм хэмжээний асуудлыг;
- эрх зүйн актын хэлбэрийг;
- эрх зүйн актыг баталсан болон түүнд гарын үсэг зурж баталгаажуулан хүчин төгөлдөр болсон хугацааг;
- Үндсэн хуульд заагдсан иргэдийн эрх, эрх чөлөөг чөлөөтэй хэрэгжүүлэх боломж, тэдгээрийн хэмжээ хязгаарыг;
- төрийн байгууллага тэдгээрийн албан хаагчийн бүрэн эрхийн хэм хэмжээг;
- Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалттай хэрхэн зөрчилдөж байгаа эсэхийг харгалзан үзнэ.

2. ҮХШ-д олон улсын гэрээ, хэлэлцээрийг Үндэсний хурлаар хэлэлцэж соёрхон батлахаас өмнө тухайн гэрээ Үндсэн хуульд нийцсэн эсэх талаар Ерөнхийлөгч ҮХШ-д хандах эрхтэй. Тухайн хэргээр ҮХШ дараах шийдвэрээс аль нэгийг нь гаргана.

- Үндсэн хуульд нийцсэн гэж үзвэл олон улсын хэлэлцээр, түүний зүйл, заалтыг нийтэд нь хүлээн зөвшөөрөх;
- Үндсэн хуульд нийцээгүй байвал түүнийг хүлээн зөвшөөрөхөөс нийтэд нь татгалзах, эсвэл хэсэгчлэн үл нийцсэн олон улсын хэлэлцээрийн зүйл, заалтыг үл зөвшөөрөх.

3. Ерөнхийлөгч болон Үндэсний хурлын гишүүдийн сонгуулийн үр дүнтэй холбоотой маргааны талаар ҮХШ-д Ерөнхийлөгч, Үндэсний хурлын гишүүдийн 1/3-ээс багагүй тооны гишүүд, түүнчлэн Ерөнхийлөгчид болон Үндэсний хурлын гишүүдэд нэр дэвшигчид ч энэхүү сонгуулийн үр дүнгийн талаархи маргааныг шийдвэрлүүлэхээр хандаж болно.

4. Улсын төрийн намын үйл ажиллагааг зогсоох тухай маргаантай холбогдсон асуудлыг ҮХШ хянан шийдвэрлэнэ. ҮХШ намын үйл ажиллагааг зогсоох тухай тогтоолыг зөвхөн тухайн нам Үндсэн хуулийн болон Намын тухай хуулийн зохих шаардлагыг хангаагүй тохиолдолд л гаргах бөгөөд энэхүү шийдвэр нь Үндсэн хуулийн шүүхийн нийт гишүүдийн дийлэнх олонхийн саналыг авсан байх шаардлагатай.

Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр, түүний хэлбэр

ҮХШ-ийн шийдвэр нь тогтоол, дүгнэлт гэсэн хэлбэртэй. Үндсэн хуулийн шүүхийн дүгнэлтийг нийт гишүүдийн олонхийн саналаар, харин тогтоолыг нийт гишүүдийн дийлэнхи олонхи буюу 2/3-ын саналаар тус тус гаргана. ҮХШ-ийн тогтоол нь эцсийн шийдвэр бөгөөд түүнийг дахин авч хэлэлцэхгүй, өөрөөр хэлбэл, гаргасан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

ҮХШ-ийн гишүүн нь санал хураалтад оролцохоос татгалзах эсвэл дэмжихгүй байх эрхгүй. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг зөвхөн өргөдлийн шаардлагын хүрээнд гаргана.

Үндсэн хуулийн шүүхийн тогтоол, дүгнэлтэд маргааны шинж байдлаас хамааран дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд, тогтоол, дүгнэлтийн нэр, гаргасан он, сар өдөр, байр, оролцогч талуудын тухай зайлшгүй мэдээлэл, хянан шийдвэрлэж буй асуудал, учир шалтгаан, үндэслэл, өргөдлийн шаардлага, агуулга, бодит шинжилгээ, бусад нөхцөл байдал, тогтоол болон дүгнэлт гаргахад удирдлага болгосон Үндсэн хуулийн зүйл, заалт, нотлох баримтууд, тэдгээрийг хэрхэн үнэлсэн тухай, маргааныг хэрхэн шийдвэрлэсэн тухай дурдана.

Тогтоол хүчин төгөлдөр болсныг Үндсэн хуулийн шүүхийн хэргийн талаар гаргасан тогтоол эсвэл дүгнэлтэд хуралдаан даргалагч гарын үсгээ зурна.

Тогтоол болон дүгнэлтийг хэвлэх, түгээх

ҮХШ-ийн тогтоол, дүгнэлтийг ёсчилсноос хойш 3 хоногийн дотор оролцогч талууд, БНУлсын Ерөнхийлөгч, Үндэсний хуралдаан, Засгийн газар, Ерөнхий прокурорт тус тус хүргүүлнэ. Мөн тогтоол, дүгнэлтийг төрийн хэвлэлд албан ёсоор бүрэн эхээр нь нийтэлдэг журамтай.

Үргэлжлэл. (түрүүч нь 2006 оны №3-т)

МЭДЭЭЛЭЛ ХАЙХ, ХҮЛЭЭН АВАХ, ТҮГЭЭХ ЭРХ БУЮУ НУУЦЫН ТУХАЙ ЭРХ

/Мэдээллийн бүрдүүлбэрийн эрхийн хүрээнд бичсэн илтгэл/

Хоёрдугаар өгүүлэл



ХЗДХЯ-ны мэргэжилтэн
Ш.Үнэнтөгс

Монгол Улсын иргэний төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрх нь НҮБ-аас баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд "Хүн бүр өөрийн үзэл бодолтой байж, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, үүнд үзэл бодлоо ямар ч хориг цээргүй баримтлах, аливаа үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан боломжтой арга замаар эрж сурвалжлах, олж ашиглах, түгээн дэлгэрүүлэх эрх багтана" болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 18 дугаар зүйлийн 1-д "Хүн бүр чөлөөтэй бодож, сэтгэх ... үзэл бодолтой байх, чөлөөтэй сонгох ... болон үзэл санаагаа ... заан түгээх замаар илэрхийлэх эрх чөлөөтэй", 19 дүгээр зүйлийн 2-т "Хүн бүр санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй: энэ эрх нь төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр буюу хэвлэлээр, эсхүл уран сайхны хэлбэрээр, түүнчлэн өөрийн сонгосон бусад аргаар чөлөөтэй ... түгээх эрх чөлөөг багтаана" гэж заан баталгаажуулсан ба энэ нь иргэдийн аль болох өргөн хүрээнд мэдээлэл хайж, олж авч ашиглах, түүнийгээ түгээн дэлгэрүүлж, хэрэгжүүлэх боломж хэр нээлттэй байгаагаар илэрнэ.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.16 дахь заалтад "Монгол Улсын иргэн нь төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй" гэж тусгагдан баталгаажсан ба Төрийн нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуулиар уг харилцааг зохицуулж байна.

Түүнчлэн Төрийн нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай, Эрүү, Иргэний хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Улсын Их хурлын сонгуулийн тухай, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Аймаг, нийслэл сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай, Захиргааны хариуцлагын тухай, Засгийн газрын тухай, Төрийн албаны тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай, Шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах журмын тухай, Шүүхийн тухай, Прокурорын байгууллагын тухай, Цагдаагийн байгууллагын тухай, Өмгөөллийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Онц байдлын тухай, Гадаад худалдааны арбитрын тухай, Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалтын тухай, Ард нийтийн санал асуулгын тухай, Соёлын тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Улсын Их хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай, Улсын Их хурлын хуралдааны дэгийн тухай, Статистикийн тухай, Иргэний хамгаалалтын тухай, Аюулгүй байдлыг хангах тухай, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай, Олон улсын гэрээний тухай, Дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Эрдэнэсийн сангийн тухай, Үндсэн хуулийн цэцийн тухай, Хүний эрхийн үндэсний комиссын тухай, Геодези, зураг зүйн тухай, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Дампуурлын тухай, Архивын тухай, Дайн бүхий байдлын тухай, Эмийн тухай, Дайны байдлын тухай, Дайчилгааны тухай, Хүнсний тухай, Галын аюулгүй байдлын тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зэрэг 70 шахам салбар хуулиудаар зарим төрлийн харилцааг зохицуулсан байна.

Энэхүү төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхээ илэрхийлэх гол арга замын нэг иргэдийн хэр үнэн зөв, шаардлагатай мэдээллээр хангагдаж байгаа болон эрж хайх явдал нь зөвхөн хуулийн хүрээнд бөгөөд улсын аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусад хүний эрх, нэр төрийг хамгаалах ашиг сонирхлын үүднээс хязгаарлаж болно. Энэ нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 29 дүгээр зүйлийн 2-т "Хүн бүр эрх, эрх чөлөөг эдлэхдээ бусдын эрх, эрх чөлөөг зүйн дагуу зөвшөөрөн хүндлэх, ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх, ардчилсан нийгэмд байдаг хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосон зохих хязгаарлалтад л захирагдана" болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19.3-т "Энэ зүйлийн 2-т дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлагыг ногдуулна. Энэ нь гагцхүү хуулиар тогтоосон зарим хязгаарлалттай холбоотой бөгөөд тэдгээр нь: а/ бусдын эрх, алдар хүндийг хүндэтгэх, б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд буюу ёс суртахууныг хамгаалахад зайлшгүй шаардлагатай байна" гэж заасан.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16-18 дугаар зүйлд "Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална" гэж заасан нь олон улсын гэрээгээр хүний эрхийн талаар хүлээсэн үүрэгт нийцэж байна.

Нөгөөтэйгүүр манай Үндсэн хуульд зөвхөн мэдээлэл хайх, хүлээн авах эрх тусгагдсан бөгөөд олж авсан мэдээллээ түгээх эрх тусгагдаагүй байгаа нь ихээхэн дутагдалтай зүйл юм. Үүнийг тулгуур хуульдаа хэзээ нэг цагт оруулж өгөх шаардлагатай.

Энэхүү хүний эрх болон бусдад задруулж үл болох нууцыг хуулиар тогтооно гэсэн зарчим нь Монгол Улсын хууль тогтоомжид бүрэн тусгагдан баталгаажсан гэж хэлж болох байна. Тухайлбал,

Төрийн нууцын хүрээнд: Төрийн нууцын тухай хуулийн зарим тодорхой хязгаарлалт тогтоосон байна. Уг хуулийн 5.1.1-д " Монгол Улсын аюулгүй байдлын үзэл баримтлал, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээ, баримт бичиг, бусад зүйлийн нууцалбал зохих хэсэг", 5.1.2-т "Монгол Улсын гадаад бодлого, байр суурьтай холбоотой түүнчлэн Монгол Улсаас гадаад орнуудтай байгуулсан нууцалбал зохих гэрээ, хэлэлцээр, тэдгээрийн төсөл"-ийг төрийн нууцад хамруулахаар тодорхойлжээ. Түүний дотор батлан хамгаалах хүрээнд 9, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, технологийн хүрээнд 4, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажлын хүрээнд 5 зүйлийг төрийн нууцад хамааруулсан байна. Төрийн нууцын жагсаалтын тухай хуулиар 73 зүйлийг нууцлан хамгаалахаар баталжээ. Төрийн нууцын тухай хуулийн 12.5-д "төрийн нууцыг олж авах зорилгоор хайж олох, бусдад тараахыг хориглоно" гэсэн байна. УИХ-ын хуралдааны дэгийн хуульд хэлэлцэх асуудлын шинж байдлыг харгалзан чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг хаалттай явуулж болно. Улсын нууцын жагсаалтад хамаардаг асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ гэж заасан. Түүнчлэн өндөр албан тушаалтнуудын харилцаа холбоо болон захидал харилцааных нь нууцыг хамгаалах тухай тусгай заалтууд Ерөнхийлөгчийн тухай, УИХ-ын гишүүний эрх зүйн байдлын тухай, Засгийн газрын тухай, Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд тусгагдсан байна. Харин энэ мэт хязгаарлалтад чухам юуг нууцлах нь тодорхой бус байгаа нь дур зоргын хэрэг болж болзошгүй байна.

Аливаа үүргийн хувьд төрийн нууцыг мэдэх ёсгүй этгээд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр төрийн нууцыг задруулсан бол 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж Эрүүгийн хуулийн 272.2-т заасан. Эдгээр байдлаас харахад төрийн нууцын жагсаалт хэтэрхий өргөн хүрээг хамарсан, тойм төдий зохицуулалт хийгджээ. Иймхүү хязгаар тавихдаа нууцын мөн чанар, нууцалбал зохих шалгуурт нийцэж буй эсэхийг зохицуулаагүй байгаа нь нууцын зэрэглэлийн алинд нь ч олон нийтийн болон мэдээллийн хууль ёсны ашиг сонирхлыг харгалзаагүй байна гэх үндэслэл байна. Жишээ нь, Төрийн нууцын тухай хуулийн 5.1.2-т Монгол Улс болон гадаадын бусад орны хоорондох нууц гэрээ, хэлэлцээр, тэдгээрийн төслүүд нууц байхаар заасан нь тус улсын Засгийн газар, гадаад орнуудтай ард олноос нууцлах ямар гэрээ, хэлэлцээр хийсэн болох нь хаана ч тодорхойгүй, зохисгүй байдал юм. Учир нь, тус улсад болон бусад улс оронд тухайн засгийн эрх баригчид эх орноосоо урваж, бусад улс оронд эх орноо найр тавих юм уу, цаашилбал аль нэг улсад улс төр, эдийн засаг, бас бус зүйлийн хэт давуу байдал олгох, өөрийн орны иргэд болон дэлхийн улс түмний эрх ашигт бодитой занал учируулахуйц гэрээ хэлцлийг нууцлах тохиолдол бий байсныг тэмдэглүүштэй. Тухайлбал, Богд хаант Монгол Улс 1919 онд Дундад иргэн улсад дагаар орох 64 зүйлийн бичигт эрх баригчид нууцаар гарын үсэг зурснаар тусгаар байдлаа алдахад хүрч хятад цэрэг Нийслэл хүрээнд орж байсныг санахад илүүдэхгүй санагдана.

Байгууллагын нууцын хүрээнд: Байгууллагын нууцын тухай хуулийн 3.2, 4.2-т "байгууллагын албан үйл ажиллагааны онцлогтой холбоотой ... нууцыг байгууллага ... өөрөө тогтооно" гэж заасан. Энэ нь байгууллагын дарга, эрх баригчдад нууцлахгүй байх зүйлийг ч нууцлах боломж олгосон нь хүний мэдээлэлд нэвтрэх, олж авах, түгээх эрхийг нь үндэслэл муутай хязгаарлаж буй явдал гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Мөн хуулийн 5.2-т байгууллагын нууцыг мэргэжлийн үйл ажиллагааны дагуу ... олж мэдсэн этгээд уул нууцыг чанд хадгалах үүрэгтэй гээд зөрчсөн тохиолдолд 20000-50000 төгрөгөөр торгоно гэсэн байна. Нөгөө талаас тус хуулийн 6.1-д тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж буй нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл; 6.2-т тухайн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээлэл; 6.3-т гэмт хэргийн тухай болон нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээллийг нууцлахыг хориглох мэдээллийн хүрээнд тогтоож өгсөн нь сайшаалтай.

Тухайлбал, Цагдаагийн ерөнхий газрын даргын 1997 оны 58 дугаар тушаалаар Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын нууцыг хамгаалах журам батлан мөрдүүлж байна. Уг журмаар нууц мэдээ баримт хүлээн авах, танилцах, бүртгэх, шилжүүлэх, хадгалах, архивт шилжүүлэх, устгах болон нууцын ажилтны эрх, үүргийг тодорхойлон заасан байдаг.

Түүнчлэн энэ чиглэлийн судалгааг хийх явцад Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Гадаад хэргийн яам, Батлан хамгаалах яам, Монгол банк, Улсын ерөнхий прокурорын газар, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Цагдаагийн ерөнхий газар, Хилийн цэргийг удирдах газар, Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар, Зэвсэгт хүчний ерөнхий штаб гэсэн тун цөөхөн байгууллага байгууллагын нууцаа тодорхойлж, нууцын жагсаалтаа баталсан байна. Судалгааны явцад нууцлалын өндөр түвшинд байх шаардлагатай Улсын дээд шүүх, түүний нууцыг гардан хариуцах ёстой Тамгын газрын дарга нь энэ талаар жагсаалт байх шаардлагатай эсэхээ болон тийм эрх зүйн акт байдгаа мэдэхгүй

байсанд харамсаж байна.

Хувийн нууцын хүрээнд: Хувь хүний нууцын тухай хуулийн 2, 4 дүгээр зүйлд тухайн хүний хууль ёсны нэр төр, ашиг сонирхолд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хувь хүний нууц гэнэ гээд нууцын төрлийг захидал харилцааны, эрүүл мэндийн, хөрөнгийн, гэр бүлийн гэж тодорхойлжээ. Эдгээр нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглоно гэж заасан байна. Мөн хувь хүний нууцад хамаарах заалт Авилгалын эсрэг хуулийн 11.1, 11.2-д хөрөнгө, орлогын мэдүүлэг хувь хүний нууцад хамаарна, хөрөнгө, орлогын мэдүүлгийн нууцыг хамгаалах, түүнийг ил болгох асуудлыг хувь хүний нууцын тухай хуулиар зохицуулна гэж заасан байдаг. Мөн Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7.5-д өргөдөл, гомдолд дурдсан төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах тухай заасан бөгөөд Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд хамгаалуулагчийнхаа тухай өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгөх, хувийн нууцынх нь талаар хэвлэн нийтлэхийг хоригложээ. Иймхүү задруулсан бол Эрүүгийн хуулийн 146 дугаар зүйлд заасны дагуу нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу 10000-60000 төгрөгөөр торгох ял шийтгэх болжээ.

Мөн Үндсэн хуулийн 16.1.13-д иргэд болон тэдний гэр бүлийнхэн, хувийн захидал харилцаа, орон байрны тухай ерөнхий эрх агуулагдсан байдаг. Ер нь ардчилсан орны улс төр, олон нийтийн зүтгэлтнүүд өөрийнх нь хувийн амьдрал нууцад жирийн хүмүүсийнхээс илүү халддаг ба албан тушаал өндөр, чухал байхын хэрээр илүү ертдөг ба тэд үүнийгээ хүлээн зөвшөөрч сурах хэрэгтэй юм. Тийм ч үчраас улс төрч, нийгмийн зүтгэлтэн, олны танил хүмүүсийн шүүмжлэлд өртөх хүрээ өргөн бөгөөд тэд үүнд тэвчээртэй хандах ёстой гэж олон улсын практикт үздэг байна.

Бусад хязгаарлалтын хувьд: Иргэдийн мэдээлэл олж авах эрхийг хязгаарласан заалт Байгууллагын нууцын тухай, Эрүүгийн хууль болон зарим салбарын шинжтэй хууль тогтоомжид мэр сэр байна. Тухайлбал, Геодези, зураг зүйн тухай хуулийн 12.1.1-д нууцын зэрэглэлтэй байр зүйн зураг, тоон мэдээллийг геодези, зураг зүйн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр хэвлэн нийтлэх, хувилах, олшруулах, сурталчилгаанд ашиглах, бусдад дамжуулахыг хоригложээ. Эрүүгийн хуулийн 209 дүгээр зүйлд урьдчилсан мөрдөн байцаалт, хэрэг бүртгэлтийн мэдээ баримтыг прокурор, мөрдөн байцаагч болон хэрэг бүртгэж байгаа этгээдийн зөвшөөрөлгүйгээр задруулж болохгүй бөгөөд зөрчвөл 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу 15000-50000 хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ гэжээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.4-д хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүчирхийлэл, аллага, хядлага, садар самуун, гэмт хэрэг үйлдэх аргыг нарийвчлан харуулсан нийтлэл, нэвтрүүлэг хийхийг, 5 дугаар зүйлд шүүхээр гэм буруутай нь нотлогдоогүй байхад хэнийг ч гэм буруутай гэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг тус тус хоригложээ. Байгууллагын нууцын тухай хуулийн 3.2-т хамаарах нууцыг байгууллага өөртөө тогтооно гэж заасан ба мөн 5.1-д Байгууллагын нууц нь тухайн байгууллагын хамгаалалтад байна; Байгууллага нь нууцаа хамгаалах журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн өөрөө тогтоож мөрдөнө гэжээ. Мөн 5.3-д байгууллага нь эрхэлж буй үйл ажиллагааныхаа дагуу олж мэдсэн хувь хүний нууцыг байгууллагын нууцын нэг адил хамгаална гэж заасан байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд, өнөөдөр Монгол Улсад иргэд, төр засгийн болон хувийн аль ч байгууллагаас хүссэн мэдээллээ олж авах бололцоо алга байна. Энэ нь ялангяа сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын олон нийтийн өмнө "тэдний ашиг сонирхолд нийцсэн мэдээлэл түгээх"-ээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд хамгийн их саад бэрхшээл учруулж байгаа юм.

Нөгөөтэйгүүр манайд мэдээллийн эх сурвалжийг нууцлах, хамгаалах, сэтгүүлчийн ажилгүй байдал, нэр төрийг хамгаалахыг тодорхой тусгасан заалт ямар нэгэн хуульд байхгүй байна. Энэ эрхийг хуульчлаагүйн улмаас сэтгүүлч цагдаа, шүүхэд дуудагдаж эх сурвалжаа албадан хэлүүлсний эцэст тухайн мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдийн ажилгүй байдал, нэр төр, ажил төрөлд дарамт шахалт, хавчлага учруулах явдал тохиолддог. Харин манай нөхцөлд тухайн мэдээлэл үнэн бодитой нь батлагдвал эх сурвалжийг илчлэх ёсгүй, нууцлах нь зөв. Энэ нь хэн хэнийх нь өөрөөр хэлбэл, сэтгүүлчдэд мэдээлэл өгөгч, сэтгүүлч хоёрын нэр төрийн хэрэг юм. Харин буруу байвал хоёул хариуцлага хүлээх болдог.

Хүний эрхийн тухай Олон улсын Пактуудад заасан шалгуураар нууцлах зүйлс улс орнуудад бий боловч түүнийг өргөсгөх буюу бүдүүвчлэх нь албаны бүх мэдээллийг нууц гэж үзэхэд хүргэж байна. Энэ нь эрх зүйн сөрөг үр дагавартай байх нь тодорхой. Манай орны хувьд хэдийгээр мэдээлэл хайх, олж авах эрх нь Үндсэн хуулиараа баталгаажсан хэдий ч түүнийг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн зохицуулалт хийгдээгүй байна.

"Төрийн нууц" гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, тус улсын гадаад бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологи, батлан хамгаалах, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажилтай холбоотой бөгөөд задруулбал Монгол Улсын ашиглүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээллийг томъёолол дүрс зураг, дохио тэмдэг, техник, технологийн шийдэл болон үйл ажиллагааны хэлбэрээр өөртөө агуулж буй мэдээ, баримт бичиг биет зүйлийг хэлнэ" гэж Төрийн нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан. "Хувь хүний нууц гэж Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ"; Хувь хүний нууцын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан ба хувь хүний нууц нь

- захидал харилцааны нууц: захидал, цахилгаан, илгээмж, өргөдөл зэрэг шуудан холбооны хэрэгслээр бусад хүн, байгууллагатай солилцож буй мэдээллийг;
- эрүүл мэндийн нууц: хувь хүний бие эрхтний гажиг, нийтэд аюултай онцлог зарим халдварт

өвчнөөс бусад өвчнөөр өвчилсөн тухай мэдээллийг;
- хөрөнгийн нууц: эд хөрөнгө, оюуны өмч, эрхийн эзэн, эсхүл түүний итгэмжилсэн хүмүүс мэдэх, түүнчлэн эрх бүхий байгууллага албан тушаалтны албан үүргийнхээ дагуу олж мэдсэн мэдээ, баримт бичиг, тоо, гэрээ, хэлцэл, биет зүйлийг;
- гэр бүлийн нууц: бусдад задруулбал тухайн хувь хүн, гэр бүлийнх нь нэр хүнд, ашиг сонирхолд харшлах мэдээллийг;
- хуулиар тогтоосон бусад нууц орно.

"Байгууллагын нууц гэж хүний эрх, нэр төр, алдар хүнд тухайн байгууллагын хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг байгууллагын нууцад хамааруулж болно" гэж Байгууллагын нууцын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан байдаг ба 2 дугаар зүйлд "Байгууллагын нууцтай албан үүргийнхээ дагуу танилцсан, эсхүл олж мэдсэн этгээд уул нууцыг зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журамд нийцүүлэн ашиглах бөгөөд бусдад задруулахыг хориглодог; 3 дугаар зүйлд "Эрх бүхий байгууллага, албан тушаалтан бүрэн эрхийнхээ дагуу хэрэгжүүлж байгаа хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчиж нууцалсан байгууллагын нууцыг ил болгох эрхтэй бөгөөд тухайн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалтай холбогдолтой байгууллагын нууцад хамаарах зарим тодорхой мэдээллийг бусдын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахгүй тохиолдолд нийтэд мэдээлэх болно" гэж заасан байдаг ба байгууллагын нууцыг тухайн байгууллага өөрөө тодорхойлдог байна. Энэ нь тухайн хариуцаж буй мэдээллээ алдсан этгээд л хариуцлага хүлээх болж буй ба тухайн мэдээлэл олж авсан сэтгүүлч хариуцлагад татагдахгүй болж байна. Энэ үүднээс сэтгүүлчдэд мэдээлэл өгөхгүй байх асуудал тавигддаг.

Манай нөхцөлд тухайн мэдээлэл үнэн бодитой нь батлагдвал эх сурвалжийг илчлэх ёсгүй, нууцлах нь зөв. Энэ нь хэн хэнийх нь өөрөөр хэлбэл сэтгүүлчдэд мэдээлэл өгөгч, сэтгүүлч хоёрын нэр төрийн хэрэг юм. Харин мэдээлэл худал хуурмаг, буруу ташаа гэж нотлогдвол сэтгүүлчдэд мэдээлэл өгөгч, сэтгүүлч хоёр хоёулаа хариуцлага хүлээх ёстой. Сэтгүүлч мэдээ баримтаа нягтлаж шалган, нотлохгүйгээр мэдээлэл түгээсэн гэсэн утгаараа буруугаа хүлээх нь зөв. Энэ дэвшүүлж буй санал нь бидний баримтлах ёс зүйн хэм хэмжээ, магадгүй цаашид гарах ямар нэгэн хуулийн хүрээнд тусгах шаардлага урган гарч байна.

Монгол Улсын хувьд Засгийн газрын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 6-д зааснаар "Монгол Улсын Засгийн газар нь ... төрийн удирдлагын хүрээн дэх мэдээллийн албыг зохион байгуулж, хүн амыг үнэн зөв мэдээллээр хангах нөхцөл бүрдүүлнэ" гэж заажүндсэн чиглэлийг тодорхойлсон байдаг.

Зарим улс оронд энэ мэдээлэл нь нээлттэй, нийтэд ил тод байдаг. Иргэд өөрсдийнхөө эрх ашигтай холбоотой асуудлаар чөлөөтэй мэдээлэл хүртэх эрхтэй байх ёстой гэсэн агуулга бөгөөд Засгийн газрын байгууллагуудын бүхий л мэдээлэл иргэдэд нээлттэй байх зарчимд үндэслэдэг.

Нөгөөтэйгүүр энэ нь төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл хүртэх тухайд зөвшөөрөл, итгэмжлэл авах мэдээлэл хүртэх асуудалтай тодорхой хэмжээгэр холбоотой. Итгэмжлэл гэж итгэл хүлээлгэх гэсэн утгатай патени акреди /аккредитация/ гэдэг үгнээс гаралтай эртний Грек, Ромын үеийн итгэмжлэлийн институтээс үүсэлтэй юм. Тухайлбал, эрт болон эдүгээгийн үед ч дипломатуудад Итгэмжлэх жуух бичиг олгон түүнийгээ тухайн орны төрийн тэргүүнд барьснаар тодорхой тусгайлсан эрх эдэлдэг. Үүнийг хэвлэл мэдээллийн орчинд хэрэглэх асуудлын тухайд ярьж байна. Саяхнаас энэ итгэмжлэлийн ойлголт нь сэтгүүл зүйн нэг институт болж хувирч байна. Харамсалтай нь үүнийг зарим нь хязгаарлалт болгон хэрэглэх нь элбэг байна. Гэвч энэ нь төрийн зохих байгууллагаас итгэмжлэл олгосон бол тэрхүү сэтгүүлчид нэмэлт мэдээлэл хүртэх эрхтэй бөгөөд аливаа товлогдсон зүйлийг тэдэнд мэдэгдэх ёстой болдог бөгөөд тэд тодорхой үүрэг хүлээж, давуу эрх эдэлдэг тухай ойлголт юм. Итгэмжлэлийг олгох үйл явц нь ердийн бүртгэх журмаар явагдах ёстой болдог ба хэт хязгаарлалт тавихыг хориглох хэрэгтэй. Жишээ нь, АНУ-д Мэдээлийн эрх чөлөөний тухай хууль 1966 онд батлагдсан бөгөөд уг хуулиар АНУ-ын зөвхөн засаг захиргааны мэдээллийг авах талаар шаардах эрх эдэлдэг. Түүнийг нь АНУ-ын Хууль зүйн яамны дэргэдэх Мэдээлэл ба хувийн нууцын алба нэгтгэн зохицуулж эрхэлдэг.

Иймд төрөөс Засгийн газрын байгууллагуудын мэдээлэл хүртэх тухай буюу Захиргааны мэдээллийг нээлттэй болгох хууль боловсруулан батлуулах шаардлагатай байна. Энэ нь Франц ад 1978 онд баталсан Захиргааны баримт бичгийг нийтэд нээлттэй болгох тухай хууль, Данид 1970 онд баталсан Захиргааны баримт бичгийг нийтэд хүртээх тухай хууль, Норвегид 1970 оны Засаг захиргаа нээлттэй байх тухай хууль, АНУ-д 1966 онд баталсан Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Шведэд 1766 батлаж, 1949 онд нэмэн засварласан Хэвлэл нийтлэлийн эрх чөлөөний тухай хууль, Нидерландад 1978 онд баталж 1991 онд нэмж засварласан Захиргааны мэдээллээс хүртэх эрхийн тухай хууль, Австралид 1982 онд баталж 1983, 1986, 1991, 1994 онд өөрчлөн засварласан Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Канадад 1982 онд баталсан Мэдээллээс хүртэх тухай хууль, Шинэ Зеландад 1982 онд баталж 1983,1987 онд нэмж засварласан Захиргааны мэдээллийн тухай хууль, Бельгид 1994 онд Засаг захиргааг нээлттэй болгох тухай хууль батлан гаргаж, мэдээлэл нээлттэй байлгах тогтолцоог бүрдүүлсэн байдаг. Мөн Энэтхэг, Япон, Өмнөд Африк, Их Британи зэрэг улс орон ч энэ талаар эрхийн акт гарган мөрдөж байна.

Иймд төрөөс Засгийн газрын байгуулагуудаас мэдээлэл хүртэх тухай буюу Захиргааны мэдээллийг нээлттэй болгох хууль боловсруулан батлуулах шаардлагатай байгааг тэмдэглэж байна.

Ардчилсан улс орнуудад төр, засгийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл хүмүүст нээлттэй байх ёстой гэсэн зарчим баримтладаг. Энэ үүднээсээ ч ийм алхам хийх шаардлагатай.

АРД ТҮМЭН ТӨРИЙН ХЭРЭГТ ШУУД ОРОЛЦОХ ЭРХ БҮЮУ АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГА

Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн
багш С.Эрдэнэболор

I. Ард нийтийн санал асуулгын тухай ойлголт, түүхэн хөгжил

Ард нийтийн санал асуулга бол нийгэм, улс төрийн амьдралд иргэдийн оролцооны шууд ардчиллын сонгодог хэлбэр төдийгүй төрийн удирдлагын чухал хэрэглүүр юм. Ард түмний оновчтой санал улс орны тусгаар тогтнол, цаашдын хөгжил цэцэглэлтэд үнэтэй хувь нэмэр оруулах бөгөөд энэ нь тэдний амьдралд эргээд ашиг тусаа өгдөг билээ. Иймээс ч БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчид 1945 оны 9 дүгээр сарын 21-нд "БНМАУ-ын тусгаар тогтнолын талаархи асуудлын талаар бүх ард түмний саналыг гаргуулах тухай" шийдвэр гаргаж үүнээс яг сарын дараа буюу 1945 оны 10 дугаар сарын 20-нд бүх нийтийн санал хураалтад сонгуулийн насны иргэдийн 98,4 хувь нь оролцож, тэдгээрийн 100,0 хувийн саналаар буюу санал хураалтад оролцсон бүх хүний гарын үсэг болон баруун гарын эрхий хуруугаа хээгээр батлаж тусгаар тогтнолоо бүрэн дэмжсэн санал өгсөн байна. Харамсалтай нь Монголын түүхэнд нэг л удаа ард нийтийн санал асуулга явуулсан гэхэд буруутахгүй. Түүхэндээ дөрвөн Үндсэн хууль батлахдаа нэг ч удаа ард нийтийн санал аваагүй. Үүнээс улбаалаад бид улс төрийн ямар системтэй улс гүрэн байх, эдийн засгийн ямар тогтолцоог сонгох, хувийн өмчтэй, өмчгүй байхаа ч хэдхэн субъектээр тодорхойлуулж ирсэн нь нууц биш. 1992 оны Шинэ Үндсэн хуулийг батлахад албан бус мэдээгээр 900.000 иргэдийн санал авсан гэх боловч энэ ард нийтийн албан ёсны санал асуулга байсангүй. 2000 онд өнөөгийн шинэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орсон боловч ард нийтийн санал асуулга явагдсангүй. Үүнтэй холбоотойгоор засаглалын тэнцвэрт байдал алдагдсан. Хэрэв ард нийтийн санал асуулга явуулсан бол үүнийг дэмжих үгүй нь эргэлзээтэй гэж ярилцах болсон. Мөн 2005 онд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг шинэчлэхийн тулд Үндсэн хууль болон Ард нийтийн санал асуулгын тухай хуульд заасны дагуу төрийн дотоод бодлогыг тодорхойлохтой холбогдсон эл асуудлаар ард нийтийн санал хийлгэх шаардлагатай гэж үзэж Ерөнхийлөгчийн сонгуультай хамт явуулах байсан боловч тодорхойгүй шалтгаанаар явагдаагүй байна.

Нийт улс үндэстний болон Үндсэн хуулийн асуудлаар тэдийгүй орон нутаг, салбар, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагууд, төрийн ба орон нутгийн удирдлагын бүх түвшинд зарчмын чухал асуудал шийдлийг олон нийтийн оролцоо, шууд ардчиллын энэ хэлбэр буюу нийтийн санал асуулга хэлэлцүүлгийн хэлбэрээр шийдвэрлэж байх зөв хэвшил, механизмыг бий болгох нь чухал хэмээн өнөөгийн Ерөнхийлөгч Н.Энхбаяр дэвшүүлсэн байдаг. Мөн тэрээр жил бүрийн 10 дугаар сарын 20-ны өдрийг улсынхаа тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлаа бататгах, эх орон, бүс нутаг, нутаг орон, хот тосгодоо хөгжүүлэх арга замын тухай нээлттэй өргөн хэлэлцүүлэг, бүтээлч хөдөлгөөн өрнүүлдэг, иргэдийн саналыг засаглалын бүх түвшинд сонсох нээлттэй хаалганы өдөр болгох саналыг ч дэвшүүлсэн байдаг.

II. Ард түмэн төрийн үйл ажиллагаанд оролцох эрх зүйн үндэслэл

Олон нийтийн оролцоо гэдэг нь олон нийт идэвхтэй арга хэмжээ хэрэгжүүлж, улс төрийн шийдвэрт нөлөөлөхийг хэлнэ.

Иргэд төрийн хэрэгт оролцох 2 үндсэн хэлбэр байдаг. Үүнд:

- Шууд бус оролцоо: Иргэд УИХ-ын гишүүн, өөрийн оршин суугаа аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдөөр дамжуулан шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох.
- Шууд оролцоо: Аливаа төр, нийгэм, орон нутгийн хүрээний асуудлыг шийдэх үйл хэрэгт өөрийн биеэр оролцохыг ойлгож болно. Тухайлбал:
  - Өөрийн орших газрын баг, хорооны иргэдийн нийтийн хуралд оролцох;
  - УИХ-ын гишүүнээр дамжуулах;
  - Олон нийтийн санал асуулга явуулахад оролцох;
  - Хуулийн хэлэлцүүлэгт оролцох;
  - ТББ-аар дамжуулах;
  - Сонин хэвлэл, телевиз, радиогоор үзэл бодлоо илэрхийлэх;
  - Төрийн байгууллага, албан тушаалтанд захидал бичих гэх мэт.

Мөн төрийн үйл хэрэгт шууд оролцох оролцоо гэдэг нь төр, засгийн бодлогод нөлөөлж, хүсч буй шийдвэрээ гаргуулахыг хэлнэ. Та өөрийн сонгосон төлөөллөөр дамжуулан төрийн хэрэгт оролцоно. Таны төлөөлөлтэй байх эрх сонгох, сонгогдох эрх чөлөөгөөр дамжин хэрэгждэг юм. Төлөөлөл гэдэг бол шийдвэр гаргах түвшинд таны нэрийн өмнөөс дуу хоолойгоо илэрхийлэх боломж юм.

Ардчилсан оронд иргэд өөрсдийг нь төлөөлөн төр удирдах хүмүүсийг сонгоно. Төлөөлөгчид нь шийдвэр гаргахдаа ард түмний хүсэл эрмэлзлийг илэрхийлнэ. Иргэд хүний эрх, олон түмний сайн сайхан байдлыг хангахын төлөө төр засагтай эрх тэгш байдлаар хамтран ажиллана. Иргэд идэвхгүй байваас улс орноо удирдах хэрэгт оролцогч бус харин удирдлагын обьект болон хувирна. Ингэвэл төр засаг тэдний оролцоогүйгээр бүхнийг шийдэх болно.

Иргэдийг ардчиллын хэрэгт оролцуулах хамгийн дөт зам бол сонгууль, санал хураалт юм. Сонгууль нь ялсан хүмүүст хууль ёсны эрх мэдэл олгоно. Эрх мэдэл авч сонгогдсон удирдагч нар эрх

мэдлээ хэтрүүлэхгүй байх явдалд хяналт тавих нь иргэдийн үүрэг юм. Шийдвэр гаргах болон бодлого боловсруулах явцад иргэд идэвхтэй оролцдог байх ёстой.

Монгол Улсад сонгууль 4 түвшинд явагддаг.

- Улсын Их Хурал /УИХ/-ын сонгууль;
- Ерөнхийлөгчийн сонгууль;
- Орон нутгийн сонгууль;
- Ард нийтийн санал асуулга.

Та эдгээр сонгуульд чөлөөтэй оролцож, сонгох эрхээ баталгаатай эдлэх эрхтэй.

"Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ." /Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйл/.

"Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

... 9/ шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно. /Монгол Улсын Үндсэн хуулийн 16.1.9 дэх хэсэг/.

1. Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:

... 16/ ард нийтийн санал асуулга явуулах. Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонхи нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож, олонхийн санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзнэ; /Монгол Улсын Үндсэн хуулийн 25.1.16 дахь хэсэг/.

1. Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.

2. Ерөнхийлөгчөөр дөчин таван нас хүрсэн, сүүлийн тавааc доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно /Монгол Улсын Үндсэн хуулийн 30 дугаар зүйл/.

... Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Эдгээр Хурлын болон сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно /Монгол Улсын Үндсэн хуулийн 59.3 дахь хэсэг/.

... 2. Үндсэн хуулийн цэц . . . дараахь маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна:

... 2/ ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;

...3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргана /Монгол Улсын Үндсэн хуулийн 66.2, 66.3 дахь хэсэг/

... 2. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулга явуулж болно. Санал асуулгыг үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16-д заасан үндэслэлийн дагуу явуулна /Монгол Улсын Үндсэн хуулийн 68.2 дахь хэсэг/.

III. Ард нийтийн санал асуулгын тухай гадаад улс орнуудын эрх зүйн зарим зохицуулалт

Ард нийтийн санал асуулгыг дараахь тохиолдолд явуулдаг байна.

- Хуулийн төсөл боловсруулах;
- Олон улсын гэрээ конвенцэд нэгдэх;
- Ард түмний нийтлэг ашиг сонирхолтой холбоотой хууль, эрх зүйн хэм хэмжээний актын тухай;
- Төрийн гадаад болон дотоод бодлого тодорхойлох.

Швед улсад хуулийн төсөл боловсруулахад ард түмэн нь саналаа шууд ардчиллын зарчмаар өгдөг. Итали, Орос гэх зэрэг улсад төрийн байгууллагаар эсвэл орон нутгийн байгууллагаар дамжуулж санал оруулдаг.

Санал хураалтын дүрэм ёсоор онц чухал, тулгамдсан, урьд нь ард түмэнд ил тод болсон, бэлтгэгдсэн асуудлыг ард нийтийн санал асуулгаар шийддэг байна. Австрид /Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 44 зүйлд/ үйлчилж байсан хууль, төслийг хооронд нь харьцуулж хуулийн санал асуулга явуулдаг.

Санал асуулга нь 2 төрөлтэй:

1. Хэрэгсэхгүй болгох;
2. Хүчин төгөлдөр хэвээр үлдээх.

Хуулийн төслийг бүтнээр болон хэсэгчилэн өөрчилж болохыг Италийн Үндсэн хуулийн 75 дугаар зүйл, Швейцарийн Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 89 дүгээр зүйлд, Францын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлд санал асуулгаар оруулсан хуулийн төслийг батлах процессийг тодорхойлон заасан байна. Европын холбооны орнууд олон улсын эрх зүйн асуудлаархи сүүлийн 20 жилийн туршид үүссэн асуудлын талаар санал асуулга явуулах болсон. 1990 оны эхээр санал асуулгыг Франц, Дани, Ирландад Маастрихтскийн гэрээгээр санал асуулгыг явуулдаг болсон.

Захиргааны санал асуулгад төрийн удирдах ажлын шинжийг агуулсан байна. Энэ нь засаг захиргааны нутаг дэвсгэр өргөсгөх эсвэл холбооны хил хязгаарыг тогтоох талаар байж болно /Францын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлд, Италийн Үндсэн хуулийн 132 дугаар зүйлд заасан байна/.

Үндсэн хуулийн хороогоор боловсруулж, референдум буюу бүх нийтийн санал хураалтаар авч үзэн сайшаах /Франц/: Референдум явуулах тохиолдолд ард түмэн өөрсдийн хүсэл зоригийн хариуд "тийм", эсвэл "үгүй" гэсэн хариулт өгдөг.

Заримдаа ард нийтийн санал асуулгыг харгис хүчинд ашигладаг. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн агуулга нь ардчиллын эсрэг бөгөөд авторитар, тоталитар дэглэмийн үндсэн элементүүдээр тодорхойлогдсон нөхцөлд түүнийг ашигладаг.

Бүх нийтийн санал хураалт нь засаглалыг зохион байгуулах,

хэрэгжүүлэхэд ашиглагддаг процедурын нэг юм. Үндсэн хуулийн референдумыг явуулахдаа Үндсэн хуулийг батлах болон өөрчлөхийг хүссэн өргөдөлд тодорхой гарын үсгийн тоог шаарддаг.

Үндсэн хуулийг Үндсэн хуулийн хороогоор эсвэл үүсгэн байгуулах хурлаар боловсруулаад дараа нь түүнийг бүх нийтийн санал хураалтаар сайшаадаг. Бүх нийтийн санал хураалт явуулах нь нарийн үйл явцтай.

Тухайлбал, Франц улс нь Үндсэн хуульдаа засвар оруулах, түүнийг батлахын тулд конгрессийн гишүүдийн тавны гурвын саналаар бүх нийтийн санал хураалт явуулдаг байна. Франц улсын Үндсэн хуульд зааснаар Үндсэн хууль, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах 2 журам байдаг.

1. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачлагыг Төрийн тэргүүн буюу Ерөнхийлөгч, Парламент гаргах бөгөөд Ерөнхийлөгч Үндсэн хууль, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг, Парламент энэ тухай саналыг гаргана. Энэ журмын дагуу Үндсэн хууль, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл болоод санал нь Парламентийн 2 танхимаар дэмжигдсэн байх ёстой. Энэхүү санал болон төслийг ард нийтийн санал асуулгаар авч шийдвэрлэнэ.

2. Хэрэв анхны төслөөр ард нийтийн санал асуулга явуулах шаардлагагүй гэж авч үзвэл Ерөнхийлөгч, Парламентийн тавны гурвын саналаар[1] хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргаж болно.

Хууль тогтоох байгууллагаар боловсруулж, ард нийтийн санал хураалт явуулах /Грек, Испани/: Парламент нь Үндсэн хуульд засвар оруулах, түүнийг батлахдаа бусад хуулийг батлахаас өөр өвөрмөц онцлогтойгоор авч үздэг.

Үндсэн хуулийг боловсруулж батлахад гишүүд тодорхой тооны ирцтэйгээр хүрэлцэн ирсэн байх шаардлагатай бөгөөд ард нийтийн санал асуулга явуулж өндөр квотоор батална.

Үндсэн хууль, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах арга. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал нь түүнийг батлахтай нэгэн адил нарийн, чухал асуудал байдаг бөгөөд түүнтэй адил Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дараахь арга байдаг.

1. Бүх ард түмний санал асуулгаар -Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар ард нийтийн санал асуулга явуулахыг хэлнэ;
2. Зохион байгуулах байгууллагаар-Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгайлан байгуулагдсан байгууллага;
3. Төрийн тэргүүн Парламенттай зөвшилцөн;
4. Октроирование. Эзэн хаан, Ерөнхийлөгч зэрэг төрийн тэргүүн дангаараа Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах.

Испани: Үндсэн хуулийн 167 дугаар зүйл. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл батлагдсанаас хойш 15 хоногийн дотор Парламентийн аль нэг танхимын гишүүдийн аравны нэгээс доошгүй нь шаардаснаар ард нийтийн санал асуулга явуулж болно.

Испани улс нь Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулахдаа 3 журам баримталдаг.

1. Парламентийн хоёр танхимаар хуульд заасан хувиар дэмжигдэх, эс тэгвэл нэгдсэн Комисс байгуулан авч хэлэлцэх;
2. Ерөнхий Кортесоор батлуулах;
3. Ард нийтийн санал асуулга явуулах.

Итали: Үндсэн хуулийн 138 дугаар зүйлд:

"Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлт нь танхим тус бүрээр 2 удаа хэлэлцэгдэж /3 сарын зайтай/, 2 дахь санал хураалтаар нийт гишүүдийн дийлэнх олонхиор дэмжигдсэн байна.

Үндсэн хууль, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Парламентын танхим бүрийн нийт гишүүдийн тавны нэгээс доошгүйн саналаар, 500 мянган сонгогчдын буюу 5 мужийн зөвлөл шаардаснаар ард нийтийн санал асуулга явуулна. Бүх ард түмний санал асуулгыг танхимын 2 дахь санал хураалтаар явуулахгүй бөгөөд нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар батална.

Итали улсын хувьд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах 4 журам баримталдаг.

1. Парламентаар хоёр удаа авч хэлэлцэх;
2. Нийт гишүүдийн дийлэнх олонхоор дэмжигдэх;
3. Батлахын өмнө ард нийтийн санал асуулга явуулах;
4. Батлах.

Ирланд: Үндсэн хуулийн 46-47 дугаар зүйл. Үндсэн хуулийг дахин хянаж үзэхийн тулд Үндсэн хуулийг өөрчлөх тухай актад тусгагдсан журам болоод Референдумын тухай хуульд заагдсан журмыг баримтална.

1. Энэхүү Үндсэн хуулийг өөрчлөх тухай санал бүрийг Парламентийн танхимын төлөөлөгчид хүлээн авч дараа нь ард түмний санал асуулга явуулж шийдвэрлэх ёстой.
2. Хэрвээ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь ард түмний санал асуулгаар дэмжигдвэл, Ерөнхийлөгч тэр даруй түүнд гарын үсгээ зурах ёстой.

Япон: Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачлагыг Парламент гаргах бөгөөд 2 танхимын нийт гишүүдийн гуравны хоёрын дэмжлэг авах шаардлагатай.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар ард нийтийн санал асуулга явуулж батлуулахаар шилжүүлэх, эсвэл парламентийн тусгай сонгууль явуулж сонгосон шинэ Парламентаар 2 удаа хэлэлцүүлсний дараа түүнийг Үндсэн хуулийн нэгэн адил хүчин төгөлдөр хэмээн үзнэ.

Өөрөөр хэлбэл, тухайн хуулийн төслийг Парламентээр хэлэлцүүлж, ард түмэнд мэдэгдэж тэдний дэмжлэгийг авах ёстой. Дэмжлэг авсан тохиолдолд эзэн хаан тухайн хуулийг улсын нэрийн өмнөөс баталж хүчин төгөлдөр болгоно.

Япон улс Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа 3 журам баримталдаг.

1. Тэрхүү санаачилгыг Парламентын гишүүдийн

[1] "Конституция государств Европейского союза", Мк., 1999 г, с. 158

дэмжлэгийг тогтоосон хувиар олж авах;
2. Батлахын тулд зайлшгүй ард нийтийн санал асуулга явуулах, эсвэл Парламентаар 2 удаа авч хэлэлцэх;
3. Хаан батлаж, хүчин төгөлдөр хэмээн зарлах.

Швейцарь: Үндсэн хуулийг ерөнхийд нь эсвэл хэсэгчлэн хянаж үзэхээсээ хамааралд дараахь онцлогтой.

1)Холбооны хурлын нэг болон хоёр танхимаас санаачлах эсвэл 100 мянган сонгогчдын саналыг авах ёстой. Санал оруулсны дараа үндэсний ард нийтийн санал асуулга явуулна. Хэрвээ сонгогчдын ихэнх нь хянаж үзэх тухай санал гаргавал 2 танхим задарна. Энэхүү төслийн дараа ард нийтийн санал асуулга явуулна. Гэхдээ парламентийн гишүүдийн олонхиор сайшаагдсан байх ёстой.

2) Хэсэгчлэн хянаж үзэх санаачлагыг дурын холбооны хурлаар, 100 мянган сонгогчдоор баталж болно. Хэрвээ санаачлагчид сонгогчид бол зүйл бүрийг эсвэл шинэ зүйл санаачилж болно. Ард түмний санаачлага нь ерөнхий эсвэл тодорхой зүйлийн хэлбэрт чиглэсэн байж болно. Санаачилгыг эхний тохиолдолд холбооны хурлаар хянаж үзнэ. Түүнийг танхимаар дэмжихгүй бол хянаж үзэх тухай ард түмний санал асуулга явуулах эсэх тухай асуудал тавигдана. Хэрвээ тийм гэвэл холбооны шийдвэрийг сайшаах болно.

Өөрөөр хэлбэл, нэмэлт, өөрчлөлт оруулахдаа:

- Ерөнхий (томьёологдоогүй);
- Тодорхой зүйл, заалт (томьёологдсон);
- Тодорхой зүйлийн хэлбэрт хянах саналын тухай санаачлагыг холбооны хурал сайшаавал тэр төслийг ард түмэн болон Кантонуудын сонгууль руу шилжинэ. Хэрвээ холбооны хурлаар түүнийг сайшаахгүй бол тусгай төсөл боловсруулж болно. Мөн ард түмний санаачлах төслийн журамд саналаа буцааж болно.

Швейцарь Улс Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулахдаа бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хянаж үзэхээсээ хамаарсан журмыг баримталдаг ч ерөнхийдөө дараахь байдалтай байна.

1. Нэмэлт, өөрчлөлт оруулахаар Парламентын гишүүд болон иргэд санаачлага гаргах;
2. Шинэ танхим байгуулах;
3. Ард нийтийн санал асуулга явуулах.

Польш: 1992 оны 4 дүгээр сарын 23-нд Үндсэн хуулийг боловсруулах болон батлах журмын тухай Үндсэн хуулийн хуулийг баталсан. Үндсэн хуулийн хууль нь Үндсэн хуулийг үндэстний хурлаар батлах хууль ёсны журмыг тодорхойлсон байдаг.

Шинэ Үндсэн хуулийн төслийг Үндсэн хуулийн комисс (46 сеймийн депутат, 10 сенатор), үндэстний хурлын гишүүд (56), Ерөнхийлөгч, иргэд (500 мянга) санаачлах эрхтэй.

Үндэстний хурлын нийт гишүүдийн талаас доошгүй буюу ойролцоогоор гуравны хоёрын саналаар Үндсэн хуулийг батална.

Орос: 1995 онд бүх ард түмний санал асуулга орон даяар явагдсан. Дайны онц чухал нөхцөлд явуулсан санал асуулгыг хүчингүй болгосноос хойш 3 сарын дараа дахин санал асуулга явуулж болно. Давтан санал асуулгыг бүтэн жилийн дараа албан ёсоор хэвлэгдсэний үр дүнг гаргасны дараа, урьд санал асуулга явуулсан утга буюу асуултаар хийгдэнэ. Санал асуулгад холбооны улсын статусыг өөрчлөн, Ерөнхийлөгчийг хугацаанаас нь өмнө огцруулах, хугацааг нь сунгах асуудлыг ард түмний санал асуулгаар хэлэлцэхгүй.

Холбооны төсвийг батлах, өөрчлөх, улсын дотоод санхүүгийн гүйцэтгэлийг өөрчлөх, холбооны татвар төлөөсийг батлах, өөрчлөх, чөлөөлөх, хүн амын эрүүл мэндийг хамгаалахад яаралтай чухал арга хэмжээг авах талаар санал асуулга явуулах тухай Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн 3.2 дахь хэсэгт заасан байна. Орост 2 сая иргэдээс санаачлага гаргавал санал асуулгыг явуулдаг. Энэ тухай Үндсэн хуулийн 135 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан.

Санал асуулгыг ОХУ-ын Ерөнхийлөгч товлоно. Ерөнхийлөгчийн захирамж хэвлэгдэн гарснаас хойш 2-3 сарын дараа амралтын өдөр явуулна. Санал асуулгыг болсонд тооцохдоо болон асуулгыг шийдвэрлэхэд санал өгөх эрхтэй иргэдийн тал хувь оролцож санал хураалт өгсөн байх ёстой байдаг.

Үндсэн хуулийг бүх ард түмний санал хураалтын дүнд баталдаг. Үндсэн хуулийн байгуулал, хүний болоод иргэний эрх, эрх чөлөө, Үндсэн хуулийг өөрчлөх журмыг зохицуулах тухай Үндсэн хуулийн бүлгийг өөрчлөхийн тулд Холбооны хурал, төрийн Думын депутатууд болон Холбооны зөвлөлийн нийт гишүүдийн тавны гурвын саналаар Үндсэн хуулийн хурлыг хуралдуулах бөгөөд энэхүү тусгай байгууллага нь түүнийг өөрчлөх хэрэгтэй эсэхийг шийдвэрлэнэ. Хэрвээ тийм гэж үзвэл нийт гишүүдийнхээ гуравны хоёрын саналаар, эсвэл бүх ард түмний саналаар ОХУ-ын Үндсэн хуулийн шинэ төслийг боловсруулна.

Бусад бүлгийн зүйлүүдийг төрийн байгууллагууд ердийн аргаар өөрчлөлт оруулдаг. Гэхдээ дан ганц Холбооны хурлаар бус. ОХУ нь Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулахын тулд дараахь 2 журам баримталж байна:

1. Холбооны зөвлөлийн дөрөвний гурвын санал, Төрийн Думын гуравны хоёр санал;
2. Холбооны субъектүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар батална.

IV. Дүгнэлтийн хэсэг

Зарим эрдэмтэд судлаачдийн дэвшүүлсэн санал. Үүнд:

1. Орон нутгийн санал асуулгын тухай хууль гаргаж иргэдийн санаа бодлыг бүх шатанд сонсч байх асуудлыг хуульчлах;

2. Ард нийтийн санал асуулга явуулах: 1995 онд батлагдсан эл хуулийг бараг нэг ч удаа хэрэглээгүй. Тиймээс уг хуульд зарим нэг өөрчлөлт оруулах, мөн уг хуулиар шийдэх асуудлуудын жагсаалтыг батлах. Энэ хуулийг 10 жилийн хугацаанд нэг ч удаа хэрэглээгүй нь Парламент хууль тогтоох эрхээ ард түмэнд шилжүүлэх дургүй байдгийг

харуулсан маш сайхан жишээ болж байна;

3. Иргэд хууль санаачлах эрхтэй болгох: Үндсэн хуульд заасанчлан Парламентын гишүүдэд санал, гомдлоо хэлснээр, тэдэнд итгэж найдсанаар асуудал шийдэгдэхгүй гэдэг нь газар, ашигт малтмал, татвар, сонгууль, нийгмийн халамжийн хууль зэрэг дээр тод харагдлаа. Иргэд нөлөөлж чадахгүй байна. Иймээс Үндсэн хуульд өөрчлөлт оруулж Австри, Польш, Испани лугаа адил иргэд өөрсдөө хэрэгцээтэй хуулиа санаачилдаг, парламент түүнийг хэлэлцэн батлах эсэхээ шийддэг болох, төр засаг нь нийгмээ мэдэрч чадахгүй байгаа өнөөгийн нөхцөлд хамгийн оновчтой шийдэл болох юм;

4. Ард нийтийн санал асуулгын дотоод боломжийг бүрэн шавхан ажиллах замаар нийгмээ ардчилах, олон түмний оролцоог хангах, ард нийтийн саналыг бодлого, шийдвэрт байнга тусгаж байх.

Өөрийн зүгээс гаргаж буй саналууд

1. Үндсэн хуулийг шинээр батлах тохиолдолд ард нийтийн санал албан ёсоор авч байх;
2. Нийгмийн байгуулал, хүний болон иргэний эрх, эрх чөлөө, Үндсэн хуулийг өөрчлөх журмыг зохицуулах тухай Үндсэн хуулийн бүлгийг өөрчлөхийн тулд ард нийтийн санал асуулгыг заавал авч байх;
3. Хүн амын нэгээс дээш хувийн саналаар ард нийтийн санал асуулга явуулах эрх зүйн зохицуулалт бий болгох;
4. Ард нийтийн санал асуулгыг сонгуулийн буюу сонгуулийн бус аль ч цаг үед үзвэл явуулж байхаар хуульчлах;
5. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, соёл уламжлалд нөлөөлөх аливаа өөрчлөлтийн асуудлаар заавал ард нийтийн санал асуулга авч байх. Жишээлбэл, Төрийн албан ёсны хэл, бичгийг өөрчлөх гэх мэт асуудал гарвал;
6. Улс төрийн албан тушаалтныг эгүүлэн татах асуудлаар ард түмэн өөрсдөө санал асуулга зохион байгуулах эрх зүйн боломжийг бий болгох;
7. Сонгуулийн тогтолцооны талаар ард нийтийн санал асуулга авч байх.

V. Төгсгөлийн оронд


Төрийн гадаад, дотоод бодлогыг тодорхойлоход ард түмэн бид шууд оролцох Үндсэн хуулиар олгогдсон эрхтэй билээ.

Энэ эрхээ хэрэгжүүлэх шаардлага практик амьдралд алхам тутам урган гардаг боловч эрхээ хэрэгжүүлсэн нь үгүй байна. Тухайлбал, уйгаржин бичгийг кирил үсгээр сольсноор алдсан оносон нь мэдэгдээгүй байхад одоо латин үсгээр солино гэсэн яриа ч сонсогдох болсон. Аливаа үндэстний тусгаар тогтнолын баталгаа нь хэл, хил, соёл 3 байдаг. Тэгвэл хэл соёлын уламжлан үлдэх баталгаа нь хэл бичиг яах аргагүй мөн. Энэ мэт асуудлаар заавал ард нийтийн санал асуулга авч байх нь хойч үеийнхнийхээ өмнө хүлээх бидний үүрэг мөн. Бид нэг үндэстэн атал зарим нь уйгаржин бичигтэй, зарим нь кирил, зарим нь латин үсгээр бичдэг болвол хил хязгаараар таслагдсан үндэс нэгтэн маань биднээс бүр холдон хөндийрөх биш үү.

Бид өөрийгөө хамгаалах батлан хамгаалах цэрэгтэй байх ёстой. Гадаадад цэрэг гаргаж энхийг сахиулах ажиллагаанд оруулж болох хэдий ч энэ тухай ард түмний саналыг төр засаг маань асууж байх учиртай.

Учир нь, эрүүл аюулгүй орчинд амьдрах баталгаа болон терроризм дэлхийн хэмжээнд нүүрлэж буй өнөө үед улс үндэстэнд маань энэ сөрөг үзэгдэл халдварлахгүй гэх баталгаа алга.

Ард нийтийн санал асуулгыг явуулж нийтийн хүсэл зоригийг сонсох ийм тохиолдол, асуудал ихийг дурдаж болно. Жишээлбэл, сонгуулийн систем, Ерөнхийлөгчийн засаглал, авилгал, Үндсэн хуулийн асуудлууд зэрэг олон асуудлыг дурдаж болно.



ШҮҮХИЙН МЕНЕЖМЕНТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ



Нийслэлийн шүүхийн
Тамгын хэлтсийн дарга
Н.Дагва

Юуны өмнө **шүүхийн менежмент гэж юу вэ, хэзээ, хаана, хэрхэн үүсэв** гэдэг талаас нь товч өгүүлье.

Менежмент гэх энэ үг манайд жинхэнэ утгаараа хэрэглэгдэж эхлээд 10 гаран жилийн нүүр үзэж байна. Үгийн утгыг толь бичгээс шүүн үзвэл, захирах, тушаах, гүйцэтгэх, биелүүлэх, чиглүүлэх, удирдах, хянах, эрх барих, зохицуулах, үр дүнд хүрэх, шалгах, хөтлөх, жолоодох, аргыг нь олох, нөлөөлөх зэрэг 30-аад утгатай ба эдгээр нь менежментийн ойлголтод бүгд багтдаг байна.

Менежментийг явцуу утгаар нь, удирдлагын урлаг, үйл ажиллагааны ерөнхий нэр ухагдахуун, харин өргөн утгаар нь, хаана хэсэг, бүлэг нэг зорилгыг шийдвэрлэх гэж байна тэнд менежмент хэрэгтэй гэж тодорхойлжээ. Эдгээрээс үзвэл, менежмент гэж "Зорилгоо тодорхойлж, түүнд хүрэх арга замыг төлөвлөн, ажиллах хүч, санхүү материалын бүх нөөцийн ашиглалтыг оновчтой зохион байгуулж, хүмүүсээ шилж сонгон, тэдгээрийг идэвхижүүлэн манлайлж ажиллах, үйл ажиллагааныхаа явц, үр дүнг үнэлэн, хяналт тавих нэгдмэл үйл ажиллагаа" гэж ойлгогдож байна.

1908 оны үеэс АНУ-ын Барын холбооны ерөнхийлөгч Россов Фаунд шүүхийн менежментийн талаар "Шүүх өөрөө хэргийн хөдөлгөөн хийж, үүнийгээ хариуцах ёстой" гэж анх ярьж эхэлжээ. Гэвч тодорхой зүйлийг хэрэгжүүлж, хийж чадаагүй байна. Санаа төдий л гаргажээ. Харин 1930 оноос энэ тухай дахин ярих болж улмаар 1939 оноос АНУ-ын Барын холбооны шүүхийн захиргааны хэлтсээс шүүх бүр өөрийн менежертэй байх ёстой гэснээр 1940 оноос АНУ-ын хоёр ч мужид менежер ажиллах болсон ба 1960 он гэхэд 15-20 хүн мужийн түвшинд менежерээр ажиллах болжээ.

1960-1980 оны хооронд шүүхийн менежментийг боловсронгуй болгоход чиглэгдсэн нэлээд ажил дэс дараалалтайгаар хийгдсэн байна. Хамгийн түрүүнд Шүүхийн зөвлөлийг бий болгосон ба энэ зөвлөл нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд огт хамааралгүй боловч шүүхийн төсөв батлах, шүүхийн захиргааны ажилтны орон тоо, бүтцийг судалж шийдвэрлэх, шүүгчдийг сонгон шалгаруулах зэргээр одоогийн Шүүхийн ерөнхий зөвлөл, Тамгын газар, хэлтсийн ажлыг эрхэлдэг байжээ.

1992 онд баталсан **Монгол Улсын Үндсэн хуульд** "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана", "Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана", "Шүүхийн ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно" гэж шүүх эрх мэдлийг бие даан үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлсон бол Монгол Улсын Шүүхийн тухай хуульд:

- Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах үүрэг бүхий хамтын удирдлагын, орон тооны бус байгууллага мөн;
- Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах, шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангах үүргийг хэрэгжүүлнэ;
- Шүүхийг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана;
- Шүүхийн төсөв нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх шаардлагыг бүрэн хангасан байна ... гэж шүүгчийн хараат бус, бие даасан байдлыг хангах тулгуур зарчмуудыг хуульчлан баталгаажуулсан юм.

Шүүхийн менежмментийг боловсронгуй болгох асуудлын үндсийн үндэс нь гагцхүү дээрх зарчмуудыг шүүхийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх явдал юм.

Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөг УИХ-аас 2000 онд баталж хэрэгжүүлж эхэлсэн нь шүүхийн менежментийг шинэчлэх, боловсронгуй болгох шаардлагатайг харуулсан чухал баримт бичиг болсон. Уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад зах зээлийн нөхцөлд шүүхийн менежментийг чадварлаг авч явах, мэргэжлийн түвшинд хариуцан удирдах тийм боловсон хүчнийг зориуд бэлтгэж ажиллуулах, шүүхийг техникжүүлэх, компьютержуулах, хөдөлмөр хөнгөвчлөх, үйл ажиллагаагаа бие дааж гүйцэтгэх бүхий л боломжийг бүрдүүлсэн шинэ менежментийг буй болгох, шүүхүүд өөрийн байртай, шүүгчид ажиллах, амьдрах хамгийн наад захын боломж нөхцөлөөр хангагдах, шүүх, шүүгчдийн бие даасан, хараат бус байдлыг хангах талаарх Үндсэн хуулийн зарчмыг хэрэгжүүлж, үүнтэй холбоотой эдийн засгийн баталгааг

хангахад УИХ, Засгийн газар онцгой анхаарч шийдвэрлэх зэрэг олон асуудал тулгамдсан зорилт болон тавигджээ.

2004 онд Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлөөс "Шүүхийн менежментийг боловсронгуй болгох үзэл баримтлал", 2005 онд уг үзэл баримтлалыг 2005-2008 онуудад хэрэгжүүлэх ажлын ерөнхий төлөвлөгөө батлагдсан. Тус үзэл баримтлалд "шүүхийн менежмент" гэсэн ойлголтыг "шүүхийн эрхэм зорилгод хүрэхийн тулд шүүхийн хүний болон материаллаг нөөцийг оновчтой төлөвлөж, үр дүнтэй удирдан зохион байгуулах, зорилтын биелэлтийг хянах, дүн шинжилгээ хийх, үр дүнг тооцох зэрэг шүүхийн /захиргааны/ удирдлага, үйлчлэх үйл ажиллагааны тасралтгүй явцыг ойлгоно" гэж тодорхойлжээ.

Шүүхийн менежментийг боловсронгуй болгосноор шүүхийн байгууллагын ажлын бүтээмж нэмэгдэнэ, зөв зохион байгуулалттай үйл ажиллагаа нь шүүхийн ачааллыг багасгаж, шүүхийн ил тод байдлыг хангах замаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь сөрөг үр дагаврыг арилгаж, олон нийтийн зүгээс шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Шүүхийн менежментийг боловсронгуй болгох үндсэн шаардлага юу вэ?

- Нийгмийн амьдралын бүхий л хүрээнд өөрчлөлт гарч, хүмүүсийн амьдрал улам олон талтай болж, төрөл бүрийн шинэ харилцаа үүсч бий болохын хэрээр хүмүүсийн хувьд шүүхийн байгууллагад хандах ямар нэг шаардлага заавал гарч ирдэг гэж хэлж болно. Энэ нь Монгол Улс дэлхий нийтийн маш хурдан хувьсан өөрчлөгдөж байдаг хөгжлийн ерөнхий чиг хандлагад нийцэж, ардчилал, зах зээлийн эдийн засгийн замаар замнах болсноос улбаатай бөгөөд нөгөө талаар нийгмийн харилцаа бүхэлдээ эрх зүйн хүрээнд зохицуулагдах болсонтой холбоотой юм.
- Мөн 1990 оноос өмнө ердөө 30 хүрэхгүй хуулиар нийгмийн харилцааг бүхэлд нь зохицуулдаг байсан бол өнөөдөр 300 хол гарч нийгэм, улс төр, эдийн засаг, хууль, эрх зүйн болон төрийн байгууллагын оршин тогтнох агуулгад гарсан өөрчлөлтүүд нь шүүх эрх мэдлийн байгууллагуудын тогтолцоо үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн орчинд нөлөөлж байна.
- Хэргийн тоо хэмжээ нэмэгдсэн, хэрэг улам бүр ээдрээ төвөгтэй болсон. Энэ нь шүүхүүдэд ачаалал үүсгэж, улмаар урьд өмнөхөөсөө илүү шуурхай, хүртээмжтэй, зохион байгуулалттай ажиллахыг шаардсан.
- Шүүхийн мэдээлэл дутмагаас олон нийтийн зүгээс шүүх удаан, ойлгомжгүй, хүнд сурталтай байна, шүүх шударга бус байна гэх мэт шүүмжлэлд өртөх болсон.
- Шүүхийн төсөв хүрэлцээгүй, шүүгчийн цалин хангамж хэтэрхий бага байгаагаас шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдалд сөргөөр нөлөөлсөн.
- Шүүхийн үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх шаардлага тавигдсан.
- Шүүгч, шүүхийн ажилтнуудыг сургах, давтан сургах, хүний нөөцийг оновчтой төлөвлөх бэлтгэх цогц бодлого шаардагдсан.

Эдгээр хүчин зүйлс нь шүүхийн менежментийг боловсронгуй болгох үзэл баримтлалд нөлөөлсөн гол хүчин зүйл гэж хэлж болно.

Шүүхийн менежментийг боловсронгуй болгох үзэл баримтлал ба түүний хүрээ

Үүнийг хамгийн энгийнээр тодорхойлъё гэвэл эдгээр 6 хүрээ, түүнд тавигдсан зорилтуудыг хэрэгжүүлэх явдал гэж хэлж болно.



Хүрээ тус бүрээр нь товчхон авч үзвэл: Хэргийн хөдөлгөөний менежмент гэдэг бол шүүхэд хэрэг маргааныг хянан шийдвэрлэх бүхий л ажиллагааг зохион байгуулж, хүндрэл, хойшлолт, хүлээлт зэргийн шалтгааныг илрүүлэн тогтоох, тэдгээрийг залруулах арга замыг тодорхойлох, хэрэгжүүлэх, үр дүнд нь хяналт шинжилгээ хийх зэрэг ойлголтыг өөртөө багтаасан шүүхийн менежментийн үндсэн цөм нь юм.

Хэргийн хөдөлгөөний менежментийн хүрээнд шүүгч хэргийн хөдөлгөөнийг манлайлан удирдаж, хуульд заасан хугацаанд шуурхай хянан шийдвэрлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах, шүүхийн тамгын газар, хэлтэс нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрт бүртгэлээр хяналт тавьж, шаардлагатай мэдээллээр ерөнхий шүүгч, шүүгчид болон олон нийтийг хангах, мөн иргэний хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг өргөжүүлж, шүүгч хэргийн оролцогч, зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээдтэй ганцаарчлан уулзах ажиллагааг хязгаарлаж нэгэн зэрэг уулзах, урьдчилсан шүүх хуралдааны хэлбэрийг хэвшүүлэх зэрэг зорилтыг тусгасан.

www.mjs.gov.mn

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд 120 гаруй, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд 40 орчим, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд 120 гаруй заалт хэргийн хөдөлгөөнийг зохицуулдаг юм байна. Гэвч хэргийн хөдөлгөөн гэдэг ойлголт нь өргөн хүрээг хамардаг учир хуулиар зохицуулагдаагүй олон ажиллагаа /харилцаа/ үлдсэн байдаг бөгөөд эдгээрийг бүгдийг хуулиар зохицуулах ч боломжгүй юм. Тиймээс хэргийн хөдөлгөөний менежментийг боловсронгуй болгох замаар шийдвэрлэж болох юм. Тухайлбал, прокуророос ирсэн эрүүгийн хэргийг хэн хүлээж авдаг вэ? гээд үзэхэд л нарийн бичгийн дарга, шүүгч, шүүхийн бүртгэл хариуцсан нарийн бичгийн дарга гэх мэт шүүхүүдийн хувьд өөр өөр, мөн түүнчлэн хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдлыг ямар хуваарийн дагуу хэн, хэдээс хэдэн цагийн хооронд хүлээж авах нь бас л янз бүр байсан ба үүнээс шалтгаалж иргэдэд багагүй хүндрэл учруулдаг байсан.

Шүүхийн /захиргааны/ удирдлага, зохион байгуулалтын менежмент гэдэгт анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн удирдлага нь шүүхийн эрхэм зорилгод үндэслэн стратегийн зорилтуудыг тодорхойлж, төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжилтийн явц, үр дүнг хянах, цаг үеийн нөхцөл байдалд тохируулан зохицуулах, шүүгч, ажилтнуудын үйл ажиллагааг зохион байгуулалтын арга хэмжээ авах зэргийг хамааруулан ойлгоно.

Бүх шатны шүүхийн өөрөө удирдах ёсны хэлбэр болсон шүүгчдийн зөвлөгөөнөөр өөрийн шүүхийн стратегийн зорилтыг тодорхойлж, түүнийгээ тамгын газар, хэлтэстэй хамтран хэрэгжүүлдэг болох, шүүгч, шүүхийн ажилтны ажлын гүйцэтгэлийн чанар, үр дүнг сайжруулах зорилгоор тэдний ажлыг үнэлж дүгнэдэг болох, Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх, үүргийг өргөжүүлэхийн тулд Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газартай шууд харилцдаг төдийгүй шүүхийн төсвийн төслийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн өргөн барьснаар Засгийн газар нэгтгэн УИХ-аар хэлэлцүүлж батлуулдаг болох, түүнчлэн шүүхийн хүний нөөц, төсөв санхүүг оновчтой байршуулах, хуваарилах ажиллагааг Шүүхийн ерөнхий зөвлөл бие даан гүйцэтгэдэг болох, давж заалдах шатны шүүхийг тойргийн журмаар байгуулах, бүсчилэх асуудлыг шийдвэрлүүлэх зэрэг зорилтыг шүүхийн /захиргааны/ удирдлага, зохион байгуулалтын менежментийн хүрээнд дэвшүүлсэн юм.

Шүүхийн хүний нөөц, сургалт, давтан сургалтын менежмент гэдэгт шүүгч, ажилтнуудыг бэлтгэх, сонгон шалгаруулах, томилох, шинээр томилогдсон шүүгч, ажилтнуудыг дадлагажуулах, урт, богино хугацааны сургалтыг зохион байгуулах, үргэлжилсэн болон давтан сургалтад хамруулах, мэргэшүүлэх, албан тушаалын ангилал, зэрэглэл, үйл ажиллагааны үр дүнд дүйцэхүйц цалин хөлс олгох, ажлын байрны эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх, албан тушаал дэвших, зэрэг дэв ахих боломжоор хангах, удирдах болон бусад ажилтнуудын хоорондын үр ашигтай харилцаа холбоог тогтоох, ажлын гүйцэтгэл, үр дүнг хянаж дүгнэх, урамшуулах, хариуцлага хүлээлгэх зэрэг ажиллагааг хамаарна.

Тус менежментийн хүрээнд бүх шатны шүүхийн шүүгчдийг давтан сургах нэгдсэн бодлого боловсруулж зайны сургалтад шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах, хүний нөөцөд бүртгэгдсэн хүмүүсийг сургаж, дадлагажуулах болон шүүгчдийн сургалтын одоогийн тогтолцоог өөрчилж, тойргийн болон бүсчилсэн сургалтад шилжих, шүүгчдэд эрх зүйн төдийгүй эдийн засаг, сурган, сэтгэл судлал, санхүү, ня-бо бүртгэл, харилцааны ёс зүй, гадаад хэл, мэдээллийн техник хэрэгсэл дээр ажиллах чадвар эзэмшүүлэх зэрэг сургалт зохион байгуулж байх, шүүгчийн сонгон шалгаруулалтын журмыг өөрчлөн сайжруулах зорилгоор шүүгчид нэр дэвшигчээс эрх бүхий хүмүүсийн шийдвэрээр шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн талаар дүгнэлт гаргах ажиллагааг судалж шийдвэрлүүлэх зэрэг зорилтыг дэвшүүлсэн.

Шүүхийн мэдээлэл зүй, технологийн болон олон нийттэй харилцах менежмент гэдэгт шүүхийн үйл ажиллагааны техник технологийн боломжуудыг нэмэгдүүлэх, интернэт болон дотоод мэдээллийн системд техник хэрэгсэл ашиглах, орчин үеийн техник технологийг ашиглан мэдээлэл хүргэх аргыг нэмэгдүүлэх, шүүхийн шийдвэр, хууль тогтоомжийн мэдээллийн санг бий болгох, олон нийттэй харилцахад нээлттэй байлгах зэрэг үйл явцыг ойлгоно.

Ер нь шүүх нь мэдээллийн найдвартай баазгүйгээр цаг хугацаанд нь шийдвэр гаргах, өөрийн үйл ажиллагаанд хяналт тавих, үйл ажиллагааныхаа талаар нийтэд мэдээлэх боломжгүй юм. Мэдээллийн хангалтгүй байдал нь хүмүүсийн дунд шүүх үйл ажиллагааны талаарх эргэлзээг төрүүлдэг. Шүүхийн хаалттай байдал нь зөвхөн эргэлзээ төрүүлээд зогсохгүй хууль зөрчих нөхцөлийг бүрдүүлж байдаг. Иймээс үүнээс шалтгаалж иргэдэд багагүй хүндрэл учруулдаг байсан.

Дэлхий нийтэд технологи нэвтрүүлснээр шүүх улам бүр цаасгүй орчин руу шилжиж байна. Шүүхийн үйл ажиллагааны техник технологийн боломжуудыг нэмэгдүүлэх, интернэт болон дотоод мэдээллийн системд техник хэрэгсэл ашиглах, орчин үеийн техник технологийг ашиглан мэдээлэл хүргэх аргыг нэмэгдүүлэх, шүүхийн шийдвэр, хууль тогтоомжийн мэдээллийн санг олон нийттэй харилцахад зориулж нээлттэй байлгах зэрэг нь шүүхийн үйл ажиллагааг хөнгөвчилж, түргэн шуурхай байлгахад нөлөөлөх төдийгүй мэдээлэл түгээх замаар олон нийтийн дунд шүүхийн тухай зөв төсөөллийг бий болгоно.

Шүүхийн мэдээлэл зүй, технологийн болон олон нийттэй харилцах менежментийн хүрээнд шүүхийн шийдвэр, тогтоолыг эмхтгэн хэвлэж нийтийн хүртээл болгох, мэдээллийн сүлжээг саадгүй ажиллуулах мэргэжлийн ажилтнаар орон нутгийн шүүхийг хангах бүх шатны шүүхийн болон хуулийн бусад байгууллагын хооронд мэдээллийг компьютерийн сүлжээгээр /электрон аргаар/ дамжуулан солилцох аргыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх, шүүхүүд олон нийттэй харилцах орон тооны алба бий болгож мэдээлэл,

лавлагааны ажлыг хариуцуулах, бүх шатны шүүхийг интернэтэд холбож, вэбсайттай болгох, олон нийтэд нээлттэй байлгах нөхцөлийг бүрдүүлсэн шүүх хуралдааны танхимтай болох зэрэг зорилтыг тодорхойлсон.

Шүүхийн төсөв, санхүү хангамжийн менежмент гэдэгт шүүхийн төсвийн төслийг бодит хэрэгцээ шаардлагад үндэслэн боловсруулах, төсөв боловсруулах үйл явцад нэгжийн оролцоог нэмэгдүүлэх, шүүхийн төсвийг төлөвлөсөн хэмжээгээр батлуулах, батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулах зэрэг шүүхийн бие даасан байдлыг хангахуйц хэмжээний төсвийг бүрдүүлэх ажиллагаа хамаарна.

Тус менежментийн хүрээнд орчин үеийн техник хэрэгслээр шүүхүүдийг цаг тухайд нь хангах асуудлыг боловсруулж, хэрэгжүүлэх, төсвийн төлөвлөлтийг үндэслэлтэй болгохын тулд хэрэг хянан шийдвэрлэхэд гарах дундаж зардлыг бүсчилэн тогтоосон нормативын дагуу төлөвлөдөг болох, зохих стандартад нийцсэн зориулалт бүхий шүүхийн байртай болгох, шүүгчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх нэгдсэн бодлого боловсруулж мөрдөхийн зэрэгцээ тэдгээрийн орон сууны асуудлыг төрийн албан хаагчдын орон сууцны хөтөлбөрт хамруулах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх, шүүн таслах ажиллагааны үр дүнгээр улсын төсөвт орж байгаа орлогын тодорхой хувийг шүүхийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор хуваарилах асуудлыг судалж шийдвэрлүүлэх зэрэг зорилтыг тодорхойлсон.

Шүүх улсын төсвийн 5-10 хувийг эзэлж байхад хараат бус ажиллаж чадна гэж дэлхий нийтэд үздэг байхад манай шүүх ердөө л төсвийн 0.4 хувийг эзэлж байгаа нь хэтэрхий бага байгаа юм. Иймээс ядаж 1.5 хувьд хүргэх бодит шаардлага гарч байна.

Шүүхийн төсвийг улсын нэгдсэн төсвийн 1-1.8 хувиар тогтоодог улс орны жишиг ч байдаг юм байна. Тухайлбал, Европ тивд л гэхэд Швейцарь, Словак, Португали, Литва, Хорват, Румын зэрэг улсад нэгдсэн төсвийн 1 хувь, Польш, Норвеги улсад 1.7-1.8 хувь ногддог байна.

Шүүхийн статистик тоон мэдээлэл, шүүн таслах ажиллагааны практикийг нэгтгэн судлах ажлын менежмент гэдэгт шүүн таслах ажиллагааны статистик тоон мэдээлэл, практикийг судлах, боловсруулалт хийх, олон нийтийг болон байгууллагыг бодит мэдээллээр хангах, хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх, ялын бодлогыг оновчтой тодорхойлох, санал зөвлөмж боловсруулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг боловсронгуй болгох, түүнийг шүүхийн нэгдсэн практик тогтооход чиглүүлэх үйл ажиллагааг хамааруулан ойлгоно.

Тус менежментийн хүрээнд шүүхийн практик судлалын холбогдолтой мэдээллийн сан бүрдүүлэх программыг боловсронгуй болгох, шүүхэд нөлөөлж болзошгүй гадаад, дотоод орчны судалгаа хийж байх, шүүхэд өдөр тутам хэрэглэгддэг хуулиудын хэрэгжилт, зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр шүүхийн практикийг нэгтгэн судалж, үр дүнг хууль тогтоогчид мэдээлж байх, шүүхийн судалгааны төвийг эрдэмтэд мэргэшсэн судлаачдаар бэхжүүлж, орон тоо, техник хэрэгслийг нэмэгдүүлэх замаар эрдэм шинжилгээний байгууллагын түвшинд хүргэх, шүүн таслах болон захиргааны ажлын практикийг судалж үр дүнг компьютерийн сүлжээгээр нийт шүүхэд мэдээлэх зэрэг зорилтыг тус менежментийн хүрээнд тодорхойлсон.

Үзэл баримтлалд тусгагдсан олон зорилт хэрэгжиж байна. Тухайлбал:

- Шүүх хуралдаанд хэвлэл мэдээллийн болон бусад байгууллагын төлөөлөгч, иргэнийг оролцуулахад бичгээр зөвшөөрөл авдаг байсныг шинэчилснээр иргэд, олон нийт шүүх хуралдааныг чөлөөтэй сонирхох таатай нөхцөл бүрдлээ.
- Нийт шүүхэд "Мэдээлэл лавлагааны төв" байгуулагдлаа.
- Шүүхэд өргөдөл, гомдол, нэхэмжлэл хүлээн авахдаа өдөр, цаг зааж хязгаарладаг байсныг ажлын өдөр бүр авдаг болсноор иргэдийн чирэгдлийг арилгалаа.
- Нийслэл, дүүргийн шүүхийн шүүх хуралдааны танхимуудыг олон улсын жишигт нийцсэн тавилга, тоног төхөөрөмжөөр шинэчилсэн нь талууд мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх, шүүн таслах ажиллагаа хэвийн явагдах нөхцөл дээшиллээ.
- Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын санхүүгийн дэмжлэгээр шүүхүүдийг компьютержуулах, шинэ байртай болгох, байрыг засварлах тавилга, тоног төхөөрөмжөөр хангах, шүүгч, ажилтнуудыг сургах, давтан сургах, гарын авлага бэлтгэх зэрэг олон ажил өргөн хүрээтэй хэрэгжиж байна.
- Шүүхийн шийдвэр, шийтгэх тогтоолууд хэвлэгдэж нийтийн хүртээл боллоо. Цахим хөтөлбөрийн хүрээнд шүүхэд хянагдаж буй хэрэг бүрийн ажиллагааг иргэд, олон нийт гэрээсээ хянах боломж нөхцөл бүрдлээ.
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны болон Улсын дээд шүүхийн тамгын газрын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөж, аймаг, нийслэлийн болон нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн тамгын хэлтсийн үйл ажиллагааны дүрэм батлагдлаа. Шүүхийн бусад үйл ажиллагааг зохицуулсан олон арван дүрэм, журам стандарт шинэчлэгдэн мөрдөгдөж байна.

Түүнчлэн үзэл баримтлалын бүтэц бүрийг хэрэгжүүлэх ажлын хэсгүүд Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоолоор байгуулагдан судалгаа шинжилгээ хийж байгаагийн зэрэгцээ Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг боловсруулж байна.

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВШИЛ

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн О.Зандраа

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "... эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно" гэсэн заалтын дагуу 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар Захиргааны хэргийн шүүх байгуулагдан 2004 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс Захиргааны хэргийн дагнасан шүүх аймаг, нийслэлд үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш хоёр жил гаруй хугацаа өнгөрлөө. Аймаг, нийслэлийн Захиргааны хэргийн шүүхүүдэд нийт 70 шүүгч ажиллахаас өнөөдрийн байдлаар 58 шүүгч, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд 6 шүүгч ажиллахаас 5 шүүгч тус тус ажиллаж байгаа бөгөөд Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн 2 шүүгч гадаадад сургалтад хамрагдаж байна.

Манай улсад анх удаа нийтийн эрх зүйн субъект болох захиргааны байгууллага, албан тушаалтны хууль дээдлэн, хүний эрхийг хэрхэн хангаж байгааг иргэд, хуулийн этгээдийн нэхэмжлэлийн үндсэн дээр хянан шалгаж, тэдгээр байгууллага, албан тушаалтны хууль бус акт, /үйлдэл, эс үйлдэхүйгээр илэрдэг/ дур зоргын үйл ажиллагаанаас хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг нь сэргээн тогтоох зорилготой Захиргааны хэргийн шүүх байгуулагдсан нь Монгол Улсын эрх зүйн шинэтгэл, шүүхийн тогтолцоонд чухал ач холбогдолтой үйл явдал болсон бөгөөд цаашид шинэ шүүхийн зорилгыг биелүүлж, үйл ажиллагааг зөв төлөвшүүлэн явуулах эрхэм үүрэг бидэнд ногдсон билээ.

Ардчилсан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмуудын хэрэгжилт, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангахад шүүх байгууллагын тогтолцоо оновчтой, эрх мэдэл хүрэлцэхүйц байх ёстой. Энэ шаардлагаас урган гарсан нийгмийн хэрэгцээ олон улсын хандлагаас улбаалан нийтийн засаглалын байгууллага, албан тушаалтнууд үйл ажиллагаандаа ардчиллын үндсэн зарчмуудыг хэрхэн баримталж буйд захиргааны хэргийн шүүх дагнан хяналт тавих боломж бүрдсэн юм.

Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагаа нь ардчилсан төрийн салшгүй нэг чухал элемент болохын хувьд хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг хангах нэгэн баталгаа болдог бөгөөд өнөөдрийн байдлаар Аймаг, нийслэлийн Захиргааны хэргийн шүүх, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ хуульд захирагдан, хуулиар харьяалуулсан хэрэг, эрх зүйн маргааныг хэний ч нөлөөнд авталгүйгээр, гагцхүү нотлох баримтад тулгуурлан хуулийн заалтад чанд нийцүүлэн, гадны ямар нэгэн хязгаарлал, дарамтгүйгээр шийдвэрлэж, шүүн таслах ажиллагааг мэтгэлцэх зарчмын үндсэн дээр явуулж, хараат бусаар, бие даан ажиллаж байна.

2004 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс 2006 оны 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд Захиргааны хэргийн шүүхүүд бүгд 1737 нэхэмжлэл хүлээн авч, 836 захиргааны хэргийг зохих хуулийн дагуу хянан шийдвэрлэжээ. Дээрх хугацаанд шийдвэрлэсэн нийт хэргийн 25.8 хувь буюу 216 хэргийг Газрын тухай хуулиар, 12.5 хувь буюу 105 хэргийг Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай хуулиар, 15.5 хувь буюу 130 хэргийг Төрийн албаны тухай хуулиар, 8.8 хувь буюу 74 хэргийг Татварын багц хуулиар, 5.7 хувь буюу 48 хэргийг Ашигт малтмалын тухай хуулиар тус тус шийдвэрлэснээс үзэхэд "хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх", "шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох, төрийн байгууллагад сонгох, сонгогдох", "ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах", "эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах" зэрэг эрхүүдээ хууль бус захиргааны актын улмаас зөрчигдсөн гэж үзэж иргэн, хуулийн этгээдээс захиргааны хэргийн шүүхэд хандаж байгаа явдал олонтаа байна.

Мөн хянан шийдвэрлэсэн хэргийн 50 хувь буюу 418 нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хангаж, захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргасан захиргааны актыг хүчингүй болгож, иргэд, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээн шийдвэрлэснээс үзэхэд захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны улмаас хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдөөгүй бөгөөд түүнийг таслан зогсоож, тэдгээрийн хууль бус үйл ажиллагаанаас хүний эрхийг хамгаалах зорилготой байгуулагдсан Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагаа, эрх хэмжээг багасгах биш, харин улам өргөжүүлж, Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлж, төрийн эрх мэдлийн тэнцвэрт байдлыг бий болгон хүний эрх, эрх чөлөөг хангахад хууль тогтоох болон хуулийг хэрэгжүүлэх үүрэг бүхий гүйцэтгэх засаглалын зүгээс анхаарч, шинэ шүүхийн үйл ажиллагааг дэмжин, цаашид өргөжүүлэх шаардлагатайг харуулж байна. Энэ хугацаанд шийдвэрлэсэн нийт хэргийн 26.1 хувь буюу 219 нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа хуульд нийцсэн болохыг тогтоожээ.

Өнгөрсөн хугацаанд Захиргааны хэргийн шүүхийн талаарх тодорхой ойлголт олон нийтийн дунд сайн биш байгаагаас нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг дутуу бүрдүүлэх, урьдчилан шийдвэрлүүлэх ажиллагааг хангахгүйгээр шууд шүүхэд хандах явдал их байлаа.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны улмаас эрхээ зөрчигдсөн гэж үзсэн хэн боловч дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж, урьдчилан шийдвэрлүүлэхээр заасан бөгөөд энэ нь захиргааны байгууллага, албан тушаалтанд өөрсдийн гаргасан хууль бус шийдвэрээ засах боломжийг олгосон явдал юм.

Иргэд, хуулийн этгээдээс энэ

журмаар захиргааны байгууллагад хандахад хариу өгөхгүй удаах, уг өргөдөл, гомдлыг шийдвэрлээгүй байж тухайн захиргааны актыг хэрэгжүүлэх зэргээр Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6, 7, 8, 9 дүгээр зүйл, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 11, 12, 13, 15, 16 дугаар зүйлийн заалтуудыг нэг мөр хэрэгжүүлэхгүй байгаагаас шинэ шүүхийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх хандлага ажиглагдаж байна. Учир нь иргэн, хуулийн этгээд хуулийн дээрх заалтыг бүрэн гүйцэд ойлгоогүй, захиргааны хэргийн шүүхэд шууд хандах, үүнийг нь хуульд зааснаар урьдчилан шийдвэрлүүлэхээр буцааснаас иргэн, хуулийн этгээд чирэгдэх явдал цөөнгүй байна.

Улсын дээд шүүхийн 2004 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Улсын дээд шүүхэд Захиргааны хэргийн танхим байгуулагдаж, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т зааснаар захиргааны хэргийг давж заалдах болон хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэх, захиргааны хэргийн шүүхүүдийг мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд давж заалдах журмаар аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүхүүдээс нийт 316 хэрэг ирүүлснээс давж заалдах шатны шүүх хуралдаанаар 269 хэргийг хянан шийдвэрлэснээс 119 шийдвэрийг хэвээр үлдээж, 62 шийдвэрт өөрчлөлт оруулан, 88 шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэжээ. Мөн хугацаанд хяналтын журмаар аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүхүүдээс нийт 182 хэргийг хүлээн авч, хяналтын шатны шүүх хуралдаанаар 122 хэргийг хянан шийдвэрлэснээс 70 хэргийн шийдвэр, магадлалыг үлдээж, 19 шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, 33 шийдвэр, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны 37 тогтоолыг эс зөвшөөрч Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчид гомдол гаргаснаас 35 хэргийг Ерөнхий шүүгч дүгнэлт бичих үндэслэлгүй гэж хариуг өгсөн, 2 хэрэгт Ерөнхий шүүгч дүгнэлт бичиж, Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцүүлснээс хяналтын шатны шүүх хуралдааны 1 тогтоолд өөрчлөлт оруулан, 1 тогтоолыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэсэн байна.

Захиргааны хэргийн танхимаас аймаг, нийслэлийн захиргааны хэргийг мэргэжлийн удирдлагаар хангах чиглэлээр "Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар", "Газрын тухай хуулийг шүүхийн практикт нэг мөр ойлгож, зөв хэрэглэх тухай", "Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 79, 90 дүгээр зүйлийг хэрэглэж байгаа шүүхийн практикийн тухай" зөвлөмжүүдийг гаргаж, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтуудыг тайлбарлах тухай төсөл боловсруулж, нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж батлууллаа. Цаашид Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинжлэх ухааны тайлбарыг Ханнс-Зайделийн сантай хамтран гаргахаар ажиллаж байна.

ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, Дэлхийн банкны "Шүүх, эрх зүйн шинэчлэлт төсөл", АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн "Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр" төслийн багийн хамт олон болон дотоод, гадаадын эрдэмтэн, судлаачид Захиргааны хэргийн шүүхийг байгуулах, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг батлуулах, түүнийг боловсронгуй болгох, захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийг сургах, давтан сургах, тус шүүхийн үйл ажиллагааг сурталчлах, ахуй хангамжийг сайжруулан, техник технологийн туслалцаа үзүүлэх зэргээр бидний ажилд байнга дэмжлэг, туслалцаа үзүүлсний үр дүнд захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагаа харьцангуй хурдан төлөвшиж байна.

ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн "Эрх зүйн боловсрол" академиас Захиргааны хэргийн шүүгч нарт 5, нарийн бичгийн дарга, туслахуудад 1 удаа, Дэлхийн банкны шүүх, эрх зүйн шинэчлэлт төслөөс шүүгч, нарийн бичгийн дарга, туслахуудад 3 удаагийн сургалтыг тус тус амжилттай зохион байгуулж, захиргааны хэргийн шүүхийн шүүгч, нарийн бичгийн дарга, туслахууд бүрэн хамрагджээ.

Мөн Ханнс-Зайделийн сангаас ХБНГУ-ын Бавари муж улсын Мюнхен хотын Захиргааны хэргийн шүүх болон захиргааны байгууллагын ажиллагаатай танилцуулах сургалтыг зохион байгуулж, Улсын дээд шүүхийн шүүгч нар болон аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 19 шүүгчийг хамруулсан байна.

Дэлхийн банкны шүүх, эрх зүйн шинэчлэлт төслийн хүрээнд Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн барилга, шүүх хуралдааны танхим болон шүүгч нарын өрөөг засаж, компьютер, техник хэрэгслээр тоноглосноос гадна Увс аймгийн шүүхийн барилгыг шинээр барих, Архангай, Хөвсгөл, Хэнтий, Төв аймгийн шүүхийн байрыг өргөтгөх, Баян-Өлгий, Завхан, Ховд, Сэлэнгэ, Орхон аймгийн шүүхийн барилгад их засвар хийх, шүүх хуралдааны танхимуудыг сүүлийн үеийн тавилга, техник хэрэгслээр бүрэн хангах, компьютер, принтерээр хангах ажлууд хийгдэж байна.

Захиргааны хэргийн шүүхийн зорилго, чиг үүрэг, шийдвэрийн үндэслэл, ач холбогдол, үр дагаврыг иргэд олон нийт, байгууллага, албан тушаалтанд сурталчлах ажлыг эрчимжүүлж, захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагаанаас эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах боломжтой болохыг тайлбарлан таниулах ажлыг төв, орон нутгийн шүүхүүд, эрдэмтэд, судлаачид, төслийн багийн хамт олонтой хамтран зохион байгуулах шаардлага ч зүй ёсоор тавигдаж байна.

Үүний үндсэн дээр Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх хэрэг, эрх зүйн маргаан ихэссэнээр шинэ шүүхийн үйл ажиллагаа жигдэрч, дадлага туршлага хуримтлуулан, үйл ажиллагаагаа төлөвшүүлэх ач холбогдолтой юм.

Цаашид "... Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно" гэсэн Үндсэн хуулийн заалтын дагуу шинэ тутам байгуулагдсан захиргааны хэргийн шүүх үйл ажиллагаагаа явуулж, шударга ёс, хууль зүйг чандлан сахиж ажиллах болно.

ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ТУХАЙД

Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн нарийн бичгийн дарга,
хууль зүйн магистр Ц.Баярмаа

Шүүх ажиллагаа гэдэг бол ярьж буй хууль, хууль гэдэг бол үл яригч шүүх

Шүүх эрх мэдэлд шүүх, шүүн таслах ажиллагаа гэсэн хоёр ойлголт багтах ба шүүн таслах ажиллагаа шүүх эрх мэдэл хоёр нь тусдаа тодорхойлогдоно.

Шүүн таслах ажиллагаа

Эхлээд социалист эрх зүйн систем үйлчилж байх үед манай хөрш орон ОХУ-д (одоогийн ОХУ ба ТТУХ-ийн орнууд) **шүүн таслах ажиллагааг** ямар утга агуулгаар тодорхойлж байсныг авч үзье.

Тэр үеийн төлөөлөгчдийн нэг болох Б.Н.Чичерин "хуулийн дагуу үнэлж болох бүхнийг үнэлэх"[1] гэсэн бол 1920-иод оны үед социалист эрх зүйн онолын үүднээс Н.Н.Полянский "эрүүгийн шүүх шүүн таслах ажиллагаа нь шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолыг (шийтгэх) мөрдлөг болгох замаар обьектив эрх зүйн дэг журам, засгийг хамгаалах өөрийн зорилгыг агуулна"[2] гэснээс гадна Зөвлөлт засгийн үеийн сонгодог гэгдэх сурах бичгийг зохиогчдын нэгдсэн дүгнэлтээр "шүүн таслах ажиллагаа нь шүүх хуулийг хэрэглэх онцгой төрөл"[3] гэж тодорхойлж байв.

Дээрх ойлголтуудыг өнөөгийн судлаачдынхтай харьцуулбал (эрх зүйт төрийн) мэдээж учир дутагдалтай, явцуу утгыг илэрхийлнэ. Тэдгээр судлаачдын тодорхойлсноор тухайн үед хамгийн ерөнхий утгаар шүүн таслах ажиллагаа нь "эрх зүйг хэрэглэх өөрийн гэсэн утга агуулгатай төрийн үйл ажиллагааны хэлбэрийн нэг, өөрөөр хэлбэл эрх зүйг хэрэглэх хэрэг шүүн шийдэх үйл ажиллагаа"[4] юм. Энд хууль, эрх зүй хоёрын байрыг сольсон нь уг хоёр ойлголтыг нэг утга агуулгаар ойлгож байсныг харуулж байна.

Хэрвээ үүнийг орос хэлний хэл зүйн талаас нь тайлбарлавал *Шүүн таслах ажиллагаа* буюу *правосудие* нь эрх зүйг хэрэглэх шүүхийн үйл ажиллагаа болно. Үүнээс харахад дээр дурдсан тодорхойлолт нь хэл зүйн утганд үндэслэсэн бололтой.

Монгол хэлний тайлбар тольд шүүх эрх мэдлийг тусад нь авч үзэлгүй зөвхөн эрх мэдэл гэсэн ойлголтыг тайлбарлажээ. Уг тайлбарт "эрх мэдэл-ямар нэг үйл ажлыг өөрийн санасан бодсоноор таслан шийдвэрлэх хувь мэдэл"[5] гэжээ.

Дээрх сурах бичгийн тодорхойлолтоос харахад хэл зүйн ойлголт хууль зүйн ойлголт нь хоорондоо уялдаа холбоотой ч өөр өөрийн онцлогтой бие даасан шинжлэх ухаанууд гэдгийг харгалзаж үзээгүйгээс ямар алдаанд хүрдгийг мөн шүүх эрх мэдэл нь ямар өргөн ойлголт болохыг харж болно. Тухайн үед хууль зүйч эрдэмтэдийн ихэнх нь "шүүн таслах ажиллагаа-төрийн тусгай байгууллага болох шүүх эрх зүйн хэм хэмжээг эрүү, иргэний хэрэгт сонгож хэрэглэх процессийн дэг журамд (эрх зүйд) гардаг (үйлдэгддэг), шаардлагатай тохиолдолд, төрийн ба олон нийтийн байгууллага иргэний эрхийг хамгаалах үйл ажиллагаа"[6] гэж үзэж байв.

Шүүн таслах ажиллагааг арай өргөн хүрээнд түүний эрх зүйн зарчимд тулгуурлан ойлгох болсон 1990-ээд оны судлаачдын бүтээлээс авч үзье.

"Шүүн таслах ажиллагаа гэдэг нь шүүхийн шийдвэрийн ерөнхий хариуцлага ба шударга ёс, үндэслэл хууль ёсыг ханган хуулийн шаардлага тэдгээрт тогтоосон дэг журмыг хэлбэрэлтгүй сахин биелүүлэх замаар эрүү, иргэний хэргийг хянан, таслан шийдвэрлэх шүүхээр гүйцэтгэгдэх хууль хамгаалах үйл ажиллагаа"[7] гэснийг ажиглавал:

1. Шүүхийг хууль хамгаалах байгууллагуудын (цагдаа, прокурор) тоонд оруулжээ. Шүүх нь хууль хамгаалах болон гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагын аль нь ч биш иргэдийн зөрчигдсөн эрхийг хамгаалах байгууллага юм;
2. Зөвхөн шүүх гүйцэтгэх гэж онцолж авч үзээгүй учир хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өөр ямар нэгэн байгууллага гүйцэтгэж болох юм шиг, шүүх тэдгээр байгууллагуудын нэг хэсэг мэт ойлгогдож байна;
3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь зөвхөн үйлдсэн хэргээр хязгаарлагдахгүй, бусад төрлийн дагнасан шүүх байгуулж болохоор шүүхийн тухай хуульд заасан;
4. Шүүхийн хараат бус, бие даасан байдлын талаар огт хөндөөгүй юмуу гэсэн санаа гарч байна.

Шүүх эрх мэдэл

Монгол Улсын Үндсэн хуулийн 47 дугаар зүйлд "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ". Үүнээс л бүх заалтын утга агуулга эх ундаргатай.[8] Үүнээс үзвэл шүүх эрх мэдэл нь зөвхөн шүүхэд хамаарагдах ойлголт юм. 1992 оны Үндсэн хуулийг баталж байхад шүүх эрх мэдэл бүлгийн нэрийн тухайд "шүүх засаг, шүүх, шүүхийн үйл ажиллагаа" гэж нэрлэх саналууд орж ирсэн ч 54 хувийн

[1] Чичерин.Б.Н "Курс государственной науки. Часть 1-Общее государственное право". Мк., 1894, с.319.
[2] Полянский.Н.Н "Очерк общей теорий уголовного процесса". Мк., 1927, с. 66
[3] См. Суд и правосудие в СССР /Под ред. Б. А. Галкина/, Мк., 1981, с. 15
[4] Мөн тэнд, с. 12.
[5] Я. Цэвэл "Монгол хэлний товч тайлбар толь". УБ., 1996
[6] Филиппов.П.М "Судебная защита и правосудие в СССР". Саратов, 1987, с. 29
Строгович.М.С "Курс советского уголовного процесса". Т.1. Мк., 1968, с. 14
Семёнов.В.И "Суд и правосудие в СССР". Мк., 1976, с. 21
[7] Правоохранительные органы в СССР / Под ред К. Ф. Гуценко. Мк., 1991, с. 235
[8] Шүүх эрх мэдэл - Шинэ зуун. 44 дэх тал

саналаар "шүүх эрх мэдэл" гэсэн нэр хэвээр батлагджээ.[1]

Шүүх эрх мэдлийн талаарх оросын орчин үеийн үзэл баримтлалаас авч үзвэл: Шүүх эрх мэдлийг (судебная власть) зөвхөн шүүх хэрэгжүүлэх ба шүүх нь ард түмний төлөөлөл болж шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг гүйцэтгэнэ. Шүүх эрх мэдэл нь бие даасан байх ба хууль тогтоох гүйцэтгэх засаглалаас хараат бусаар ажиллана.[2]

Шүүх эрх мэдэл гэсэн ойлголтод[3]:

1. **Гүнзгий утгаараа**, шүүх эрх мэдэл нь тусгай журмын дагуу нийгэмд үүссэн маргааныг тусгай журмын дагуу хянан шийдвэрлэх бүрэн эрх;
2. **Зохион байгуулалтын.** Зөвхөн шүүх эдлэх бүрэн эрх гэсэн салшгүй нэгдмэл үндсэн хоёр санаа агуулагдана.

Шүүх, шүүх эрх мэдэл ба шүүн таслах ажиллагаа нь адил биш ч уялдаа холбоотой ойлголтууд ба шүүх эрх мэдэл нь шүүн таслах ажиллагааг гүйцэтгэж, шүүн таслах ажиллагааг зөвхөн шүүх хэрэгжүүлнэ. Шүүх эрх мэдэл нь шүүн таслах ажиллагааны хэлбэрээр хэрэгждэг (үндсэн хууль, захиргаа, иргэн, эрүү, процессийн) ба Үндсэн хуульд заагдсан хүн, иргэний эрх, эрх чөлөөг хамгаалах чиг үүрэгтэй. Шүүх эрх мэдлийн агуулга нь хүний эрх, эрх чөлөөг хангахад оршино[4].

Өнөө үед шүүх эрх мэдлийг ямар агуулга, хэмжээ хүрээнд ойлгож байгаагаар нь тухайн улсын шүүхийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээг тодорхойлох боломжтой. 1992 онд шинэ ардчилсан Үндсэн хууль батлагдсанаар шүүх эрх мэдэл (шүүх засаглал), шүүхийн бие даасан шүүгчийн хараат бус байдал гэсэн шинэ ойлголтууд гарч эрдэмтэд судлаачдын хувьд судлах зүйлүүдийн нэг болон тавигджээ.

2001 онд судлаачид хэрхэн тодорхойлж байсныг авч үзвэл «Шүүх эрх мэдэл» гэдэг бол шүүн таслах ажиллагаа явуулах бүрэн эрхийн цогц нийлбэр бөгөөд:

- Эрүү, иргэн, захиргааны болон Үндсэн хуулийн хэрэг, маргааныг байцаан шийтгэх хууль тогтоомжид заасны дагуу хянан шийдвэрлэх бүрэн эрх;
- Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах /зарим оронд эрх зүйн хэм хэмжээг тогтоох/ бүрэн эрх;
- Хяналтын бүрэн эрх /баривчилсан буюу албадан саатуулсан нь хууль ёсны эсэхийг шалгах/;
- Өөр бусад бүрэн эрх /зарим оронд фактыг тогтоох, хуулийн этгээдийг бүртгэх/ зэргээс бүрдэнэ[5] гэж үзсэн бол, доктор (Ph) Б. Чимид шүүх эрх мэдэл нь **нэгдүгээрт,** эрүү, иргэний хэрэг тэдийгүй эрх зүйн бусад "бүх" маргааныг эцэслэн[6] хянан шийдвэрлэх; **хоёрдугаарт** хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаанд хуулиар тогтоосон хэмжээ хязгаарын дотор гадны хяналт тавьж хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн эрх мэдлийн бие даасан салаа мөн[7] гэвэл шүүх эрх мэдэл нь шүүн таслах ажил гэдгээс илүү өргөн бөгөөд өөр утга чанартай гэж тэмдэглэжээ.

Өөр нэгэн судлаачийн тодорхойлсноор "Үндсэн бүрэн эрх болсон шүүх эрх мэдэл нэгэнтээ хэргийн эцсийн хувь заяаг буюу үйлдэл, эс үйлдлийн гэм буруутай эсэхийг тогтоох эрх тул энэ нь зөвхөн шүүх хуралдааны үед шүүх бүрэлдхүүнээс шийдвэр гаргах хэлбэрээр хэрэгжүүлэх эрх мэдэл"[8] гэсэн нь шүүх эрх мэдлийг зөвхөн шүүн таслах ажлын хүрээнд авч үзжээ.

Шүүх эрх мэдлийн чиг үүрэг нь нийгмийн дотор хууль тогтоогчдоос тогтоосон хэм хэмжээг гүйцэтгэж биелүүлэх явцад эрх зөрчигдсөн тохиолдолд шүүх эцсийн шийдвэр гаргах юм.

- Маргааны үндсэн дээр асуудлыг шийдэх;
- Бусдаас хараат бус байж бие даасан асуудлыг шийдэх эрх;
- Шийдвэрлэж буй асуудлаар эцсийн шийдвэр гаргах эрх;
- Гаргасан шийдвэр нь заавал биелэгдэх хүчинтэй байх эрх ба шаардлагатай бол албадан гүйцэтгэх зэрэг шүүн таслах эрх эдгээр нь шүүх бүрэн эрхийн онцлог ба бусад бүрэн эрх, хууль тогтоох эрх мэдэл, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудад хамааралтай бүрэн эрхээс ялгагдах гол ялгаа нь юм.

Шүүх эрх мэдэл нь шүүхийн үйл ажиллагаанаас гадна түүний бүтэц, зохион байгуулалттай холбоотой ба түүнээс хамаарна. Энэ нь бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөхийн хирээр шүүх эрх мэдлийн агуулга шинэчлэгдэн өөрчлөгдөж шүүхийн зохион байгуулалт нь түүнийг тодорхойлох нэг хүчин зүйл гэж үзсэнийх. Шүүх эрх мэдлийг бүрэн эрхийн нийлбэр цогц гэж үздэг байсан бол дагнасан шүүх (захиргааны) байгуулагдсаны буюу ажиллаад хэсэг хугацаа өнгөрсний дараа хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад хяналт тавигчийн үүднээс ойлгох ойлголт давамгайлах хандлагатай болох юм. Энэ нь шүүхийн нэр хүндийг ч өсгөнө.

Шүүх эрх мэдлийг өөрийн үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчмын хүрээнд Үндсэн хууль болон бусад хуульд заасны дагуу хүний зөрчигдсөн эрх, эрх чөлөөг сэргээн хамгаалах зөвхөн шүүх хэрэгжүүлэх бүрэн эрхийн нийлбэр цогц ба гүйцэтгэх, хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих эрх мэдэл гэж ойлговол зүйтэй юм.



[1] Шүүхийн Ерөнхий Зөвлөл "Шүүх эрх мэдэл сэтгүүл", 2001, №12. 32 дахь талд. БНМАУ-ын АИХ-ын 1991 оны12 дугаар сарын 14-ний өдрийн 32 дугаар протоколоос

[2] См. Ведомости Сьезда народных депутатов Российской Федераций и Верховного Совета Российской Федераций 1992, 3, с. 1792. 1993, 17, с. 606

[3] "Государство и право" 2001. №5, с. 50. В. А. Лазарева. Судебная власть и уголовное судопройзводство

[4] Стецовский.Ю.И "Судебная власть. Учебное пособие". Мк., 1999 идр. с. 54

[5] Шүүх эрх мэдэл-Шинэ зуун. Ханнс Зайделийн сан. 2001, МУ-ын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ч.Ганбат "Шинэ зуун ба шүүх", 37 дахь тал

[6] Зохиогч энд гүйцэтгэх эрх мэдлийн ямар ч байгууллага маргааныг зөвхөн урьдчилан шийдвэрлэдэг, эцэстээ тэр нь шүүхээр хянагддаг гэсэн утгаар хэлэв.

[7] Шүүх эрх мэдэл-Шинэ зуун. Ханнс Зайделийн сан. 2001, Б. Чимид "Шүүх эрх мэдлийн талаархи Үндсэн хуулийн үзэл баримтлалын тухайд", 45 дахь тал

[8] Эрх зүй сэтгүүл. №2-3. Н.Мягмар "Шүүхийг өөрөөр ойлгохуй", 100 дахь тал

Ял эдэлж буй хэрэгтний бусдад учруулсан хохирлыг төлүүлэх ажиллагаа

Нэгдсэн Үндэсний Байгууллагаас 1985 онд "Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирсон хохирогчийн талаарх эрх зүйн зохицуулалтын үндсэн зарчмын тухай тунхаглалд"[1]-д Нэгдсэн Үндэсний Байгууллагын гишүүн бүхий бүх улс орнууд нэгдэн орсон юм.

Уг тунхаглалаар гэмт хэргийн хохирогчдын эрх ашгийг хамгаалах үндсэн зарчмыг тогтоож, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг бусад эх үүсвэрээс барагдуулах боломжгүй тохиолдолд хүч хэрэглэсэн, хүнд гэмт хэргийн улмаас сэтгэл санаа, бие эрхтэн, эд хөрөнгийн хувьд хохирсон хохирогч болон түүний гэр бүлийн гишүүд, асрамж, халамжинд нь байсан бусад этгээдэд учирсан хохирлыг төрөөс нөхөн олговор олгох замаар барагдуулж байх нь зүйтэй гэж үзсэн.

Үүний зэрэгцээ Европын холбооноос 1983 онд гэмт хэргийн улмаас хохирол барагдуулах ажлыг зохион байгуулах, төрийн тусгай сан байгуулах асуудлаар "Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчдын хохирлыг нөхөн барагдуулах тухай" конвенцийг батлаж уг конвенц 1988 оноос хүчин төгөлдөр үйлчилж, Европын холбооны 12 улс соёрхон баталж, 9 улс гарын үсэг зурааж байгаа юм.

Судалгаануудын дүнгээс үзэхэд, гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн хохирлыг төрөөс барагдуулах ажиллагаа дэлхийн 30 гаруй оронд хийгдэж байна.

Зарим улс орны нөхөн төлбөр олгож буй үндэслэл, зориулалт нь харилцан адилгүй. Тухайлбал, гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирол болон сэтгэцийг хэвийн байдалд оруулан сэргээх үйлчилгээний зардлыг олгож байхад нөгөө хэсэгт гэмт хэргийн улмаас оршин суух газар, ажлаа сольсоны зардал, оршуулгын зардал, нас барсан этгээдийн гэр бүл, төрөл



ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих тасгийн хяналт шалгалтын байцаагч, ахлах дэслэгч Ч.Өнөрцэцэг

садан, санхүүгийн хувьд хараат байсан этгээдийн алдсан орлого, асрамж, халамж зэрэг хохирлыг барагдуулах замаар нөхөн төлбөрийг олгож байна.

Нөхөн төлбөр олгох санхүүгийн эх үүсвэрийг гэмт хэрэг, зөрчилд ногдуулсан торгууль, хураагдсан орлогын эх үүсвэрээр санхүүжүүлдэг байна. Америкийн Нэгдсэн Улс болон зарим оронд "гэмт хэрэгт холбогдсоны торгууль" ногдуулан нөхөн төлбөрийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлдэг байна.

Төрөөс хохирол барагдуулах ажиллагааг эрдэмтэд төр нь иргэдээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл боломжоор хангах, иргэдийг гэмт халдлагаас хамгаалах үүрэг, иргэддээ үзүүлэх баталгаатай холбон тайлбарласны зэрэгцээ энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд ч иргэн нь "хууль, шүүхийн найдвартай хамгаалалтад байж учруулсан хохирлоо арилгуулах"[2], "зөрчигдсөн эрхээ нөхөн сэргээх"[3] үүргийг тус тус тунхагласан билээ.

Монгол Улсад гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирол хэрхэн төлөгдөж байгаа талаарх судалгааны дүнгээс харахад гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүсийн[4]

- 1.2 хувь нь бүрэн;
- 9.3 хувь нь боломжийн хэмжээнд;
- 48.8 хувь нь хагас дутуу;
- 11.1 хувь нь огт төлөгдөөгүй;
- 29.5 хувь нь хэлж мэдэхгүй байна гэж хариулсан байна.



[1] "Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх". УБ., 1996. 174 дэх тал
[2] Монгол Улсын Үндсэн хууль. 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 14 дэх заалт.
[3] Мөн тэнд. 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.
[4] ХЭҮТ, НЦГ, ШУА-ийн ФСЭХ-ийн "Гэмт хэргийн хохирогч" судалгааны тайлан, УБ., 2003 он

Дээрх үзүүлэлтээс харахад хамгийн их нөхөн төлөгдөж буй нь эд материалын хохирол байх бөгөөд санаа сэтгэл, нэр төрийн мөнгөн хөрөнгийн хохирол барагдуулалт доогуур үзүүлэлттэй[1] харагдаж байгаа юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд зааснаар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь "эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоолын хөрөнгө гаргуулах заалт, тэдгээрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх баримт бичиг"-ийг[2] үндэслэн, гэмт хэргийн улмаас хохирсон нь шүүхээр тогтоогдсон иргэн, хуулийн этгээд өөрөөр хэлбэл, төлбөр авагчийн хохирлыг арилгах, нөгөө талаас төлбөр төлөгч-иргэн, байгууллага түүний эрх залгамжлагчдаас хууль тогтоомжид зааснаар төлбөр гаргуулах ажиллагааг хуульд заасны дагуу явуулж байна.

Эдгээр ажиллагаанд:

- Төлбөр төлөгчид эд хөрөнгө байгаа эсэх талаар хуульд заасан журмаар мэдээлэл олж авах;
- Төлбөр төлөгчийн мөнгөн хадгаламж болон харилцах данснаас хасалт хийх, эд хөрөнгө болон биед үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгийг битүүмжлэх, албадан барьцаалах, хураах, худалдан борлуулах;
- Төлбөр төлөгчөөс эд хөрөнгийн тухай мэдүүлэг авах, өртэй этгээдийн бүртгэлд оруулах, хуульд заасан журмын дагуу олон нийтэд мэдээлэх;
- Төлбөр төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос суутгал гаргуулах;
- Төлбөр төлөгчийн бусдад байгаа өмч хөрөнгөөс хуульд заасан журмын дагуу төлбөр гаргуулах;
- Шийдвэрт нэр заасан тодорхой эд хөрөнгийг төлбөр төлөгчөөс гаргуулж төлбөр авагчид шилжүүлэх, эсхүл тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх, хуульд заасан бусад үйл ажиллагаа тус тус багтана.[3]


Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын онцлог бол эрүүгийн хэргийн талаархи шүүхийн шийдвэрээс гадна мөн иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэх үүрэг бүхий төрийн байгууллага учраас дээрх ажиллагааг эрүүгийн ба иргэний шийдвэр гүйцэтгэл, тэдгээрийн төлбөр төлөгчийн онцлогт тохируулан хэрэгжүүлэхийг шаардана.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2005 онд 31399 гүйцэтгэх баримт бичгт холбогдох 77.5 тэрбум төгрөгийн төлбөрт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас 8892 гүйцэтгэх баримт бичгийн 8.3 тэрбум төгрөгийн төлбөр буюу нийт гүйцэтгэвэл зохих баримт бичгийн 27.9, мөнгөн дүнгийн 11.0 хувь нь эрүүгийн гүйцэтгэх баримт бичигтэй холбоотой байна.

Эрүүгийн хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гүйцэтгэвэл зохих 5295 гүйцэтгэх баримт бичгийн 2.9 тэрбум төгрөгийн төлбөр барагдуулахаас 2298 гүйцэтгэх баримт бичгийн 1.5 тэрбум төгрөгийн төлбөрийг барагдуулж, 53.7 хувийн бодит биелэлттэй, 2997 гүйцэтгэх баримт бичгийн 1.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хорих ял эдэлж буй ялтнаас иргэд, байгууллагад олгох 2123 гүйцэтгэх баримт бичгийн 1.7 тэрбум төгрөгийн төлбөр барагдуулахаас 1317 гүйцэтгэх баримт бичгийн 1.4 төгрөгийн төлбөрт хуульд заасны дагуу байцаан шийтгэх ажиллагаа явуулж, иргэдэд олгох 701 гүйцэтгэх баримт бичгийн 302.5 сая төгрөгийн төлбөрөөс 241 гүйцэтгэх баримт бичгийн 102.8 сая төгрөгийг биелүүлж, бодит биелэлт 34.0 хувьтай, байгууллага, аж ахуйн нэгжид олгох 105 гүйцэтгэх баримт бичгийн 76.0 сая төгрөгийн төлбөр биелүүлэхээс 10 гүйцэтгэх баримт бичгийн 4.1 сая төгрөгийг барагдуулж, 5.3 хувийн бодит биелэлттэй байна.

Эдгээр тоо баримтаас үзэхэд хамгийн бага хэмжээгээр төлбөр хийгдэж



байгаа ажиллагаа нь эрүүгийн гүйцэтгэлийн ажиллагаа байна. Өнгөрсөн оны байдлаас авч үзэхэд, эрүүгийн гүйцэтгэх ажиллагааны 40 гаруй хувь нь биелэгдэж, үлдсэн хэсэг нь он дамжсан төлбөр болж байна.

Гэтэл хорих ял эдэлж буй төлбөр төлөгчөөс гаргуулан иргэд, байгууллагад олгох төлбөрийн гүйцэтгэл дөнгөж 28.2 хувьтай байхад иргэний гүйцэтгэлийн ажиллагаа тухайлбал, байгууллагад олгох төлбөр 69.8%, иргэдэд олгох төлбөр 63.2% байна.

Үүний дотор банкны зээлийн гүйцэтгэл 73.6%, татвар 57.5% үзүүлэлттэй байна.[4]

---

[1] ХЭҮТ, НЦГ, ШУА-ийн ФСЭХ-ийн "Гэмт хэргийн хохирогч" судалгааны тайлан, УБ., 2003 он, 20 дахь тал

[2] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хууль. 10 дугаар зүйл. /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хууль, түүнд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл/. УБ., 2003, 8 дахь тал

[3] Мөн тэнд. 34 дүгээр зүйл

[4] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2001-2005 оны үндсэн мэдээ. УБ., 2005

Хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn



Эрүүгийн хэргийн талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь гэмт хэргийн улмаас эрүүл мэнд, эд хөрөнгө, сэтгэл санааны хохиролд орсон хохирогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, хохирлыг арилгах, тэдний эрхийг нөхөн сэргээхэд чиглэгдэх ёстой. Бодит байдал дээр ямар байгааг бид дээрх үзүүлэлтээс харж болно. Энэ нь ***нэгдүгээрт:*** зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед хүн амын ядуурал, архидан согтуурах болон бусад нөхцөл байдлаас шалтгаалж гэмт хэрэг эрс өссөн, гэмт хэргийг гол төлөв дээрх ядуу, төлбөрийн чадваргүй этгээдүүд ихэвчилэн үйлдэж байна.

Хоёрдугаарт: төрийн зүгээс гэмт хэргийн хохирогчдын талаар цэгцтэй бодлого явуулж, олон улсын эрх зүйн баримт бичиг, гадаад улс орнууд энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар анхааралгүй.

Гуравдугаарт: эрүү, эрүүгийн байцаан шийтгэх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүй нь хохирогчийн эрх ашгийг хамгаалах, бусдын учруулсан хохирлыг арилгах асуудлыг зарчмын хувьд тунхаглаж, түүнийг амьдрал дээр хэрэгжүүлэх санхүү, зохион байгуулалтын асуудлыг хуульчлаагүй.

Дөрөвдүгээрт: гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлж байгаа ялтныг ажлын байраар хангах, тэднийг хөдөлмөрөөр хүмүүжүүлэх төрийн зохицуулалт байхгүй.

Тавдугаарт: гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаар төрийн болон олон нийтийн шугамаар сан байгуулах ажлыг санаачилгагүй ажилласан зэрэг шалтгаан нөхцөл нөлөөлсөн гэж үзэж байна.

Нөгөө талаар ялтны төлбөр барагдуулалт доогуур үзүүлэлттэй байгаа явдал нь шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг эрүүгийн хэрэг үүсгэсэн даруй хийгдэггүй, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарах хүртэл хугацаанд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь эд хөрөнгөө үрэн таран хийх, эсхүл төлбөрийн чадваргүй байх явдалтай үндсэндээ шууд холбоотой юм.

Хохирогч, төлбөр авагчид гэмт хэргийн улмаас учруулсан хохирол төлөгдөхгүй байгаа нь нийгэм, эдийн засгаас үүдэлтэй ядуурал, ажилгүйдэлтэй холбоотойн зэрэгцээ гэмт этгээдийн хорт үйл ажиллагаа, тэдний хөрөнгийн чадваргүй байдал зэргээс болж огт төлөгдөхгүй байх нь олон бөгөөд дээрх шалтгааныг дараах байдлаар тодорхойлсон байна.[1] Үүнд:

- гэм буруутай этгээд хөрөнгийн чадваргүй - 67.3 хувь;
- хохирол барагдуулах тогтолцоо бүрдээгүй - 43.4 хувь;
- гэмт этгээд хөрөнгөө нуун далдалсан - 32.1 хувь;
- хуульд тодорхой заалт байхгүй - 14.8 хувь;
- хуулийн байгууллагын ажилтнуудын үйл ажиллагааны доголдол - 12.2 хувь.

Ийм учраас хохирогчдын аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах зорилгоор тэдний гэмт халдлагаас хамгаалах, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, учирсан хохирлыг арилгах нэгдсэн механизм, тогтолцоог хуульчид бий болгох шаардлагатай гэж үздэг.[2]

2002 оноос эхлэн мөрдөгдөж буй "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай" Монгол Улсын хуульд[3] "...гэмт хэрэг үйлдсэний улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн бол түүнийг ялаас хугацааны өмнө суллах саналыг шүүхэд гаргана" гэж хуульд шинэ зохицуулалт оруулж өгснөөр ялтнаас гэмт хэрэг үйлдсэний улмаас бусдад учруулсан хохирлоо нөхөн төлөх онцгой хөшүүрэг болсон.

Дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлэх үүднээс Шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хорих ангид ял эдэлж буй ялтны хохирол барагдуулалтанд тавих хяналтыг 2005 оноос эхлэн Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих тасгийн чиг үүрэгт нэгтгэн өгснөөр өнгөрсөн хугацаанд 226 ялтанд холбогдох 43.5 сая төгрөгийг зохих дансанд төвлөрүүлж, төлбөр авагч нарт олгох ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд "...хорих ангид ял эдэлж буй ялтны төлбөрийг түүний хувьд ногдох эд хөрөнгөөс төлүүлэх, ялтны хөдөлмөр хөлснөөс сар бүр суутгал хийж шийдвэр гүйцэтгэх дансанд төвлөрүүлж байх"[4]-аар заасан.

Ялтны гэмт хэрэг үйлдэж бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх гүйцэтгэлийн ажиллагаа хүндрэлтэй байгаа бөгөөд ял эдлэгсэдийн ихэнх хувь нь ихэвчлэн төлбөрийн чадваргүй, хөрөнгө орлогогүй, оршин суух тодорхой хаяггүй, ганц бие эсхүл гэр бүл нь салсан гэх мэт шалтгаанаар энэ төрлийн гүйцэтгэлд хүндрэл бэрхшээл тулгарч байна. Иймээс учраас ялтныг ял эдлэх хугацаанд нь хөдөлмөрийн бүтээмж өндөртэй ажилд татан оруулж, хөдөлмөр хөлснөөс нь суутгал хийх замаар төлбөр барагдуулах ажиллагааг хорих ангийн онцлогт нь тохируулан зохион байгуулж байна.

[1] ХЭҮТ, НЦГ, ШУА-ийн ФСЭХ-ийн "Гэмт хэргийн хохирогч" судалгааны тайлан, УБ., 2003, 21 дэх тал

[2] Ч.Нямсүрэн "Виктимологийн шинжлэх ухааны онол, практикийн тулгамдсан асуудлууд" /Гэмт явдалтай тэмцэх асуудал. Онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл/. УБ., 2002.№2. 13-16 дахь тал

[3] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 126 зүйлийн 126.2 дахь хэсэг

[4] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.2 дахь хэсэг

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ:
Хорих ял ба эмэгтэйчүүд

Улсын дээд шүүхийн 2005 оны ажлын тайланд дурдсан статистик тоо баримтаас үзэхэд 2004 онд 735 эмэгтэй ял шийтгүүлж байсан бол 2005 онд 876 болж даруй 19.2 хувиар өссөн байна.

Ийнхүү сүүлийн жилүүдэд эмэгтэйчүүдээс гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлэх нь тооны хувьд өсөхөд олон хүчин зүйлс нөлөөлсний нэг нь гэр бүлийн хүчирхийлэгчид, тэдгээрийн хууль бус ажиллагаа зохих "хувь нэмэр" оруулсан нь судалгаагаар тогтоогдож байна.

- Хүмүүнлэг ардчилсан нийгэм байгуулахыг тунхагласан 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд "Хүн амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах, аюулгүй орчинд амьдрах, халдашгүй чөлөөтэй байх" эрхийг баталгаажуулан хуульчилсан ба хэрэв хуульд заасан эрх нь зөрчигдвөл шүүхэд гомдол гаргаж хамгаалуулах болон бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхийг шаардах эрхтэйг мөн тодорхойлон заасан байна.

Гэтэл эмэгтэйчүүд яагаад Үндсэн хуульд заасан хууль ёсны эрхээ эдэлж чадахгүй гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэхдээ буруу арга хэлбэрийг сонгож улмаар гэмт хэрэг үйлдэх болов гэсэн асуулт зүй ёсоор урган гарч байна.

Улсын Их Хурлаас 2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр 20 зүйл бүхий "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хуулийг батлан гаргасан нь нийгмийн хөгжлийн сөрөг үзэгдэл болох гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хохирогчдын аюулгүй байдлыг хангаж, тэдгээрийн зөрчигдсөн эрхийг сэргээж хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэх механизмыг бий болгоход чухал ач холбогдолтой болсон юм. Харамсалтай нь энэхүү хууль 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн өнгөрсөн хугацаанд нүдэнд



УЕПГ-ын цл эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн прокурор, докторант Ц.Мөнхбат

харагдахуйц, чихэнд сонсогдохуйц нааштай өөрчлөлт, шинэчлэлтийн үр дүн гарсангүй.

- Хууль хэрэгжихгүй байгаа шалтгаан юунд вэ? Юуны өмнө олон зуун жил үе дамжин уламжлагдан ирсэн нийгмийн сэтгэлгээтэй шууд холбоотой юм. Түүхийн шаргал хуудсыг сөхвөл энэ асуудал нь нийгмийн хөгжлийн явц, хүний ухамсар, соёлоос ихээхэн хамааралтай байсан бөгөөд өрх гэрт эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг хариуцлагыг үлэмж нэмэгдүүлсэн, тэдгээрийн эдлэх эрхийг дордуулсан тэгш бус харилцаа ноёрхож иржээ. Хүний оюун ухамсарт хүчтэй нөлөөлөгч шашны зарим урсгалд ч энэ талаар тодорхой дурдаж номлосон нь бий.

Хоёр жилийн өмнө төрийн бус байгууллагуудаас хийсэн судалгаа дүгнэлтэд гэр бүлийн хүчирхийлэгчид өөрөөр хэлбэл, 1999 онд батлагдсан Гэр бүлийн тухай хуульд заасан гэр бүлийн гишүүн, төрөл садан, түүнчлэн төрийн эрх байгууллагад бүртгүүлээгүй боловч хамтын амьдралтай хүмүүс, холбогдох хуулийн дагуу хүүхдийг гэр бүлдээ авч хүмүүжүүлсэн асран хамгаалагч, харгалзан дэмжигч зэрэг этгээдүүдийн аль нэг нь бие махбодийн, сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн аливаа хэлбэрээр нөгөө этгээдийнхээ эрх чөлөөг хууль бусаар хязгаарлаж гэм хор учруулсан буюу учруулахаар завдах, заналхийлэх байдлаар хүчирхийлэл үйлдэх нь түгээмэл шинжтэй, хүчирхийлэгчдийн 60-65 хувь нь эр нөхрүүд байгаа тухай дурдсан байна.

Тэгвэл энэ тоо Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш буурах биш харин ч өсч нийт хүчирхийлэгчдийн 90-95 хувийг эрэгтэйчүүд эзэлж байгаа нь анхаарал татаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл нь ахуйн хүрээнд далд байдлаар үйлдэгддэг, хохирогч нь хүчирхийлэгчтэй гол төлөв нэг дор хамт амьдардаг, үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх, мөнгө төгрөгний хэрэгцээ зэрэг амьдралын тулгамдсан болон олон асуудлаас эмэгтэйчүүд нь хүчирхийлэгчдийг холбогдох байгууллагад илчилж чаддаггүй, нуун дарагдуулахаас өөр аргагүй байдалд хүрдэг, нөгөө талаар төр захиргаа, хууль хяналтын байгууллагад цөөн боловч гаргасан хүчирхийллийн талаархи гомдол, мэдээлэлд ч эрх бүхий албан тушаалтнууд төдийлөн ач холбогдол өгдөггүй, өгсөн ч хэлбэрийн төдий ханддаг, хүчирхийллийг бууруулах, таслан зогсооход хуулиар хүлээсэн үүргээ хариуцлагагүй биелүүлдэг, хохирогч хүчирхийлэгч нарыг "хоорондоо зохиц, өөрсдөө учраа ол, та нарын хувийн асуудал" гэх мэтээр асуудлыг хойш тавьдаг нийтлэг дүр зураг бий болсон нь үнэн хэрэгтээ хүчирхийлэгчдийг өөгшүүлж байгаа явдал юм.

Энэ байдал нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, үйлдлийн онцлог нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдгээрийг шийдвэрлэх тусгайлсан журмыг хуульчлан тогтоох шаардлагатайг харуулж байна.

Эрүүгийн хуулийн 71 дүгээр зүйлд "Хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн гэм буруутай этгээд хохирогчтой сайн дураараа эвлэрсэн, учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно" гэсэн заалтад гэр бүлийн хүчирхийлэгчид холбогдох хэргийг хамааруулан хэрэгсэхгүй болгох нь олонтаа байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсөд, хохирогчид ямар учраас гомдлоо татаж хүчирхийлэгчтэй эвлэрэх болсон шалтгааныг анхааран судалдаг, хүчирхийлэгчдийг ухуулан сэнхрүүлдэг, тэдэнтэй тулж ажилладаг үр дүнг тооцдог байгууллага алга байна.

Манай орны таван гэр бүлийн нэгд нь хүчирхийллийн аль нэг хэлбэр амь бөхтэй оршиж байна. 1999 онд УИХ-аас баталсан Гэр бүлийн тухай хуулийн өмнөх хуулиудаас онцлог нэг давуу тал нь болох гэр бүлийн гишүүд нь бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх заалт нь өнөө хэр биеллээ олсонгүй.

2006 оны 5 дугаар сард улсын хэмжээнд хийсэн судалгаагаар нийт 335 эмэгтэй жирийн болон чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлж байсны 107 буюу 31.9 хувь нь бусдыг санаатай алсан /үүнээс 61 нь нөхөр буюу хамтран амьдрагчийнхаа амь насыг хохироосон/, 12 эмэгтэй эр нөхөр буюу хамтран амьдрагчийн биед хүнд гэмтэл учруулсан гэмт хэрэгт ял шийтгүүлсэн байна.

Хорих ял эдэлж байгаа эмэгтэйчүүдтэй ганцаарчлан уулзаж, гэмт хэрэг үйлдэх болсон шалтгааныг тодруулахад 86 хувь нь эр нөхрийн байнгын дарамт шахалт, айлган сүрдүүлэлт, байнгын архидалт, үндэслэлгүй хардалт сэрдэлт, зодуур нүдүүр хэрээс хэтэрч тэвчихийн аргагүй байдалд орсноос хүнд гэмт хэрэг үйлдэхэд хүрсэн болон ял эдлэх хугацаанд үр хүүхдийн хүмүүжил доройтож ар гэрийн амьдрал нь сүйрсэн талаар нулимс урсган ярьж байна.

Судалгааны явцад гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирогч бологсод хэргийн холбогдогч болж ял шийтгүүлж байгаа өнөөгийн тогтолцоог өөрчлөх шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Иймд гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, таслан зогсоох бууруулахад тодорхой үе шаттай ажил зохиох, тухайлбал, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн хэрэгжилтийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуультай уялдуулан эрчимжүүлэх, төр захиргаа, хууль хяналтын байгууллагын үүрэг хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг нь нэгтгэн зангидаж үр дүнг тухай бүр тооцож байх, гэр бүлийн хүчирхийллийн хор уршиг, үр дагаврын талаар иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг явуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслийг өргөн ашиглах, гэр бүл бологсдын эрх зүйн ухамсар соёлыг дээшлүүлэх зэрэг дорвитой арга хэмжээг төр засгаас авах цаг нэгэнт болжээ.

Улсын хэмжээнд хорих ял эдэлж байгаа эмэгтэйчүүдийн талаархи судалгаа

2006 оны 5 дугаар сарын байдлаар

Үзүүлэлтүүд			МД	Тоо	Хувь
Хорих ял эдэлж байгаа нийт эмэгтэйчүүд			1	335	100%
Үүннээс	Үйлдсэн гэмт хэргийн байдал	Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйл ангиар	2	85	25.3%
		Эрүүгийн хуулийн 96 дугаар зүйл ангиар	3	22	6.5%
		Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйл ангиар	4	57	17%
		Эрүүгийн хуулийн 146 дугаар зүйл ангиар	5	8	2.3%
		Эрүүгийн хуулийн 147 дугаар зүйл ангиар	6	31	9.2%
		Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйл ангиар	7	89	26.5%
		Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйл ангиар	8	22	6.5%
		Бусад	9	21	6.2%
	Насны байдлаар	14-18 нас	10	6	1.7%
		19-20 нас	11	16	4.7%
		21-25 нас	12	37	11%
		26-30 нас	13	49	14.6%
		31-35 нас	14	58	17.3%
		36-40 нас	15	47	14%
	Боловсролын байдлаар	41-50 нас	16	96	28.6%
		51-ээс дээш нас	17	26	7.7%
		Боловсролгүй	18	18	5.3%
		Бага	19	22	6.5%
		Дунд	20	185	55.2%
		Тусгай дунд	21	44	13.1%
		Дээд	22	66	19.7%
	Согтуугаар гэмт хэрэг үйлдсэн		23	71	21.1%
	Эрүүл үедээ гэмт хэрэг үйлдсэн		24	264	78.8%
	Нөхөр буюу хамтран амьрагчийн амь насыг хохироосон		25	61	18.2%
	Нөхөр буюу хамтран амьдрагчийн биед хүнд гэмтэл учруулсан		26	12	3.5%
	Бусдын амь насыг хохироосон		27	46	13.7%
	Бусдын биед хүнд гэмтэл учруулсан		28	24	7.1%
	Хүүхдийн амь насыг хохироосон		29	13	3.8%

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.legalinstitute.mn

Хөдөлмөрийн гэрээ цуцалсан маргаан шийдвэрлэх зарим асуудал



Отгонтэнгэр Их сургуулийн дэд захирал, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Л.Баасан

Нэг. Шүүхээр хянан шийдвэрлэж байгаа иргэний хэргийн нэлээд хэсэг нь хөдөлмөрийн харилцаанаас үүссэн маргаан бүхий хэргүүд эзэлдэг. Үүнд:

бүхий хэргийг шүүх шууд хүлээн авч шийдвэрлэх маргаан (хуулийн 128 дугаар зүйлийн 128.2-128.11 дэх хэсэг) хөдөлмөрийн маргаан таслах комисс шийдвэрлэсний дараагаар шүүх хүлээн авч шийдвэрлэх маргаан гэж ангилж болно.

Хоёр. Шүүх шууд шийдвэрлэх маргаануудын дотор ажил олгогчийн санаачлагаар ажлаас буруу халсан буюу өөр ажилд шилжүүлсэн тухай ажилтны гомдолтой маргаан багтах бөгөөд энэ нь ихэнх тохиолдолд ажил олгогчийн санаачлагаар хөдөлмөрийн гэрээг цуцалсан асуудлыг хамаардаг. Хөдөлмөрийн гэрээг ажил олгогчийн санаачлагаар цуцалсан маргаан шүүхээр хянан шийдвэрлэх хөдөлмөрийн бусад маргаантай харьцуулан үзэхэд дараах онцлогтой. Үүнд :

1. Нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацааны хувьд тусгай хөөн хэлэлцэх хугацааг баримталдаг. Өөрөөр хэлбэл, Хөдөлмөрийн тухай хуулийн 129 дүгээр зүйлд зааснаар "ажилтан ажлаас буруу халсан буюу

№	Онууд	Улсын хэмжээгээр хянан шийдвэрлэсэн иргэнии хэрэг	Хөдөлмөрийн харилцаанаас үүссэн хэрэг	
			Тоо	Хувь
1.	2002	24100	1095	4.5
2.	2003	23407	819	3.5
3.	2004	23290	591	2.5
4	2005	24492	649	2.6

гэх мэт байдал харагддаг. 4 жилийн дунджаас үзэхэд Монгол Улсын хэмжээгээр хянан хэлэлцсэн иргэний бүх төрлийн хэргийн 3 орчим хувийг хөдөлмөрийн харилцаанаас үүссэн маргаан бүхий хэргүүд эзэлдэг нь тодорхой. Хөдөлмөрийн тухай хуулийн 128 дугаар зүйлд зааснаас үзэхэд шүүхээр хянан шийдвэрлэх хөдөлмөрийн харилцаатай холбоо өөр ажилд буруу шилжүүлсэн тухай гомдлоо ажил олгогчийн шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш нэг сарын дотор шүүхэд гаргах" журамтай. Энэ хугацааг чанд баримталсан эсэхээс ажилтны зөрчигдсөн буюу маргаж буй эрх хамгаалагдах асуудал шийдвэрлэгддэг. Хуульд заасан энэ хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн бол нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох нөхцөл бүрддэг байна.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 82 дугаар зүйлд зааснаар ажлаас үндэслэлгүйгээр халсан, өөр ажилд шилжүүлсэн тухай гомдолтой хэргийг шүүгч дангаараа даргалсан хуралдаанаар хянан шийдвэрлэх журамтай. Энэ нь асуудлыг шуурхай шийдвэрлэх нөхцөлийг хангах чухал механизм болно.

3. Ажлаас үндэслэлгүй халагдсан, шилжүүлсэн тухай нэхэмжлэлтэй хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч гэх мэт эрх зүйн байдлын хувьд харилцан адилгүй хоёр тал оролцдог. Ажилтныг ажилд авах, ажлаас халах шийдвэр гаргадаг илт давуу эрхтэй ажил олгогч тал нь хууль бус тушаал гаргаж ажилтнуудыг ажлаас халах явдал шүүхийн практикт нэлээд ажиглагддаг. Иймээс учраас шүүх өөрийн үзэмжээр эсхүл зохигчийн хүсэлтээр бусдыг үндэслэлгүйгээр ажлаас халах шийдвэр гаргасан буруутай этгээдийг гуравдагч этгээдээр татах журам бий. Энэ нь уг маргааныг шүүхээр шийдвэрлэх нэгэн онцлог гэж болно.

Гурав. Хөдөлмөрийн гэрээг цуцалж, ажилтныг өөр ажилд үндэслэлгүй шилжүүлсэн, ажлаас халсан тухай нэхэмжлэлийг шүүх хянан үзээд ажилтныг хууль бусаар ажлаас халсан, шилжүүлснийг зохих нотлох баримтаар магадлан тогтоосон нөхцөлд:

а/ Ажилтныг урьд эрхэлж байсан ажилд нь эсхүл түүнтэй нийцэх ажилд нь эгүүлэн тогтоох;

б/ Хөдөлмөрийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд зааснаар ажилгүй байсан бүх хугацааны цалинг ажил олгогчоос гарган олгох;

в/ Ажилгүй байсан хугацааг нийгмийн даатгалын шимтгэл төлсөнөөр тооцохыг ажил олгогч этгээдэд даалгах;

г/ Хууль зөрчиж үндэслэлгүй тушаал гаргасан гуравдагч этгээдэд ажлаас халагдсан ажилтанд ажилгүй байсан хугацааны хөлс олгосноос ажил олгогчид учруулсан хохирлыг хариуцуулах гэх мэт асуудлуудыг шийдвэрлэдэг. Ажил олгогчийн буруугаар ажилтан бага цалинтай, бага тушаалын ажил гүйцэтгэгч байсны зөрүүг ажил олгогчид хариуцуулах шийдвэрийг шүүх гаргах тал бий.

Ажилтны хүсэлтийг хангасан энэ мэт шийдвэр гаргах үндэслэл нь ажил олгогчийн хууль бус ажиллагаатай холбоотой. Үүнд:

1. Ажил олгогч хуульд байхгүй үндэслэлээр хөдөлмөрийн гэрээг цуцлах нь ажилтныг өмнөх ажилд нь эгүүлэн тогтоох үндэслэл болно. Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд ажил олгогчийн санаачлагаар хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэлүүдийг хуульчлан заасан байхад эрх бүхий ажил олгогч зарим байгууллагын эрх баригчид Монгол Улсын хуульд байхгүй үндэслэлийг баримталж гэрээг цуцлах эсхүл Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд буй заалтыг өөрийнхөөрөө тайлбарлах замаар ажилтныг ажлаас үндэслэлгүй халах тохиолдол бий. УБТЗ-ын санхүүгийн 2003, 2004 оны үйл ажиллагаанд "Нимм" аудитын газраас шалгалт хийж, зөвлөмж, тайлан гаргасан бөгөөд энэ зөвлөмж, тайланд УБТЗ-ын хэмжээнд зайлшгүй залруулан зөвтгөвөл зохих дутагдал нэлээд тусгагдсан байна. Энэ дутагдлууд санхүүгийн анхан шатны нэгжийн ажилтнуудын үйл ажиллагаанаас шууд шалтгаалан үүссэн нь аудитын баримтад тусгагдсан байхад УБТЗ-ын удирдлагууд болох Цогбадрах, Бадамханд, Ариунаа, Оюун-Эрдэнэ, Долгорсүрэн гэх мэтийн хэлтсийн дарга нарын үйл ажиллагаатай холбон үзэж 2005 оны 7 дугаар сарын 22-ны өдөр тэднийг ажлаас халах шийдвэр гаргажээ. УБТЗ-ын даргын тушаалд эдгээр хэлтсийн дарга нарыг Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт буюу мөнгө болон эд хөрөнгө хариуцсан ажилтан ажил олгогчийн итгэлийг алдсан бууруутай үйлдэл, эс үйлдэл гаргасан нь тогтоогдсон гэдэг үндэслэлийг баримталжээ. Эдгээр хүмүүс бол эд хөрөнгө шууд гардан хариуцдаггүй санхүүгийн хэлтсийн дарга нар байхын хамт аудитын болон бусад баримтаар ажил олгогчийн итгэлийг алдсан гэдгийг нотолж тогтоогоогүй. Нөгөө талаар, УБТЗ-ын нэр бүхий ажилтнуудын хөдөлмөрийн гэрээг цуцлахдаа Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хуулиудыг зөрчсөн учир Баянгол дүүргийн шүүхийн шийдвэрээр эдгээр хүмүүсийг өмнөх ажилд нь эргүүлэн тогтоосон байна. "УБТЗ-ын даргын дээрх тушаалыг шүүхэд хамгаалж чадахгүй, муу ажилласан" гэдэг үндэслэлээр УБТЗ-ын хууль зүйн албаны дарга О-г 2006 онд ажлаас халсан бөгөөд Баянгол дүүргийн шүүх хуульч О-г өмнөх ажилд нь эргүүлэн тогтоогоод байна. Энэ мэтээр Хөдөлмөрийн хуульд заагаагүй үндэслэлээр иргэдийг ажлаас халах явдал 2004-2005 онд МИАТ, УБТЗ, Улсын Мэргэжлийн Хяналтын Газар, Улсын Ерөнхий Прокурорын газар зэрэг олон байгууллагад гарсан бөгөөд ажлаас үндэслэлгүйгээр халагдсан эдгээр ажилтнуудын 90-95 хувь нь өмнөх ажилдаа эргэн тогтоогдсон байна.

2. Хөдөлмөрийн тухай хуульд заасан жүрмыг биелүүлээгүйн улмаас бусдыг ажлаас үндэслэлгүйгээр халах явдал олон гардаг. Үүнд :

- Хөдөлмөрийн гэрээг цуцлах зарим тохиолдолд мэдэгдэл өгөх журмыг зөрчих (хуулийн 40.5 дахь хэсэг, 41.1.3 дахь заалт);
- Ээлжийн амралттай, чөлөөтэй, өвчтэй гэх мэт хүндэтгэн үзэх шалтгаантай ажилтнуудыг ажил олгогчийн санаачлагаар ажлаас халахыг хориглосон заалтыг зөрчих (хуулийн 35, 36 дугаар зүйл, 40.3, 100.1 дэх хэсэг);
- Хүндэтгэн үзэх шалтгаан-аар хөдөлмөрийн гэрээг цуцалж буй зарим тохиолдолд ажлаас халагдсаны тэтгэмж олгох журмыг зөрчих (хуулийн 42 дугаар зүйл, 41.1.3 дахь заалт);
- Хөдөлмөрийн гэрээг цуцлах тухай ажил олгогчийн ямар нэгэн шийдвэр гаргахгүй, эсхүл нийгмийн даатгалын дэвтэр, ажлаас халагдсан тушаалыг гардуулахгүй чирэгдүүлснээс ажилгүйдлийн тэтгэмж авах бололцоог алдагдуулах (энэ бол бусдыг санаатайгаар хорлон хохироож буй хэрэг бөгөөд энэхүү хорлох үйл ажиллагааг Улаанбаатар банк, Хан-Уул дүүрэгт үйл ажиллагаа явуулах эрчим хүчний барилга угсралтын трест гэх мэт газрууд эрчимтэй хэрэгжүүлж олон хүнийг хохироож иржээ);
- Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлд буй "ажил олгогч нь ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлахдаа ажил хүлээлгэн өгөх хугацааг тогтоож, уг хугацааг ажил хүлээлгэн өгсөн сүүлчийн өдрийг ажлаас халагдсан өдөр гэж үзнэ" гэсэн хэм хэмжээг зөрчсөн шийдвэр гаргах зэргээр ажилтнуудын хөдөлмөрлөх эрхийг хохироосны ихэнх нь шүүхээр залруулагдаж иржээ.

Ажил олгогч, түүнийг төлөөлсөн албан тушаалтнууд хууль дээдлэх зарчмын дагуу ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтныг өмнөх ажилд нь эргүүлэн тогтоож, ажил олгогчийн хууль бус тушаалыг хүчингүйд тооцож, ажилгүй байсан хугацааны хөлсийг олгох шударга шийдвэр гаргасан шүүхийн шийдвэрийг өөрчлүүлэхээр улайран хөөцөлдөх. Үндсэн хуульд заасан эрхийнхээ дагуу шүүхэд хандсан иргэнийг "Заргач" гэж нэр хоч зүүн гадуурхах, тэдний эрхийг аль болохоор хохироох, ажилд эргүүлэн тогтоосон шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх, шүүх

юу юм гэж ихэрхэх, өөрийгөө төлөөлөн оролцсон хуульчдыг бидний шийдвэрийг хамгаалж чадаагүй гэж ажлаас халах зэрэг зохисгүй байдлууд шүүхийн практикт нэлээд байгааг тэмдэглэх нь чухал. Шүүхийн зарим шийдвэрт ажилтны ажилгүй байсан хугацааны хөлсийг олгохдоо үндсэн хөлсийг баримтлан шийдвэрлэсэн нь Хөдөлмөрийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд буй "ажилгүй байсан бүх хугацаанд нь урьд авч байсан дундаж хөлстэй тэнцэх олговор, хэрэв бага цалинтай ажил хийж байсан бол зөрүүтэй тэнцэх олговрыг олгоно" гэсэн хэм хэмжээг зөрчиж буй хэрэг мөн.

Хөдөлмөрийн гэрээг цуцалсан маргаан шийдвэрлэж буй практикт зарим үнэлэлт хийж үзэхэд бусдыг ажлаас үндэслэлгүй халсан, өөр ажилд шилжүүлсэн, тэдний хөдөлмөрлөх эрхийг хохироосон нь албан тушаалтнуудын эрх зүйн боловсрол дутагдалтай, ажил олгогчийн дэргэдэх хууль зүйн алба олигтой ажилладаггүй, тэнд ажиллагсдын хууль зүйн боловсрол, дадлага дутагдалтай зэрэг хүчин зүйлтэй холбоотой байна. Эдгээр байдлаас гарах, иргэдийн хөдөлмөрлөх эрхийг тууштай хангахын тулд:

1. Үйлдвэр, албан газар, байгууллага, хувь хүн гэх мэт ажил олгогч этгээдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, үүний тулд хууль зүйн сурталчилгааг өргөжүүлэх, ажил олгогчийн буруугаар ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтныг өмнөх ажилд нь эргүүлэн тогтоосон шүүхийн шийдвэрийг нийт иргэдэд сурталчлах;
2. Бүх шатны байгууллагын дэргэдэх хууль зүйн албыг бэхжүүлэх, түүнд ажиллагсдыг мэргэжлийн хувьд нь чадваржуулах;
3. Албан газруудаас Хөдөлмөрийн тухай хуулийг хэрхэн хэрэгжүүлж байгаад тавих төрийн болон олон нийтийн хяналтыг эрчимжүүлж, үр дүнтэй болгох;
4. Ажлаас үндэслэлгүйгээр халагдсан ажилтныг өмнөх ажилд нь эргүүлэн тогтоосон шүүхийн шийдвэрийг заавал биелүүлдэг тогтолцоонд шилжих, шүүхийн шийдвэрийг санаатайгаар биелүүлэхгүй байгаа албан тушаалтнуудыг Эрүүгийн хуулийн 258 дугаар зүйлд зааснаар эрүүгийн хариуцлагад татах гэх мэт арга механизмуудыг өргөнөөр хэрэгжүүлэх нь чухал. Энэ мэт үйлсэд ажилтнууд өөрсдөө идэвхтэй оролцох, хөдөлмөрлөх эрхийнхээ төлөө тэмцэж чаддаг, эл үйл хэрэгт нь үйлдвэрчний эвлэл, олон нийтийн бусад байгууллага өргөн дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.



Хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn

Санхүүгийн түрээс, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал

Санхүүгийн түрээс гэж активыг тодорхой заасан хугацааны дотор түрээслэн эзэмшээд түүнд ногдох төлбөрийг мөнгөөр гүйцэтгэх эрх, үүргийг заасан гэрээг хэлдэг.

Санхүүгийн түрээс гэдэг нэр томьёо нь Англиин "to lease" буюу түрээслэх гэсэн үгнээс гаралтай, хөрөнгө оруулалтын зориулалттай зээлийн өвөрмөц нэгэн төрөл юм.

Санхүүгийн түрээсийн хэлбэр манай эриний өмнөх 2000 жилийн тэртээгээс эртний Вавилонд үүссэн гэдэг. Зээллэгийн энэ төрөл 1877 оноос АНУ-ын "Бэлл Телефон Компани" гэдэг компани өөрийн үйлчилгээний телефон харилцааны хэрэгслийг худалдахын оронд урамшуулалт төлбөртэйгөөр түрээсээр гэрээлэн өгсөн нь амжилт авчирчээ. Энэ үеэс гадаадын судлаачид, бизнесийн хүрээнд санхүүгийн түрээс анхаарал татах болсон гэдэг. Ийнхүү лизингийн зээл хөгжихийн хэрээр санхүүгийн түрээсийн төрөлжсөн компани байгуулагдаж улмаар лизинг худалдааны бодлогод нөлөөлөн, бодит үйл ажиллагаа болон төлөвшжээ.

Анхны санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхэлдэг компани 1952 онд АНУ-ын Сан Франциско хотод "Юнаттэд Стейтс лизинг корпорейшн" нэртэйгээр байгуулагджээ. Харин европт анх 1962 онд ХБНГУ-ын Дюссельдорф хотод "Дойче лизинг ГИХБ" компани байгуулагдаж, Европын зах зээлд санхүүгийн түрээсийн үндсийг тавьсан гэж үздэг байна.[1]

Санхүүгийн түрээсийн онцлог. Санхүүгийн түрээс нь үйлдвэрлэлийн машин, тоног төхөөрөмж, үл хөдлөх хөрөнгө тэдгээрийг ашиглах хугацаа бусад нөхцөлийг заасан гэрээгээр биет зүйлээр хөрөнгө оруулалт явуулах арга болович зээлээс ялгарах гол онцлог нь түүний объекттой



Улсын Дээд шүүхийн шүүгч А.Доржготов

холбогдсон хугацаа, төлбөр дууссаны дараа уг объект элэгдэл, хорогдлыг хассан үлдэгдэл үнээр тооцсон дүнгээр санхүүгийн түрээс өгөгчийн өмч болдог.

Санхүүгийн түрээс нь Иргэний эрх зүйн "зээл" гэдэг ойлголтоос ялгаатай. Зээлийн гэрээгээр зээлдэгч нь зээлээр шилжүүлэн авсан эд хөрөнгөтэй ижил төрөл, тоо, чанар хэмжээний эд хөрөнгө буюу мөнгийг тохирсон хугацаанд буцаан төлнө.

Санхүүгийн түрээсийг зээлээр худалдах-худалдан авах гэрээнээс ялган ойлгох нь чухал. Зээлээр худалдах-худалдан авах гэрээгээр худалдагч нь худалдан авагч үнийг төлөхөөс өмнө эд хөрөнгийг шилжүүлнэ. Худалдан авагч нь эд хөрөнгийн үнийг гэрээнд заасны дагуу тодорхой цаг хугацааны дараа хэсэгчлэн буюу бүрэн төлнө. Эсхүл гэрээгээр тохирсон тодорхой цаг хугацааны туршид хэсэгчлэн төлнө. Эдгээр шинжээрээ санхүүгийн түрээстэй төстэй боловч гагцхүү эд хөрөнгийн үнийг төлдөг. Иймээс гэрээнд эд хөрөнгийн үнэ, эсхүл үнийг тодорхойлох журмыг нарийвчлан тодорхойлдог. Мөн хүү тогтоож болдог. Энэ мэтээр гэрээний зүйл, үнэ, төлбөр төлөх журам, талуудын хүлээх эрх, үүрэг хариуцлага зэргээрээ ялгаатай.

Монгол Улсад санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа түрээсийн гэрээний хүрээнд 1990-ээд оноос эхэлсэн гэж үзэж болно. Олон улсын санхүүгийн байгууллагын судалгаагаар Монгол Улсад санхүүгийн түрээсийн жилийн эргэлт 2000 оны байдлаар 60 тэрбум төгрөг байжээ. Зах зээл хөгжсөн орнуудад санхүүгийн түрээсийн эх үүсвэрийн 20 хувийг санхүүгийн түрээс эзэлдэг. (АНУ-22.0, Япон 72.3, ХБНГУ 35.7, Англи 20.4 тэрбум ам.долларын жилийн эргэлттэй байдаг ажээ)[2].

Монгол Улсад санхүүгийн түрээсийн эрх зүйн зохицуулалт анх Банкны тухай хуульд /1996 оны/ банк санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхэлж болохоор тусгажээ. (6 дугаар зүйл 1 дэх хэсгийн 10 дахь заалт) Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /1998 оны/-д санхүүгийн лизинг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхөөр заажээ. /9.1.1 дэх заалт/ Монгол Улсын Иргэний хууль /2002 оны/-д санхүүгийн түрээс /лизинг/-ийн талаар тусгай бүлэг, зүйлд /312-317дугаар зүйл/ санхүүгийн түрээсийн гэрээний эрх зүйн зохицуулалтыг тодорхойлжээ. Улмаар санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуулийг 2006 онд батлан мөрдсөнөөр санхүүгийн түрээсийн эрх зүйн зохицуулалт зохих ёсоор бүрэлдэн тогтов.

Монгол Улсын Иргэний хуульд санхүүгийн түрээсийн гэрээг тодорхойлохдоо түрээслэгч нь гэрээнд заасан хугацаагаар түрээслэгчийн ашиглалтад эд хөрөнгө шилжүүлэх, түрээслэгч нь тогтмол хугацаанд түрээсийн төлбөр төлөх үүргийг тус тус хүлээнэ гэжээ. Түрээслүүлэгч нь түрээслэгчийн хүсэлт, зааврын дагуу санхүүгийн түрээсийн эд хөрөнгийг бэлтгэхийн тулд дараах ажиллагааг явуулах үүрэг хүлээнэ. Үүнд: **а)** Гэрээний зүйл болох эд хөрөнгийг өөрөө үйлдвэрлэх; **б)** Гэрээний зүйл болох эд хөрөнгийг гуравдагч этгээд (бусад этгээд)-ээр үйлдвэрлүүлэх; **в)** Гэрээний зүйл болох эд хөрөнгийг худалдан авах. Эдгээр ажиллагаа нь түрээслүүлэгч нь санхүүгийн

[1] Э.Сандагдорж "Мөнгөний зах зээл, банкны нэр томъёоны лавлах толь". УБ., 2000 он. 334 дэх тал

[2] Иргэний хууль: Шинэлэг зохицуулалт. УБ., 2003 он. 156 дахь тал

түрээсийн шаардлага хангахуйц, гэрээний зүйл болох эд хөрөнгийг ямар аргаар бий болгож болохыг тодорхойлсон заалт юм.

Иргэний хуульд түрээсийн гэрээний хугацаа дууссаны дараа гэрээний зүйл болох эд хөрөнгийг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг дараах байдлаар тусгасан. Үүнд: **а)** эд хөрөнгийг түрээслэгч худалдан авч болно; **б)** эд хөрөнгийг үргэлжлүүлэн түрээсэлж болно.

Анх санхүүгийн түрээсийн гэрээ байгуулахдаа уг гэрээний хугацаа дууссаны дараа гэрээний зүйл, эд хөрөнгийг хэрхэх талаар тусгаж байх нь зохимжтой юм. Мөн гэрээний хугацаа дуусахад гэрээний зүйлийн элэгдэл, хорогдол болон нийт өртгийг барагдуулсан тооцоо гарвал эд хөрөнгийг түрээслэгч нь худалдан авах буюу хөлслөх эрх, үүрэгтэй байхаар гэрээгээр тохиролцож болдог.

Санхүүгийн түрээсийн гэрээний хэлбэр, нөхцөл нь Монгол Улсын Иргэний хуулиар /313 дугаар зүйл/ зохицуулагджээ. Хэлбэрийн хувьд санхүүгийн түрээсийн гэрээг заавал бичгээр байгуулна. Санхүүгийн түрээсийн гэрээний нөхцөлд: **а)** гэрээний нийт үнэ; **б)** түрээсийн төлбөр; **в)** түрээсийн төлбөрийг төлөх журам; **г)** Гэрээний хугацаа; **д)** гэрээний хугацаанаас өмнө дуусгавар болох тохиолдол; **е)** Гэрээний үнийг төлж дуусгах журам зэрэг асуудлыг заавал тусгахаар хуульчилжээ.

Дээр дурдсан гэрээний хэлбэр, нөхцөлийн талаар хуулиар тогтоосон журмыг зөрчсөн санхүүгийн түрээсийн гэрээ хүчин төгөлдөр бус байх болно.

Энэ нь санхүүгийн түрээсийн гэрээний ерөнхий нөхцөлийг тодорхойлсон явдал юм. Тэгвэл Санхүүгийн түрээсийн тухай хууль /8 дугаар зүйл/-д гэрээний агуулгыг нарийвчлан тодорхойлжээ.


Санхүүгийн түрээсийн гэрээний нөхцөлийн талаар Иргэний хуульд зааснаас гадна гэрээний агуулгад дараах зүйлийг тусгах ёстой болж байна. Үүнд:

- Гэрээний талуудын албан ёсны нэр, хаяг, хуулийн этгээд бол түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдийн нэр, албан тушаал. Энэ нь түрээслүүлэгч, түрээслэгч, гуравдагч этгээдийн аль алинд нь хамаатай. Гэрээний хугацаа (эхлэх, дуусах, он, сар, өдөр);
- Талуудын эрх, үүрэг тэдгээрийн хүлээх хариуцлагыг нарийвчлан тодорхойлно;
- Түрээсийн зүйл болох эд хөрөнгийн тодорхойлолт. Энд эд хөрөнгийн нэр, үйлдвэрлэгч, үйлдвэрлэсэн огноо, техникийн үзүүлэлт, хэмжээ, тоо, чанар, онцлог шинж, түүний бүрдэл хэсэг, дагалдах зүйлийн тухай мэдээлэл, эд хөрөнгийн ашиглалт зориулалтыг тодорхой тусгах ёстой;
- Түрээсийн зүйл болох эд хөрөнгийг гэрээний аль тал нь сонгосон болох тухай заана;
- Мөн гэрээнд оролцох гуравдагч этгээдийг түрээслүүлэгч, түрээслэгчийн аль тал сонгосныг гэрээний агуулгад тусгах нь ач холбогдолтой байдаг;
- Түрээсийн зүйлийг түрээслүүлэгчид шилжүүлэх журмыг гэрээгээр нарийвчлан тодорхойлно. Энд түрээсийн зүйлийг угсрах, суурилуулах, ашиглалтад оруулах хугацаа, хүлээлгэн өгөх, хүлээн авах этгээд, шилжүүлэн өгөх өдөр, газар, шаардлагатай тохиол-долд хэсэгчлэн шилжүүлэх хугацаа, нөхцөл, шилжүүлсэн гэж үзэх үндэслэл хамаарна;
- Баталгаат хугацаа, түүний дараа үеийн засвар үйлчилгээний талаар тодорхой тусгах ёстой;
- Түрээслүүлэгч түрээсийн зүйлийн ашиглалт, засвар үйлчилгээтэй ямар журмаар танилцах, түүнд танилцуулахаар тохиролцсон санхүүгийн болон бусад бичиг баримтын нэр, эдгээртэй танилцах журмыг тусгана;
- Түрээсийн зүйлийг ямар нөхцөлд ямар журмаар буцаан авах тухай гэрээнд заана;
- Гэрээний биелэлтэд хяналт тавих, маргаан шийдвэрлэх журмыг гэрээгээр тохиролцоно;
- Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээ дуусгавар болох, гэрээг хугацаанаас өмнө цуцлах, шаардлагатай бол түрээсийн зүйлийг түрээслэгчийн өмчлөлд шилжүүлэн өгөх, нөхцөл журмыг тодорхойлно;
- Түрээсийн төлбөр, хүүгийн хэмжээ, түрээсийн үнэ төлбөрийг гүйцэтгэх журам зэрэг шаардлагатай зүйлүүдийг талууд гэрээндээ заан тусгах ёстой.

Эдгээр асуудал нь санхүүгийн түрээсийн гэрээнд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлох, үүргийн гүйцэтгэлийг тооцох, маргаан гарсан тохиолдолд түүнийг шийдвэрлэх зэрэгт чухал ач холбогдолтой байдаг. Санхүүгийн түрээсийн гэрээний хэлбэр, нөхцөл, агуулгыг хуулиар нарийвчлан тогтоожээ.

Хуульд заасан журмыг зөрчвөл хүчин төгөлдөр бус байхаар зохицуулсан нь уг гэрээний сул талтай холбоотой юм. Энэ нь: **а)** хөрөнгийн эргэлт удаан, урт хугацаанд хэрэглэдэг; **б)** үүнээс уламжлан түрээслэгч санхүүгийн түрээсээр хүлээсэн үүргээ зөрчих магадлал өндөр байдагтай холбоотойгоор эрсдэлээс болгоомжлох шаардлагатай байдаг.

Санхүүгийн түрээсийн гэрээний үнэ гэсэн ойлголтыг Санхүүгийн түрээсийн тухай хуулийн 7 дугаар зүйлд тодорхойлжээ. Хуулийн энэ заалтаас үзвэл санхүүгийн түрээсийн гэрээний үнэ, түрээсийн төлбөрийг дараах



байдлаар ялган ойлгож болох юм.

Санхүүгийн түрээсийн гэрээний үнэ, төлбөрийн ойлголт нь Иргэний хуулийн 313 дугаар зүйлд заасан түрээсийн гэрээний журмыг биелүүлэхэд чухал ач холбогдолтой.

Санхүүгийн түрээсийн төрөл. Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа: **а)** санхүүгийн түрээсийн тоног төхөөрөмж үйлдвэрлэж, түүнээ түрээслэгч; **б)** санхүүгийн байгууллага; **в)** санхүүгийн түрээс дагнан эрхэлдэг компаниуд эрхэлдэг байна. Санхүүгийн түрээсийн хугацааны хувьд урт хугацааны, дунд болон богино хугацааны санхүүгийн түрээс гэж ангилан үзэж болно. Санхүүгийн түрээсийн гэрээний зүйлээр нь үл хөдлөх, хөдлөх хөрөнгийн түрээс хэмээн ангилна. Санхүүгийн түрээсийн тухай хуульд санхүүгийн түрээсийн төрлийг анхдагч, дамжуулах, хоёрдогч, эргэх түрээс хэмээн ангилан заажээ.

Анхдагч түрээс. Барилга, байгууламж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл зэрэг ашиглалтын явцад үндсэн шинж чанараа алддаггүй, үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгийг үйлдвэрлэх буюу бусдаар үйлдвэрлүүлэх эсхүл худалдан авч түрээслэхийг хэлнэ. Санхүүгийн энэ түрээс нь гэрээний үндсэн дээр тодорхой хугацаатай, хариу төлбөртэйгөөр түрээслэгчийн эзэмшил ашиглалтад шилжүүлнэ. Түрээслэгч нь тогтмол хугацаанд түрээсийн төлбөр төлнө.

Санхүүгийн дамжуулах түрээс. Түрээслүүлэгчийн зөвшөөрлийг бичгээр авч, санхүүгийн түрээсийн зүйлийг гэрээний дагуу бусдад түрээслүүлнэ. Энэ тохиолдолд түрээслэгч өөрөө түрээслүүлэгчийн эрх, үүргийг хүлээнэ. Санхүүгийн дамжуулах түрээсийн онцлог нь: **а)** дамжуулан түрээслүүлэгч, түрээслэгчийн хооронд түрээсийн гэрээг хуульд заасан нөхцөл журмын дагуу байгуулна; **б)** анхдагч түрээсийн гэрээг цуцлах буюу талууд гэрээнээс татгалзсан зэрэг шалтгаанаар дуусгавар болгоход дамжуулах түрээсийн гэрээ дуусгавар болдог; **в)** ийнхүү санхүүгийн түрээсийн гэрээ хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд дамжуулан түрээслэгч хүсвэл анхдагч түрээслүүлэгчтэй тэргүүн ээлжинд гэрээ байгуулах эрхтэй байдаг; **г)** дамжуулах түрээсийн гэрээний хугацаа анхдагч түрээсийн гэрээний хугацаанаас илүү байж болохгүй; **д)** анхдагч түрээсийн гэрээг шүүхээс хүчин төгөлдөр бус гэж тооцсон тохиолдолд дамжуулах түрээсийн гэрээ хүчин төгөлдөр бусад тооцогдоно.


Санхүүгийн хоёрдогч түрээс. Энэ нь санхүүгийн гэрээ дуусгавар болсонтой холбоотой. Түрээслүүлэгч нь санхүүгийн түрээсийн гэрээ дуусгавар болсны дараа анхдагч түрээслэгчээс түрээсийн зүйлийг буцаан авсан тохиолдолд өөр түрээслэгчид түрээслүүлэх боломж бий болно. Энэ боломжийн дагуу анхны түрээслэгчээс өөр түрээслэгчид эд хөрөнгийг түрээслүүлэхийг санхүүгийн хоёрдогч түрээс гэдэг байна.

Санхүүгийн эргэх түрээс. Санхүүгийн түрээсийн гэрээгээр түрээсийн зүйл түрээслэгчийн өмчлөлд шилжсэнтэй холбоотой бий болно. Гэрээний дагуу түрээсийн зүйлийг өмчлөлдөө шилжүүлж авсан түрээслэгч нь түрээсийн зүйлийг захиран зарцуулах, бусдад түрээслэх эрхтэй болно. Түрээслэгч нь энэ эрхээ хэрэгжүүлэн түрээслүүлэгчийн эрх, үүрэг хүлээн бусдад (гуравдагч этгээдэд) буцаан түрээслүүлэхийг санхүүгийн эргэх түрээс гэнэ. Харин эргэх түрээс байгуулснаар түрээслэгч гуравдагч этгээдийн эрх эдэлж, үүрэг хариуцлагыг хүлээдэг.

Санхүүгийн түрээсийн зүйл. Санхүүгийн түрээсийн зүйл нь барилга, байгууламж, тоног төхөөрөмж зэрэг биет эд хөрөнгө байдаг. Эдгээр эд хөрөнгө нь дараах шинжийг агуулна: **а)** ашиглалтын явцад шинж чанараа алддаггүй эд хөрөнгө байна; **б)** үндсэн хөрөнгөд хамаарах биет эд хөрөнгө байна.

Түрээсийн зүйл байж болохгүй эд хөрөнгийг хуульд тодорхойлсон. Иймхүү түрээсэлж үл болох эд хөрөнгийг хүснэгтээр үзүүлбэл:

Төрийн болон орон нутгийн өмчийн хуульд Төрийн өмч нь:



а) Төрийн нийтийн зориулалттай өмч, **б)** Төрийн өөрийн өмч хэмээн ангилан тодорхойлж, эдгээр өмч нь Иргэний хуульд заасны дагуу үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгөд хуваагдах тухай заажээ. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийтийн зориулалтаар ашиглахаар бүх ард түмний өмч болгон заасан зүйлийг нийтийн зориулалттай өмч гэдэг. Нийтийн зориулалттай төрийн өмчид газар (иргэдэд өмчлүүлснээс бусад газар); газрын хэвлий, түүний баялаг, ус түүний доторх баялаг; ой, түүний дагалдах баялаг; ургамал, ан амьтны нөөц; түүх соёлын үнэт цогцолбор, хөшөө, дурсгал; археологийн болон

палентологийн олдвор зэрэг хуулиар нийтийн зориулалтаар ашиглахаар тогтоосон бусад эд хөрөнгө, (үл хөдлөх, хөдлөх хөрөнгө) хамаарна.

Төрийн өөрийн өмч гэдэгт төрийн байгууллага, албан газарт эзэмшүүлсэн хөрөнгө; төрийн өмчит үйлдвэрийн газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө; улсын төсвийн хөрөнгө болон төрийн бусад тусгай сангийн эд хөрөнгө; төрийн тусгай хэрэгцээний нөөц, хуульд заасан бусад үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө тус тус хамаарна.

Орон нутгийн өмчийн зүйл. Энэ нь мөн нийтийн зориулалттай өмч, орон нутгийн өөрийн өмчөөс бүрдэнэ. Үүнд: а) Төрийн өмчөөс хууль тогтоомжийн дагуу хуваарилж, шилжүүлсэн эд хөрөнгө, б) Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчид ногдох ашгаар олж авсан эд хөрөнгө, в) Хуульд заасан бусад үндэслэлээр бий болсон эд хөрөнгө хамаарна. Эдгээр хөрөнгө нь санхүүгийн түрээсийн зүйл байж болохгүй.

Санхүүгийн түрээсийн гэрээний талуудын эрх, үүрэг. Санхүүгийн түрээсийн гэрээний талууд нь хуулиар тодорхойлсон эрх, үүрэгтэй байдаг.

А) Түрээслүүлэгчийн үүрэг ба эрх нь Иргэний хууль, санхүүгийн түрээсийн гэрээний нөхцөлөөр тодорхойлогдоно.

Түрээслүүлэгчийн үүрэг. Түрээслүүлэгч нь эд хөрөнгө хөлслөх гэрээний хөлслүүлэгчийн эрхтэй адил эрх эдэлж хэрэгжүүлнэ. Жишээ нь: гэрээнд заасан хугацааны туршид гэрээний дагуу ашиглах боломжтой, ашиглалтын шаардлага хангаж чадахуйц эд хөрөнгө түрээслэгчид шилжүүлнэ. Энэ эд хөрөнгө нь биет байдлын болон эрхийн доголдолгүй байх ёстой. Эд хөрөнгөтэй холбоотой зайлшгүй зардлыг хууль буюу гэрээнд зааснаар нөхөн төлнө. Гэрээнд өөрөөр заагаагүй бол түрээслүүлсэн эд хөрөнгөд засвар үйлчилгээ хийнэ гэх мэт. Үүнээс гадна түрээсийн зүйлийг гэрээнд заасан нөхцөлийн дагуу хугацаанд нь түрээслэгчид шилжүүлнэ. Энэ үүргийг хэрэгжүүлэхдээ түрээслэгчийн хүсэлт, захиалгын дагуу гэрээгээр тогтоосон нөхцөлийн дагуу хэрэгжүүлнэ. Энэ нь: **а)** түрээсийн зүйлийг өөрөө үйлдвэрлэх; **б)** түрээсийн зүйлийг гуравдагч этгээдээр үйлдвэрлүүлэх; **в)** түрээсийн гэрээг худалдан авч шилжүүлэхтэй салшгүй холбоотойгоор тодорхойлогддог. Жишээ нь: Түрээсийн зүйл болох сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах машиныг Герман улсад үйлдвэрлүүлэхээр гэрээнд заасан атлаа гэрээгээр хүлээсэн хугацаанд нь нийлүүлэхийн тулд Хятад улсын Эрээн хотын бараан зах дээрээс худалдан авч түрээслэгчид шилжүүлж болохгүй.

Түрээсийн гэрээний зүйлийг гуравдагч этгээдээр үйлдвэрлүүлэх, худалдан авч байгаа тохиолдолд түүнийг санхүүгийн түрээсийн зүйл болгох гэж байгаа тухайгаа заавал мэдэгдэнэ. Энэ нь санхүүгийн түрээсийн зүйлийг түрээслэгчийн хүсэлт, захиалгын дагуу нийлүүлэх хийгээд биет зүйлийн болон эрхийн зөрчилгүй зүйлийг түрээслэгчид шилжүүлэх нөхцөлийг хангахад чухал ач холбогдолтой. Бас уг зүйлийн талаар гарч болох гомдлын шаардлагыг зохицуулах хэрэгтэй байж болно.

Мөн түрээсийн зүйлийн талаар гуравдагч этгээдэд мэдэгдэх үүрэг бий болох тохиолдол байдаг. Үүнд: **а)** гомдлын шаардлага тавих хугацаа дуусаагүй байхад түрээсийн зүйлийг өөр бусдын өмчлөлд шилжүүлбэл; **б)** уг түрээсийн зүйлийг түрээслэгч нь солигдвол тус тус түүнийг үйлдвэрлэсэн ба худалдан авсан гуравдагч этгээдэд заавал мэдэгдэнэ.

Харин түрээсийн зүйлийг түрээслэгчийн өмчлөлд шилжүүлэхээр гэрээнд зааж болно. Энэ тохиолдолд гэрээнд заасан нөхцөлийг зохих ёсоор хангасны дараа шилжүүлнэ. Гэрээний нөхцөлийг зохих ёсоор хангана гэдэгт түрээсийн зүйлийг түрээслэгчийн хүсэлт, захиалгын дагуу үйлдвэрлэсэн, эсхүл гуравдагч этгээдээр үйлдвэрлүүлсэн, худалдан авсан байхын хамт гэрээний дагуу ашиглах боломжтой чанарын шаардлага хангасан биет байдлын болон эрхийн ямар нэгэн доголдолгүй болсон, гэрээний үүргээ ямар нэгэн байдлаар зөрчигдөхгүй болсныг хамааруулан ойлгоно. Иймхүү гэрээний нөхцөлийг зохих ёсоор хангасан бол түрээсийн зүйлийг түрээслэгчид саадгүй шилжүүлэн өгөх үүрэгтэй. Түрээслүүлэгч нь хууль, гэрээнд заасан бусад үүргээ бүрэн биелүүлнэ.

Түрээслүүлэгчийн эрх нь Иргэний хуульд заасан эд хөрөнгө хөлслөх гэрээний хөлслүүлэгчийн эрхтэй адил байдаг. Үүнд: Түрээсийн зүйл болох эд хөрөнгөөс салгаж болох засан сайжруулалтыг авч үлдэж болно. Түрээслэгч үүргээ биелүүлээгүйн улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй. Энэ нь доорх хоёр үндэслэлд хамаатай юм: **а)** түрээслүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр түрээсэлсэн эд хөрөнгө, тоног төхөөрөмж, түүний хийц, зохион байгуулалтыг өөрчилсөн түүнийг засахгүй байснаас шалтгаалж учирсан хохирол; **б)** түрээслэн авсан эд хөрөнгийг ердийн элэгдэл, гэрээгээр тохиролцсон элэгдлээс илүү муутгахгүй байх үүргээ зөрчсөнөөс үүссэн хохиролд хамаатай зохицуулалт юм.

Энэхүү хуульд заасан үндэслэлийн дагуу гэрээг хугацаанаас өмнө цуцлахаар шаардах, үүний улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй. Иймхүү шаардах үндэслэл нь: **а)** Түрээслэгчид урьдчилан сануулсаар байтал түрээсийн зүйл, эд хөрөнгийг муутгасан буюу гэмтээсэн явдал нь гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах, үүнээс улбаалан бий болсон учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах эрх бий болно; **б)** Түрээсийн зүйл болох эд хөрөнгийг муутгах, гэмтээх бодит нөхцөлийг бий болгосон явдал нь гэрээг цуцлах түүнээс болж учирсан хохирлоо шаардах эрхтэй юм. Хуулийн энэ зохицуулалт нь түрээсийн зүйлийг муутгахгүй түүнийг гэмтээхгүй байгаа боловч түрээсийн гэрээг үргэлжлүүлэх нь зайлшгүй муутгах, эвдэж гэмтээх нь зайлшгүй болсон байх ёстой. Барьцааны зүйл муудах, гэмтэх нь түүнийг зориулалтын дагуу хэвийн ашиглах боломжгүй болох, устгаж үгүй болохоор байх, сэргээн засварлахад гарах хохирол нь их байх, бодитой нөхцөл бий болсон байх ёстой; **в)** Түрээслэгч

3 сарын турш хөлсөө төлөөгүй нь гэрээг хугацаанаас өмнө цуцлахыг шаардах үндэслэл болно. Үүнээс гадна түрээсийн төлбөрийг гэрээнд заасан хугацаандаа хүлээн авна. Түрээслэгч үүргээ биелүүлээгүйн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, түүнээс шаардан нэхэмжлэх эрхтэй байдаг. Мөн хууль ба гэрээнд заасан үндэслэлийн дагуу түрээсийн зүйлийг буцаан авах гэрээг цуцлахтай холбогдсон зардлыг түрээслэгчээр төлүүлэхээр шаардах эрхтэй юм.

Гэрээнд заасны дагуу түрээслэгчийн санхүүгийн баримтыг хүлээн авна.

Түрээсийн зүйлийн ашиглалт, засвар үйлчилгээтэй газар дээр нь танилцана. Энэ мэтээр хууль, гэрээнд заасан бусад эрхийг эдэлнэ.

В) Түрээслэгчийн эрх ба үүрэг нь Иргэний хуулийн эд хөрөнгө хөлслөх гэрээний хөлслөгчийн хүлээх үүрэг, эдлэх эрхтэй адил байдаг. Үүнээс гадна Санхүүгийн түрээсийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан үүрэг, эрхийг хэрэгжүүлнэ.

Түрээслэгчийн үүрэг. Түрээслэгчийн үүрэг эд хөрөнгө хөлслөгчийн үүрэг. (ИХ-ийн 289 дүгээр зүйлийн 289.1)-тэй адил байдаг. Санхүүгийн түрээсээр авсан эд хөрөнгийг зөвхөн гэрээнд заасан нөхцөл зориулалтын дагуу ашиглах үүрэгтэй байна. Түүнийг түрээсээр ашигласны үнэ, төлбөр, хүүг гэрээнд заасан хугацаанд төлнө. Түрээслүүлэгчийн зөвшөөрөл авахгүйгээр түрээсийн зүйл түүний хийц, зохион байгуулалтыг өөрчлөх буюу өөрийн хүсэл зоригт нийцүүлэн засварлахгүй байх үүрэгтэй. Түүнчлэн авсан эд хөрөнгийг ердийн элэгдэл ба гэрээгээр тохиролцсон элэгдлээс илүү муутгахгүй байна. Санхүүгийн түрээсийн гэрээнд ердийн элэгдлийг тооцох журам, мөн түрээсийн зүйлийн элэгдэл ямар байх, түүнийг хэрхэн тодорхойлох талаар тусгаж байх нь зүйтэй байдаг.

Гэрээ дуусгавар болоход түрээсийн зүйлийг түрээслэгчид бүрэн бүтэн буцааж өгнө. Түрээсийн зүйлийн бүрэн бүтэн байдлын талаар түрээслэгчид нэн даруй мэдэгдэнэ. Энэ үүрэг нь дараах тохиолдолд бий болно: **а)** Түрээслэн авсан эд хөрөнгөд доголдол илэрсэн; **б)** Гэнэтийн нөхцөл байдал бий болсноор эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зайлшгүй шаардлага гарсан тохиолдлуудад бий болно.

Гэнэтийн нөхцөл байдал бий болсон гэдэг нь түрээсийн зүйлийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, түүний хэвийн ажиллагааг хангах талаар зайлшгүй арга хэмжээ авбал зохих нөхцөл байдал үүссэнтэй холбоотой байна. Энд гол төлөв гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлыг хамааруулан үзэж болох юм. Жишээ нь: Гал түймэр, үер, газар хөдлөлт, ган зуд зэрэг байгалийн гамшигт үзэгдэлтэй холбоотойгоор гэнэтийн нөхцөл байдал бий болж болох мөн хорио цээрийн дэглэм тогтоосон, дайн байлдааны ажиллагаа, үйлдвэрлэлийн осол, бослого тэмцэл, ажил хаялт зэрэг нийгмийн онцгой байдлаас шалтгаалан "гэнэтийн нөхцөл байдал бий болох" тохиолдол.

Түүнчлэн цахилгаан, дулаан эрчим хүчний доголдол, уур усны хангалт зэргээс үйлдвэрлэлийн дотоодын хувийн үйл ажиллагаа алдагдсан доголдол гарсантай холбоотойгоор түрээсэлсэн хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зайлшгүй арга хэмжээ авах шаардлага гарч болно. Энэ мэтээр түрээсийн зүйлийн бүрэн бүтэн байдлыг хангах шаардлага гарсан тохиолдолд түрээслүүлэгчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй байдаг.

Энэ мэтээр хууль ба гэрээнд заасан үүргийг биелүүлэх ёстой.

Санхүүгийн түрээсийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т түрээслэгч нь "түрээсийн зүйлийг хүлээн авах, түрээсийн төлбөрийг хугацаандаа төлөх үүрэгтэй болохыг заагаад түрээслүүлэгчийн түрээсийн зүйлийн байгаа газарт саадгүй нэвтрүүлэх үүргийг тодорхойлжээ". Энэ үүрэг нь түрээсийн зүйлийн ашиглалт, засвар үйлчилгээтэй түрээслүүлэгчийг танилцах эрхтэй холбоотой зохицуулалт юм.

Түүнчлэн түрээслэгч нь гэрээнд тохиролцсоны дагуу санхүүгийн болон түрээсийн зүйлтэй холбоотой бусад бичиг баримттай түрээслүүлэгчид танилцуулах үүрэг хүлээдэг.

Санхүүгийн түрээсийн гэрээгээр талуудын тохиролцсон бусад үүрэг хүлээнэ.

Түрээслэгчийн эрх нь эд хөрөнгө хөлслөх гэрээгээр эд хөрөнгө хөлслөгчийн эрхтэй адил зохицуулалттай байдаг. (ИХ-ийн 289 дүгээр зүйлийн 289.2) Түрээслэгчийн буруугүйгээр түрээслэн авсан эд хөрөнгө ашиглах боломжгүй болсон бол түрээсийн төлбөр төлөхөөс татгалзах эрхтэй. Түрээслэн авсан эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангахтай холбоотой зайлшгүй зардлыг түрээслүүлэгчээс шаардана.

Хуульд заасан үндэслэлийн дагуу гэрээг цуцална. Энэ үндэслэлд түрээслэн авсан эд хөрөнгө нь бусдын амь бие, эрүүл мэндэд аюул учруулж болохуйц байгаа байдалд хамаарна.

Төлбөрийн чадвартай өөр түрээслэгчийг санал болгон гэрээгээ цуцалж болно. Энэ эрх нь дараах нөхцөлд хэрэгжих боломжтой юм. Үүнд:

- **а)** Санхүүгийн түрээсийн гэрээний үндсэн хугацаагаар эд хөрөнгийг түрээслэн авах хүсэлтэй этгээдийг санал болгоно;
- **б)** санал болгосон этгээд нь төлбөрийн чадвартай санхүүгийн хувьд түрээсийг хэрэгжүүлэх боломжтой байна;
- **в)** Түрээслүүлэгчид нэг сарын (нэг сараас доошгүй) хугацааны өмнө мэдэгдэнэ.

Хуульд заасан эдгээр шаардлагыг биелүүлсэн бол хугацаанаас нь өмнө гэрээгээ цуцлах боломжтой.

Санхүүгийн түрээсийн гэрээ дуусгавар болсны дараа түрээслүүлэгчээс зардал төлүүлэхээр шаардаж болно. Зардал шаардах эрх нь дараах нөхцөлд бий болно: **а)** түрээсэлсэн эд хөрөнгийг өөрийн зардлаар засаж сайжруулсан байх; **б)** энэ нь эд хөрөнгийг засаж сайжруулахад гарсан зайлшгүй зардлын хэмжээгээр хязгаарлагдана. Тухайн эд хөрөнгийг засаж сайжруулахад гаргасан зайлшгүй биш зардал үүнд хамаарахгүй юм. Жишээ нь: Түрээсийн зүйлийг засаж сайжруулахдаа гоёл чимэглэлийн зүйл нэмсэн, түүнийг зориулалтаар нь ашиглахад шаардлагагүй нэмэлт тоног тоноглол хийсэн зэрэг; **в)** өөр эд хөрөнгийг өөрийн зардлаар засаж сайжруулахдаа зөвхөн түрээслүүлэгчийн зөвшөөрөлтэйгөөр хэрэгжүүлнэ. Хэрэв түрээслүүлэгчийн зөвшөөрөл аваагүй буюу түүний зөвшөөрөөгүй байхад түүнийг засаж сайжруулах, улмаар эд хөрөнгийг

засаж сайжруулсан гэх үндэслэлээр зардал шаардах эрхгүй.

Харин энэ талаар гэрээний талууд өөрөөр тохиролцсон бол гэрээний зохицуулалтын дагуу уг асуудлыг шийдвэрлэнэ.

Дээр дурдсан түрээсийн зүйлийг засаж сайжруулсан зардал нь эд хөрөнгөөс салгаж болохгүй сайжруулалттай холбоотой юм.

Харин түрээслэн авсан эд хөрөнгөд салгаж болох засан сайжруулалт хийсэн бол гэрээ дуусгавар болоход түүнийгээ салган авах эрхтэй байдаг.

Түрээслүүлэгчийн зөвшөөрлөөр эд хөрөнгийг гуравдагч этгээдэд шилжүүлэх буюу дамжуулан хөлсөлж болно. Энэ мэтээр хуульд заасан болон гэрээгээр тохиролцсон бусад эрхийг хэрэгжүүлнэ.

Санхүүгийн түрээс (лизинг)-ийн тухай хуульд Иргэний хуулийн 289 дүгээр зүйлд заасан эд хөрөнгө хөлслөгчийн эрхээс гадна түрээслэгч нь дараах эрхийг хэрэгжүүлэхээр тогтоожээ:

- Түрээсийн зүйлийг гэрээнд заасан нөхцөлийн дагуу өөрийн өмчлөлд шилжүүлэн авах, санхүүгийн түрээсээр үргэлжлүүлэн ашиглах хүсэлт гаргах, уг зүйлийг түрээслэгчид буцаах эрхтэй;
- Гэрээний хугацаа дуусгавар болоход түрээсийн зүйлийг түрээслэгчийн өмчлөлд шилжүүлэхээр тусгасан бол тохирсон хугацааныаас өмнө үнийг урьдчилан төлж, түрээсийн зүйлийг өөрийн өмчлөлд шилжүүлэн авах хүсэлт түрээслэгчид гаргах эрхтэй. Уг хүсэлтэд түрээслүүлэгч бичгээр хариу өгнө;
- Гуравдагч тал хохирол учруулсан тохиолдолд түрээслүүлэгчид гомдлын шаардлага гаргахаас өмнө гуравдагч этгээдээс хохирлоо нэхэмжлэх эрхтэй. Энэ талаар гэрээнд өөрөөр заасан бол гэрээгээр тохиролцсон журмыг баримтална;
- Түрээсийн төлбөрийг түрээсийн зүйл хүлээн авсан үеэс эхлэн төлнө. Харин үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж түрээсэлсэн бол үйлдвэрлэл эхэлсний дараа түрээсийн төлбөр төлж эхэлнэ;
- Түрээслэгч нь түрээсийн зүйлийг буцаах, төлбөрийг бууруулах зөрчлийг арилгахыг шаардаж болно. Түрээсийн зүйлийг: **а)** Түрээсийн зүйлийг хүлээн авах үед уг зүйл биет байдлын доголдолтой бол түүнийг буцаах, үнэ төлбөргүй засуулах, иж бүрэн болгох, түрээсийн төлбөрийг зохих хэмжээгээр бууруулахыг шаардана; **б)** Түрээсийн зүйлийг хүлээн авах үед эрхийн зөрчилтэй байвал түрээсийн зүйлийг буцаах, эсхүл түүний зөрчлийг үнэ төлбөргүй арилгуулах, эрхийн зөрчлийг арилгахад гарах зардлаа холбоотойгоор түрээсийн төлбөрийг бууруулахыг шаардах эрхтэй юм.
- Түрээсийн зүйл биш бол түүнийг хүлээн авахаас татгалзана. Энэ эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор түрээслүүлэгчийн хүлээлгэн өгч байгаа эд хөрөнгө нь түрээсийн зүйл мөн эсэхийг түрээслэгчийн зүгээс шалгаж хүлээж авна;
- Түрээслүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд түрээсийн төлбөрийг түр зогсоож болно.

Санхүүгийн түрээсийн гуравдагч этгээдийн эрх ба үүрэг. Санхүүгийн түрээсийн харилцаанд гол төлөв гуравдагч этгээд оролцдог. Санхүүгийн түрээсийн харилцаанд оролцож байгаа гуравдагч этгээд нь түрээсийн зүйлийг үйлдвэрлэх, худалдах, хадгалах зэрэг үйл ажиллагаа гүйцэтгэх үүрэгтэй холбоотойгоор Иргэний хуулийн холбогдох зүйл, заалтаар зохицуулагдана.

Тухайлбал, санхүүгийн түрээсийн зүйлийг худалдах-худалдан авах гэрээтэй холбоотойгоор Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.2-т зааснаар худалдаж байгаа эд хөрөнгийн зориулалт, хэрэглээний шинж чанар, хадгалах, хэрэглэх, тээвэрлэх нөхцөл журам баталгаат болон эдэлгээний хугацаа, үйлдвэрлэгчтэй холбогдох үнэн зөв, бүрэн мэдээллийг өгөх үүрэгтэй байдаг.

Түүнчлэн Иргэний хуулийн 246 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгө илгээх талаар худалдагчийн хүлээх үүргийг гүйцэтгэнэ. Жишээлбэл: худалдагч нь гэрээ ёсоор эд хөрөнгийг тээвэрлэгчид шилжүүлнэ. Уг эд хөрөнгийг илгээсэн тухай худалдан авагчид мэдэгдэнэ. Ачааны дэлгэрэнгүй жагсаалтыг илгээнэ. Мөн эд хөрөнгийг тээвэрлэгчид шилжүүлэхдээ түүнд таних тэмдэг, тэмдэглэл хийнэ. Тэрээр эд хөрөнгийг худалдан авагчид илгээх үүрэг хүлээсэн бол тохирсон газарт хүргэх тухай тээвэрлэлтийн гэрээг тээвэрлэлтийн ердийн нөхцөлөөр хийнэ. Мөн тээвэрлэлтийн явцад эд хөрөнгийн даатгалын гэрээ байгуулахад шаардагдах өөрт байгаа бүх мэдээллийг өгөх зэрэг үүргийг хэрэгжүүлэх ёстой.

Мөн Иргэний хуулийн 253 дугаар зүйлд зааснаар эд хөрөнгийн доголдлын талаар заасан худалдсан эд хөрөнгө доголдолтой бол доголдлыг арилгах, түүнийг сольж өгөх, доголдол арилгахтай холбогдсон зардлыг хариуцах зэрэг үүрэгтэй байна.


Иргэний хуулийн 258 дугаар зүйлд зааснаар худалдсан түрээсийн зүйл болох эд хөрөнгийг хадгалах тухай эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Иргэний хуулийн 316 дугаар зүйлд зааснаар санхүүгийн түрээсийн гэрээний гуравдагч этгээд нь: **а)** түрээслэгчийн захиалагаар гэрээний зүйл болох эд юмыг үйлдвэрлэх, нийлүүлэх; **б)** түрээслэгчээс зохих хөлс, зардлыг шаардах эрхтэй; **в)** гэрээнд зааснаар гэрээний зүйлд засвар үйлчилгээ хийнэ; **г)** Гэрээний зүйлийг тохируулах, суурилуулах, ашиглахтай холбоотой үнэн зөв мэдээллийг түрээслэгчид өгөх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн түрээсийн гэрээний талууд нь үүрэг ба эрхээ **бусдад шилжүүлж** болно. Үүнд: **а)** Түрээслүүлэгч нь эрх ба үүргээ бусад этгээдэд бүхэлд нь эсхүл хэсэгчлэн шилжүүлэх бол түрээслэгчид урьдчилан бичгээр мэдэгдэнэ. Тэрээр түрээсийн зүйлийг бусдын өмчлөлд шилжүүлэх бол түрээслэгчид урьдчилан мэдэгдэнэ. Түрээсийн зүйлийг өмчлөх эрхийг шилжүүлэн авсан этгээд санхүүгийн түрээсийн гэрээг түүнд заасан нөхцөлийн дагуу үргэлжлүүлэх үүрэгтэй байдаг; **б)** Түрээслэгч мөн гэрээнд заасан эрх, үүргээ бүхэлд

нь эсхүл хэсэгчлэн шилжүүлж болно. Ингэхдээ түрээслүүлэгчээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр хэрэгжүүлнэ. в) Гуравдагч этгээд түрээсийн зүйлтэй холбоотой үүргээ бусдад шилжүүлэх бол түрээслүүлэгч, түрээслэгч хоёулангаас нь бичгээр зөвшөөрөл авна. Ийнхүү санхүүгийн түрээсийн харилцаанд оролцож байгаа талууд эрх үүргээ бусдад шилжүүлсэн нь тухайн гэрээг өөрчлөхийг шаардах үндэслэл болохгүй.

Санхүүгийн түрээсийн гэрээний талуудын хүлээх хариуцлага нь уг гэрээний биелэлтийг хангахад чухал ач холбогдолтой байдаг.

Талуудын хүлээх хариуцлагыг Иргэний хууль (314, 315 дугаар зүйл) Санхүүгийн түрээсийн тухай хуулийн 13 дугаар зүйлүүдэд тус тус тодорхойлжээ.



Талуудын хариуцлага хүлээх үндэслэлийг хялбарчлан үзүүлбэл:


Эдгээр үндэслэлээр хүлээх хариуцлага нь эд хөрөнгө хөлслөх гэрээний хариуцлагатай адил байна.

Иргэний хуулийн "эд хөрөнгө хөлслөх" гэсэн дэд бүлэгт дээр дурдсан үндэслэлүүдэд түрээслүүлэгчид хүлээлгэх хариуцлагын тухай заалт тодорхойгүй байна. Энд хөлслүүлэгчийн эрх, үүрэг эд хөрөнгийн доголдолтой холбоотой хуулийн зохицуулалтаас үзвэл шаардах эрх, гэрээг цуцлах, хохирлоо нөхөн төлүүлэх зэрэг хариуцлагын шинжтэй заалтууд байдаг. Иймээс санхүүгийн түрээсийн гэрээнд дээр дурдсан түрээслүүлэгчийн хүлээх хариуцлага, түүнийг хүлээлгэх үндэслэлийг тодорхой зааж байх нь зүйтэй юм.

Түүнчлэн санхүүгийн түрээсийн гэрээнд Иргэний хуулийн гэрээний болон үүргийн эрх зүйн үүрэг биелүүлээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй улмаас үүссэн үр дагаврыг хариуцан арилгах, хүлээх хариуцлагын талаарх зохицуулалтыг ашиглаж болохоос гадна үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг хэрэглэж болно. Энэ асуудлыг талууд гэрээндээ нарийвчлан тодорхойлно.

Гэрээнд түрээслүүлэгчид гомдлын шаардлага гаргахаас өмнө эд хөрөнгийг худалдагч, тээвэрлэгчээс учирсан хохирлоо нөхөн төлүүлэхийг шаардахаар тохиролцож болно. Гэвч энэ нь түрээслүүлэгчид хариуцлага хүлээлгэх, түүнд гомдлын шаардлага гаргахаас бүрэн чөлөөлж байгаа хэрэг биш юм.

Гуравдагч этгээд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас үүссэн хохирлыг түрээслүүлэгч арилгах үүрэгтэй. Энэ асуудлыг гэрээнд өөр



арилгах үндэслэлийг дараах байдлаар зохицуулжээ.

Түрээслэгч нь санхүүгийн түрээсийн зүйлийг өөрөө үйлдвэрлэсэн бол тэрээр гэрээний харилцаанд гуравдагч этгээдтэй адил эрх эдэлж, үүрэг хариуцлагыг нь хүлээнэ.

Санхүүгийн түрээсийн гэрээг түрээслүүлэгч, түрээслэгч, гуравдагч этгээдийн хооронд гурван тал байдлаар тохиролцож болно.

Харин түрээслэгч гуравдагч этгээдийг өөрөө сонгосон бол түрээслүүлэгч хариуцлагаас чөлөөлөгдөх үндэс болно.

Түрээслэгчийн гэм буруугаас санхүүгийн түрээсийн гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд түрээслүүлэгч нь хохирлоо шаардах эрх үүснэ. Түүний **шаардлагын хэмжээг тодорхойлох** журмыг Иргэний хуулийн 315 дугаар зүйлээр зохицуулжээ. Энд түрээслүүлэгчээс тавих шаардлагын хэмжээг тодорхойлохдоо түрээсийн эд хөрөнгөтэй холбоотой дараах үзүүлэлтийг харгалзан үзнэ. Үүнд: **а)** Түрээсэлсэн эд юмсын үнэ харгалзах үзүүлэлтийн нэг болно. Энэ үнийг тодорхойлохдоо эд юмсын элэгдлийг тооцсон үнэ байна; **б)** Түрээсийн төлбөрөөс төлөгдөөгүй төлбөр хэд байгааг тодорхойлно; **в)** Санхүүгийн түрээсийн гэрээ үйлчилж байх хугацаанд хэмнэгдсэн зардлыг тодорхойлно. Эдгээр үзүүлэлтийг харгалзан шаардлагынхаа хэмжээг тодорхойлно.

Санхүүгийн түрээсийн тухай хуульд /13 дугаар зүйл/ талуудын хүлээх хариуцлагыг тодорхойлсон. Энд түрээслэгч хохирол хариуцан оролцон (гурвалсан гэрээ) байгуулж болдог. Энэ тохиолдолд гуравдагч этгээд үүргээ биелүүлээгүйн хариуцлагыг түрээслүүлэгч, түрээслэгчийн өмнө хариуцдаггүй. Харин гэрээнд өөр байдлаар тохиролцож болно.

Харин түрээслүүлэгч нь дараах тохиолдолд гуравдагч этгээд, түрээслэгчид учирсан хохирлыг хариуцан арилгана. Үүнд:

а) Санхүүгийн түрээсийн зүйлийг гуравдагч этгээдээр үйлдвэрлүүлэх, худалдан авч байгаа бол түрээсийн гэрээний зүйл болгох тухай түүнд мэдэгдэх үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлээгүйгээс үүссэн хохирлыг түрээслүүлэгч хариуцна;

б) Гуравдагч этгээдэд дор дурдсан ажиллагааг мэдэгдэх үүрэгтэй:
- Гомдлын шаардлага тавих хугацаа дуусаагүй байхад түрээсийн зүйлийг бусдын өмчлөлд шилжүүлбэл;
- Түрээслэгч солигдох тохиолдлыг мэдэгдээгүй явдал нь түүнээс шалтгаалан үүссэн хохирлыг түрээслүүлэгч хариуцах үндэслэл болдог.

Түрээсийн зүйлийг дамжуулан түрээсэлж болно. Энэ талаар өмнө дурдсан билээ. Ийнхүү дамжуулан түрээсэлснээр түрээслэгчийг түрээсийн төлбөрөөс чөлөөлөх үндэслэл болохгүй. Түүнчлэн гэрээг өөрчлөх, өөрчлөхийг шаардах үндэслэл болдоггүй. Энэ нь түрээслэгч түрээсийн зүйлийг зөвхөн эзэмшиж, ашиглах эрхтэй холбоотой.

Санхүүгийн түрээсийн баталгаа нь Санхүүгийн түрээсийн тухай хуулийн 18 дугаар зүйлд зааснаар зохицуулагдана. Түрээслүүлэгч нь түрээсийн гэрээнд заасан үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Иргэний хуульд заасан аргыг хэрэглэнэ. Үүнд:

Түрээслэгчээс барьцаа авах. Барьцааг Иргэний хуульд заасан үндэслэл, журмын дагуу барьцааны гэрээ байгуулах замаар хэрэгжүүлнэ. Барьцааны эрх зүйн зохицуулалт нь Иргэний хуулийн 153-184 дүгээр зүйлд заасан байдаг. Санхүүгийн түрээсийн гэрээнд заасан түрээсийн зүйл, тэдгээртэй холбоотой эрхийг улсын бүртгэлд бүртгүүлж болно. Энэ нь үл хөдлөх хөрөнгийн санхүүгийн түрээс болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зэрэгт хамааралтай. Жишээ нь: Үл хөдлөх хөрөнгө барьцаалсан бол Иргэний хуулийн 166 дугаар зүйлийн 166.1-д зааснаар бүртгүүлнэ. Энэхүү бүртгэл нь эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн буюу эрхийн улсын бүртгэлийн хуульд зааснаар зохицуулагдана.

Батлан даалт. Иргэний хуулийн 458 дугаар зүйлд зааснаар батлан даалтын гэрээ байгуулна. Батлан даалтын гэрээгээр батлан даагч нь үүрэг гүйцэтгэгч, өөрийн үүргийг гүйцэтгэж чадна гэж үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө баталж үүрэг гүйцэтгэхгүй бол өөрөө хариуцах үүрэг хүлээдэг. Санхүүгийн түрээсийн гэрээнд энэ зохицуулалтыг ашиглаж болно.

Баталгаа гаргуулах. Санхүүгийн түрээсийн гэрээнд банкны баталгаа гаргуулахдаа Иргэний хуулийн 457 дугаар зүйлд заасан зохицуулалтын дагуу хэрэгжүүлнэ.

Санхүүгийн түрээсийн зүйлийг барьцаалах. Түрээслүүлэгч санхүүгийн түрээсийн зүйлийг түрээслэгчээс бусад этгээдэд барьцаалж болно. Энэ нь үг түрээсийн зүйлийг зөвхөн барьцааны гэрээний зүйл болгон ашиглахтай холбоотой.

Түрээсийн зүйлийг бусад этгээдэд барьцааны гэрээний зүйл болгон ашиглах эрх нь түрээслэгчийн бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжинэ.

Харин барьцаанд тавьсан түрээсийн зүйл нь гэрээнд заасан үүрэг ёсоор бусдын эзэмшилд шилжих тохиолдолд уг зүйлийг шилжүүлэн авсан этгээд санхүүгийн түрээсийн гэрээг үргэлжлүүлэх үүрэгтэй. Энэ нь түрээслэгч санхүүгийн түрээсийн гэрээний хугацаанд түрээслүүлэгчтэй байгуулсан нөхцөлийн дагуу түрээсийн зүйлийг эзэмших, ашиглах гэрээгээр тохиролцсон түрээсийн төлбөр төлөх эрх, үүрэг хэвээр хадгалагдах нөхцөлийг бүрдүүлнэ.

Тэгвэл түрээслэгч санхүүгийн түрээсийн зүйлийг барьцааны зүйл болгон ашиглаж болохгүй. Тийм эрх эдлэх ч боломжгүй юм.

Тухайлбал, банкны баталгааны гэрээний дагуу түрээслэгчийн өмнөөс мөнгөн төлбөрийг банк гүйцэтгэж, тэрээр баталгаа гаргасан банканд төлбөр гүйцэтгэх үүргийг гэрээгээр хүлээж болно. Энэ бол үүргийн гүйцэтгэлийг хангах нэлээд найдвартай аргын нэг байдаг.

Мөн банкнаас бусад этгээдээр баталгаа гаргуулж болно. Мөн баталгаа нь Иргэний хуулийн 234 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулагдана. Энэ нь санхүүгийн түрээсийн гэрээний түрээслэгч тал үүргээ биелүүлээгүй тохиолдолд түрээслүүлэгч нь түрээсийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаа гаргагчаас үл маргах журмаар шаардах боломж бүрдүүлнэ.

Үүргийн гүйцэтгэлийг хангах эдгээр аргыг санхүүгийн түрээст хэрэглэхдээ Иргэний хуулийн холбогдох зүйлд заасан нөхцөл журмыг баримтлан гэрээ байгуулах ёстой.

Даатгал. Санхүүгийн түрээсийн зүйлийг эрсдэлээс хамгаалах зорилгоор гэрээний талууд тохиролцон гэрээний зүйлийг даатгуулж болно. Ийнхүү түрээсийн зүйлийг даатгуулахдаа Иргэний хуулийн 431- 444 дүгээр зүйл, Даатгалын тухай Монгол Улсын хууль (шинэчилсэн найруулга. 2004 он)-д заасан нөхцөл, журмыг баримтлан даатгалын гэрээ байгуулах журмаар хэрэгжүүлнэ.

Санхүүгийн түрээсийн гэрээний хамаарал. Санхүүгийн түрээсийн гэрээ нь Иргэний хуульд заасан бусад гэрээнүүдтэйгээ өргөн хамааралтай байдаг. Санхүүгийн түрээс нь эд хөрөнгө хөлслөх гэрээтэй адил зохицуулалт нэлээд байдаг. Иргэний хуулийн 317 дугаар зүйлд "санхүүгийн түрээс" гэсэн хорин зургадугаар бүлэгт өөрөөр заагаагүй бол санхүүгийн түрээсийн гэрээнд эд хөрөнгө хөлслөх гэрээний талаар Иргэний хуульд заасан журам нэгэн адил үйлчилнэ гэжээ.

Үүнээс гадна санхүүгийн түрээсийн зүйлийг худалдах, худалдаж авахад Иргэний хуулийн холбогдох заалтаар зохицуулна. Түрээсийн зүйлийг даатгуулахтай холбоотой бол даатгалын хууль тогтоомжийн зохицуулалт үйлчилнэ. Санхүүгийн түрээсийн эд хөрөнгийг тээвэрлэхэд тээвэрлэлтийн гэрээ байгуулна гэх мэт холбогдох эрх зүйн зохицуулалтыг судалж, санхүүгийн түрээсийн гэрээг хэрэгжүүлэхэд ашиглах шаардлагатайг анхаарах ёстой.



Ажлын байран дахь бэлгийн дарамтлалын эсрэг хууль тогтоомжийн хэрэгцээ

ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, ОТИС-ийн багш Д.Эрдэнэчимэг
ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал Ц.Алтанцэцэг

Оршил

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 3, 5 дугаар зүйлд "... Улс түмэн хүний эрх, бие хүний нэр төр, үнэ хүндийг сахин хамгаалах, эрэгтэй эмэгтэйчүүдийн тэгш эрхэд итгэл төгс байх, бүхий л эрх, эрх чөлөөг ямар ч ялгаваргүйгээр эдлэх, хүн бүр халдашгүй дархан байх эрхтэй. Хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хэрцгий, хүний ёсноос гадуур эсхүл нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэхийг хориглоно..." хэмээн хүний эрхийн суурь зарчмыг тунхагласан. Монгол Улс НҮБ-д гишүүнээр элсэж Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг бүрэн хүлээн зөвшөөрч, хүний эрхийг хангах, хамгаалах хүрээнд идэвхитэй ажиллах үүрэг хүлээсэн юм. Үүнтэй холбоотойгоор 1992 оны Үндсэн хуульд заасан ёсоор төр нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээсэн ба энэхүү үүргээ хэрэгжүүлж иргэний эрх, эрх чөлөөг хангах баталгааг өргөтгөн бэхжүүлэх талаар сүүлийн жилүүдэд нилээд ажил зохион байгуулсан билээ.

Гэвч өмнөх нийгмийн гажуудал, хоцрогдлоос үүдсэн хямралт байдлаас гадна ядуурал, ажилгүйдэл болон бусад нөхцөл, бэрхшээлийн улмаас хүний эрх зөрчигдөх, иргэн нь үүргээ умартах явдал гарсаар байна. Үүний нэг тод жишээ нь хөдөлмөрийн эрх зүйн харилцаанд ажилтны халдашгүй эрх зөрчигдөж, бэлгийн дарамтлалд өртөх явдал юм. Ажлын байран дахь бэлгийн дарамтлал нь байнга давтагдаж, улам бүр хурцдаж, лавширч байдгаас хохирогчийн өөрийгөө үнэлэх үнэлэмж болон нэр төр, хамт олны дундах харилцаанд сөргөөр нөлөөлж, улмаар хохирогчийн хөдөлмөрийн бүтээмжийг бууруулаад зогсохгүй, ажлаа орхих, ажлаас үндэслэлгүйгээр халагдах, эсвэл хүсээгүй бэлгийн харилцааг удаан хугацаанд тэвчих зэргээр ноцтой үр дагаваруудыг дагуулж байна.

Бэлгийн дарамтлал нь хүйсээр ялгаварлан гадуурхах явдлын нэг тодорхой хэлбэр гэдгийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч байна. Тухайлбал:

1. 1992 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан Ерөнхий зөвлөмжид... Эмэгтэйчүүдийг бэлгийн хүчирхийллээс хамгаалах тодорхой арга хэмжээ авахыг засгийн газруудад уриалсан.
2. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцид хүний үндсэн эрх, хувь хүний нэр төр, үнэ цэнэ болон эрэгтэй, эмэгтэй хэн боловч тэгш эрхтэй болохыг нотолж хувь хүн, байгууллага, үйлдвэрийн газрын эздийн зүгээс хөдөлмөрийн салбарт эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахыг устгахад чиглэсэн арга хэмжээ авах шаардлагатай болохыг заасан.
3. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хавсралт Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай тунхаг бичгийн 2 дугаар зүйлд хүн бүр биеийн болон сэтгэл санааны аливаа шаналал, зовлонд өртөхгүй байх, шударга, таатай орчинд ажиллах, шийтгэл, доромжлол, хүмүүнлэг бус, бүдүүлэг болон тарчлаан зовоох маягаар харьцах мэтэд өртөхгүй байх эрхийг эдлэх ёстой. Эмэгтэй хүнд хүч хэрэглэх явдлыг зөвхөн биеийн, бэлгийн, сэтгэл санааны хүрээгээр хязгаарлан ойлгож болно. Үүнд ажил хөдөлмөр дээр хүйсээр ялгаварлах болон бэлгийн дарамтлал мөн хамаарна гэж заасан.
4. Хөдөлмөр эрхлэлтэд ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх тухай Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенцийн тайлбарт ... бэлгийн дарамтлал нь хувь хүний дархан байдал, ажилтнуудын аж байдалд аюул занал учруулж ажлын байран дахь эрх тэгш байдлыг үгүй болгож хөдөлмөрийн харилцааны үндэс суурийг сулруулж үйлдвэрлэлийг бууруулдаг. Үүний ноцтой үр дагавар хөнөөлийг харгалзан улс орнууд иргэний болон эрүүгийн хариуцлага ногдуулах эрх зүйн актыг батлан гаргах боллоо ... хэмээн заасан байна.

Дээр дурдсан гэрээ, конвенци, зөвлөмжийг удирдлага болгон улс орон бүрт ажлын байран дахь бэлгийн дарамтлалыг өөр өөрийн орны онцлогт тохируулан янз бүрийн эрх зүйн актаар журамлан зохицуулж байна. Жишээ нь, Англи, Австрали улсад холбооны болон мужийн хүйсийн байдлаар ялгаварлан гадуурхахын эсрэг буюу тэгш бололцооны тухай хуулиар, Канад, Шинэ Зеландад Хүний эрхийн тухай хуулиар, АНУ-д Иргэний эрхийн тухай хуулиар, Энэтхэг улсад түр журмаар тус тус зохицуулж байна.

Манай улсад Ажлын байран дахь бэлгийн дарамтлалын талаархи олон нийтийн үзэл, бэлгийн дарамтлалын илрэх хэлбэр, өртөлт, сэтгэлзүйн байдлын талаар НҮБХХ болон ХЭҮК-оос хамтран хэрэгжүүлж буй төслийн багийн хийсэн судалгаагаар тус улсад хоёр хүн тутмын нэг нь аль нэг хэлбэрийн бэлгийн дарамтлалд өртдөг болох нь тогтоогджээ. Гэхдээ бэлгийн

дарамтлалын талаар ойлголт мэдлэг хангалтгүй, нийгмийн сэтгэл зүй бүрэн тогтоогүй байгаагаас ажлын байран дахь бэлгийн дарамтлалын аль нэгэн хэлбэрт ертсөн атлаа яг хүчиндүүлчихээгүй л бол ноцтой хэмээн үздэггүй, гомдол гаргадаггүй байдал ажиглагдаж байна. Мөн ажлын байран дахь бэлгийн дарамтлалын ихэнхи хувийг эрэгтэйчүүд тэр дундаа удирдах албан тушаалтан, хамтран ажилладаг хүмүүс ихээр үйлддэг болох нь судалгаанаас харагдаж байсан.

Ажлын байран дахь бэлгийн дарамтлалын хохирогч айж ичих, нэр төр, ажил алба, амьдралын байдал зэрэг олон хүчин зүйлийн нөлөөнөөс шалтгаалж эрхээ хамгаалж чадахгүй, чимээгүй дарагдуулж өнгөрөх нь бий. Ялангуяа тухайн асуудлыг нэг мөр шийдвэрлэх хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй, хэрэг шийдвэрлэх механизмын хүнд суртал, мөн айж эмээх, ичиж зовох зэргээс төвөгшөөж хууль хяналтын холбогдох байгууллагад хандаж чадахгүйгээс эрх нь зөрчигдсөөр байна.

Монгол Улс НҮБ-д гишүүнээр элсэж Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг бүрэн хүлээн зөвшөөрсөн боловч олон улсын хэмжээнд мөрдөж байгаа, нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, зөвлөмж, тунхаглалуудыг хууль хяналтын байгууллага нь ч тэр, хэрэгжүүлэгч байгууллага нь ч тэр огт хэрэглэдэггүй, дагаж мөрддөггүй болох нь судалгааны явцад ажиглагдаж байсан.

Бэлгийн дарамтлал нь хүний эрх чөлөөнд халдсан албадлагын шинжтэй, хүлээж авашгүй хүчирхийллийн нэг хэлбэр билээ. Иймд Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан, олон улсын хэмжээнд нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн хүний халдашгүй эрхийн нэг зөрчил болсон ажлын байран дахь бэлгийн дарамтлалын талаархи нийгмийн сэтгэлзүйг өөрчилж, хохирогчийн эрхийг хамгаалах, үүний тулд холбогдох хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага зайлшгүй байгаа энэ үед НҮБХХ болон ХЭҮК-оос хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд зарим хууль тогтоомжид ажлын байран дахь бэлгийн дарамтлалыг таслан зогсоох, энэ зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар тодорхой арга хэмжээнүүдийг авч байгаа нь цаг үеэ олсон ач холбогдолтой асуудал бөгөөд энэ нь бэлгийн дарамтлалтай тэмцэх хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэхэд чиглэгдэж байгаа юм.

Бэлгийн дарамтлалын эсрэг хууль тогтоомжийн хэрэгцээ

Манай улс Үндсэн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид хүний эрх, эрх чөлөөг хангахуйц бүхий л салбар дахь баталгааг бүрдүүлэх, хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар ерөнхийд нь зааж хуульчилжээ. Гэвч ямар ч хуульд ажлын байран дахь бэлгийн дарамтлалыг хориглох талаар хуульчлан зохицуулагдаагүй байна. Иймд энэ төрлийн гэмт үйлдлээс урьдчилан сэргийлж, иргэдийнхээ халдашгүй байх эрхийг хангахын тулд энэ талаархи хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор урган гарч байна. Ингэхдээ бие даасан хууль гаргахдаа гол нь биш харин холбогдох хууль тогтоомжид (хөдөлмөрийн, захиргааны, эрүүгийн хууль гэх мэт) нэмэлт, өөрчлөлт, оруулах, улмаар эдгээр хуулиудын уялдаа холбоог сайжруулах замаар эрх зүйн орчинг бүрдүүлэх нь зүйтэй хэмээн үзэж байна. Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг хавсралт 1-д тусгасан болно.

Хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх асуудлууд

Ажлын байран дахь бэлгийн дарамтлалын эсрэг хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгох саналыг боловсруулахдаа дараахь асуудлыг шийдвэрлэхэд голлон анхаарсан болно.

1. Хүний үндсэн эрхийн нэг болох халдашгүй дархан байх эрхийг баталгаажуулан илүүтэй хангахад хувь нэмрээ оруулах;
2. Бэлгийн дарамтлал нь ажлын байранд болон боловсролын салбарт илүүтэй үйлдэгддэг учир холбогдох хууль тогтоомжид энэхүү үйлдэл нь хууль бус болохыг хуульчлах;
3. Бэлгийн дарамтлал нь хүний эрхийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэл болохыг тодорхойлох.

Үүний тулд:

a. Ажлын байрны бэлгийн дарамтлал гэдэгт ямар зан авирыг ойлгохыг нарийвчлан тодорхойлох,
b. Эх хэлээрээ нэгдсэн нэг нэр томьёог тогтох,
c. Ажлын байран дахь бэлгийн дарамтлалын илрэх хэлбэр болох биеэр дарамтлах, үг хэлээр дарамтлах зэрэг нь ямар үйлдэл, эс үйлдлээр илэрдэг болохыг тодорхойлох.

4. Эрх нь зөрчигдсөн тохиолдолд хэрхэн хамгаалуулах талаар нэгдсэн ойлголтод хүрэх, үүний тулд гомдол барагдуулах оновчтой, шударга, түргэн шуурхай шийдвэрлэх механизмыг тогтоох;
5. Буруутай этгээдэд ногдуулах шийтгэлийн төрөл хэлбэрийг хуульчлах зэрэг болно.

Дүгнэлт

1. Нийгмийн сэтгэл зүйг өөрчлөх гэгээрлийн ажлыг шат шатанд нь явуулах. Үүний тулд иргэдийг энэ талаархи мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах, зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах гэх мэт;

2. Хурьцал үйлдэхээс өмнө хэн нэгэн хүнд бэлгийн дарамтлалын бусад хэлбэрээс учирч буй сэтгэл зүйн болон бие махбод, эд хөрөнгийн хор хохирлыг хэрхэн барагдуулах талаар нэг мөр ойлголттой болох;

3. Ажлын байран дахь бэлгийн дарамтлал нь хууль бус үйлдэл болохыг хуульчлах: Ийнхүү бэлгийн дарамтлалыг хориглох нь хүний эрхийг хангах баталгаа болж байдгаараа ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл, эмэгтэй хүн хүчиндүүлж байх ёсгүйн адил бэлгийн бусад хэлбэрийн дарамтад өртөх ёсгүй билээ.

Хавсралт 1

Ажлын байран дахь бэлгийн дарамтлалаас сэргийлэх болон ажил олгогчоос авах арга хэмжээний талаар Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал

А. Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хуульд оруулах нэмэлт

1. 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо
   a. 3.1.16. "Бэлгийн дарамтлал" гэж ажилтны хүсэл зоригийн эсрэг бэлгийн сэдэлтээр биеийн эмзэг хэсгүүдэд хүрэх, үнсэх, чимхэх, нудрах, тэврэх, эд зүйлийг нь гэмтээх, хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхгүйгээр хүчиндэх, албан тушаалаараа түрэмгийлж буюу өндөр цалин хөлс, шагнал, албан тушаал амлах замаар биеэ хамгаалж чадахгүй байдлыг нь далимдуулан хурьцал үйлдэх зэргээр бие махбодид нь халдах, хэл амаар доромжлох, заналхийлэх, бие галбир, хувцаслалт, нас хүйс, гэр бүлийн байдал, яс үндэс, гарал угсаа, шашин шүтлэг зэргээр нь дооглож тохуурхах, албадан ятгах, садар самуун зураг үзүүлэх зэрэг аман хэлбэрээр болон үйлдлээр илэрсэн доромжлол, түрэмгийллийг;
   b. 3.1.17 "Ажлын байр" гэж ажилтан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу ажил олгогчоос тогтоосон горимд нийцүүлэн түүнээс олгосон багаж хэрэгслээр, ажил олгогч эсхүл түүний төлөөлөгчийн удирдлагын дор баталсан норм, сүлжээ, үнэлгээгээр гүйцэтгэх ажил үүрэг болон энэ үүргээ ажлын болон ажлын бус цагаар гүйцэтгэж буй орон зайг;

2. 7 дугаар зүйл. Хөдөлмөрийн харилцаанд ялгаварлал, хязгаарлал, давуу байдал тогтоохыг хориглох
   a. 7.3. Ажилтан нь ажлын байранд бэлгийн дарамтлалаас хамгаалуулах, халдашгүй дархан байх эрхтэй.
   b. 7.4. Ажил олгогч болон тодорхой эрх мэдэл бүхий албан тушаалтан хувьдаа болон бусдад давуу байдал тогтоох, ашиг хонжоо олох, бэлгийн дур хүслээ хангах болон бусад зорилгоор ажлын байранд бэлгийн дарамтлал явуулах, бэлгийн дарамтлал явагдах нөхцөл бололцоогоор хангахыг хориглоно. (7.3, 7.4, 7.5 дахь заалтууд нь 7.5, 7.6, 7.7 дахь заалт болж дугаарлагдана.)

3. 40 дүгээр зүйл. Хөдөлмөрийн гэрээг ажил олгогчийн санаачлагаар цуцлах
   a. 40.1.8. Ажилтан болон тодорхой эрх мэдэл бүхий албан тушаалтан хувьдаа болон бусдад давуу байдал тогтоох, ашиг хонжоо олох, бэлгийн дур хүслээ хангах болон бусад зорилгоор ажлын байранд удаа дараа бэлгийн дарамтлал явуулсан, бэлгийн дарамтлал явагдах нөхцөл бололцоогоор хангасан.
   b. 40.4. Ажил олгогч буюу эрх бүхий албан тушаалтан, харилцагч байгууллагын ажилтны зүгээс эд материал, шагнал, албан тушаал, өндөр цалин амлах замаар бэлгийн дарамтлалын шинжтэй аливаа өдөөлтийг хүлээн авааагүйн төлөө хариу арга хэмжээ авах зорилгоор ажил олгогчийн санаачлагаар хөдөлмөрийн гэрээг цуцлахыг хориглоно.

4. 94 дүгээр зүйл. Амь бие, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажлаа зогсоох
   a. 94.2. Энэ хуулийн 94.1-т заасан ажлаа зогсоох нөхцөл байдал нь ажил олгогчийн буруутай үйл ажиллагааны улмаас бий болсон бол энэ хуулийн 93.1-т заасан хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан алба, зөвлөлд мэдэгдэх буюу шүүхэд хандах замаар эрхээ хамгаалуулна (94.2 дахь заалт нь 94.3 дахь заалт болж дугаарлагдана).

5. 97 дугаар зүйл. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчин, бэлгийн дарамтлалд өртсөний хохирлыг нөхөн төлөх
   a. 97.2.Ажлын байранд бэлгийн дарамтлалд өртсөний улмаас эрүүл мэнд нь хохирсон хөдөлмөрийн чадвар нь буурсан, хэрэглээ нь нэмэгдсэн бол буруутай этгээдэд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага ногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр ажил олгогч сар бүр мөнгө төлөх замаар хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй (дугаар өөрчлөгдөнө).
   b. 97.3.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчин, бэлгийн дарамтлалын улмаас ажилтанд сэтгэл санааны гэм хор учирсан бол ажилтан Иргэний хуулийн эдийн бус гэм хорын тухай холбогдох заалтийн дагуу хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй (дугаар өөрчлөгдөнө).

6. 128 дугаар зүйл. Шүүхээр хянан шийдвэрлэх маргаан
   a. 128.1.11. Ажлын байранд бэлгийн дарамтлалд өртсөн тухай маргаан.

7. 141 дүгээр зүйл. Хөдөлмөрийн хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага
   a. 141.1.13. Ажил олгогч буюу эрх бүхий албан тушаалтан, харилцагч байгууллагын ажилтны зүгээс эд материал, шагнал, албан тушаал, өндөр цалин амлах замаар бэлгийн дарамтлалын шинжтэй аливаа өдөөлтийг хүлээн авааагүйн төлөө хариу арга хэмжээ авах зорилгоор ажил олгогчийн санаачлагаар хөдөлмөрийн гэрээг цуцалсан бол албан тушаалтныг .... төгрөгөөр шүүгч торгох;
   b. 141.1.19. Ажил олгогч болон тодорхой эрх мэдэл бүхий албан тушаалтан хувьдаа болон бусдад давуу байдал тогтоох, ашиг хонжоо олох, бэлгийн дур хүслээ хангах болон бусад зорилгоор ажлын

байранд бэлгийн дарамтлал явуулах, бэлгийн дарамтлал явагдах нөхцөл бололцоогоор хангасан бол албан тушаалтныг …. төгрөгөөр, аж ахуйн нэгж байгууллагыг … төгрөгөөр шүүгч торгох;

Б. Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хуульд оруулах өөрчлөлт

1. **5 дугаар зүйл. Ажил олгогчийн эрх, үүрэг**
   a. 5.2. Ажил орлогч нь ажилтныг ажлаар, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангах, ***аюулгүй ажиллагааны болон сэтгэл санааны хохирлоос ангид чөлөөтэй ажлын орчинг бүрдүүлэх,*** хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, энэ хууль болон хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журамд заасан үүргээ биелүүлэх үүрэгтэй.

2. 6 дугаар зүйл. Ажилтны эрх, үүрэг
   a. 6.1. Ажилтан нь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, ***бэлгийн дарамтлалаас ангид*** хөдөлмөрийн нөхцлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, ***бие махбодь болон сэтгэл санаанд учирсан гэм хороо арилгахыг шаардах,*** өөрөө болон төлөөллийн байгууллагаараа дамжуулан эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор эвлэлдэн нэгдэх, хууль тогтоомжинд заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж авах, хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээрт заасан бусад эрх, хөнгөлөлт эдлэх эрхтэй.

3. 83 дугаар зүйл.Ажлын байранд тавих ерөнхий шаардлага
   a. Ажлын байрны зохион байгуулалт нь үйлдвэрлэлийн технологийн шаардлагад зохицсон, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, ***бэлгийн дарамтлал, сэтгэл санааны дарамтаас чөлөөтэй байх нөхцлийг бүрдүүлсэн байна.***

4. 94 дүгээр зүйл. Амь бие, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажлаа зогсоох
   a. 94.1. Ажилтан хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны журам зөрчигдсөн, ***ажлын байранд ялгаварлал, хязгаарлал, давуу байдал тогтоогдсон, бэлгийн дарамтлалын аливаа хэлбэрт өртсөн,*** болон амь бие, эрүүл мэндэд нь сөрөг, аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажлаа зогсоож энэ тухай ажил олгогчид нэн даруй мэдэгдэнэ.

5. 97 дугаар зүйл. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний хохирлыг нөхөн төлөх
   a. 97 дугаар зүйл. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчин, ***бэлгийн дарамтлалд өртсөний*** хохирлыг нөхөн төлөх
   b. 97.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, ***бэлгийн дарамтлалд өртсөн,*** мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвчилсөн ажилтан болон эдгээр шалтгаанаар нас барсан ажилтны ар гэрт учирсан хохирлыг нөхөх зорилгоор үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулсан эсэхийг үл харгалзан ажил олгогч нь дор дурдсан хэмжээний нөхөн төлбөр олгоно.
   c. 97.1.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчин, ***бэлгийн дарамтлалын*** улмаас хөдөлмөрийн чадвараа 30 хувь хүртэл алдсан ажилтанд 5 сар, 31-50 хувь алдсан ажилтанд 7 сар, 51-70 хувь хүртэл алдсан ажилтанд 9 сар, 71- хувиас дээш алдсан ажилтанд 18 сарын цалингийн дундажтай тэнцэх хэмжээний нөхөн төлбөрийг нэг ба түүнээс дээш удаа;
   d. 97.1.2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчин, ***бэлгийн дарамтлалын*** улмаас нас барсан ажилтны ар гэрт 36, түүнээс дээш сарын цалинтай тэнцэх нөхөн төлбөрийг нэг ба түүнээс дээш удаа;



Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын зарим конвенцийн хэрэгжилтийн талаар цухас авч үзэх нь



ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний дэд ажилтан С.Ганцэцэг

Аж үйлдвэрийн салбарт ажилд авах насны доод хязгаарын тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 59 дүгээр конвенцийн тухай

Монгол Улс Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүнээр элсэн одоогоор 13 конвенцид нэгдэн ороод байгаа билээ. Тэдгээрийн нэг нь "Аж үйлдвэрийн салбарт ажилд авах насны доод хязгаарын тухай" Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 59 дүгээр конвенц бөгөөд түүнийг 1937 оны 6 дугаар сарын 22-ны өдөр баталж, 1941 оны 2 дугаар сарын 21-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Энэ конвенцид аж үйлдвэрийн салбарт хамаарах үйлдвэрлэлийн салбаруудыг нэрлэн зааж улмаар тэдгээрт ажилд авах насны доод хязгаар нь хэд байх, конвенцийн гишүүн улс үндэсний хууль тогтоомждоо тусгавал зохих зүйлүүд, зарим улсад /Япон, Энэтхэг, Хятад/ хамаарах тусгай заалтуудыг оруулж өгсөн байдаг. Манай улсын хувьд эл конвенцид нэгдэн ороод багагүй хугацаа өнгөрч байгаа хэдий ч анхаарвал зохих зүйлс байсаар байна[1]. Аж үйлдвэрийн салбарт ажилд авах насны доод хязгаарын тал дээр юуны өмнө насанд хүрээгүй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлд дүгнэлт хийх нь зүйтэй болов уу.

Насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг салбараар нь авч үзвэл, оёдол, нэхмэлийн салбарт 32.5 хувь, уул уурхайн салбарт 11.2 хувь, тээврийн салбарт 6.7 хувь, худалдаа үйлчилгээний салбарт 31.5 хувь, хүнс хөдөө аж ахуйн салбарт 9 хувь, барилгын салбарт 2.2 хувьд нь насанд хүрээгүй хүүхдүүд хөдөлмөр эрхэлж байна[2].

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн шалтгааны хувьд ар гэрийн санхүүгийн гачигдал, эцэг эхийн шаардлага зэргээс дийлэнхи хувь нь үүдэлтэй байгаа нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хийгээд зарим байгууллагын хийсэн судалгааны дүнгээс харагдаж байна. Тухайлбал, МҮЭХ-оос явуулсан судалгаанаас харахад насанд хүрээгүй хүүхдийн ажиллаж байгаа хөдөлмөрийн нөхцөлд дүн шинжилгээ хийвэл нийт хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн 15.9 хувь нь хэвийн, 6.6 хувь нь бүгчим, 11.8 хувь нь гадаа, 12.3 хувь хүйтэн, 5.2 хувь нь доргионтой нөхцөлд ажилладаг болох нь харагдаж байна.

Мөн дээрх аж үйлдвэрийн салбарт дээрх конвенцид зааснаас доогуур насны хүүхдүүд ажиллаж байгаа нь судалгаанаас харагдаж байна. Түүнчлэн Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт сэдэвт судалгааны явцад үйлдвэрчний эвлэлийн идэвхтэн сонгуультан нартай уулзаж насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар саналыг авахад тэд хийсэн хөдөлмөртөө тохирсон цалин хөлс авч чаддаггүй гэж 26.1 хувь нь хариулсан байгаа нь насанд хүрээгүй хүүхдүүд хөдөлмөрийн харилцаанд ороход тэдний хөдөлмөрлөх наад захын эрх ашиг зөрчигддөгийг харуулж байна. Энэ нь мөн л Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан "Тэгш шан хөлс олгох тухай" 100 дугаар конвенцийн агуулгатай үл нийцэж байгаа юм.

Насанд хүрээгүй хүн үйлдвэрлэлийн осолд өртсөн 42 тохиолдол гарсан гэдгийг үйлдвэрчний эвлэлийн идэвхтэн сонгуультны өгсөн хариултаас харж болно. Мөн тэд үйлдвэрлэлийн осолд өртсөн насанд хүрээгүй хүний хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх болон Хөдөлмөрийн тухай хуульд заасан нөхөн төлбөрийг ажил олгогчоос нөхөн төлдөггүй гэж 72.7 хувь, бүрэн олгодог гэж 18.2 хувь, олгодоггүй гэж 9.1 хувь нь хариулсан байсан. Цаашид албан хэвшлийн секторт хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээгээр зохицуулах шаардлагатай байгаа нь харагдлаа. Мөн хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдаас насанд хүрээгүй хүүхдийн ажиллаж байгаа албан хэвшлийн салбарыг нэрлэнэ үү гэсэн асуултад худалдаа үйлчилгээ гэж 40.4 хувь, уул уурхай 21.3 хувь, хөдөө аж ахуй 10.7 хувь, барилга 8.5 хувь, тээвэр 6.4 хувь,

Д/д	Нийтлэг зөрчлүүд	Хувь
1.	Амралтын өдөр ажилладаг.	14,8
2.	Эрүүл мэндийн үзлэгт оруулдаггүй.	13,0
3.	Хуульд заасан амралт эдэлдэггүй.	12,2
4.	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангахгүй ажлын байранд ажилладаг.	12,2
5.	Илүү цагаар ажилладаг.	10,4
6.	Хийсэн хөдөлмөртөө тохирсон цалин хөлс авч чаддагүй.	10,4
7.	Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл олгодоггүй.	9,6
8.	Нийгмийн даатгалд хамрагддаггүй.	9,6
9.	Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байранд ажилладаг.	5,2
10.	Шөнийн цагаар ажилладаг.	2,6

[1] Монгол Улс 1969 оны 5 дугаар сарын 10-ны өдөр нэгдэн орсон.
[2] МҮТВ. Цагийн хүрд мэдээллийн хөтөлбөр 2006.03.12.

авто зам 2.1 хувь, геологи хайгуул 2.1 хувь гэж хариулсан байна.

Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдын үзэж байгаагаар насанд хүрээгүй хүний хөдөлмөрийн эрх хэрхэн зөрчигдөж байгааг авч үзвэл:

Насанд хүрээгүй хүний хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах, улмаар хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгахад улсын байцаагчдын тавьж буй саналуудаас тодруулбал:

- Монгол Улсын хууль хяналтын байгууллагын үүрэг, оролцоо, үзлэг шалгалтыг нэмэгдүүлэх, чанарын ахиц гаргах;
- Аж ахуйн нэгж, байгууллагын дэргэдэх үйлдвэрчний эвлэлийн байгууллагын хяналт, гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх;
- Энэ чиглэлээр сургалт, семинар зохион байгуулах, түүнээс дэвшүүлсэн санааг амьдралд хэрэгжүүлэх тал дээр анхаарах.

Хүүхэд аж үйлдвэрийн салбарт ажиллаж байгаагийн бас нэг хөшүүрэг нь энэ салбарын цалин бусад салбарыг бодвол харьцангуй өндөр байдагтай холбоотой болов уу. Тухайлбал, уул уурхайн салбарт нүүрс гаргадаг, тээврийн салбарт автобусны кондуктор хийдэг хүүхдүүд цалин их авдаг, харин оёдлын үйлдвэрт ажилладаг хүүхдүүд сард ойролцоогоор 10,0-30,0 мянган төгрөгийн цалин авдаг статистик мэдээ байна. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 59 дүгээр конвенцийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "15 нас хүрээгүй хүүхдийг ажиллуулж үл болох ажлын байр"-ыг заасан. Энд юуны өмнө ашигт малтмал газраас олборлох уурхай, ил уурхай, бусад үйлдвэр орж байгаа юм. Гэтэл өнөөдөр ил уурхай буюу манайхны хэлж заншсанаар гар аргаар нэг суманд алт олборлож байгаа хүмүүсийн 20.7 хувь нь 15 нас хүрээгүй хүүхдүүд гэр орны байдал, эцэг эхээ даган алт олборлож байгаа[1]. Энэ бүгдээс үүдэн дараахь санааг дэвшүүлж байна.

- Хөдөлмөрийн тухай хуулийн нэр томъёоны тодорхойлолт гэсэн хэсэгт "аж үйлдвэрийн салбар" гэсэн нэр томъёог тусгах буюу аж үйлдвэрийн салбар гэдэгт үйлдвэрлэлийн ямар төрлийг оруулах талаар Улсын дээд шүүхээс тайлбар хийх;
- Ажил олгогчоос 18 насанд хүрээгүй ажилтны төрсөн он, сар, өдрийг тусгасан бүртгэл хөтөлж буй эсэхэд хяналт тавих ажлыг эрчимжүүлэх;
- Бичил уурхайд эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүмүүс ажиллаж байгаа нь дээрх конвенцийг зөрчиж буйг анхаарах;
- Аж үйлдвэрийн салбарт 15 наснаас доош насны хүүхэд авч ажиллуулж байгаа ажил олгогч нарт тооцох хариуцлагын механизмыг Хөдөлмөрийн тухай хуульд тодорхойлон зааж, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
- Насанд хүрээгүй ажилтан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин зэрэгт өртсөн тохиолдолд тэдгээрт нөхөн төлбөрийг нэн даруй олгож байх талаар байгууллага бүр хамтын гэрээ болон хөдөлмөрийн гэрээндээ тусгах, насанд хүрээгүй ажилтны үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг судлан бүртгэх тал дээр тусгайлсан журам гаргах, тэдгээрийг холбогдох байгууллага бүр нь хэрэгжүүлэх, эсрэг тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлох.

Зохион байгуулах, хамтын хэлэлцээ хийх эрхийн тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 98 дугаар конвенцийн тухай

Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын 98 дугаар конвенцийг 1949 оны 7 дугаар сарын 1-ний өдөр баталж, 1951 оны 7 дугаар сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

Конвенцийн гол агуулга нь ажилтан хөдөлмөр эрхлэлттэй холбоотой эвлэлдэн нэгдэхийн эсрэг чиглэсэн алагчлах үйлдлээс хэрхэн хамгаалуулах, энэ эрхийг хэрэгжүүлэхэд ажил олгогчийн зүгээс ямар нөхцлөөр хангах ёстой талаар тусгаж өгсөн.[2]

"Шүүхээс Хөдөлмөрийн тухай хуулийг хэрэглэж байгаа практик" сэдэвт судалгааны явцад үйлдвэрчний эвлэлийн байгууллагын ажилтнуудтай уулзах явцад ажиглагдсан нэг зүйл бол ажил олгогч, холбогдох албан тушаалтны зүгээс ажилтныг үйлдвэрчний эвлэлийн гишүүн гэдгээр нь ялгаварлан гадуурхах тохиолдол цөөнгүй байдаг бөгөөд тухайлбал, эдгээрийн илрэх хэлбэр нь сануулга, сүрдүүлэг, загнах, хэл амаар доромжлох, сахилгын арга хэмжээ авах, далд хэлбэрээр ялгаварлах (мэргэжлийн сургалтанд хамрагдах боломжоос хасах) зэргээр илэрдэг байна.

Үйлдвэрчний эвлэлийн гишүүн гэдгээр нь буюу үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаанд оролцсонтой нь уялдуулан далд хэлбэрээр ялгаварлах явдал одоо байсаар байгаа билээ. Иймд энэ асуудалд анхаарлаа хандуулах хэрэгтэй юм.

Ажилтнууд үйлдвэрчний эвлэл байгуулах, гишүүнээр элсэхийн тулд юу хийх хэрэгтэй талаар үйлдвэрчний эвлэлийн идэвхтэн сонгуультнуудаас асуухад тэдний бараг 92 хувь нь өөрсдөө санаачлах, цөөн хувь буюу 4.2 хувь нь ажил олгогчоос зөвшөөрөл авах гэж хариулсан байна. Энэ байдлаас үзвэл хүмүүс үйлдвэрчний эвлэлийн талаар цэгцтэй ойлголттой болсныг харуулж байгаа юм. Үйлдвэрчний эвлэлийн байгууллага хамтын гэрээ, хэлэлцээр байгуулдаггүй, байгуулсан ч түүний үр дүнг жил бүр дүгнэдэггүй зэрэг зөрчил доголдлын талаар Хөдөлмөрийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь сэдэвт бага хурал дээр ярьж байсан бөгөөд энэ нь үйлдвэр, албан газар, компанийн эдийн засгийн чадавхи муу, ажил олгогч татгалздаг, үйлдвэрчний эвлэлийн санхүүгийн чадавхи муу зэрэгтэй холбоотой гэж үзэж байлаа. Түүнчлэн үйлдвэрчний эвлэлийн байгууллага ажилтнуудын эрх ашгийг хамгаалахын тулд ихэвчлэн яриа хэлэлцээр хийх, хамтын гэрээ байгуулж байгаа нь хамтын гэрээ бол ажилтнуудын хамтын шаардлагыг ажил олгогчоор хүлээн зөвшөөрүүлэхийн тулд үйлдвэрчний эвлэлээс шахалт үзүүлэхэд хэрэглэдэг арга мөн болохыг гэрчилж байгаа юм.

Өнөөдөр манай улсад Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан 87, 97 дугаар конвенцуудын үзэл санаа, гол заалтууд хэрэгжих орчин Монголд нэгэнт бүрэлдэн тогтсон байна.

[1] TV-9 телевиз. "Энэ өдөр мэдээллийн хөтөлбөр" 2006.07.18

[2] Монгол Улс 1969 оны 5 дугаар сарын 10-ны өдөр нэгдэн орсон.

Гэхдээ Монголын хөдөлмөрийн зах зээл дээр ялангуяа хувийн хэвшлийн зарим үйлдвэр, аж ахуйн нэгж, компанид ажилтнууд эвлэлдэн нэгдэж, зохион байгуулагдан үйлдвэрчний эвлэлээ зохион байгуулж чадахгүй байгаа бөгөөд хамтын гэрээ, хэлэлцээрийн үр өгөөж чанаргүй байгаа нь нууц биш билээ.

Үндэсний статистикийн газраас гаргасан 2005 оны хүн амын ажил эрхлэлтийн тайлангаас үзэхэд Монгол Улсад 870 мянга гаруй иргэн хөдөлмөр эрхэлж байгаагийн 53.8 хувь нь хувийн хэвшилд, 17.9 хувь нь компанид, 15.5 хувь нь төсвийн байгууллагад, 6 хувь нь улсын үйлдвэрийн газарт, 5.7 хувь нь нөхөрлөл хоршоонд, 1.2 хувь нь төрийн бус байгууллагад ажиллаж байна.

Хувийн хэвшилд ажиллагсдын дунд үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн эзлэх хувийн жин дөнгөж 0.4 хувь байгаа нь[1] үнэхээр чамлалтай юм. Гэтэл энэ дүн улсын төсвийн байгууллагуудад 62 хувь, компанид 37 хувь, хоршоо, нөхөрлөлд 0.7 хувьтай байна.

Эндээс дүгнэлт хийвэл, хүний үндсэн эрх болох эвлэлдэн нэгдэх эрхээ ямар нэг шалтгаанаар олон хүн эдэлж чадахгүй байна. Иймээс эвлэлдэн нэгдэж, зохион байгуулагдаж чадахгүй байгаа албан бус секторт үйлдвэрчний эвлэлийн үүрэг, нөлөөллийг нэмэгдүүлэх хэрэгтэй.

Гэрээ хэлэлцээ хийх эрхийн хэрэгжилт мөн л хангалтгүй байна. Зарим үйлдвэр, аж ахуйн нэгж, компанид үйлдвэрчний эвлэл ажиллаж байгаа боловч хамтын гэрээгээ байгуулж чадахгүй, хамтын гэрээтэй гэгдэх боловч цалингийн асуудлыг зохицуулж чаддаггүй, эсхүл хамтын гэрээгээр хүлээсэн цалин нэмэх үүргийн биелэлт хангалтгүй байгаа зэрэг дутагдал байна.

Тэгш шан хөлс олгох тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 100 дугаар конвенцийн тухай

Олон улсын Хөдөлмөрийн байгууллагаас гаргасан 100 дугаар конвенцийг 1951 оны 6 дугаар сарын 29-ний өдөр баталж, 1953 оны 5 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон.

Уг конвенцийн агуулгыг харвал шан хөлс, адил хөдөлмөр эрхэлж буй эрэгтэй, эмэгтэй ажилтанд тэгш шан хөлс олгох гэсэн нэр томъёоны тайлбарыг зааж, гишүүн улс бүр шан хөлсийг хэрхэн тогтоох, ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай талаар тусгасан[2].

Манай улсад өнөөдөр адил хөдөлмөр эрхэлж байгаа мөртөө тэнцвэргүй цалин авч байгаа тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал, жендерийн тэгш эрхийн төвөөс гаргасан мэдээнээс үзэхэд төсөвт байгууллагын нийт ажилтны 80 гаруй хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд тэд хийсэн хөдөлмөртөө тохирсон цалин хөлс авч чаддаггүй болох талаар дурджээ.

Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 100 дугаар конвенцид заасны дагуу цалин хөлсний хэмжээг тогтоох аргыг манай улсад хэрэгжүүлэх бүрэн боломжтой юм.

Учир нь, манай улс цалин хөлсний тухай асуудлыг Хөдөлмөрийн тухай хууль, хийгээд бусад холбогдох хуулиар зохицуулдаг тул цалин хөлсийг тогтоох журмын талаар хуульчлан тусгах нь зүйтэй юм.

Мөн байгууллага бүр хамтын гэрээндээ ижил нөхцөлд ижил хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэй хүнд ижил цалин олгох талаар тусгаж байхыг гэрээний гол нөхцөл болгохоор хуульчлах нь зүйтэй. Адил хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэй хүмүүст тэгш шан хөлс олгох тал дээр маргаан гарсан тохиолдол шүүхийн практикийг судлах явцад гараагүй байсан нь сайшаалтай. Гэхдээ энэ нь огт маргаангүй асуудал гэж үзэхэд бас учир дутагдалтай. Тухайлбал, ижил хөдөлмөрт адил цалин хөлс олгох зарчмыг зөрчих нь хөдөлмөр эрхлэлтэд байгаа ялгаварлалын нэг ноцтой илрэл гэж үзэж болно. Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд дээр яг адилхан ажил хийж байгаа монгол ажилтан гадаадын ажилтанд ихээхэн зөрүүтэй хөлс олгож байгаа тухай өргөдөл, гомдол ХЭҮК, МҮЭХ зэрэг байгууллага дээр ирдэг тохиолдол цөөнгүй бий. Уул уурхайн салбар дахь хөдөлмөрийн хүрээн дэх суурь зарчмууд болон Монгол Улсын хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан эрхийн хэрэгжилтийн төлөв байдалд ХЭҮК-оос 2005 онд хийсэн шалгалт судалгааны тайланг үзэхэд ОХУ-ын хөрөнгө оруулалттай алт олборлодог нэгэн компанийн монгол болон орос гагнуурчны цалингийн зөрүү 145 ам доллар, машины жолоочийн цалингийн зөрүү 155 ам доллар байсан байна.

Өөрөөр хэлбэл, энэ нь уг асуудал манай улсад бүрэн шийдэгдсэн асуудал гэж үзэх нөхцөл хараахан биш бөгөөд иргэд хуулиа мэддэггүй, улмаар олон улсын гэрээ конвенцид нэгдэн орсон талаар иргэд бүү хэл холбогдох зарим албан тушаалтан нь тэр бүр мэдэхгүй байгаатай холбоотой болов уу.

Конвенцид зааснаар шан хөлс гэдэгт зөвхөн цалин төдийгүй бусад нэмэлт шанг оруулдаг. Хөдөлмөрийн тухай хуулийн энэ талаархи зохицуулалт конвенцийн заалттай зохицуулалтын хувьд нийцэж байгаа ч түүний хэрэгжилт мөн л хангалтгүй байна.

Өөрөөр хэлбэл, манай улсад хөдөлмөрийн хөлсний нэмэгдлийн талаар хангалттай зохицуулалт байгаа хэдий ч түүнийг хуульд зааснаар олгодог, цаашлаад нэмэгдэл хөлс авах ёстой гэдгээ мэддэг ажилтнууд ч бага байдаггүй холбоотой.

Эцэст нь, Монгол Улс өнөөдрийн байдлаар Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан 13 конвенцид нэгдэн орж, тэдгээрийн агуулга нь Хөдөлмөрийн тухай хууль, бусад хуульчилсан актад илрэлээ олсон хэдий ч эдгээр конвенцийн заалтыг хэрэгжүүлэх механизм бүрэн бүрдээгүй, хууль хэрэглэгчид конвенцийн заалтыг мэддэггүй зэргээс болж хөдөлмөрийн харилцаатай холбоотой маргаан зөрчил цөөнгүй гардаг нь харагдаж байна.

[1] Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны 2005 оны жилийн эцсийн статистик мэдээнээс

[2] Монгол Улс 1969 оны 5 дугаар сарын 10-ны өдөр нэгдэн орсон.

Аккредитивийн төлбөр тооцоо, түүнийг хэрэгжүүлэх журам

2002 онд Иргэний хуулийг шинээр батлагдахад баримталж байсан үзэл баримтлалд "дэлхий нийтийн эдийн засаг, эрх зүйн харилцааны хөгжлийн түгээмэл зүй тогтлыг өөрийн орны хөгжлийн чиг хандлагатай оновчтой нийцүүлж загварчлан хуульчлах..."[1] гэж удирдлага болгосон бөгөөд үүнтэй холбоотойгоор хэд хэдэн гадаад нэр томъёо, ойлголт шинээр гарч ирсний нэг нь аккредитив юм.

Аккредитивийн талаархи ойлголт

Бэлэн бус төлбөр тооцооны нэг хэлбэр болох аккредитив нь олон улс орны төлбөр тооцоонд маш их дэлгэрсэн байдаг.

Утгын талаас нь тайлбарлавал: Аккредитив нь латины **accreditivus** буюу **итгэмжлэгдсэн** гэсэн гаралтай үг юм[2].

Аккредитивийн төлбөр тооцоо хийх гол утга нь худалдагч төлбөрийн баталгаа авах, худалдан авагч нь тэзвэрлэсэн болон ачсан барааны бүрэн эрхийг авахад оршдог. Өөрөөр хэлбэл, худалдагч нь бараг ачсан гэдгийг нотлож /гэрчилж байгаа/ байгаа баримтыг банкинд өгөх үед аккредитиваас мөнгөө авах боломжтой байдаг, харин худалдан авагч нь баримтыг хүлээж авмагц барааны өмчлөгч болох эрхтэй болчихдог. Ийм учраас үүнийг баримтын аккредитив гэж нэрлэдэг[3]. Гэхдээ баримтын аккредитивийг товчилсон байдлаар аккредитив гэж нэрлэх явдал нийтлэг бөгөөд агуулгын болон ойлголтын зөрөө гарахгүй юм.

Аккредитив нь Олон улсын төлбөр тооцооны хэлбэр тул түүнийг хэрэглэхдээ улс орнууд Олон



Хуульч Г.Батчимэг

Улсын Худалдааны Танхимаас батлан гаргасан "UCP500" буюу "Аккредитивийн нэгдсэн журам №500"-ыг хэрэглэх зайлшгүй шаардлагатай байдаг. "UCP500" буюу "Аккредитивийн нэгдсэн журам №500" гэдэг нь аккредитиваар төлбөр гүйцэтгэхэд мөрдөх Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолт, зааврын багц цуглуулга юм[4].

Анх Олон Улсын Худалдааны Танхимаас 1933 онд Аккредитивийн (UCP-н) талаарх журмыг батлан гаргасан. Түүнээс хойш ойролцоогоор арван жил тутамд шинэчлэн найруулж байсан юм. Өөрөөр хэлбэл, анх 1933 онд батлагдсан. Түүнээс хойш 1951, 1962, 1974, 1983, 1993 онуудад шинэчлэгдэж байсан байна[5].

Аккредитивийг хэрэглэх шаардлага

Өмнө нь аккредитивийг хэрэглэж байсан эрх зүйн зохицуулалтын хүрээг зөвхөн олон улсын хувийн эрх зүйн хүрээнд авч үздэг байсан бол Монгол Улсын Иргэний хуулиар /Иргэний хуулийн 449 дүгээр зүйл/ зохицуулах болсноор дотоодын гэрээний харилцаанд хэрэглэх боломжтой боллоо.

Аккредитивийг дараахь тохиолдлуудад илүү хэрэглэдэг[6]:

- Бизнесийн үйл ажиллагааг шинээр эхэлж буй буюу худалдагч, худалдан авагч талууд сайн түншүүд биш байх үед;
- Экспортлох гэж буй орны нийгэм, эдийн засгийн байдал тогтворгүй тохиолдолд;
- Худалдан авагчийн төлбөрийн чадвар эргэлзээтэй бол;
- Худалдан авагч авсан бараа бүтээгдэхүүнээ цагт нь хүлээн авахыг хүссэн тохиолдолд;
- Нийлүүлэх бараа бүтээгдэхүүний үнийн дүн их байх нөхцөлд;
- Тодорхой зориулалттай тоног төхөөрөмж худалдах, худалдан авах зэрэгт аккредитив илүү үр дүнд хүргэдэг байна.

Аливаа худалдааны харилцаанд худалдагч болон худалдан авагч талуудын санааг зовоосон нэг асуудал бол тэдгээрийн хүсэл сонирхлын зөрчил юм. Өөрөөр хэлбэл, худалдагч талын хувьд барааг ачуулсны дараа худалдан авагч төлбөрөө найдвартай төлөх болов уу, төлөхгүй байх эрсдлийг хэрхэн багасгах вэ гэдгийг мэдэх шаардлагатай байдаг ба төлбөр

[1] Иргэний хууль "Шинэлэг зохицуулалт" УБ., 2003 он

[2] А.Н.Азрилян "Юридический словарь" Мк., 2004, с.24

[3] А.П.Сергеев, Ю.К.Толстой "Гражданское право" II-Обязательственное право М 2004, с.539-540. Аккредитив нь нэг талаас төлбөр тооцоог гүйцэтгэх хэрэгсэл нөгөө талаас баримт байдаг. - Документарный аккредитив/Кредитное письмо; - Documentary credit/Letter of credit

[4] Кредит Суисс "Гадаад худалдаа найдвартай хийх тухай гарын авлага" УБ., 2000 он, 22 дахь тал.

[5] Website: www.iccthailand.or.th ICC Thailand, International Chamber of Commerce, The World Busniness Organization. Trasitioning towards UCP600 Seminar. 10 November 2005. 2007 оноос эхлэн аккредитивийг шинэчилэн найруулан "Аккредитивийн нэгдсэн журам-№600" буюу UCP600-г хэрэглэж эхлэх гэж байна. Энэхүү журам нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй журмын зарим зүйл, заалтыг илүү тодорхой байдлаар шинэчилэн найруулсан байх юм байна.

[6] Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим "Гадаад худалдааны иж бүрэн гарын авлага" УБ., 2005 он, 56-57 дахь тал

хийгдсэний дараа бараагаа ачуулахыг эрмэлздэг бол худалдан авагч нь худалдагчийн талаар сайн мэдэхгүй, тиймээс тэр бараагаа цагт нь авчирах болов уу, төлбөрөө төлөхийн өмнө тэдгээр бараа нь миний захиалсан бараа яг мөн эсэхийг хэрхэн мэдэх вэ гэсэн асуудлуудтай тулгардаг бөгөөд барааг гар дээрээ хүлээн авах хүртэл төлбөр төлөхгүй байх сонирхолтой байдаг явдал юм.



Аккредитивийг хэрэглэснээр дээр дурдсан ашиг сонирхлын зөрчлүүд харьцангуй багасах төдийгүй худалдагч нь худалдан авагчийн төлбөрийн чадваргүй болох, төлбөр хийхээс татгалзах эсэхээс хамаарахаа болино.

Аккредитив нь өнөөг хүртэл Олон улсын худалдаанд төлбөрийн найдвартай байдлыг хангадаг хамгийн үр ашигтай хэрэгсэл болсоор байна[1].

Монгол Улсын Иргэний хуулийн 449 дүгээр зүйлийн 449.3-т "Аккредитивийн төлбөр тооцоог гүйцэтгэхэд олон улсад хэрэглэгддэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлыг баримтална" хэмээн заажээ. Тиймээс ч Парис дахь Олон Улсын Худалдааны Танхимаас боловсруулан гаргасан "UCP500" буюу "Аккредитивийн нэгдсэн журам №500"-ыг удирдлага болгон аккредитивийн төлбөр тооцоог хийх ёстой юм.

Энэхүү журмаар зохицуулагдаж буй аккредитивийн талаар авч үзье.

Аккредитивийн төлбөр тооцоонд оролцогч талууд[2]

Үндсэн оролцогчид:

- Аккредитив нээхийг хүсэгч /өргөдөл гаргагч/ буюу худалдан авагч (applicant/ buyer/importer);
- Аккредитив нээгдсэн банк буюу худалдан авагчийн банк (Issuing/opening bank);
- Худалдагчийн банк /Энэ нь аккредитив нээгдсэн тухай экспортлогчид мэдэгддэг аккредитив нээсэн харилцагч банк юм. Гэхдээ зарим үед аккредитивийн баталгаа гаргаснаараа тухайн банк баталгаа гаргагч болж хувирна/; (advising /confirming bank)
- Худалдагч (beneficiary/seller/ exporter).

Туслах оролцогчид:

- Тодорхой тохиолдолд, нээгч банк ба мэдээлэгч банкууд нь харилцан корреспондент данс байхгүй тохиолдолд оролцох гуравдагч банк болох рембурсны банк / reimburse bank/;
- Худалдагч нь үндсэн бараа нийлүүлэгч биш үед оролцох үндсэн бараа нийлүүлэгч;
- Ачаа тээврийн болон хадгалалтын байгууллагууд.

Уг аккредитивийн төлбөр тооцооны харилцаанд банк үндсэн оролцогчдын нэг төдийгүй худалдан авагч, худалдагчийн гол харилцагч нь байдаг.

Аккредитивийн үйлчилгээг үзүүлж буй банкны оролцоог дараахь байдлаар ангилах боломжтой. Үүнд:

1. Нэг банк оролцох (худалдан авагч, худалдагчийн данс нэг банкинд байгаа бол);
2. Хоёр банк оролцох (худалдан авагчийн болон худалдагчийн банк);
3. Гурав ба түүнээс дээш тооны банк оролцох (худалдан авагчийн, худалдагчийн мөн өөр нэг банк буюу баталгаа (мэдээлэгч) гаргагч банк[3]).

Аккредитивийн үе шат

Аккредитив дараахь схемийн дагуу явагдана[4]:



1. Худалдагч, худалдан авагч хоёр худалдааны гэрээ байгуулж төлбөрийг аккредитиваар хийхээр тохиролцдог энэ үе шат нь гэрээний талуудын хувьд хамгийн чухал. Учир нь талууд төлбөр тооцоогоо аккредитиваар гүйцэтгэх тухай болон түүний ямар төрлийг хэрэглэх, талууд ямар банкаар харилцах, үндсэн гэрээний болон аккредитивийн хугацаа хэдийд дуусгавар болох, ачилт болон хадгалалт хийх газар, үүнтэй холбоотой шаардлага хангах баримт бичгүүдийн жагсаалт зэрэг талуудын анхаарвал зохих асуудлуудыг тохиролцох ажиллагаа байдаг. Энэхүү үе шатыг талууд үр дүнтэй сайн тохиролцож чадвал дараагийн үе шатууд хурдан шуурхай, асуудал багатай явагдах юм.

[1] Кредит Суисс "Гадаад худалдаа найдвартай хийх тухай гарын авлага" УБ., 2000 он, 22 дахь тал

[2] ICC Uniform Customs and Practice for Documentary Credit. 1993 revision in force as from 1 January 1994.

[3] Баталгаа гаргагч банк- Confirming bank/Guarantor bank; Мэдээлэгч банк- Advising Bank

[4] ICC Uniform Customs and Practice for Documentary Credit. 1993 revision in force as from 1 January 1994. B-D

2. Худалдан авагч өөрийн үйлчлэгч банкинд хандаж, худалдагчид зориулан, түүний нэр дээр үндсэн гэрээндээ тохирсны дагуу аккредитив нээлгэх хүсэлт[1] гаргана. Ийнхүү хүсэлт гаргахдаа аккредитивийг хэрэглэхэд зайлшгүй шаардагдах мэдээллийг банкинд өгөх хэрэгтэй бөгөөд баримт бичгийг бүрдүүлж өгснөөр банкнаас өгөх аккредитив нээлгэх хүсэнгтийг бөглөх боломжтой юм. Аккредитив нээлгэх хүсэлт гарган, банк түүнийг нь хүлээн авна гэдэг нь "худалдагчийн зүгээс ирэх шаардлага хангасан баримтууд ирвэл одоо байршуулсан мөнгийг өгч болно" гэсэн утгыг илэрхийлнэ.

Банкинд байршуулах мөнгийг худалдан авагчийн данснаас тусгаарлах, бэлэн мөнгө байршуулах, эсвэл эх үүсвэргүй аккредитив нээлгэх замаар тухайн мөнгийг төвлөрүүлж болно. Өөрөөр хэлбэл, шаардлага хангах бараг болон түүнийг гэрчлэх баримтуудыг илгээсэн тохиолдолд гэрээ ёсоор тохиролцсон мөнгө бэлэн, хөдөлгөөнгүй гэсэн утгатай. Энэ үйл ажиллагаа нь худалдагч бараа ачуулахад бэлэн болсноо мэдэгдсэнээр эсхүл талууд үндсэн гэрээнд заасан хугацааны дагуу эхэлж болно.

3. Тэгээд худалдан авагч нь өөрийн үйлчлэгч банкаараа дамжуулан талуудын тохиролцсон нөхцөлтэй аккредитивийг худалдагчийн банк руу болон өөр нэг банк буюу мэдээлэгч банкаар дамжуулан худалдагчид аккредитив нээгдсэн тухайгаа мэдэгдэнэ. Хэрэв талууд гэрээндээ харилцах банкныхаа талаар тохиролцоогүй тохиолдолд худалдан авагчийн банк өөрийн үйлчлүүлэгчийн зааврын дагуу өөр нэг банкыг туслах байдлаар оролцуулна. Ийнхүү туслах байдлаар оролцож байгаа банкны эрх үүргийг "Аккредитивийн



нэгдсэн журам №500"-д тодорхой зааж өгсөн байдаг. Харин худалдагч тал уг мэдээлэгч банкыг өөрийн үйлчлүүлэгч банкаар сонгон авч болно, эсвэл өөрийн дансны дугаар байгаа банк хэрэв байхгүй бол өөр банк сонгох эрхтэй бөгөөд ингэсэн тохиолдолд мэдээлэгч банк өөрт ирсэн тухайн нээгдсэн аккредитивийг уг сонгогдсон банкинд анх харилцсан банкны зааврааар шилжүүлнэ. Харин уг ажиллагаа явуулсан зардлыг хэн хариуцахыг дээрх журмаар мөн зохицуулсан.

4. Худалдагчийн банк өөрийн үйлчлүүлэгчид тухайн нээгдсэн аккредитивийг илгээнэ.

5. Худалдагч бараг худалдан авагч руу гэрээнд заасны дагуу ачуулах болон хадгалуулах үйл ажиллагаа хийнэ[2].

6. a,b (a) Худалдагч нь ийнхүү ачуулсан болон хадгалуулсан бол үүнийгээ гэрчилсэн баримтуудыг бүрдүүлж өөрийн банкиндаа хүлээлгэн өгнө. (b) Худалдагчийн банк баримтыг шалгаад худалдан авагчийн банкинд шилжүүлнэ. Шалгаад гэдгийн учир нь худалдан авагчийн банкнаас ирсэн аккредитивийн хүсэлтэд шаардлага хангах баримтуудыг дурдаж өгсөн байдаг. Тэдгээр шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг зөвхөн



баримтын хүрээнд шалгах явдал юм. Худалдан авагчийн банк баримтуудыг зохих ёсоор шалгаад уг баримтыг худалдан авагчид илгээнэ.

7. a, b, c (a) Худалдан авагчийн банк баримтыг үйлчлүүлэгчдээ шилжүүлсний дараа худалдан авагч тухайн баримтууд нь аккредитивд заасан баримтуудыг бүрдүүлсэн эсэхийг шалгаад зохих журмын дагуу байна гэж үзвэл (b) өөрийн үйлчлүүлэгч банкиндаа төлбөр хийх зааврыг өгнө. (c) Банк зааврын дагуу байршуулсан мөнгийг худалдагчийн банк руу шилжүүлнэ.

8. Худалдагчийн банк тухайн мөнгийг худалдагчид шилжүүлнэ. Аккредитив нь ерөнхийдөө эдгээр дарааллын дагуу явагддаг ба Монгол Улсын Иргэний хуулийн 449 дүгээр зүйлийн 449.1-д заасан аккредитивийг мөн дээрх утгаар ойлгож болно.



Аккредитив нь хэд хэдэн үндсэн хэлбэртэй бөгөөд найдвартай байдлын түвшин, банк хэр зэрэг хугацаанд эрсдэл дааж байгаагаас хамааран өөр хоорондоо ялгаатай[3]. Аккредитивийн эдгээр хэлбэрийн талаар Доктор, дэд профессор Т.Мэндсайхан "Төлбөр

[1] Аккредитив нээлгэх хүсэлтэд дараахь зүйлүүдийг тусгасан байдаг. Үүнд: 1.Шаардагдах баримтууд; 2.Төлбөрийн дүн ба төлбөр хийх арга; 3.Худалдагчийн нэр, хаяг; 4.Аккредитивийн хүчинтэй байх хугацаа; 5.Барааны нэр төрөл, тоо хэмжээ; 6.Бараа ачуулах хугацаа болон бусад холбогдох баримтууд.

[2] Улс дамжин хийгдэж байгаа худалдаанд ихэвчлэн Олон улсын худалдааны танхимаас батлан гаргасан "Инкотермс 2000" хэрэглэдэг. Энэ нь худалдагч, худалдан авагчийн барааны гэмтэл, гэнэтийн сүйрлийн хариуцлага, эрсдэл, худалдагчаас худалдан авагчид шилжих хугацааг тогтоох зэрэг ач холбогдолтой байдаг. /ICC publication №620, ICC Guide to Incoterms 2000/

[3] Доорхи аккредитивийн хэлбэрүүдийг мэдсэнээр гэрээний талууд үндсэн болон аккредитивийн гэрээнд мөн аккредитив нээлгэх хүсэлтийг өөрийн ашиг сонирхолд хохиролгүйгээр бөглөхөд ач холбогдолтой. /Кредит Суисс "Гадаад худалдаа найдвартай хийх тухай гарын авлага" УБ., 2000 он, 22 дахь тал/; - Export and import- Экспортын ба импортын; - Revocable or Irrevocable- Буцаан дуудагдах ба буцаан үл дуудагдах; - Confirmed or unconfirmed credit- Баталгаатай ба баталгаагүй буцаан үл дуудагдах аккредитив /Аккредитивийн төрөл, хэлбэрийн талаар сэтгүүлийн дараагийн дугаарт илүү тодорхой гаргах болно/

тооцооны харилцаа, түүний эрх зүйн зохицуулалт"[1] сэдэвт нийтлэлдээ тодорхой бичсэн байдаг.

Олон улсын банкны практикт янз бүрийн аккредитивийг бий болгож түүнийгээ тодорхой төрлүүдэд ангилсан байдаг. Эдгээр төрлүүд нь санхүүжүүлэх эх сурвалжаараа мөн тухайн үүргийг гүйцэтгэх оролцогчдын эрхээр ялгардаг байна.

Аккредитивийг төлбөр гүйцэтгэхэд хэрэглэгдэж буй аргынх нь байдлаар мөн ангилж болдог. Мөн түүнчлэн аккредитивүүдийн хослол болон аккредитивийн төлбөрийг хэрхэн хийх талаар тусгай тохиролцоо хийж болно[2].

"Аккредитивийн нэгдсэн журам №500"-д заасны дагуу аккредитив нөхцөл нь худалдах, худалдан авах гэрээ, ажил гүйцэтгэхтэй холбоотой гэрээнүүдэд илүү тохиромжтой. Эдгээр гэрээнүүдийн үе шат, онцлог байдалтай аккредитив нь бүрэн тохирч, талуудын ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн байдаг.

Аккредитивийн өөрийн зохицуулалтын онцлогоос хамаараад дурын гэрээнд хэрэглэх боломж ховор юм. Гэхдээ талууд хүлээн зөвшөөрвөл гэрээндээ тусгах боломжтой ба ийнхүү тусгахдаа гэрээний ерөнхий бүтцийн дагуу "тооцооны журам"-д багтаан зохицуулалт хийж болно.

Мөн аккредитив нь ижил түвшний эдийн засгийн боломж нөхцөлтэй этгээдүүдийн хооронд хийгдэх нь элбэг ба нэг тал нь монополь байх тохиолдолд тэр бүр сонгож хэрэглэдэггүй байна. Аккредитивийг талууд хүлээн зөвшөөрч хэрэглэхдээ үндсэн гэрээнээс гадна тусдаа гэрээг байгуулдаг хэдий ч үндсэн гэрээндээ аккредитивийн ямар хэлбэр болон төрлийг хэрэглэх, хугацаа, шаардлагатай баримтуудыг хэрхэн яаж бүрдүүлэх зэргийг тусгаж өгөх нь маргаан гарсан тохиолдолд асуудлыг шийдвэрлэхэд дөхөмтэй юм.

Олон улсын хэмжээнд хэрэглэж буй энэхүү төлбөр тооцоо хийх хэлбэр нь Олон улсын гэрээ, Олон Улсын Худалдааны Танхимаас гаргасан дүрэм, журмаар зохицуулагдах "корреспондент харилцаа"[3] бүхий банкуудаар дамжин хэрэгжих валютын ажиллагаа юм.

Өнөөдөр олон улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг банкуудаас үйлдэж буй аккредитивтай холбоотой бүх баримт "UCP-аар зохицуулагдана" гэсэн тэмдэглэгээтэй байна[4].

Иймээс UCP500 нь аккредитивийн талуудын хоорондох гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байдаг.

Монгол Улс дахь аккредитивийн хэрэглээ

Өнөөдөр үйл ажиллагаагаа явуулж буй томоохон банкуудын (Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, ХАС банк, Зоос банк) аккредитив журамтай танилцахад дараахь байдал ажиглагдлаа.

"Голомт" банк аккредитивтай холбоотой харилцааг "Голомт банкны аккредитивийн журам"[5]-аараа зохицуулдаг байна. Тэд энэхүү журамдаа аккредитивийн бүцаан үл даудагдах, бүцаан даудагдах гэсэн үндсэн хоёр хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд энэхүү аккредитивтай холбоотой харилцаанд аккредитив нээгч банк буюу худалдан авагчийн банк, болон худалдагчийн банк, харилцагч (бас өөрөөр дамжуулагч банк) зарим тохиолдолд (үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу) баталгаа гаргагч банкны үүргийг гүйцэтгэх боломжтойгоор зохицуулагдсан байна.

"Аккредитив нээлгэгч нь банкны харилцагч эсвэл тус банкны харилцагч биш аж ахуйн нэгж, хувь хүн байж болно"[6] гэсэн журмын заалтаас харахад аккредитив журмыг зөвхөн гадаад худалдаанд хэрэглэдэг гэсэн нийтлэг ойлголтыг үгүйсгэж, дотооддоо хэрэгжих нөхцлийг бүрдүүлсэн нь ач холбогдолтой юм.

"Аккредитивийн нэгдсэн журам №500"-д аккредитив нээлгэгч нь тухайн банкинд тусгаарлах хөрөнгөгүй тохиолдолд банк болон аккредитив нээлгэхийг хүссэн этгээдүүд зохих шаардлагыг тохирсны дагуу "эх үүсвэргүй аккредитив" нээх боломжийг олгосон байдаг бол Голомт банкны аккредитив журмын 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгээс[7] харахад дээрх боломжийг тусгаж өгөөгүй байгаа нь гадаад худалдаа хөгжиж буй манай улсын бизнес эрхлэгчдэд тийм ч тааламжтай заалт биш юм.

Худалдаа Хөгжлийн Банкны хувьд аккредитивтай холбоотой үйл ажиллагааг өөрсдийн боловсруулан баталсан "Гадаад худалдааны аккредитивийн заавар"[8]-ын дагуу явуулдаг байна. Тухайн банк

---

[1] "Бизнесийн эрх зүй" Хуульчдад зориулсан гарын авлага, ХЗҮТ. УБ., 2003 он, 134 дэх тал

[2] Тухайлбал, - Sight credit- Баримтаар шууд төлбөр хийх аккредитив; - Deferred payment credit- Хугацаанд нь төлбөр хийх аккредитив; - Acceptance credit- Акцептаар төлбөр хийх аккредитив; - Red and green clause credit- Урьдчилгаа зээл бүхий аккредитив; - Negotiation credit- Негоциацийн аккредитив; - Revolving credit- Сэргээгдэх аккредитив; - Transferable credit- Шилжих аккредитив.

[3] Энэ нь банкны байгууллага нь Олон улсын төлбөр тооцоог өөрийн гадаад улс дахь салбар буюу гадаад улсын банкаар дамжин гүйцэтгэх ажиллагаа юм.

[4] Website: www.iccwbo.org, Монгол Улсын хувьд мөн UCP500-аар зохицуулагдахаар заасан байдаг. Тухайлбал, Голомт банкны аккредитив холбоотой бүх үйлчилгээ, үйл ажиллагаа нь UCP500-г мөрдөнө хэмээн заасан байна. /Голомт банкны аккредитив журмын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг/; Худалдаа хөгжлийн банк "аккредитивтэй холбогдох бүхий л үйл ажиллагааг явуулахдаа UCP500-г удирдамж болгоно" хэмээн заажээ. /Гадаад худалдааны аккредитивын зааврын 1.2 дахь хэсэг/; Зоос банк аккредитив журмынхаа 1 дүгээр зүйлийн 1.2-т: "Аккредитивийн үйлчилгээ, түүнтэй уялдан гарах ажлуудыг гүйцэтгэхдээ...UCP500-ийг мөрдлөг болгоно".

[5] Голомт банкны холбогдох ажилтнаас "Голомт банкны аккредитивийн журам"-ыг авсан болно.

[6] "Голомт банкны аккредитивын журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг

[7] "Голомт банкны аккредитиын журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4-т "Банк нь аккредитив нээлгэгч төлбөр хийх хөрөнгийн эх үүсвэрийг өөрийнхөө нэр дээр аккредитивийн хөрөнгө тусгаарлах, дансанд бүрэн төвлөрүүлсэн, нээлгэгч холбогдох хүү шимтгэлийг урьдчилан төлсөн аккредитивийг нээнэ"

[8] Худалдаа хөгжлийн банкны холбогдох ажилтнаас тухайн банкны "Гадаад худалдааны аккредитивийн заавар" болон "Эх үүсвэргүй аккредитивийн журам"-ыг авсан.

аккредитивтай холбоотойгоор бий болсон харилцаанд оролцогч нь тухайн үед дансандаа мөнгөгүй боловч банкаар дамжин нээсэн тухайн экспортын аккредитивээр мөнгө орох нь баталгаатай болон бусад баталгаат төлбөрийн байдлыг харгалзан банкнаас зээл олгож хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох замаар аккредитив нээх боломжийг олгосон нь дээр дурдсан Голомт банкны харилцагч нартаа олгож чадаагүй тэрхүү боломжийг бүрдүүлснээрээ онцлогтой байлаа. Тэд дээрх зааврааc гадна "Эх үүсвэргүй аккредитивийн журам"-ыг батлан гаргасан нь "Аккредитивийн нэгдсэн журам №500"-д дурдсан байдаг төлбөр тооцоог гүйцэтгэхэд хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох боломжит нөхцөлүүдийг энэхүү журамдаа тусгаж өгсөн нь өөрийн орны төдийгүй гадаад орны бизнес эрхлэгчдэд ач холбогдолтой гэж үзэж байна.

Арилжааны банкууд "Аккредитивийн нэгдсэн журам №500"-ын дагуу өөрсдийн журмаа боловсруулан баталсан байдаг хэдий ч тэдгээр журмын заалтууд нь өөр хоорондоо уялдаа холбооны хувьд бага зэрэг, зарим нэг дутагдалтай талууд байсан нь нэг талаас гэвэл, дээр байх олон улсын банк санхүүгийн харилцаанд тавигддаг стандартад хүрэх гэсэн оролдлого, нөгөө талаас эдгээр банкуудын журам нь анх батлагдсан цагаасаа шинэчлэн найруулсан зүйл заалтүүй байгаатай холбоотой болов уу. Банкуудын аккредитив журам хэзээ анх батлагдсаныг олж мэдэхэд бэрх. Уг асуудлыг хариуцдаг мэргэжилтнүүдийн хэлснээр байгуулагдсан цагаасаа буюу ойролцоогоор 1990 оноос хойш гэх мэтээр хэдийд батлагдан гарч ямар ямар өөрчлөлт орсон, удирдлага болгож байдаг олон улсын журмынхаа өөрчлөлтийг хэрхэн тусгаж, боловсронгуй болгож байдаг нь аль ч банкны хувьд дутагдалтай байгааг судалгаа хийх явцад анзаарагдсан юм.

Манай улсын хувьд аккредитиваар төлбөр тооцоо гүйцэтгэсэнтэй холбоотойгоор 1998 онд анхны маргаан үүссэн гэж үздэг[1].

Тэгвэл хоёр дахь тохиолдол 2005 оны 11 дүгээр сард гарчээ[2]. Тухайн хэргийн оролцогчид нь Монгол Улсын талаас Голомт банк, "Мах импекс" ХК, Солонгос улсын талаас Korea Exchange банк, Export-Import bank of Korea банк, "Номаранг" корпораци, "LG international" компани байсан.

Анх Солонгос улсын "Номаранг" корпораци Монгол Улсын "Мах импекс" ХК-ын хооронд "Бараа худалдах, худалдан авах" гэрээ байгуулсан. Гэрээний төлбөр тооцоог аккредитиваар хийхээр талууд тохиролцсон бөгөөд тухайн аккредитивийн хэлбэр нь буцаан үл даудагдах, шилжих аккредитив байлаа. Төлбөрийг бараа хүлээн авснаас хойш 360 хоногийн дотор төлөгдөх нөхцөлтэйгээр хийжээ.

Аккредитивийн дагуу "Мах импекс" ХК аккредитив нээх хүсэлтийг Голомт банкинд гаргаж 2001 оны 8 дугаар сарын 17-нд нээсэн бөгөөд хүлээн авагч банк нь Солонгос улсын талаас Korea Exchange банк, Export-Import bank of Korea банк байсан байна.

Тухайн аккредитивийг үндэслэн Солонгосын "LG international" компани нь "Мах импекс" ХК-д 10 удаагийн ачилтаар 9.8 сая ам.долларын бараа ачуулсан. Голомт банк нь аккредитивийн дагуу дээрх ачигдсан барааны 4 удаагийн ачилтын төлбөрийг төлсөн бөгөөд үлдсэн төлбөрийг төлөөгүйн улмаас Солонгос улсын Korea Exchange банк, Export-Import bank of Korea банкуудын эрх ашгийг хохироосон тул тэд Голомт банкнаас аккредитивийн үндсэн төлбөр 6401751.86 ам.долларыг, хохирол буюу олох ёстой байсан орлого гэж 2262723.55 ам.долларыг Korea Exchange банкинд, аккредитивийн үндсэн төлбөр 1015182.20 ам.доллар, хохирол буюу олох ёстой байсан орлого гэж 374466.87 ам.долларыг Export-Import bank of Korea банкинд олгохыг хүссэн нэхэмжлэлийг Монгол Улсын Чингэлтэй дүүргийн шүүхэд гаргасан.

Шүүх хуралдаан 2005 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр болжээ. Шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.2.2, 116, 118, 120-д заасныг удирдлага болгож, Иргэний хуулийн /1994 он/ 424, 423 дугаар зүйлийн 2, 10, 184 дүгээр зүйлийн 184.1, Иргэний хуулийн /2002 он/ 449 дүгээр зүйлийн 449.1, 449.3 Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д заасныг баримтлан Голомт банкнаас 6401751.86 ам.доллар буюу 7778128510 төгрөгийг гаргуулж Korea Exchange банк банкинд, 1015182.20 ам.доллар буюу 1233446373 төгрөгийг гаргуулан Export-Import bank of Korea банкуудад төлөөгүй үлдсэн мөнгийг гүйцээн төлүүлэх шийдвэр гаргасан байна.

Дүгнэлт

Хэдийгээр аккредитивийг шинэ нөхцөлд, шинэ аргаар хэрэглэх боломж нь бүрдсэн боловч манай улсын бизнес эрхлэгчид аккредитивийн талаарх ерөнхий ойлголттой болохоор тухайн төлбөр тооцооны ач холбогдлыг мэдэрч чадахгүй байна. Энэ нь аккредитивийн талаарх мэдээлэл бага байгаа учраас түүнийг өөрсдийн бизнесийн үйл ажиллагаандаа бүрэн дүүрэн ашиглаж, үр ашгийг нь хүртэж чадахгүй байгаатай холбоотой болов уу.

Манай улсын арилжааны банкууд өөрсдийн үйл ажиллагаандаа аккредитивийг нэвтрүүлж үйлчилгээнийхээ хүрээг өргөсгөснөөр хэрэглэгчдийнхээ тоог тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж байна. Гэхдээ аккредитивтай холбоотой маргаантай асуудлууд ч гарч эхлээд байна. Энэ нь дотооддоо үйлдэж буй эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох, олон улсын худалдаанд өргөн хэрэглэгддэг энэхүү нөхцлийг цаашид түлхүү судлах шаардлагатайг харуулж байна.

Сэтгүүлийн дараагийн дугаарт аккредитивийн төрөл, хэлбэрийн талаар илүү тодорхой нийтлэх болно.

[1] *Д.Амарбаясгалан "Олон Улсын төлбөр тооцоонд аккредитив хэлбэрийг хэрэглэх нь" сэдэвт судалгааны ажлын 74-75 дахь тал.*

[2] *Чингэлтэй дүүргийн шүүхийн мэдээлэл, лавлагааны төв*

Үргэлжлэл. (түрүүч нь 2005 оны №2, №3, №4, 2006 оны №1, №2, №3-т)

ИРГЭНИЙ ХУУЛИЙН ТАЙЛБАР[1]

/Цуврал/

ХОЁРДУГААР ДЭД БҮЛЭГ
Хуулийн этгээдийн төрөл

33 дугаар зүйл. Хуулийн этгээдийн төрөл

33.1.Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр байгуулна.

33.2.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна.

ТАЙЛБАР

33.1 дэх хэсэг

Ашгийн төлөө ба ашгийн төлөө бус хуулийн этгээдийн талаар Иргэний хуулийн 25.2 дахь хэсгийн тайлбараас харна уу. Ашгийн төлөө хуулийн этгээд нь нөхөрлөл, компани гэсэн үндсэн хоёр хэлбэртэй байна. Нөхөрлөл, компанийн талаар Иргэний хуулийн 34, 35 дугаар зүйлийн тайлбараас үзнэ үү.

33.2 дахь хэсэг

Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь холбоо, сан, хоршоо гэсэн гурван хэлбэрээр байгуулагдаж болно. Холбоо, сан, хоршооны талаар Иргэний хуулийн 36 дугаар зүйлийн тайлбараас үзнэ үү.

34 дүгээр зүйл. Компани

34.1.Хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан хөрөнгөтэй, ашгийн төлөө үндсэн зорилготой хуулийн этгээдийг компани гэнэ.

34.2.Компанийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

ТАЙЛБАР

34.1 дэх хэсэг

Иргэний хуулийн 34.1-д заасан хувь нийлүүлэгчдийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг гэдэг нь хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгө нь нэрлэсэн үнэ бүхий тодорхой тооны хувьцаагаар илэрч, нийтдээ компанийн өөрийн хөрөнгийг бүрдүүлсэн байхыг ойлгоно.

Жишээ:

А компанийн хөрөнгө нь 1000000000 төгрөг бөгөөд нэг бүр нь 10000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100000 ширхэг хувьцаанаас бүрдэнэ гэх мэт.

А. Компанийн хөрөнгө оруулагчдын худалдаж авсан хувьцаагаар илрэх эд хөрөнгө нь хуулийн этгээдийн хувьд үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчдийн хувийн эд хөрөнгөөс тусдаа "компанийн" тусгайлсан эд хөрөнгийг бүрдүүлж, хуулийн этгээдийн хувьд оршин тогтнох эдийн засгийн үндэс болдог. Компанийн өөрийн хөрөнгийн доод хязгаарыг хуульчлан тогтоосон байдаг. Компанийн тухай хуульд зааснаар хувьцаат компанийн өөрийн хөрөнгийн доод хязгаар 10 сая төгрөг, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн өөрийн хөрөнгийн доод хязгаар 1 сая төгрөг байна.

Б. Хувь нийлүүлэгчид нь компанийн хувьцааг худалдан авах замаар хөрөнгө оруулахдаа тус компанийн үйл ажиллагааны орлогоос ногдол ашиг хүртэж, өөртөө орлогын шинэ эх үүсвэртэй байх зорилго агуулдаг. Тийм ч учраас компани нь хуулийн этгээдийн хувьд тусгайлсан эд хөрөнгө дээрээ үндэслэн бизнесийн үйл ажиллагаа явуулж ашиг олох, ногдол ашиг хуваарилах талаар хөрөнгө оруулагчтайгаа нэгэн зорилго бүхий байна.

34.2 дахь хэсэг

Компани үүсгэн байгуулах, бүртгэх, удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувь нийлүүлэгчдийн эрх, үүргийг тогтоох болон компани татан буулгахтай холбогдсон харилцааг "Компанийн тухай" Монгол Улсын хуулиар зохицуулдаг. Харин банк, санхүү, даатгал, үнэт цаасны салбарт компани үүсгэн байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааны онцлогтой холбогдсон харилцааг "Банкны тухай", "Банк бус санхүүгийн байгууллагын тухай", "Даатгалын тухай", "Үнэт цаасны зах зээлийн тухай" зэрэг бусад хуулиар, нийтлэг асуудлыг "Компанийн тухай" хуулиар зохицуулна. Мөн төрийн өмчит үйлдвэрийн газрыг хувьчлах замаар байгуулагдсан компанийн үйл ажиллагааг Компанийн тухай хуулиар, тэдгээрийг үүсгэн байгуулахтай холбогдсон, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанид төрийн ба орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулна.

Компанийн гол шинж болох хувь нийлүүлэгчдийн хариуцлага нь түүний эзэмшиж байгаа хувьцаагаар хязгаарлагддаг онцлогийг компанийн тодорхойлолтыг өгсөн Иргэний хуулийн 34.1-д тусгаагүй орхигдуулсан байна. Гэвч Компанийн тухай хуулиар энэ онцлог нь илүү нарийвчлан зохицуулагдсан бөгөөд энэ онцлог нь компанийн хөрөнгө оруулагчдын эрсдэлийг хязгаарладгаараа нөхөрлөлөөс давуу талтай.

35 дугаар зүйл. Нөхөрлөл

35.1.Гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ уг эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хуульд заасны дагуу хариуцдаг хуулийн этгээдийг нөхөрлөл гэнэ.

[1] Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн "Хуульчдын сургалт ба давтан сургалт" төслөөс эрхлэн гаргасан "Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар"-аас Уншигч Танд зориулан цувралаар нийтэлж байна.

35.2.Нөхөрлөлийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

ТАЙЛБАР

35.1 дэх хэсэг

Иргэний хуулийн 31.1-д заасан "гишүүд" гэдгийг бодгаль этгээд, ашгийн төлөө ба ашгийн төлөө бус хуулийн этгээд гэж ойлгоно. Гишүүдийн тоо хоёроос доошгүй байна.

А. Гишүүд буюу үүсгэн байгуулагчид нь нөхөрлөлдөө хувь хөрөнгөө оруулах замаар нөхөрлөлийн эд хөрөнгийг бүрдүүлнэ. Компанийн хувьд түүний гаргасан хувьцааг худалдан авах замаар түүний тусгайлсан эд хөрөнгийг бүрдүүлдэг бол нөхөрлөлийн гишүүдийн оруулах хувь хөрөнгө нь мөнгө, үнэт цаас, бусад эд хөрөнгө, мөнгөөр илэрхийлэгдэх эдийн бус эрх байна. Хуульд нөхөрлөлийн эд хөрөнгийн доод хязгаарыг заагаагүй учир нэг төгрөгтэй ч байсан нөхөрлөл байгуулах боломжтой. **Жишээ нь:** хоёр сайн аудиторч хамтран аудитын үйл ажиллагаа явуулахаар нөхөрлөл байгуулахад их хэмжээний хөрөнгө шаардлагатай биш гэдэг нь ойлгомжтой. Нөгөө талаар нөхөрлөлийн хөрөнгийн хэмжээг хуульчлан тогтоогоогүй нь түүний үйл ажиллагаанаас үүсэх үүргийг бүрэн хариуцлага бүхий гишүүн хариуцдагтай ч холбоотой гэж ойлгож болно.

Б. Нөхөрлөлийн үйл ажиллагаанаас үүсэх үүргийг нөхөрлөлийн эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хариуцдагаараа нөхөрлөл нь компаниас ялгаатай. Иргэний хуулийн 35.1-д заасан "хуульд заасны дагуу" гэдэг нь Нөхөрлөлийн тухай хуульд зааснаар нөхөрлөлийн хүлээсэн үүргийг гишүүд нь нөхөрлөлд оруулсан болон хувийн өмчийн хөрөнгөөр хамтран хариуцдаг /бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл/, нөхөрлөлийн хүлээсэн үүргийг наад зах нь нэг гишүүн нөхөрлөлд оруулсан болон хувийн өмчийн хөрөнгөөр бүрэн хариуцдаг, бусад гишүүд нь гагцхүү нөхөрлөлд оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцдаг /зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл/ нөхөрлөлийн хэлбэрүүд байдгаар тайлбарлагдана.

35.2 дахь хэсэг

Нөхөрлөлийг үүсгэн байгуулах, бүртгүүлэх, түүний удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтцийг тогтоох, бүртгэл тайлан гаргах, өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдон үүсэх харилцааг "Нөхөрлөлийн тухай" Монгол Улсын хуулиар зохицуулна.

36 дугаар зүйл. Холбоо, сан, хоршоо

36.1.Нэгдмэл, тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, гишүүнчлэл бүхий хуулийн этгээдийг холбоо гэнэ.

36.2.Нэг буюу хэд хэдэн үүсгэн байгуулагч нийгэмд ашиг тустай, нэгдмэл зорилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх замаар байгуулсан гишүүнчлэлгүй хуулийн этгээдийг сан гэнэ.

36.3.Холбоо, сангийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

36.4.Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.

36.5.Хоршоог үүсгэн байгуулах, бүртгэх, хоршооны үйл ажиллагааг дуусгавар болгох, хоршооны гишүүнчлэл, хяналт болон хоршоотой холбоотой бусад харилцааг хуулиар зохицуулна.

36.6.Сүм хийд иргэний эрх зүйн харилцаанд оролцохдоо сангийн эрх зүйн байдлын талаарх хуулийн заалтыг мөрдөнө.

ТАЙЛБАР

36.1 дэх хэсэг

Иргэд Үндсэн хуульд заасан эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөө хэрэгжүүлэх нэг арга нь холбоо байгуулах явдал юм. Иймхүү эвлэлдэн нэгдэхдээ нэгдмэл, тодорхой зорилго тавина. Иргэний хуулийн 36.1-д заасан хэд хэдэн этгээд гэдгийг тухайн холбооны дүрэмд заасан шаардлагыг хангасан гурав буюу түүнээс дээш бодгаль буюу хуулийн этгээд гэж ойлгоно.

"Гишүүнчлэл бүхий" гэдэг нь тухайн холбоог үүсгэн байгуулсан, эсхүл үүсгэн байгуулагдсаны дараа дүрэмд заасан журмаар шинээр элссэн тухайн холбооны үйл ажиллагаанд оролцож, дүрэмд заасны дагуу санхүүжилтэд хувь нэмрээ оруулах, санал өгөх, удирдах байгууллагад сонгох, сонгогдох зэрэг эрх бүхий бодгаль буюу хуулийн этгээдтэй холбооны оршин тогтнох үндэс нь нягт холбоотой байхыг ойлгоно. Холбооны гишүүд татвар төлөхтэй холбоотой харилцааг дүрмээрээ зохицуулна.

А. Холбоо үүсгэн байгуулах, улсын бүртгэлд бүртгүүлэх, удирдах, хянах зэрэг үйл ажиллагаатай холбоотой харилцааг "Төрийн бус байгууллагын тухай" хуулиар, үйлдвэрчний эвлэл байгуулах эрх зүйн үндсийг "Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай" хуулиар, улс төрийн нам байгуулах, түүний үйл ажиллагаатай холбогдсон харилцааг "Улс төрийн намуудын тухай" хуулиар тус тус зохицуулдаг. Мөн "Өмгөөллийн тухай", "Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай", "Улаан загалмайн нийгэмлэгийн тухай" зэрэг хуулиудыг дурдаж болно.

36.2 дахь хэсэг

Сангийн үүсгэн байгуулагч нь нэг буюу хэд хэдэн бодгаль ба хуулийн этгээд байж болно. **Жишээ нь:** Соросын сангийн үүсгэн байгуулагч нь АНУ-ын иргэн Жорж Сорос гэдэг хүн байдаг.

А. Санг үүсгэн байгуулагчдын зорилго нь нэгдмэл байхыг хууль тогтоогч шаардаж байна. Тэднийг нэгтгэж буй "нийгэмд тустай" зорилго гэдэгт буяны болон нийгэм, соёлын, боловсролын зэрэг нийгмийн хөгжлийг дэмжих зорилгууд хамаарна.

Жишээ нь: орлого багатай хүмүүсийн чадавхийг дээшлүүлэх, иргэний нийгмийг хөгжүүлэх, музей, номын сан, театр хөгжүүлэх, боловсрол мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх гэх мэт.

Б. Нэгдмэл, нийгэмд тустай зорилгодоо хүрэх арга нь хөрөнгө төвлөрүүлэх явдал байна.

Жишээ нь: Монголын эмэгтэйчүүдийн сан гэдэг төрийн бус байгууллага нь эмэгтэйчүүдийн байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдаас мөнгөн хөрөнгө

бүрдүүлэх замаар уг зорилгодоо чиглэсэн үйл ажиллагаанд санхүүжилт олгодог.

В. Сан нь гишүүнчлэлгүй байдгаараа холбооноос ялгаатай. Өөрөөр хэлбэл, санг үүсгэн байгуулагч нь заавал сангийн үйл ажиллагаанд оролцох, санг удирдах эрх, үүрэггүй.

36.3 дахь хэсэг

Холбоо, сан үүсгэн байгуулах, бүртгүүлэх, удирдлага, хяналт, өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг "Иргэний хууль", "Төрийн бус байгууллагын тухай" хуулиар зохицуулж байна. Энэ тайлбарыг бичих үед Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хууль боловсруулахаар бэлтгэж байлаа.

36.4 дэх хэсэг

36.4. Хоршоо байгуулах зорилго нь түүний үүсгэн байгуулагчдын эдийн засаг, нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах явдал байна. "Эдийн засаг, нийгэм соёлын хэрэгцээ" нь хоршоо байгуулах болсон зорилго, үйл ажиллагааны онцлогоос хамаарч хэрэглээний (бэлтгэн нийлүүлэх, худалдах) хөдөө аж ахуйн (мал аж ахуй, газар тариалангийн), тусгай (орон сууцны, зуслангийн, гаражын) гэх мэт байж болно. "Хоршооны тухай" хуульд зааснаар ес буюу түүнээс дээш иргэн хоршоо байгуулж болно. Харин хадгаламж зээлийн хоршооны хувьд үүсгэн байгуулагчдын тоо 20-иос доошгүй байна. Үүсгэн байгуулагч буюу гишүүд нь хоршоогоо нэг хүн нэг саналын эрхтэйгээр хамтран удирдаж, хамтран хяналт тавих замаар үйл ажиллагаагаа явуулна. Үүсгэн байгуулагчдын хоршоонд оруулсан хөрөнгө нь тэдгээрийн дундын өмч байна.

Хоршооны эрх зүйн тусгай чадамж нь ашгийн төлөө бус бусад төрлийн хуулийн этгээдээс эрс ялгаатай. Хоршоо нь гишүүдийнхээ эдийн засаг, нийгэм, соёлын хэрэгцээг хангах зорилгоор үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа явуулдаг бол бусад төрлийн ашгийн төлөө бус хуулийн этгээдийн үндсэн зорилго нь нийгмийн баялагт хүрэх эдийн бус шинжтэй зорилго бүхий байдаг. Ийм учир хоршоо нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлээд зогсохгүй, түүнээс бий болох ашгийг гишүүддээ хуваарилж өгөх эрхтэй.

36.5 дахь хэсэг

Хоршооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлох, хоршоог үүсгэн байгуулах, бүртгэх, хоршооны үйл ажиллагааг дуусгавар болгох, хоршооны гишүүнчлэл, хяналт болон хоршооны тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангахтай холбогдсон харилцааг "Хоршооны тухай" Монгол Улсын хуулиар зохицуулна.

36.6 дахь хэсэг

Сүм хийд нь сүсэгтэн олны шашны зан үйл, хурал ном, боловсролын хэрэгцээг хангах зорилгоор байгуулагддаг. Сүм хийдийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг "Иргэний хууль", "Төр, сүм хийдийн харилцааны тухай" Монгол Улсын хуулиар тодорхойлно.

37 дугаар зүйл. Сангийн тусгай зохицуулалт

37.1.Сангийн эрх барих байгууллага буюу удирдах зөвлөл нь хандивлагч, дэмжигч, тэдгээрийн томилсон төлөөллөөс бүрдэнэ.

37.2.Сангийн эрх барих байгууллага нь гүйцэтгэх удирдлага болон хяналтын байгууллагыг томилно.

37.3.Сангийн гүйцэтгэх удирдлага сангийн дүрэмд нийцсэн үйл ажиллагаа явуулж, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг эрх барих байгууллагаараа хэлэлцүүлэн хэвлүүлж, олон нийтэд түгээнэ.

ТАЙЛБАР

37.1 дэх хэсэг

Сангийн удирдах байгууллага, түүний бүрэн эрхийг дүрмээр тодорхойлно. Иргэний хуулийн 37.1-д сангийн эрх барих байгууллага буюу удирдах зөвлөл нь хандивлагч, дэмжигч, тэдгээрийн томилсон төлөөллөөс бүрдэнэ гэжээ.

"Хандивлагч" гэдэг нь санд хөрөнгөө төвлөрүүлсэн үүсгэн байгуулагч, түүнчлэн сан байгуулагдсанаас хойш түүний нийгэмд тустай, тусгай зорилгын төлөө хөрөнгөө төвлөрүүлж байгаа иргэн, хуулийн этгээд байна.

"Дэмжигч" гэдэгт сангийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог, эсхүл сангийн үйл ажиллагааны үр дүнг хүртэгч иргэн, хуулийн этгээдийг ойлгоно.

Санг үүсгэн байгуулагч нь сангийн удирдлага, хяналтын байгууллагын талаар дүрэмдээ сайтар бодож тусгах шаардлагатай. Сангийн зорилгын төлөө үнэнчээр ажиллах удирдах болон хянах баг бүрдүүлэх, буюу тийм баг бүрдүүлэх механизмыг оновчтой тодорхойлж, бүрэн эрхийг нь зөв хуваарилах явдал нь ирээдүйд санг зорилгынхоо төлөө тасралтгүй, амжилттай ажиллах нөхцөл болно.

37.2 дахь хэсэг

Сангийн эрх барих байгууллагаас томилогдсон гүйцэтгэх удирдлага нь санг өдөр тутмын удирдлагаар хангаж, эрх барих байгууллагынхаа өмнө ажлаа хариуцан тайлагнана. Сангийн хяналтын байгууллага нь сангийн үйл ажиллагаа, удирдах байгууллагын гаргасан шийдвэр сангийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт нь хууль тогтоомж, сангийн зорилгод нийцэж байгаа эсэх, гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хянах бүрэн эрхтэй. Хяналтын байгууллагыг сан заавал байгуулж ажиллуулна.

37.3 дахь хэсэг

Иргэний хуулийн 37.2 дахь хэсэг нь сангийн гүйцэтгэх удирдлагад үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа эрх барих байгууллагаараа хэлэлцүүлж, олон нийтэд түгээх үүрэг хүлээлгэсэн. Гүйцэтгэх удирдлагын энэ үүргээ биелүүлэх журмыг хуулиар тогтоогоогүй тул тайлангаа хэвлэх, түгээх арга хэлбэрээ өөрөө сонгох эрхтэй. Гэхдээ сангийн үйл ажиллагаа явуулж байгаа нутаг дэвсгэрийн хүрээг харгалзан бүх сонирхогч этгээд сангийн үйл ажиллагааны талаар мэдээлэл авах боломжийг хангахуйц хэвлэл, мэдээллийн хэрэгслийг сонгож мэдээллээ түгээвэл зохино.

38 дугаар зүйл. Санг татан буулгах журам

38.1.Татан буулгах ажлыг энэ тухай шийдвэр гаргасан байгууллагаас томилогдсон татан буулгах комисс эрхлэнэ. Онцгой тохиолдолд шүүхээс татан буулгах өөр байгууллага томилж болох бөгөөд тэрээр татан буулгах комиссийн гишүүдийн

нэгэн адил хариуцлага хүлээнэ.

38.2.Санг татан буулгахдаа өдөр тутмын ажил хэргийг зогсоож, бэлэн байгаа эд хөрөнгийг мөнгөөр үнэлэн тодорхойлж, харилцагчидтай тооцоо хийнэ.

38.3.Энэ хуулийн 38.1-д заасны дагуу тооцоо хийсний дараа үлдсэн эд хөрөнгийг татан буугдсан сангийн зорилго нэг буюу ижил төстэй зорилго бүхий нэг, эсхүл хэд хэдэн этгээдэд шилжүүлэх, тийм байгууллага байхгүй тохиолдолд төрийн өмчид шилжүүлэх шийдвэр гаргаж болно.

ТАЙЛБАР

38.1 дэх хэсэг

Сан татан буулгах тухай шийдвэрийг Иргэний хуулийн 32.1.1-32.1.4-т заасан байгууллага гаргаж болно. Ийнхүү татан буулгах тухай шийдвэр гаргасан байгууллага нь татан буулгах комисс томилох ба түүнд Иргэний хуулийн 32.2-32.11 дэх хэсэг нэгэн адил хамаарна. Иргэний хуулийн 38.1-д заасан "онцгой тохиолдол" гэдгийг дараахь байдлаар ойлгоно:

- сан төлбөрийн чадваргүй болсон;
- сан дүрэмдээ заасан зорилгоо үйл ажиллагаагаараа зөрчсөн;
- хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн. Эдгээр онцгой тохиолдолд шүүхээс татан буулгах өөр байгууллага томилж болно.

38.2 дахь хэсэг

Санг татан буулгах шийдвэр гармагц түүний өдөр тутмын ажил хэргийг зогсооно. Хуулийн этгээд татан буугдахад эхлээд мөнгөн хөрөнгийг нэхэмжлэгч нарт хуваарилан тэр нь нэхэмжлэгч нарын нэхэмжлэлийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй бол хуулийн этгээдийн эд хөрөнгийг дуудлага худалдаагаар борлуулан нэхэмжлэлийн шаардлагыг хангах арга хэмжээ авдаг бол санг татан буулгахад татан буулгах комисс сангийн бэлэн байгаа хөрөнгийг мөнгөөр үнэлэн тодорхойлж, харилцагчидтай тооцоо хийнэ. Сангийн нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг хангах ажиллагааг Иргэний хуулийн 32 дугаар зүйлд заасан журам, дарааллаар гүйцэтгэнэ.

38.3 дахь хэсэг

Иргэний хуулийн бичвэрт техникийн шинжтэй алдаа гарсан байх тул уг хуулийн 38.3-т: "38.1-д" гэснийг "38.2-т" гэж ойлговол зохино.

А. Харилцагч нартай тооцоо хийж дууссаны дараа сангийн үлдсэн эд хөрөнгийг түүний үүсгэн байгуулагч, удирдлага, ажилтнууд нь авах эрхгүй. Уг хөрөнгийг юуны түрүүн тухайн сантай зорилго нэг буюу ижил төстэй зорилго бүхий этгээдэд шилжүүлнэ.

<u>Жишээ нь:</u> залуучуудын хөгжлийг дэмжих зорилго бүхий А сан татан буугдахад мөн тийм зорилго бүхий (зорилго нэг) Б санд, эсхүл оюутнуудын хөгжлийг дэмжих (ижил төстэй) зорилго бүхий В санд, эсхүл Б, В сангийн аль алинд нь шилжүүлж болно. Ийнхүү сангийн хөрөнгийг шилжүүлж авах эрхийг нэг буюу хэд хэдэн этгээдэд олгох асуудлыг татан буулгах комисс шийдвэрлэнэ.

Иргэний хуулийн 38.3-т заасан "этгээд" гэдгийг татан буугдаж буй сантай нэг зорилготой, эсхүл ижил төстэй зорилго бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээд гэж ойлгоно.

Иргэний хуулийн 38.3-т заасан "тийм байгууллага байхгүй бол" гэдэг нь татан буугдаж буй сантай зорилго нэг, эсхүл ижил төстэй зорилго бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээд тухайн цаг үед үйл ажиллагаа явуулаагүй буйг ойлгоно. Энэ тохиолдолд үлдсэн эд хөрөнгийг төрийн өмчид шилжүүлэх шийдвэрийг татан буулгах комисс гаргана.

"Төрийн өмчид шилжүүлнэ" гэж сангийн үлдсэн мөнгө, болон эд хөрөнгийг худалдан борлуулсны үнийг улс, орон нутгийн төсөвт тушаах буюу эд хөрөнгийг ийнхүү худалдан борлуулахгүйгээр улс, орон нутгийн өмчлөлд хүлээлгэн өгөхийг ойлгоно.

ГУРАВДУГААР ДЭД ХЭСЭГ ХЭЛЦЭЛ

ТАВДУГААР БҮЛЭГ
Нийтлэг үндэслэл

39 дүгээр зүйл. Хэлцэл

39.1.Иргэний эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, шилжүүлэх, дуусгавар болгох зорилгоор хүсэл зоригоо илэрхийлсэн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-г хэлцэл гэнэ.

39.2.Нэг этгээд хүсэл зоригоо илэрхийлэн хэлцэл хийж болно.

ТАЙЛБАР

39.1 дэх хэсэг

Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид нь аж ахуйн үйл ажиллагаа байнга эрхлэдэг эсэхээс үл хамааран аж ахуйн болон ахуйн шинжтэй төрөл бүрийн хэлцэл хийж байдаг. Тийм ч учраас Иргэний хуулийн 8.1.1-д иргэний эрх зүйн харилцаа үүсэх нэг гол үндэслэл нь хуульд заасан буюу заагаагүй боловч агуулгын хувьд хуульд үл харшлах хэлцэл байдаг.

Иргэний хуулийн 39.1-д хэлцлийн тодорхойлолтыг өгсөн. Энэ тодорхойлолтоос хэлцлийн үндсэн шинжүүдийг нэрлэж болно. Хэлцэл нь хэлцэл хийгч этгээдийн хүсэл зоригийн илэрхийлэл болсон, хууль зүйн тодорхой үр дагавар бий болгоход чиглэгдсэн, эрх зүйн дагуу, үйлдэл (эс үйлдэхүй) байдаг.

Дээрхээс үндэслэн хэлцлийн үндсэн шинжүүдийг тус бүрт нь авч үзье.

а/ <u>Жишээ:</u> *А гэгч гудамжинд явж байгаад газраас 100 төгрөг олжээ. Энэ тохиолдолд А-д тодорхой эрх, үүрэг, хууль зүйн үр дагавар үүсэх боловч А газраас мөнгө олох зорилго өвөртөө тавиагүй байсан. Иймээс А-ийн энэхүү үйлдэл нь хэдийгээр эрх зүйн дагуу үйлдэл буюу хууль зүйн үйл явдал боловч өвөртөө хууль зүйн үр дагавар бий болгох хүсэл зорилгогүй байсан учраас хэлцэл биш юм. Хэрэв А сонинд гарсан зарлалын дагуу хүний гээгдүүлсэн эд юмсыг олж, амласан шагналыг авах зорилгоор тухайн эд юмсыг эрэн сурвалжилж олоод, эзэнд нь аваачиж өгсөн бол үүнийг хэлцэл (нэг талын) гэж нэрлэнэ. Учир нь А эд зүйлийг олж эзэнд нь хүргэж өгөх хүсэл зоригтой байсан ба амласан шагналыг шаардах эрх түүнд бий болно.*

б/ <u>Жишээ:</u> *Газар хөдөлснөөс болж А-ийн байшин нуржээ. Тухайн байшингийн хувьд А-ийн өмчлөх эрх дуусгавар болсон хууль зүйн үр дагавар бий болсон боловч түүний хүсэл зоригоос огт шалтгаалаагүй учраас ийм үйл явдлыг хэлцэл гэж*

нэрлэхгүй. Хэлцэл нь хэлцэл хийгч этгээдийн хүсэл зоригоос шууд шалтгаалсан, түүний илэрхийлэл болсон үйлдэл (эс үйлдэхүй) байдаг. Үүгээрээ үйл явдал болон хууль зүйн явдал (юридический поступок)-аас ялгаатай.

в/ *Хэлцэл хийгч этгээд нь хууль зүйн үр дагавар бий болгох зорилготой байдаг. Өөрөөр хэлбэл, эрх үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгоход үйлдэл (эс үйлдэхүй) нь чиглэдэг.*

Жишээ:
А нь Б компаниас их хэмжээний мөнгө зээлж авсан байсан бөгөөд түүнийгээ хугацаанд нь буцааж төлөөгүй тул Б компани шүүхэд нэхэмжлэл гаргажээ. Шүүх А-гаас мөнгийг гаргуулахаар шийдвэрлэжээ. А өөрийнх нь хөрөнгийг битүүмжилж магадгүй гэж бодоод шүүхийн шийдвэр гарахаас өмнө гэр орны зарим үнэ цэнэтэй эд хогшлыг төрсөн дүүгийндээ аваачиж тавиад өөрийнхөө машиныг дүүдээ бэлэглэсэн гэсэн бэлэглэлийн гэрээ хуурамчаар үйлдэн машинаа дүүгийнхээ нэр дээр болгожээ.
Энэ тохиолдолд А бэлэглэлийн гэрээгээр бий болбол зохих жинхэнэ үр дагаврыг хүсэж байсан уу? Тийм үр дагавар бий болсон уу? Өөрөөр хэлбэл, А-ийн дүүд машин болон гэр орны бусад эд хогшлын өмчлөх эрх үүсэж, тэдгээр эд хөрөнгийн хувьд А-ийн өмчлөх эрх дуусгавар болох хууль зүйн үр дагавар бий болоогүй. Иймд тэдгээрийг бэлэглэлийн хэлцэл хийсэн гэж үзэхгүй.

г/ *Хэлцлээр хүсэл зоригоо илэрхийлэгч этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй) нь эрх зүйн дагуу байх ёстой.*

Жишээ:
А, Б нар нэг шөнө айлын цонхоор орж үнэтэй эд, зүйлийг нь хулгайлахаар хоорондоо хэлэлцэн хулгайлсан зүйлээ тэнцүү хуваж авна гэсэн. Хулгай хийснийхээ дараа А нь хулгайлсан зүйлийнхээ ихэнхийг авааД Б-д аар саар жижиг зүйлийг нь өгсөн байна. Б үүнийг эс зөвшөөрчээ.

А, Б нар хэлцэл хийсэн үү?

А, Б нарын үйлдэл нь эрх зөрчсөн, эрх зүйн эсрэг үйлдэл учраас түүнийг хэлцэл гэж үзэхгүй.

Хэлцэл хийгч этгээд нь хүсэл зоригтой байгаад зогсохгүй, түүнийгээ гадагшаа ямар нэгэн хэлбэрээр илэрхийлсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл, "Би юу хүсэж байна?" "Үүний тулд би юу хийж байна вэ?" гэсэн асуултад хариулах ёстой. Хүсэл зоригийн илэрхийлэл нь *тодорхой үйлдлээр* (гэрээнд гарын үсэг зурах, итгэмжлэл олгох, эд хөрөнгө хүлээж авах, гэрээслэл үйлдэх гэх мэт), мөн ямар нэгэн дүгнэлт гаргаж болох бодит үйл хөдлөлөөр (гар өргөх, толгой дохих гэх мэт), хууль буюу талуудын байгуулсан гэрээнд тусгайлан заасан бол *дуугүй хүлээн зөвшөөрөх хэлбэрээр* тус тус илэрдэг.

Үйлдэл нь идэвхтэй, эс үйлдэхүй нь идэвхтэй хэлбэртэй байх ба "тийм", "үгүй" гэсэн хүсэл зоригийн илэрхийлэл болж байдаг.
Жишээ нь: Иргэний хуулийн 528.3-д зааснаар өвлөгч өвлөгдөх эд хөрөнгийг Иргэний хуулийн 528.1, 528.2-д заасан хугацаанд хүлээн авааГүй буюу хүлээн авах тухай хүсэлт зохих байгууллага, этгээдэд гаргаагүй бол түүнийг өвлөхөөс татгалзсан гэж үзнэ. Өөрөөр хэлбэл, өвлөгч хүлээн авахгүй "үгүй" гэсэн хүсэл зоригоо эс үйлдэхүй буюу идэвхтэй хэлбэрээр илэрхийлсэн гэж үзнэ.

Мөн иргэний хуулийн 296.1-д зааснаар эд хөрөнгө хөлслөх гэрээний хугацаа дууссан боловч хөлслөгч эд хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласаар байгааг хөлслүүлэгч татгалзаагүй бол гэрээг тодорхой бус хугацаагаар тухайн нөхцөлөөр сунгасанд тооцно. Хөлслүүлэгч гэрээ сунгах "тийм" гэсэн хүсэл зоригоо мөн "эс үйлдэхүй" буюу идэвхтэй хэлбэрээр илэрхийлсэн гэж үзнэ.

39.2 дахь хэсэг

Иргэний хуулийн 39.2 дахь хэсэгт нэг этгээд хүсэл зоригоо илэрхийлэн хэлцэл хийж болно. Ийм хэлцлийг нэг талын хэлцэл гэдэг. Нэг этгээд хүсэл зоригоо илэрхийлэн гол төлөв өөр этгээдэд эрх, үүрэг (хууль зүйн үр дагавар) бий болгож байдаг.

Тухайлбал, гэрээслэл нэг талын хэлцэл бөгөөд өвлүүлэгч өөрийн хүсэл зоригоо илэрхийлсэн гэрээслэл үйлдэх замаар өвлөгчид эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх өвлөх, өмчлөх эрх бий болгодог.

Түүнчлэн итгэмжлэл нь бас нэг талын хэлцэл бөгөөд итгэмжлэгч итгэмжлэлд дурдсан этгээд (итгэмжлэгдэгчид)-д итгэмжлэгчийн нэрийн өмнөөс тодорхой үйлдэл, үйл ажиллагаа хийх эрх бий болгодог.

Нэг талын хэлцлээр гагцхүү хуульд шууд заасан тохиолдолд буюу хоёр талын тохиролцоогоор хэн нэгэн этгээдэд үүрэг үүсгэдэг. Жишээлбэл, Иргэний хуулийн 420.1-д зааснаар тодорхой үйлдэл хийсэн, эсхүл тодорхой үр дүн бий болгосон этгээдэд шагнал олгохоор амлаж нийтэд зарласан этгээд уг үйлдэл хийсэн буюу үр дүн бий болгосон этгээдэд шагнал олгох үүрэгтэй.

Шагнал олгохоор нийтэд амлаж байгаа этгээд өөрөө хүсэл зоригоо илэрхийлсэн өөртөө үүрэг хүлээж нэг талын хэлцэл хийж байна. Тэгвэл шагнал авахаар хүсэл зоригоо илэрхийлсэн тодорхой үйлдэл хийсэн, эсхүл тодорхой үр дүн бий болгосон этгээд нь уг үйлдлийг хийж, үр дүн бий болгосноороо мөн нэг талын хэлцэл хийж байгаа ба энэ хэлцэл нь шагнал олгохоор амласан этгээдэд үүрэг бий болгож байна.

Дээрхийн адил дуудлага худалдаа зарлах, уралдаант шалгаруулалт, чек олгох зэрэг үйлдлүүдийг нэг талын хэлцэлд хамааруулж болно. Нэг талын хэлцэлд үүргийн болон гэрээний нийтлэг үндэслэл нэгэн адил хамаардаг.

Гэрээ болгон хэлцэл байна, харин хэлцэл болгон гэрээ байдаггүй. Нэг талын хэлцлийг гэрээ гэж нэрлэдэггүй ч гэсэн үүрэг болон гэрээний нийтлэг зохицуулалт хэлцэлд үйлчилж болно гэсэн үг.



ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХ БА ҮНДСЭН ХУУЛИЙН АСУУДАЛ

Ерөнхийдөө олон улсын эрүүгийн шүүх болон түүний шүүх эрх мэдэл нь үндэсний шүүх эрх мэдлийг нэмэгдүүлэн, нөхөх зарчимтай. Уг зарчмын дагуу Олон улсын эрүүгийн шүүх (ОУЭШ) нь Ромын дүрэмд[1] (ОУЭШ-ийн үүсгэн байгуулах гэрээ - цаашид "Дүрэм" гэх) нэгдэн орсон улс гүрнээс хүн төрөлхтний энх тайван, аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийг харьяалан шийдвэрлэхийг, эсхүл холбогдох гэмт хэргийг шийдвэрлэх (шүүн шийдвэрлэх ажиллагааг зохих түвшинд явуулах) хүсэл зориг, боломж, чадвар хомсдох үед харьяалан шийдвэрлэх эрхээсээ татгалзахыг шаардаж, хянаж байх тогтолцоо мөн. Тус дүрэмд нэгдэн орсон ямар ч гишүүн улс ОУЭШ-ийн шүүн шийдвэрлэх ажиллагаанд тус дөхөм үзүүлэх үүрэг хүлээдэг. Иймд ОУЭШ-ийн ажиллагаа бүхэлдээ гишүүн улсын дүрэмд заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаагаас шууд шалтгаалж байна. Гишүүн улсын үүргийн чухал нь гэмт этгээдийг албадан саатуулж ОУЭШ-д хүлээлгэн өгөх асуудал юм. Энэ асуудал нь төрийн дээд албан тушаалтны дархан эрхийн асуудалтай холбоотой байдаг.

Монгол Улсын Үндсэн хууль болон түүний нэгдэн орсон Ромын дүрэм хэрхэн хоорондоо уялдаж буй байдал, үндэсний хууль тогтоомжийг хэрхэн нийцүүлэх зэрэг асуудалд практик зарим зөвлөмж гаргахыг зорилоо.

1. Үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх асуудал

Ромын дүрэмд нэгдэн орсноор гишүүн улс дотоодын хууль тогтоомжоо заавал өөрчлөх ёстой болж байна гэж үзэх нь дутагдалтай. Учир нь, ОУЭШ-ийн нөхөх зарчим нь



ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрхлэгч М.Мөнхбат (LL.M.int.)

үндэсний эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг яг таг Ромын дүрмийн журмаар явуулахыг шаардана гэж ойлгож болохгүй. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа болон ял шийтгэлийн хэмжээ нь Дүрэмд тогтоосноос ялгаатай (эрх зүйн тогтолцооноос шалтгаалан) байж болно. Харин үндэсний шүүн шийдвэрлэх ажиллагааг "зохих түвшинд" л явуулах үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, гэмт этгээдийг халхавчлах, зөвтгөх зорилгоор шүүн шийдвэрлэх ажиллагааг явуулж болохгүй гэсэн үг.

Ромын дүрмийн гишүүн ихэнхи улс нөхөх зарчмыг хангах үүднээс ОУЭШ-ийн харьяалах гэмт хэргийг үндэсний хууль тогтоомждоо тусгаж өгч байна. Харин цаашид Дүрэмтэй зөрчилдөх байдал гаргахгүйн үүднээс, тухайлбал, гэмт этгээдийг "халхавчлах" зорилгоор өөрийн хууль тогтоомж дахь ялаас чөлөөлөх, хөнгөвчлөх нөхцөлийг тус Дүрэм эсхүл бусад олон улсын эрх зүйн баримт бичигтэй нийцүүлж байна. Хэдий ийм өөрчлөлт хийх зохистой боловч Ромын дүрэм нь үүнийг заавал хийхийг шаарддаггүй байна. Ромын дүрэм нь үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэн өөрчлөх үүргийг гишүүн улсад тулгадаггүй боловч ийм өөрчлөлт хийхэд хүргэх нь ойлгомжтой. Тухайлбал, ОУЭШ нөхөх зарчмын дагуу шүүх эрх мэдлээ хэрэгжүүлэх явцад яалт ч үгүй хамтран ажиллах үүргийнхээ хувьд үндэсний шүүхийн тогтолцоо байцаан шийтгэх ажиллагааг Дүрмээр тогтоосон журмын дагуу явуулахад асуудал гарах нь ойлгомжтой.

2. Хамтран ажиллах үүргийг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэх

Аливаа улс үндэсний хэмжээнд хууль тогтоомжоо Дүрэмд нийцүүлэхгүйгээр тус гэрээг соёрхон батлах ажиллагаа явуулж болох боловч дараагийн шатанд нь нийцүүлэх ажлыг зохион байгуулах нь зохимжтой. Учир нь тэгээгүйгээс практик дээр асуудалтай тулгарч олон улсын гэрээг зөрчсөн хэрэгт унах магадлалтай. Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байдлаа үндэсний хууль тогтоомжоор зөвтгөхийг олон улсын эрх зүйгээр хориглосон байдаг[2]. Харин энэ заалтыг үл тоон Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд зааснаар Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй гэж үзсэн ч ОУЭШ-ээс шаардсаны дагуу үүргээ гишүүн улс биелүүлэхгүй бол шүүх нь Гишүүн улсуудын ассамблейд, эсхүл НҮБ-ийн Аюулгүй Зөвлөлд шийдвэрлүүлэхээр хандах хүртэл арга хэмжээ авна гэдгийг тооцож анхааралдаа авах шаардлагтай[3].

Гишүүн улс бүр хамтран ажиллах нөхцөлийг (Дүрмийн 9 дүгээр хэсэг) хууль тогтоомждоо тусгах үүрэг 88 дугаар зүйлийн дагуу хүлээх нь хамгийн чухал бөгөөд энэ нь ОУЭШ-ийн шаардлагаар хамтран ажиллах ба шүүхийн туслалцааг үзүүлэх явдал юм. Уг

[1] 1998 оны 7 дугаар сарын 18-ны өдөр баталж, 2002 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 2002 оны 4 дүгээр сарын 5-нд соёрхон батласан.
[2] 1969 оны Олон улсын гэрээний эрх зүйн Венийн конвецийн 27 дугаар зүйл. (Монгол Улс 1988 оны 4 дүгээр сарын 11-нд нэгдэн орсон)
[3] 87 дугаар зүйлийн 5.b заалт, 7 дугаар зүйл

үүрэг нь ОУЭШ-ийн дүрмийн 86 дугаар зүйлд тодорхойлогдсон[1]. Мөн бусад зүйлд хамтран ажиллах хэлбэрийг заасан байдаг, тухайлбал, албадан саатуулах, шүүхэд хүлээлгэн өгөх, нотлох баримт шилжүүлэх, эд мөрийн баримт, эд хөрөнгө битүүмжлэх, хохирогч ба гэрчийг хамгаалах гэх зэрэг. Шүүхийн даалгавар гүйцэтгэх, торгууль тавих, эд хөрөнгө хураах, шүүхтэй тусгай гэрээ хийсэн бол хорих ялыг хэрэгжүүлэх зэрэг хамтын ажиллагааг хангана. Үүнээс гадна гишүүн улс болгон ОУЭШ-ийн удирдах, санхүүжүүлэх зэрэг ажилд оролцохоос гадна шүүн шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх үүрэгтэй.

Гадаад зарим улсын практикаас үзвэл тухайн хамтын ажиллагааг хангах үүднээс тусгайлан ОУЭШ-тэй хамтран ажиллах хууль тогтоосон байдаг байна. Тухайлбал, 2006 оны 9 дүгээр сарын байдлаар 18 улс[2] ОУЭШ–тэй хамтран ажиллах кодексыг баталсан байна.

Хууль тогтоомжийг нийцүүлэх ажиллагааг зөвхөн хууль тогтоох техниктэй холбож үзэж болохгүй юм. Эдгээр хууль тогтоомж нь хууль тогтоох процессоос гадна улс төрийн болон санхүүгийн бэрхшээл, хязгаарлалттай тулгарах нь зайлшгүй байдаг, тэр тусмаа Үндсэн хуулийн заалттай харшилдах бол дээрх саадтай улам хурц тулгарна. Үндсэн хууль бусад эрх зүйн актаас харьцангуй халдашгүй, тогтвортой байдаг учир түүнтэй харшилж буй олон улсын эрх зүйн хэм хэмжээг нийцүүлэх ажиллагаа асуудалтай тулгардаг. Иймд энэхүү Үндсэн хуультай харшилдах байдлын талаархи судалгаа хийх нь зайлшгүй юм.

3. Албан тушаалтны дархан эрх болон баривчлах, шилжүүлэн өгөх асуудалтай холбоотой Үндсэн хуулийн асуудал

Үндсэн хуулийн асуудал өнөөдөр дэлхийд хэдэн янзын Үндсэн хууль байна төдий чинээ ялгаатай байна. Эдгээрээс хамгийн шийдвэрлэхэд бэрхшээлтэй асуудал бол ОУЭШ-ийн шаардлагаар гэмт этгээдийг баривчлах ба шүүхэд шилжүүлэн өгөх асуудал юм. Харин энэ асуудлаар Үндсэн хууль Ромын дүрэмтэй нийцэж буй байдлыг ОУЭШ-ийн дүрмийн гурван заалтаар шалгуур болгож үздэг.

1. Албан тушаалтныг эрүүгийн хариуцлагад татахад саад болох аливаа бэрхшээлийг ОУЭШ нь эс хүлээн зөвшөөрөх ба гишүүн улсаас тийм этгээдийг Үндсэн хуулиар дархан эрх олгосон эсэхээс үл шалтгаалан баривчлан шилжүүлэн өгөхийг шаардана.

2. ОУЭШ сэжигтэнг түүний ямар харьяалалтай байгаагаас үл шалтгаалан шилжүүлэн өгөхийг шаардана. Тиймд ОУЭШ нь гишүүн улсаас Үндсэн хуулиараа шилжүүлэн өгөхгүй байсан ч өөрийн иргэнийг баривчлах ба ОУЭШ-д шилжүүлэн өгөхийг шаардана.

3. Үндэсний хууль тогтоомжоор тодорхой хугацаанаас хэтрүүлэхгүйгээр хорих ялын хэмжээтэй байсан ч ОУЭШ-ээс бүх насаар нь хорих ял ногдуулж болно.

Ромын дүрэм нь бүх этгээдэд түүний албан тушаалыг харгалзахгүйгээр үйлчлэх бөгөөд энэхүү албан тушаалын байдал нь ялаас чөлөөлөх, эсхүл хөнгөрүүлэх үндэслэл болохгүй[3]. Олон улсын эрүүгийн шүүх нь үндэсний хууль тогтоомжоор дархан эрх эдлэх этгээдүүдийг харьяалан шийдвэрлэх бүрэн эрхтэй[4] нь төрийн болон дипломат эрх дархын асуудлаар гуравдагч улсын хувьд эдлэхэд нь саад болохгүй. Өөрөөр хэлбэл, Үндсэн хууль болон олон улсын гэрээгээр олгогдсон дархан эрх нь ОУЭШ-д шүүн шийтгэх ажиллагаа явуулахад саад болохгүй байна.

Үндсэн хуулийн дагуу дархан эрхийг олгож буй байдал нь үүргээ гүйцэтгэж дууссан, эсхүл гүйцэтгэж буй төрийн тэргүүн, засгийн газар болон парламентын гишүүн, шүүгч зэрэг төлөөлөх болон гүйцэтгэх эрх мэдлийн ямар ч түвшний албан тушаалтанг улс төрийн асуудлаар болон аливаа гүтгэлэг, мөрдөн мөшгилтөөс ангид байлгах үүднээс олгодог. Иймд хамгаалалт нь тухайн албан тушаалтанг өөрийн ажил үүргээ зохих түвшинд хийхэд нь баталгаа болдог. Харин Үндсэн хуулийн дагуу дархан эрхийг эдлэнэ гэхийг түрэмгийлэл, дайны гэмт хэрэг, хүмүүнлэгийн эсрэг гэмт хэрэг, төрлөөр устгах гэмт хэрэгт буруутгагдахгүй гэж тайлбарлаж ойлгохын бол ОУЭШ-ийн харьяалах хэргээр шүүх ажиллагаа тэдгээрийн эсрэг явуулж болохгүй мэт. Энэ байдал нь, *нэгдүгээрт,* ОУЭШ-ийн шаардлагаар хамтран ажиллах ажиллагаанд бэрхшээл учруулах ба *хоёрдугаарт,* ийм гэмт хэрэг үйлдсэн ч шийтгэлгүй үлдэж болно гэх итгэл үнэмшилтэйгээр хүний эрх, эрх чөлөөнд халдах боломжтой нөхцөл байдлыг бий болгоно. Хэдий хэмжээнд ийм байр суурьтай хандана төдий чинээ 88 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүрэгтэй нь зөрчилдөнө.

Энэхүү асуудлыг шийдэх гурван гарц л байна. Нэгдүгээрт, Үндсэн хуульдаа Ромын дүрэмд нийцүүлэх үүднээс өөрчлөлт оруулах; хоёрдугаарт, холбогдох Үндсэн хуулийн заалтыг Ромын дүрэмд нийцүүлэн тайлбарлах; эцэст нь ОУЭШ-ийн харьяалагдах хэрэг манайд гарахгүй ч юм билүү гэж үзэн ямар ч арга хэмжээ авахгүй байх. Харин гарах тохиолдолд НҮБ-аас хариуцлага тооцно гэдгийг мартаж үл болно.

Эхний ээлжинд ОУЭШ-ийн харьяаллын гэмт хэрэгт дархан эрхийн асуудал үйлчлэхгүй гэх байдлаар Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулах нь чухал. Иймд өөрчлөлт оруулсан нь ОУЭШ-д шилжүүлэхгүйгээр үндэсний

[1] 86 дугаар зүйл. Хатран ажиллах нийтлэг үүрэг. Оролцогч улсууд энэхүү дүрмийн заалтуудын дагуу хэрэг шүүн шийдвэрлэхэд хамаарах гэмт хэргийн эрүүгийн мөрдөн байцаалт болон эрүүгийн мөрдөн мөшгөлт явуулахад Шүүхтэй бүх талаар хамтран ажиллана. ("Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 2005 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийнТусгай дугаар II боть).

[2] Австрали, Аргентин, Бразил, Бельги, Голланд, Испани, Их Британи, Канад, Нигер, Норвег, Өмнөд Африк, Перу, Словени Улс, Тринидад ба Тобаго, Уругвай, ХБНГУ, Франц, Швед (http://www.iccnow.org/?mod=romeimplementation)

[3] Ромын дүрмийн 27 дугаар зүйлийн 1 дүгээрт

[4] Ромын дүрмийн 27 дугаар зүйлийн 2 дугаарт

шүүх эрх мэдлийн байгууллагаар дархан эрхтэй этгээдийг харьяалан шийдвэрлэх боломжтой болох бөгөөд хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгнө. Монгол Улсын хууль тогтоомжоор Ерөнхийлөгчөөс бусад төрийн дээд албан тушаалтны эрх дархыг зохих журмын дагуу түдгэлзүүлж болох ба эрүүгийн хариуцлагад татаж болох нөхцөлтэй. Харин Ерөнхийлөгчийн хувьд түүнийг зохих журмын дагуу огцруулах нөхцөлтэй ч хариуцлагад татах боломж нь тодорхой бус байдаг.

Дархан эрхийг дээрх гэмт хэргийн хувьд хамаарахгүй гэж Үндсэн хуульд өөрчлөлт оруулснаар, эсхүл Дүрэмд нийцүүлэн тайлбарласнаар албадан саатуулах, ОУЭШ-д шилжүүлэн өгөх асуудлыг хөндөхгүйгээр үлдээх боломжтой. Учир нь гэмт хэрэг үйлдсэн дархан эрхтэй этгээдийг дотоодын хуулиар тухайн хариуцлага тооцох механизм нь бүрэлдэнэ. Тухайн шүүхийн шийдвэр нь шударга бол ОУЭШ-д шилжүүлэн өгөх шаардлага гарахгүй.

Энэ асуудалд Франц улс арай өөрөөр хандсан практиктай. Франц улс Ромын дүрэмд нэгдэн орохдоо төрийн тэргүүний дархан эрхийн талаархи Үндсэн хуулийн заалт нь тухайн Дүрэмтэй нийцэхгүй байна гэж Үндсэн хуулийн Зөвлөл нь дүгнэлт гаргаж байв. Уг асуудлыг парламентын хоёр танхимаар хэлэлцүүлэн 1999 онд Бүгд найрамдах улс нь Олон улсын эрүүгийн шүүхийн харьяаллыг хүлээн зөвшөөрнө гэсэн Үндсэн хуулийн өөрчлөлтийг[1] баталсан байна. Франц Улсын тус өөрчлөлтийг шинжилж үзвэл ОУЭШ-тэй хамтран ажиллах нөхцөлийг бүрэлдүүлж өгсөн хэдий ч төрийн тэргүүн холбогдох гэмт хэргийг үйлдвэл дотоодын шүүхээр харьяалан шийдвэрлэх бус харин дархан эрхийг нь үл харгалзан ОУЭШ-д шилжүүлэхийг сонгосон байна. Өөрөөр хэлбэл, Франц улс өөрийн төргүүнээ эрүүгийн хариуцлагад өөрөө татах "хүсэлгүй" улсын тоонд хэвээр багтан үлдсэн гэж хэлж болно. Гэхдээ энэ байдал нь олон улсын эрх зүйн дагуу хүлээсэн үүргээ зөрчиж байгаа илрэл огт биш.

Дараагийн чухал асуудал нь түрэмгийлэл, дайны гэмт хэрэг, хүмүүнлэгийн болон төрлөөр устгах гэмт хэрэг үйлдсэн хэнийг ч харьяаллаас нь үл хамааран ОУЭШ-д хүлээлгэн өгөх асуудал юм.

Манай Үндсэн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн заалтаар Монгол Улсын иргэнийг өөр *улсад* шилжүүлэн өгөхийг хориглосон. Харин Дүрэм нь гэмт этгээдийг "хүлээлгэн өгөх", "шилжүүлэн өгөх" гэсэн хоёр ойлголтыг ялгаж үзсэн байна[2]. "Хүлээлгэн өгөх"-ийг Ромын дүрмээр ОУЭШ-ийн харьяалалд тухайн этгээдийг шилжүүлэн өгөхийг ойлгох бол "шилжүүлэн өгөх"-ийг өөр улсын үндэсний шүүхийн харьяалалд шилжүүлэхийг ойлгоно. Энэ нэр томъёог дүрэмд ялгаж тусгаж өгсөн нь ОУЭШ-ийн харьяалал ямар ч улсын өөрийн иргэнийг өөр улсад шилжүүлэн өгөхгүй байх Үндсэн хуулийн заалтад харшлах зүйлийг арилгах зорилготой юм. Мэдээжийн хэрэг хууль тогтоогчид Үндсэн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн заалтыг томъёолохдоо Монгол Улсын иргэнийг гагцхүү Монгол Улсын шүүхээр харьяалан шийдвэрлэх үзэл баримтлалтайгаар хандсан байх. Үүний гол үндэслэл нь тухайн этгээдийн асуудлаар гадаад улсын шүүхээс илүүд үндэсний шүүх нь шударга шийдвэр гаргах магадлалтай. Мөн хэл, соёлын асуудлаас гадна тодорхой хэмжээгээр ял эдэлж буй этгээдийг нийгэмшүүлэх, үндэсний хэмжээнд гарч болох бусад ийм гэмт хэргээс сэргийлэх нөхцөлийг гадаад улсын практик биш зөвхөн үндэсний шүүхийн үйл ажиллагаа л бий болгодог. Хэрэв энэ үзэл баримтлалыг хөдлөшгүйгээр хамгаалах бол хүн төрөлхтний эсрэг аливаа гэмт хэргийг шийдвэрлэх, эсхүл төрийн дээд албан тушаалтанг тухайн хэрэгт буруутган шийтгэх шударга механизмтай байх шаардлагатай болж байна. Нөгөөтэйгүүр Ромын дүрмийг хүлээн зөвшөөрсөн, ОУЭШ-ийг байгуулцсан улсын хувьд хүлээсэн үүргээ дахиад л санах шаардлагатай. Ромын дүрэм нь "хүлээлгэн өгөх", "шилжүүлэн өгөх" гэсэн хоёр ойлголтыг ялгаж үзсэн нь уг асуудлыг хялбарчлах зорилго агуулж байгаа гэж үзэж болох юм. Учир нь өөрийн улсын иргэнийг гадаад шүүхэд шилжүүлэн өгөхгүй байх дээрх үзлийг хөндөхгүйгээр ОУЭШ үйл ажиллагаагаа явуулна гэж ойлгож болох юм. ОУЭШ бол нэгдүгээрт, гадаад бүрэн эрхт улсын шүүх биш, хоёрдугаарт, ОУЭШ нь шударга ёсны баталгааг гадаад улсын шүүхээс илүү хангаж өгнө. Өөрөөр хэлбэл, Дүрэм нь ямар ч улсын хууль тогтоомжоос илүү хүний эрх, эрх чөлөөг хангах олон улсын стандартыг тусгаж өгсөн. Нөгөөтэйгүүр, ОУЭШ нь олон улсын хамтын нийгэмлэгийн хүсэл зоригоор, зөвшилцлөөр бий болсон, энд хэн нэгэн улсын эрх ашиг, бүрэн эрхийн ноёрхол байхгүй. Манайх шиг тус шүүхийг байгуулсан улс болгон ОУЭШ-ийн үйл ажиллагаанд тэгшээр оролцдог. Өөрөөр хэлбэл, ОУЭШ нь улс биш юм.

Иймд нэн тэргүүнд Үндсэн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн заалтыг "эрх бүхий байгууллагаас" Ромын дүрмийн 102 дугаар зүйлтэй нийцүүлэн тайлбарлах шаардлагатай байна. Энэ заалтыг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үндэсний шүүх нь хэрэг гарах бүрт ОУЭШ-д шилжүүлж ажилгүй болно гэж ойлгож болохгүй, учир нь, нэгдүгээрт, ОУЭШ нь нэмэлт хөшүүргийн зарчмаар ажиллана, хоёрдугаарт, нэмэлт хөшүүргийн нөхцөл бүрэлдсэн ч ОУЭШ нь тухайн хэргийг шийдвэрлүүлэхээр үндэсний шүүхэд даалгаж болно. Энд дахиад л хамтран ажиллах талаархи үндэсний зохицуулалт шаардаж эхлэнэ.



[1] Бүгд Найрамдах Франц Улсын Үндсэн хуулийн 53-2 дугаар зүйл (өөрчлөлт N 99-1568, 1999 оны 7 дугаар сарын 8-ны өдөр).

[2] Ромын дүрмийн 102 дугаар зүйл.

Олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжид нийцүүлж хэрэглэх нь

ГХЯ-ны Гэрээ, эрх зүйн газрын захирал, хууль зүйн шинжлэх ухааны доктор Б.Алтангэрэл

Монгол Улсын нэгдэж орсон олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжид нийцүүлж хэрэглэх нь онолын болон практикийн ач холбогдолтой болоод байгаа нь бодит асуудал мөн.

Олон улсын харилцаанд олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжидоо хэрхэн нийцүүлэх, хэрэглэх вэ гэдэг асуудлаар үндсэндээ гурван онол буюу үзэл баримтлал оршсоор ирсэн. Үүнд:

Нэгдүгээрт: Үндэсний эрх зүй, хууль тогтоомжоо олон улсын эрх зүй (ОУЭЗ), түүний хэм хэмжээнээс дээгүүр тавих. Энэ онолыг Германы философич Гегель XIX зуунд дэвшүүлж тавьсан байдаг юм. Бидний сайн мэдэх зөвлөлтийн хуульч Вышинский эрүү, иргэний хуульд энэ онолыг баримталж байсан. **Хоёрдугаарт:** Дуализм (хосолмол) –ын онол. Эл онолын дагуу бол дотоодын эрх зүй ОУЭЗ–ээс, дотоодын хууль тогтоомж ОУ–ын гэрээнээс хамаарахгүйгээр бие биенээсээ ангид байна гэсэн онол байдаг. **Гуравдугаарт:** дэлхийн нэгдүгээр дайны дараагаар Австрийн хуульч Г.Кельзен дотоодын эрх зүйн хэм хэмжээнээс ОУЭЗ–н хэм хэмжээ давуу байх онолыг дэвшүүлэн тавьсан юм.

Өнөөдөр дэлхийн ихэнх улс орон Кельзений энэхүү үзэл бармтлалыг хүлээн зөвшөөрч мөрдөж байна. Гэхдээ олон улсын эрх зүй, ялангуяа түүний үндсэн эх сурвалжийн нэг болох олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэх асуудалд олонхи улс орон болгоомжтой, хүлээцтэй хандаж байна. Энэ бүгдийг арай дэлгэрэнгүй авч үзье.

Олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэхэд олон улсын хандлага

Дээр дурдсан дуализмын онол буюу заримдаа трансформаци хандлага ч хэмээдэг энэ онол нь олон улсын эрх зүй болон дотоодын эрх зүйг, эрх зүйн тус тусдаа хоёр өөр систем хэмээн салангид авч үзэн, түүний үндсэн эх сурвалжуудийн нэг болох аливаа олон улсын гэрээг үндэснийхээ хууль тогтоомжид нийцүүлэхдээ, тухайн улсын хууль тогтоогч дээд байгууллагаас нь тусгайлан хууль гарган дотоодын хуульдаа нийцүүлдэг бөгөөд, үүнийгээ Үндсэн хуулийн механизмаар зохицуулсан байдаг. Өөрөөр хэлбэл, олон улсын эрх зүйн актуудыг үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил хэрэглэхдээ, Үндсэн хуулийнхаа заалтын дагуу тэдгээрийг Парламентаараа заавал соёрхон батлаж байж хүчин төгөлдөр болгох буюу шилжүүлэх (трансформаци) механизмын арга замаар нийцүүлэх асуудал юм.

Кельзений онолыг заримдаа монизм буюу инкорпораци (нэгтгэх, нийлүүлэх) хандлага хэмээн нэрлэдэг. Энэ нь олон улсын эрх зүйг дотоодын эрх зүйн нэгэн салшгүй хэсэг хэмээн үзэж, олон улсын эрх зүйн актууд нь автоматаар тухайн улсын дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил шууд хэрэглэгддэг бөгөөд, тэдгээрийг хүчин төгөлдөр болгон дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэх ямар нэг үндсэн хуулийн болон бусад механизм шаардлагагүй юм. Хэдийгээр монист буюу инкорпораци арга замаар олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэх нь илүү хялбар мэт харагдах боловч, эл хандлагыг хэрэглэх үед олон улсын зан заншлын эрх зүй, мөн олон улсын эрх зүйн акт тус бүрийн онцлог шинжээс хамааран гэрээний эрх зүйн өөр өөр дүрэм, журам мөрдөгддөг.

Ихэнх улс орон олон улсын түүгээмэл эрх зүйг дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэхдээ Кельзений онол буюу монист хандлагыг хүлээн зөвшөөрч хэрэглэдэг ч олон улсын гэрээний хувьд монист гэхээс илүүтэйгээр дуалист, монист хандлагуудыг хамтад нь хэрэглэсэн байдгийг доорхи жишээнээс харж болно.

Англи улс XVIII зуунаас эхлэн монолист буюу инкорпораци хандлагыг хэрэглэж ирсэн боловч, энэ нь зөвхөн олон улсын зан заншлын эрх зүйд хамаардаг бөгөөд олон улсын гэрээний хувьд зарим гэрээг жишээ нь, Британийн Хатан хаан гарын үсэг зурж, батлах авч түүнийг нь англиийн шүүх шууд авч хэрэглэдэггүй бөгөөд заавал Англиийн Парламентийн Актаар баталсан байх ёстой болдог. Гэхдээ, ийм журам олон улсын бүхий л гэрээнд нь хамаардаггүй бөгөөд жишээ нь "харьцангуй чухал биш" (relatively unimportant) буюу дотоодын хууль тогтоомжийг ямар нэг хэлбэрээр өөрчлөөгүй хэмээн үзсэн гэрээг парламентаар заавал соёрхон батлах шаардлагагүй байдаг.

АНУ-ын хувьд Англи улстай мөн нэгэн адил монолист буюу инкорпораци хандлагыг хэрэглэдэг гэх авч, олон улсын гэрээний хувьд: АНУ-ын Үндсэн хуулийн 2 дугаар заалтад "Ерөнхийлөгч олон улсын гэрээ байгуулах бүрэн эрхтэй бөгөөд Сенатын танхимын гишүүдийн гуравны хоёр нь хүлээн зөвшөөрсөн тохиолдолд түүнийг соёрхон батлана" хэмээн заасан байдаг.

Ромын хууль давамгайлсан зарим улсад олон улсын гэрээг илүү давуу эрхтэй байхаар тусгасан байдаг бөгөөд жишээ нь Германы Үндсэн хуульд "Олон улсын түгээмэл эрх зүйн үндсэн дүрмүүд нь холбооны хууль тогтоомжийн нэгэн салшгүй хэсэг бөгөөд тэдгээр нь холбооны нутаг дэвсгэр дээр оршин суугчдад үүрэг, хариуцлага шууд үүсгэж, хууль тогтоомжоос илүү давамгай байна" хэмээн заасан нь олон улсын эрх зүйн үндсэн зарчмууд нь дотоодын хууль

тогтоомжийг хүчингүй болгох эрхтэй эсэх, эсхүл Үндсэн хуулийг нь хүртэл хөндөж болох эсэх асуудлаар санал зөрөлдөөн үүсгэж, саармаг ойлголт төрүүлдэг хэмээн үздэг.

Гэхдээ олон улсын гэрээг дотоодын хууль тогтоомжтой нийцүүлэх асуудлаар Германы Үндсэн хуулийн 59 дүгээр заалтад тодорхой тусгаж өгсөн. Үүнд: "Холбооны улс төрийн харилцааг зохицуулж буй, эсхүл холбооны эрх зүйн асуудлыг хөндөж буй олон улсын гэрээний хувьд холбогдох хууль эрх зүйн байгууллагуудын зөвшөөрөл, эсхүл оролцоо шаардлагатай бөгөөд үүний дараагаар тухайн гэрээг Германы хуульд нэгтгэн хэрэглэх (инкорпораци) бөгөөд, чингэхдээ холбооны хуулиас давуу биш, ижил түвшинд хэрэглэнэ" хэмээн заажээ.

Франц улсын хувьд олон улсын гэрээг соёрхон батлахгүйгээр, зөвхөн хууль гарган үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил хэрэглэдэг бөгөөд хууль гаргах ёстой олон улсын гэрээнд санхүүгийн харилцаа үүсгэж буй худалдааны гэрээ, дотоодын хууль тогтоомж болон хувь хүний статусыг хөндөж буй гэрээг хамруулдаг байна. Гэхдээ, Францын Үндсэн хуулийн 55 дугаар зүйлд зарим нэг олон улсын гэрээний тодорхой заалтууд нь дотоодын хууль тогтоомжоос давуу эрхтэй байж болно хэмээн заасан байдаг.

Манай хойд хөрш ОХУ шинэ Үндсэн хуулиа 1993 онд баталсан бөгөөд Үндсэн хуулийн 86 дугаар зүйлийн дагуу "Ерөнхийлөгч олон улсын гэрээг хэлэлцэх, түүнд гарын үсэг зурах, Соёрхон батлсан баримт бичигт гарын үсэг зурах" эрхтэй бөгөөд 106 дугаар зүйлийн дагуу Холбооны Зөвлөл нь Думын батлсан Соёрхон батлах, эсхүл цуцлах ёстой олон улсын гэрээг заавал хянан үзэх шаардлагатай байдаг. Үндсэн хуулийн шүүх нь мөн хүчин төгөлдөр болоогүй олон улсын гэрээг Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг хянах, хэрэв Үндсэн хуультай зөрчилдөж байна хэмээн үзвэл хүчин төгөлдөр болоход хориг тавих эрхтэй. ОХУ-ын Үндсэн хуулийн 15 дугаар зүйлийн 4-т "Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд ба хэм хэмжээ болон ОХУ-ын олон улсын гэрээг түүний эрх зүйн системийн нэгэн хэсэг хэмээн үзнэ. Хэрэв ОХУ-ын олон улсын гэрээ нь хууль тогтоомжид зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг хэрэглэнэ" хэмээн заасан байдаг нь олон улсын зан заншлын эрх зүй болон гэрээний эрх зүйг ОХУ-ын дотоодын хууль тогтоомжоос илүү эрхтэй байхаар тодорхой зааж өгсөн байна.

Энэ бүгдээс үзвэл, олон улсын гэрээг дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэхдээ, дэлхийн улс орнууд Үндсэн хуулийн болон бусад механизмаар ямар нэг "босго" тавьсан байдаг бөгөөд тухайн "босгоны өндөр нам" -ын асуудал яригдахаас бус огт "босго"–гүй байх асуудал нь олон улсын эрх зүйн практикт бараг байхгүй юм.

Монгол Улс олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжид хэрхэн нийцүүлж, хэрэглэж байгаа тухай

Монгол Улс Эзэн богд Чингисийн үеэс хууль эрх зүйг хүндэтгэн дээдэлж, олон улсын эрх зүйн үндсийг тавьсан төрт ёсны түүхэн уламжлалтай билээ. Нэг намын тогтолцоо ноёрхож байсан он жилүүдэд намын шийдвэрийг бишрэн шүтэж, олон улсын эрх зүйн зарим үндсэн хэм хэмжээг "хөрөнгөтний үзэл суртал" хэмээн шүүмжилж, хэрэгжүүлэх ажлыг хойш тавьж байснаар манай улсын олон улсын эрх зүйн хөгжилд зарим ухралт гарч байсан нь түүхэн үнэн юм.

Олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэх асуудлыг манай улс олон улсын практикт хэрэглэдэг дуалист буюу трансформаци хандлагаар шийдсэн байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3–т заахдаа "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ." гэсэн нь бид Үндсэн хуулийн механизмаар олон улсын гэрээнд тодорхой "босго" тавьж, шүүж байж тухайн гэрээг дотоодын хууль тогтоомжтой нэгэн адил хэрэглэх, эс хэрэглэхээ шийднэ гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын шүүх зөвхөн ийм олон улсын гэрээ, хэлэлцээрийг шүүн таслах ажиллагаандаа баримт болгон ашиглах болно гэсэн үг.

Монгол Улс ардчилал, зах зээлийн замыг сонгож, шинэ ардчилсан Үндсэн хууль баталснаар олон улсын гэрээг хэрэглэх, түүнийг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэх эрх зүйн зохицуулалтыг шинээр нээж, хуульчлан баталгаажуулсан билээ.

Дээр дурдсан Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд мөн "олон улсын эрх зүйн нийтээр зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх, олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх тухай" заалтууд тусгагдсан. "Үндсэн хуульд харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй" гэдгээ ч хуульчлан баталгаажуулсан.

Олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжоос давамгайлах хүчинтэй байдаг. Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцийн 27 дугаар зүйлд зааснаар гэрээнд оролцогч улс гүрэн "гэрээ биелүүлээгүй явдлаа дотоодын хууль тогтоомжийн заалтаар зөвтгөж үл болно" гэжээ. Энэхүү зарчмын дагуу үндэсний хууль тогтоомж нь олон улсын гэрээний заалттай нийцсэн байх ёстой. Гэхдээ тэдгээрийн хоорондаливаа зөрүү гарвал олон улсын гэрээг дагаж мөрддөг. Үүнтэй холбогдуулан олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжоос давуу эрхтэй хэмээн үзэж, хэрэглэж болох талаар нилээд олон хуульд зааж өгсөн байдаг. Тухайлбал, 2005 оны байдлаар Монгол Улсын Их Хурал 369 хууль батласны 190 орчим хуульд олон улсын гэрээнд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө гэж заасан тухай судалгаа байдаг.

Өөрөөр хэлбэл, олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжоос давуу эрхтэй хэмээн үзэж, хэрэглэх талаар дотоодын хууль тогтоомжид хуульчилж өгсөн. Энэ нь дээр дурдсан Австрийн эрдэмтэн

Кельзений онол билээ. Үүнээс үзэхэд Монгол Улсын үндэсний хууль тогтоомжийн заалт түүний нэгдэн орсон гэрээний заалтаас зөрвөл олон улсын гэрээнийхийг нь дээдлэн баримталдаг практик дэлгэрч байна гэж үзэж болохоор. Энэ нь олон улсын гэрээний хэм хэмжээг түгээмэл үйлчлэлтэй болгох, олон улсын эрх зүйн дэг журмыг бататгахад чухал ач холбогдолтой юм.

Өнөөгийн байдлаар 200 орчим олон талт гэрээ, конвенцийн оролцогч болж, 2000 гаруй хоёр талын хэлэлцээр байгуулаад байгаа манай улс байгуулсан гэрээ, хэлэлцээрээ өөртөө ашигтайгаар хэрэгжүүлэх талаар учир дутагдалтай байгаа. Одоогийн байдлаар 116 орчим олон улсын гэрээ, конвенцийн албан ёсны орчуулгыг хийж, Улсын Их Хурлын Тамгын газар, Гадаад хэргийн яамнаас хамтран олон улсын гэрээний 6 боть тусгай эмхэтгэл болгон хэвлэн нийтэлж, дотоодын хууль хяналтын байгууллага, шүүгч, өмгөөлөгчид түгээх ажлыг гүйцэтгэж байна. Энэхүү эмхэтгэлийг гаргаснаар түүнд багтсан гэрээ, конвенцийг хэрэглэх боломж нээгдэж байгаа. Гэвч зарим үлдсэн гэрээ, конвенц албан ёсны орчуулгатайгаар гараагүй байгаа нь тэдгээрийг хэрэглэхэд хүндрэл үүсгэсээр байна.

Нөгөө талаас өнөөгийн практикт олон улсын гэрээг соёрхон батлахдаа дотоодын ямар хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг хамтад нь оруулж байгаагүй. Зөвхөн тухайн гэрээг соёрхон батлах асуудлыг оруулдаг нь нэг талаас өрөөсгөл бөгөөд нөгөө талаас олон улсын гэрээг дотоодын хууль тогтоомжтой нийцүүлэн дагаж мөрдөх асуудлыг орхигдуулсан хэрэг юм. Манай улс олон улсын гэрээг соёрхон баталж, дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилж эхэлсний дараа ямар хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж байгаа. Үүний нэг тод жишээ бол Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн заалтуудтай нийцүүлэх ажлыг хийх ажлын хэсгийг ХЗДХЯ-нд байгуулан ажиллаж байгаа явдал юм. Гэвч энэ ажил нэлээд цаг хугацаа шаардаж байгаа нь мэдээж. Цаашид олон улсын гэрээг соёрхон батлахдаа ямар хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хамтад нь оруулж байх талаар ГХЯ, ХЗДХЯ нягт хамтран ажиллах нь зүйтэй байна.

Цаашлаад, аливаа олон улсын гэрээг дагаж, мөрдөж буй эсэхэд байнгын хяналт тавьдаг механизмыг төлөвшүүлэх, ОУГ-тэй уялдуулж дотоодын хууль тогтоомжидоо тухай бүр нь нэмэлт, өөрчлөлт оруулж байх, УИХ-аар батлах гэж буй хуулийг ОУГ-ний хэм хэмжээтэй нийцүүлэн гаргаж байхыг зүй ёсоор шаардаж байна.

Одоогийн байдлаар ОУГ-г биелүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих, парламентаас батлан гаргаж буй хуулийг ОУГ-ний заалттай нийцүүлэх зэрэг ажилд учир дутагдал нэлээд байна. ОУГ-ний тухай хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар ОУГ-гээр хүлээсэн үүргийн биелэлтийг яам, тусгай газар хангана гэж заажээ. Зарим гэрээний биелэлт 10 - 15 хувьтай л байдаг. Гарын үсэг зураад гэрээгээ мартдаг. Төлөөлөгч солилцох, хүн сургах, тусламж авах зэрэгтэй холбогдсон тодорхой заалт, зүйл ангийн хэрэгжилтэд анхааралд бусдыг нь хэрэгжүүлэхэд анхаардаггүй. Тэр ч байтугай өөрийн төлөөлөгчөө илгээх заалтад анхааралд нөгөө талаас авах төлөөлөгчийг хүлээн авахаас аль болохоор зайлсхийдэг. Энэ бол түгээмэл зүйл.

ОУГ-нд хяналт тавих талаар ОУГ-ний тухай хуулийн 20 дугаар зүйлд тодорхой заасан байгаа. УИХ соёрхон баталсан ОУГ, шаардлагатай гэж үзсэн аливаа гэрээний хэрэгжилтэд, Засгийн газар өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар байгуулсан ОУГ-ний хэрэгжилтэд хяналт тавина. Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга ОУГ -ний биелэлтийг жил бүрийн 6, 12 дугаар сарын 20-ны дотор гаргаж ГХЯ -нд ирүүлж байх бөгөөд ГХЯ биелэлтийн явцыг нэгтгэн дүгнэж шаардлагатай тохиолдолд Засгийн газарт оруулж хэлэлцүүлнэ. Хуулийн энэ чухал заалт бараг хэрэгжихгүй байгаа болов уу гэж бодож байна. Хууль батлагдаад 10 жил болж байхад ОУГ-ний биелэлтийн асуудлыг УИХ -аар авч хэлэлцсэн гэж сонсоогүй юм байна. Харин тодорхой зарим гэрээний хэрэгжилтийн асуудлыг (зээл, тусламжийн холбогдолтой гэрээ) Засгийн газраар хэлэлцсэн байдаг.

Ер нь ОУГ-г биелүүлэх, түүний хэрэгжилтэд хяналт тавих асуудал сулавтар байгаатай холбогдуулж санал болгоход:


1. ОУГ-г практикт өргөн хэрэглэх шаардлагатай хүмүүст нь хүргэж таниулах ажлыг өргөн зохион байгуулах. Тухайлбал, хүний эрхтэй холбогдолтой олон талт гэрээ, конвенц, хоёр талын хэлэлцээр (эрхийн туслалцааны гэрээ, консулын конвенц г.м.) -ийг ялангуяа шүүгчид, цагдаагийн болон хууль хяналтын байгууллагын ажилтнуудад нарийвчлан таниулах зорилгоор семинар, ярилцлагыг өргөн зохиож байх,

2. ОУГ -ний тухай хууль хүчин төгөлдөр болсноос хойш 10 жил болж байгаа боловч ОУГ-ний биелэлтэд хяналт тавих түүний заалт хэрэгжихгүй байгаа шалтгааныг холбогдох байгууллага судалж, санал боловсруулах,

3. Монгол Улсын одоо үйлчилж буй хуулиуд ОУГ-тэй хэрхэн нийцэж байгаад холбогдох байгууллагууд мэргэжлийн түвшинд нарийвчилсан судалгаа хийж, дүнг УИХ-д танилцуулах зэрэг ажлыг хийх нь зүйтэй юм.

Олон улсын гэрээг үндэсний шүүхэд хэрэглэх асуудалд

(хэрэгцээ, олон улсын практик, заншил, жишиг)



ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан
Б.Гүнбилэг

Орчин үеийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжлийн дэлхийн түвшний дэргэд балчираараа байгаа Монголын өнөөгийн эрх зүйг хөгжүүлэхэд олон улсын гэрээ, заншил, жишгийг шүүхэд хэрэглэж сурах явдал нэн чухал юм. Үүний хажуугаар олон улсын гэрээг хэрэглэж дадахад заншлын болон жишгийн эрх зүйг хэрэглэх практикийг судлах шаардлага өндөр байна. Учир нь, Монгол Улсын хувьд зөвхөн парламентаар баталсан акт буюу статутыг хэрэглэхэд нэлээд ач холбогдол өгч бусад эрх зүйн эх сурвалжийг бодит байдал дээр үгүйсгэх, түүнийг хэрэглэх явдлыг орхигдуулах байдал илт мэдрэгдэж байгаа юм.

ХЗҮТ-өөс шүүгчдийн дунд хийсэн судалгаанаас харахад олон улсын гэрээг хэрэглэх явдал тун дутуу, дулимаг байгаа ба шүүгчид мэдэхгүй буюу мэдээлэлгүйгээс, албан ёсоор олон улсын гэрээг хэвлэдэггүйгээс[1] шалтгаалан олон улсын гэрээг хэрэглэж чаддаггүй байна. Олон улсын гэрээ, заншил, жишгийн эрх зүйг хэрэглэж чадахгүй байгааг дүгнэн үзэж, учир шалтгааныг тайлан олохыг эрмэлзвээс:

1. Шүүгчид эдгээрийг ашиглах мэдлэг хомс буюу хуулиас бусад эрх зүйн эх сурвалжийн талаарх мэдээлэл олгох давтан сургалтанд хамрагдаж чаддаггүй;

2. Олон улсын гэрээгүйгээр дотоодын хууль тогтоомжоо ашиглан яаж ийгэд хэргийг шийдвэрлэдэг;

3. Өмгөөлөгчид болон бусад хуульчид, иргэдийн олон улсын эрх зүйн талаарх мэдлэг хомс тул шүүх хурал дээр олон улсын гэрээ ба заншил, жишгийг хэрэглэх талаар бодит санал дэвшүүлж чаддаггүй;

4. Олон улсын гэрээг албан ёсоор тэр бүр хэвлэж шүүгч нарт тараадаггүй;

5. Олон улсын гэрээг хэвлэж тараасан боловч тэдгээрийг уншиж ойлгох мэдлэг хомс байдаг. Наад зах нь олон улсын гэрээнд ашигласан латин нэр томъёо, олон улсын эрх зүйн ердийн нэр томъёог уншиж ойлгож мэддэггүй;

6. Олон улсын гэрээг орчуулж хэвлэсэн ч орчуулга нь ойлгомж муутай, буруу орчуулсан байх явдал цөөнгүй байдгаас эрх зүйн эх сурвалж болгон хэрэглэх шаардлагыг хангадаггүй;

7. Хуулиас бусад эх сурвалжийг яаж хэрэглэх талаар ямар ч заавар, зөвлөмж, эрдэм шинжилгээний бодит ажил байдаггүй;

8. Эрдэмтэд, судлаачид энэ талаар судлахыг эрмэлзэвч материаллаг бааз суурь боломж тааруугаас шалтгаалан дорвитой судалгаа хийж чаддаггүй зэрэг шалтгаан урган гарна.

Эдгээрийг нийтэд нь дүгнэж үзвэл олон улсын гэрээнд нэгдэн орж, соёрхон баталж буй ч Монгол Улсын төрийн зохих байгууллагууд Монгол Улсын олон улсын гэрээнүүдийг хэрэглэх, сурталчлах, хэрэгжүүлэх талаарх үүргээ орхигдуулж, олон улсын гэрээ, бусад бичиг баримтыг хэлбэрийн төдий "дүр эсгэлт" мэтээр хүлээн авч, хэрэглэж сурсантай холбон ойлгож болох юм. Мөн нөгөө талаас Монгол Улсын эдийн засгийн ядуурал, боломж хомс байдлаар бүхнийг тайлбарлаж, олон улсын нийгэмлэгээс олон улсын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, шахаж шаардах явдал тун бага үзэгдэж байна.

Төр болон олон улсын нийгэмлэгийн энэ эс үйлдэл, идэвхгүй байдалд дулдуйдан Монголын хуульчид өөрсдөө "сул зогсолт" хийн, улсынхаа эрх зүйн хөгжлийг хойш нь чангааж байна гэж хэлж болно. Энэ талаар Японы профессор Моригава Ясутомогийн хэлснээр "хуульчдын ажил эрхлэлт, ёс зүйн тухайд шүүгч, прокурорууд хангамж, өмгөөлөгчдийн ажил эрхлэлтийн эдийн засгийн үндэс суурийг цэгцэлж чадвал бусад нь өдөр тутмын үйл явцаараа зохицуулагдаж болох мэт санагдаж болох ч бодит байдалд тийм биш юм[2]" гэжээ. Өөрөөр хэлбэл, хэдий эдийн засгийн бааз суурийн хувьд дутуу дулимаг ч гэлээ, ажил мэргэжилдээ үнэнч, хамгийн гол нь бүтээлч хандлагыг бий болгох хүсэл эрмэлзэлтэй байж, эх орныхоо эрх зүйн тогтолцоог хөгжүүлж, хамгийн гол нь шударга ёсыг хамгаалж чадах юм.

Хэрэв хуульчид, нэн ялангуяа өмгөөлөгчид аливаа хэрэг шүүх ажиллагаанд олон улсын болоод жишиг, заншлын эрх зүйн зохицуулалтуудыг түлхүү ашиглан үйлчлүүлэгчдийнхээ байр суурийг хамгаалж, өөрийн талд давуу

[1] Монгол Улсын олон улсын гэрээг "Төрийн мэдээлэл" сэтгүүл дээр хэвлэж эхлээд байна.

[2] Моригава Ясутомо "Хуульчийн ёс зүй", УБ., 2006, 6 дахь тал

байдлыг бий болгож чадах юм бол, эс бөгөөс тэдгээрийг хэрэглэхээр санал оруулах юм бол шүүгч болон прокурор хүссэн, хүсээгүй хуулиас бусад эх сурвалжийг хэрэглэхээр уншиж, судалж, мэдээлэл авах зайлшгүй шаардлагатай болно. Угаас шүүх үйл ажиллагааг явуулах нь шүүгчийн үндсэн үүрэг юм. Шүүгч нь нийгмийн тухайн харилцааг зохицуулах зохицуулалтыг "манай улсын парламент хараахан гаргаагүй байна, би мэдэхгүй юм байна" гэх буюу "энэ зохицуулалт, олон улсын гэрээ, заншил, жишгийн эрх зүйн зохицуулалтыг тэр шүүгч илүү сайн мэднэ, би шийдэж чадахгүй. Энэ хууль, гэрээний зүйл, заалтыг Дээд шүүх албан ёсоор тайлбарлаагүй" гэх мэтчилэнгээр хэргийг шийдвэрлэхээс татгалзах, улмаар "хойш суух, доошоо малтаж" болохгүй юм. Тэгэхээр хууль хяналтын бүхий л байгууллагуудын ажилчид хүссэн, хүсээгүй олон улсын гэрээ, заншил, жишгийн эрх зүйг судлах шаардлагатай болж таарна. Үүнд хамгийн ихээр нөлөөлж чадах хүмүүс бол өмгөөлөгчид гэдэг нь гарцаагүй.

Өмгөөлөгчдийн энэхүү үүргээс гадна шүүгч, прокурор болон бусад хууль, хяналтын байгууллагын ажилчдын оролцоо манай улсын эрх зүйн хөгжлийг хурдасгахад нэн чухал юм. Аливаа хуулийн байгууллагын ажилтан хууль хэрэгжүүлэх, хэрэглэх үйл явцдаа бусдаас хараат бус байдаг. Хараат бус байна гэдэг аливаа улс төр, захиргааны албан тушаалтны хөндлөнгийн дарамт шахалтаас хөндий гагцхүү эрх зүйд захирагдах үйл явц мөн бөгөөд үүний хажуугаар эрхэлсэн ажилдаа мэргэжлийн хуульчийн хувьд хараат бус байх ойлголт багтдаг. Энэ нь юу гэсэн үг вэ? гэхээр эзэмшсэн мэргэжилдээ үнэнч байж, байнга өөрийгөө хөгжүүлж, мэдлэгээ тэлж байх гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, нийгмийн хөгжлийн хурдацыг даган өөрийгөө боловсруулах зорилго тавих бус харин нийгмийг жолоодогч хүчин болох боловсролтой эрх зүйч байхын тулд нийгмээс өмнө түрүүлж гишгэн, улсынхаа эрх зүйн чиг хандлагыг урьдчилан харж, дотоодын эрх зүйн зохицуулагдаагүй харилцааг зохицуулахын төлөө ажиллаж чаддаг байх хэрэгтэй. Харин энэ үйл явцад дээр дурдсан олон улсын гэрээ, заншил, жишиг, эрдэмтэн, судлаачдын бүтээлийг цаг алдалгүй олон дахин уншиж, танин мэдэж, хэрэглэх нь үнэхээрийн чухал билээ.

Энэ логикийн үндсэн дээр хуульчид тэр дундаа шүүгч, өмгөөлөгчдийн оролцоотойгоор олон улсын гэрээ, заншил ба жишгийн эрх зүйг монголд жинхэнэ утгаар нь хэрэглэж, хөгжүүлж болох юм.

Олон улсын гэрээ, заншил, жишгийн эрх зүйг шүүхэд хэрэглэх эрх зүйн үндэс хэдийнээ батлагдсан юм. Гадаад улсын хууль, заншил, жишгийн эрх зүйг хэрэглэж болох талаар Иргэний хуулийн 540 дүгээр зүйлд тодорхой заасан байдаг[1] бол олон улсын гэрээг хэрэглэх талаар Үндсэн хууль, бусад хуульд тодорхой зохицуулалт бий. Одоогоор хүчин төгөлдөр үйлчилж буй 341 хуулийн 140 гаруй нь "Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө" гэх заалт агуулах бөгөөд энэ нь Монгол Улс олон улсын эрх зүйн давуу хүчинтэй байх хандлага баримталдгийг нотолж байна[2].

Олон улсын гэрээг үндэсний шүүхэд хэрэглэх практик. Аливаа улс орон бүр тухайн олон улсын гэрээг хүлээн зөвшөөрч, өөрийн дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хэрэглэхийн тулд ямар үр дүн гарах вэ гэдэг талаар нэн түрүүнд авч үздэг. Улс бүр өөрийн эрх зүйн тогтолцоо, улс төрийн байр суурьнаас шалтгаалж, олон улсын гэрээг үндэсний шүүхэд хэрэглэх асуудал янз бүр тавигддаг.

Гадаад орнуудын туршлагаас харахад тухайн орны Дээд шүүх буюу холбогдох байгууллагуудаас олон улсын гэрээг хэрэглэх талаар удирдамж гаргасан байдаг. Тухайлбал, ОХУ-ын Дээд шүүх 2003 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн тогтоолоор "Нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээ, ОХУ-ын Олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх тухай" зааж өгчээ. Үүнд "ОХУ-ын Олон улсын гэрээний тухай Холбооны хуулийн 3 дугаар бүлгийн 5 дугаар зүйлийн дагуу албан ёсоор хэвлэгдсэн ОХУ-ын олон улсын гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой дотоодын хэм хэмжээ батлан гаргах шаардлагагүй бол ОХУ-д шууд үйлчилнэ" гэзэд "ОХУ-ын олон улсын гэрээг хэрэглэх боломжгүй нөхцөл байдал бий болсон гэрээнд оролцогч улсууд өөрсдийн дотоодын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах үүрэг хүлээдэг" гэсэн байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хууль болон Олон улсын гэрээний тухай хуулийн зарчимтай ижил утгатай юм.

• Мөн үндэсний "шүүх олон улсын гэрээ болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ тайлбарлахад бэрхшээлтэй бол шүүх нь Олон улсын байгууллагын шийдвэр, ялангуяа НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын шийдвэр, ОХУ-ын гадаад хэргийн яам, ОХУ-ын хууль зүйн яамны эрх зүйн департаментаас гаргасан шийдвэрийг удирдлага болгож болно гэж зөвлөж байна" хэмээн уг тогтоолд дурджээ. Энэ зөвлөмжийн нэгэн адил утгатай зөвлөмжийг Монгол Улсын дээд шүүх тогтоолоороо бататгаж өгөх шаардлагатай юм. Нөгөө талаас Монгол Улсын аль ч шатны шүүх үүнтэй адил тогтоолыг Дээд шүүх нь гаргасан эсэхээс үл хамааран Монгол Улсын Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тухайн харилцааг зохицуулсан нэмэлт зохицуулалт, мэдээлэл, зөвлөмжийг авах эрх, үүрэгтэй гэдгийг энд дурдууштай. Өөрөөр хэлбэл, олон улсын гэрээ, нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын хэм хэмжээг хэрэглэх тохиолдолд өөрт байхгүй мэдээллээ дээрх байгууллагуудаас лавлах эрх нээлттэй, нөгөө талаас эдгээр байгууллагууд нь мэдээллээр хангах үүрэгтэй юм. ГХЯ, ХЗДХЯ өөрт байхгүй мэдээлэлтэй холбогдох хүсэлт шүүхээс ирвэл олон улсын

[1] Энэ талаар Б.Гүнбилэг, А.Төмөр, "Харьцуулсан эрх зүй", УБ., 2005. номын 54-55 дахь талаас дэлгэрүүлж уншина уу.

[2] М.Мөнхбат, "Үндэсний шүүхэд олон улсын эрх зүйг хэрэглэх асуудал", "Хууль дээдлэх ёс сэтгүүл", 2005, №4, 65 тал. Олон улсын гэрээг үндэсний шүүхэд хэрэглэх талаарх асуудлыг уг сэтгүүлээс дэлгэрүүлж уншина уу.

байгууллагад хандан уг мэдээлэл, зөвлөмж, тайлбарыг гаргаж авсны үндсэн дээр шүүхийг мэдээллээр хангах ёстой билээ.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүрэлдэхүүний шинжийг илэрхийлсэн олон улсын гэрээг шүүхэд шууд хэрэглэж болохгүй боловч ийм төрлийн гэрээгээр улсуудыг уг гэрээнд заасан зүйлийг дотоодын хууль тогтоомжийн дагуу тодорхой гэмт хэрэгт ял ногдуулах замаар хэрэгжүүлэхийг шууд үүрэг болгодог /жишээлбэл, 1961 оны Мансууруулах бодисын эсрэг Нэгдсэн конвенци, 1979 оны Хүн барьцаалахын эсрэг олон улсын конвенци, 1970 оны Хууль бусаар агаарын хөлгийг барьцаалахтай тэмцэх тухай конвенци/[1]. Иймээс манай улсын эрүү, эрүүгийн байцаан шийтгэх хуулиудаар зохицуулагдаагүй байгаа хэрнээ Монгол Улсын олон улсын гэрээгээр үүрэг болгосон хэм хэмжээг УИХ нэн даруй хэлэлцэж үндэсний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ёстой юм. Харин нэмэлт, өөрчлөлт оруулах тухай мэдээллийг шүүх, хуулийн байгууллага, хуульчид, хууль тогтоогчид уламжлах үүрэгтэй байдаг.

АНУ-ын шүүх тухайн олон улсын гэрээний агуулга, хэрэглэх орчноос шалтгаалж олон улсын гэрээг "шууд хэрэглэх", мөн "шууд бус хэрэглэх" гэж хоёр хуваан хэрэглэдэг.

Онолын хувьд "шууд хэрэглэх" гэрээг парламентаар баталсан ямар нэг хуульгүйгээр шууд хэрэглэх ёстой юм. Тухайлбал, Иргэний ба улс төрийн эрхийн Пакт нь "*Хүн бүр ... эрхтэй*" хэмээн шууд зааж өгсөн байдаг учраас ямар нэг нэмэлт хууль батлах, түүнийг баталгаажуулах шаардлагагүйгээр ямар ч үед хүний иргэний ба улс төрийн эрхийг хүлээн зөвшөөрч, хамгаалах үүднээс уг пактыг шүүх шууд хэрэглэх учиртай. Харин эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Пактад "Нэгдэн орогч улсууд ... үүрэгтэй" хэмээн зааж өгдөг учраас тухайн үүргийг хэрэгжүүлэх үүднээс улс, гүрнүүд өөрийнхөө үүргийг хэрхэн биелүүлэх талаар нэмэлт хууль батлан гаргадаг.

Гэтэл АНУ-ын хувьд Иргэний ба улс төрийн эрхийн пактыг хүлээн зөвшөөрөхдөө, өөрийн улсын зүгээс тайлбар хийж, пактыг шүүхэд хэрэглэх бус, заавал тусгайлан хууль баталж байж, түүгээр дамжин хуулийн хүчин чадлыг нь хүлээн зөвшөөрөхөөр заасан юм. АНУ-ын Үндсэн хууль ёсоор Сенатын гуравны хоёрын хүлээн зөвшөөрсөн олон улсын гэрээг АНУ-ын олон улсын гэрээ гэж үздэг. Нөгөөтэйгүүр, Ерөнхийлөгч Конгресст олон улсын гэрээг танилцуулж, конгрессын олонхи түүнийг хүлээн зөвшөөрвөл "конгрессоор дэмжигдсэн шууд хэрэглэх" хүчин чадалтай гэрээ болдог. Тухайлбал, Умард Америкийн Чөлөөт Худалдааны Гэрээ (North American Free Trade Agreement- NAFTA) ба АНУ-ын худалдааны ихэнх гэрээнүүд энэ ангилалд багтдаг[2].

Олон улсын pacta sund servanda (пактыг хүлээн зөвшөөрөх ёстой гэсэн утгатай латин үг) номлолын хүрээнд АНУ-ын хууль нь олон улсын гэрээнд нийцэх ёстой боловч, АНУ-ын улс төрчид нэгдэн орсон олон улсын гэрээний дараа тухайн асуудлаар дахин хууль гаргавал он, цагийн хувьд сүүлд гаргасан хуулиа дагаж мөрдөнө гэж үзэх явдал бий. Мөн адилаар хууль баталсны дараа олон улсын гэрээг соёрхон батлавал өмнө нь баталсан хууль хүчингүй болно гэж үздэг. Өөрөөр хэлбэл, АНУ-д олон улсын гэрээ, хууль хоёр нэг хүчин чадалтай гэж хэлж болно.

ХБНГУ-ын шүүхэд олон улсын гэрээ нь дотоодын хуулийн нэгэн адил хүчинтэйгээр хэрэглэгддэг. Зарим тохиолдолд ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх энэ талаар үүрэгчилсэн хэм хэмжээ тогтоож өгдөг байна. Тухайлбал, ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх нь Европын Холбооны Хүний Эрхийн шүүхийн шийдвэрийг Үндсэн хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэгтэй[3] харшлаагүй тохиолдолд дотоодын шүүхэд эх сурвалж болгон хэрэглэх үүргийг ХБНГУ-ын бүх шатны шүүхэд үүрэг болгон өгсөн байна[4].

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д зааснаар "хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх" талаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулдаг. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг буюу "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ" гэсэн заалттай зөрчилдэж байгаа юм. Учир нь, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасан Монгол Улсын олон улсын гэрээ гэдэг нь Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу "Монгол Улс, Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас гадаадын нэг буюу хэд хэдэн улс, тэдгээрийн Засгийн газар, олон улсын байгууллагатай тодорхой асуудлаар харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон тогтоосон, олон улсын эрх зүйгээр зохицуулагдах хоёр буюу олон талын бичгээр үйлдсэн тохиролцоо" юм. Энд өнгөрсөн цаг дээр нэгэнт үйлдсэн гэрээний тухай ярьж байна. *Үйлдсэн* гэдэг үгийг *үйлдэх* гэдэг үгийн өнгөрсөн цаг гэж ойлговол нэгэнт хийгдсэн гэрээний тухай өгүүлж байна гэсэн үг. Харин нэгэнт хийгдсэн гэрээний хувьд Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээний тухай 1969 оны Венийн

[1] ОХУ-ын Дээд шүүхийн /зөвлөлийн, пленум/ тогтоол № 5., Москва, 2003 оны 10 дугаар сарын 10., Нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээ, ОХУ-ын Олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх тухай. 6 дугаар хэсэг.

[2] http://en.wikipedia.org/wiki/International_treaty -аас ишлэв. (хамгийн сүүлд 2006 оны 10 сарын 17-нд зочилсон).

[3] ХБНГУ-ын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлийн 3-т "Хууль тогтоогч нь Үндсэн хуульд захирагдах ба гүйцэтгэх ба шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч нь хууль ба эрх зүйд захирагдана" гэж өргөн цар хүрээтэйгээр заасан байна. Энд хууль буюу Gesetz ба эрх зүй буюуRecht гэсэн хоёр үг хоёулаа орсон байгаа юм. Өөрөөр хэлбэл, зөвхөн хууль гэдэг үгээр төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагааг чөдөрлөж өгөөгүй.

[4] http://www.bundesverfassungsgericht.de/en/decisions/rk20050405_1bvr166404en.html-аас ишлэв. (хамгийн сүүлд 2006 оны 10 сарын 17-нд зочилсон).

конвенцийн[1] *pacta sund servanda*[2] зарчмыг хүлээн зөвшөөрсөн учир уг конвенцийн 26 дугаар зүйл буюу pacta sund servanda-д зааснаар "аливаа гэрээ нь түүнд нэгдэн орсон талуудын хувьд заавал биелэгдэх хүчин чадалтай бөгөөд уг гэрээг талууд итгэл үнэмшилтэйгээр дагаж мөрдөнө" гэж заасан байдаг.

Олон улсын эрх зүйг, тэр дундаа олон улсын гэрээний эрх зүйн талаар хөндөхөд заавал олон улсын заншлын эрх зүйн талаар дурдаж байх ёстой юм. Харамсалтай нь, Монгол Улсын хувьд олон улсын заншлын эрх зүйн талаар дорвитой судалгаа хийгдээгүй, ном зохиол, бүтээл, сурах бичиггүйн улмаас энэ асуудлыг хамгийн эцсийн шатанд тавих буюу өндөр ач холбогдол өгөхгүй байгаа нь анзаарагдаж байна. Олон улсын эрх зүйд гэрээнд заасан үүргээ биелүүлэх буюу гэрээг зөрчихгүй байх үүрэг нь олон улсын заншлын эрх зүйн дагуу зохицуулагддаг. Олон улсын гэрээг хичнээн дагаж мөрдөх талаар ярьж байвч, эцсийн бүлэгт түүнийг зөрчвөл ямар механизмаар хариуцлага тооцдог талаар ойлголт үгүйгээс өнөөгийн Монголын эрх зүйн тогтолцоонд олон улсын гэрээг хэрэглэх явдал нэн хоцрогдож байна гэж хэлж болно. Энэ нь ч аргагүй юм. Аливаа эрх зүйн эх сурвалж амьдралд хэрэгжихэд түүнийг хамгаалж байдаг механизм байх ёстой. Түүнийг ямар механизм хамгаалж байгаа нь тодорхойгүй учраас монголчууд бидний ярьдгаар "Хууль бол гууль. Гууль юм чинь гурван өдрийн настай" болж таарч байгаа юм. Хуулийг гууль гэж нэрлэдэг бол хуулиас маш бага үр нөлөө үзүүлж буй олон улсын гэрээ нь түүнээс хавьгүй дор нэр хүндтэй байна.

Олон улсын гэрээ ба олон улсын эрх зүйн заншил. Олон улсын заншлын талаар тогтсон зарим ойлголт байх ч, зарим тохиолдолд түүнтэй санал нийлэхгүй явдлууд гардаг. Тийм учраас олон улсын заншил нь зарим нэг тохиолдолд энх тайван тогтоох арга хэрэгсэл, эс бөгөөс дайн, дажины эхлэл болдог байна.

Хуулийг төрөлжүүлсэн системчлэл нь тодорхой бүс нутгийн заншлыг нутгийн хуульчид аажмаар нэгтгэн бичих ажлын үр дүнд бий болсон юм. Эдгээр заншлыг нийтээр хүлээн зөвшөөрсөн ба нийгмийн гишүүдийн харилцааг зохицуулах хууль зүйн хүчин чадалтай байв. Олон улсын түвшинд улс хоорондын дипломат буюу хүчирхийллийн аль ч харилцааны дүнд үүссэн хэм хэмжээг олон улсын заншил буюу заншлын эрх зүй гэнэ. Олон улсын заншлыг улс орнууд шаардлагатай бол олон улсын гэрээ байгуулан өөрчилж болох боловч зарим заншлыг өөрчилж болохгүй. Жишээ нь, боолчлол, геноцидыг хориглох зэрэг хүний эрхийн хэм хэмжээ агуулсан зарим заншил өөрчлөгдөх буюу шинэчлэгдэх боломжгүй юм. Олон улсын гэрээнүүд урьд өмнө үйлчилж байсан заншлуудыг аль болох төрөлжүүлэн эмхэтгэхийг зорьдог.[3]

Заншлыг хүмүүс хүлээн зөвшөөрч, нийтээр дагаж мөрдөж байгаа нь ямар нэг эзэн хаан, эсвэл эрх мэдэлт субьектын шахаж шаардсанаас айсан буюу албадсаны үр дүн биш бөгөөд олон нийтэд тэр зохицуулалт үгүйлэгдсэн, нийгэмд тэр заншил бий болох урьдач нөхцөл буюу хэрэгцээ аль хэдий нь бий болсон учраас хүмүүст таалагдаж өөр хоорондынхоо харилцаанд зохицуулалт болгон хэрэглэж байгаа юм.[4]

"Олон Улсын эрх зүйн эх сурвалжийн гол хоёр хэсэг нь нэгдүгээрт, гэрээ, хоёрдугаарт, олон улсын заншил байдаг... Хэрэв олон улсын заншлыг улс орнууд зөрчвөл нэг бол дайн дэгдэх эсвэл олон улсын эрх зүйн дагуу гомдол гаргах эрх нээгддэг"[5] билээ. Тиймээс олон улсын заншлын эрх зүйг судлах, түүнтэй танилцах, мэдэх улмаар амьдралд хууль хэрэглэх үйл явцад заавал хэрэглэж байх ёстой юм.

Олон Улсын шүүхийн дүрэмд "хууль мэт хүлээн зөвшөөрөгдсөн туршлагын нотолгоог заншил гэнэ[6]" гэжээ. Заншил нь өөртөө улсын туршлага ба opinio juris гэсэн хоёр элементийг агуулдаг байна[7]. Улсын туршлага гэдэг тодорхой болсон үйл явдлын давтамж бол opinio juris[8] гэдэг нь хуулийн тухай санал, үзэл гэж хэлж болно. Х.Виктор Кондэгийн тодорхойлсноор opinio juris буюу хуулийн тухай санал гэдэг нь тухайн улсын олон улсын тавцан дээр олон улсын эрх зүйн дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэж байна гэсэн үзлээр үйлдсэн үйлдлийн сэтгэл зүйн элемент юм. Энэ нь хүндэтгэл үзүүлэх, хэрэгцээ, зохистой гэсэн үндэслэлтэй холбоогүй ба олон улсын заншлын эрх зүйн нэгээхэн хэсэг бөгөөд хүний эрхийн эрх зүйн хэм хэмжээний нэгэн төрөл, субьектив шинжтэй элемент байдаг[9].

Америкийн Нэгдсэн Улс "Хууль зүйн үүргээ шударгаар биелүүлэх зорилгоор улс гүрнүүдийн дагаж мөрдөж буй нийтлэг тогтвортой практикийг Олон Улсын Заншлын эрх зүй гэнэ"[10] гэж томъёолжээ.

Лон Фуллерийн бичсэнээр "заншлаар тогтоосон эрх, үүргийн харилцан хамаарал нь нэгдүгээрт, эрх зүйн харилцаанд оролцогч талуудын сайн дурын үндсэн дээр хүлээн зөвшөөрөгдөх,

[1] Тус конвенцид манай улс 1988 онд нэгдэн орсон.
[2] Нэгэнт тохиролцсон гэрээ нь заавал биелэгдэх хүчин чадалтай байна гэсэн утгатай латин үг.
[3] http://en.wikipedia.org/wiki/Customary_law-аас ишлэв. (хамгийн сүүлд 2005 оны 12 сарын 11-нд зочилсон).
[4] Bruce Benson's The Enterprise of Law, Extracted by Mark Sulkowski, The Enterprise of Law: Justice Without the State by Bruce Benson. pp 12-15 http://jim.com/custom.htm -аас ишлэв. (хамгийн сүүлд 2005 оны 12 сарын 11-нд зочилсон).
[5] JACK L. GOLDSMITH, ERICK A. POSNER., "A THEORY OF CUSTOMARY NTERNATIONAL LAW"., Chi. L. Rev. 1113 (1999)
[6] Олон улсын Шүүхийн дүрэм, 38(1)(b)
[7] North Sea Continental Shelf (FRG/Den.;FRG/Neth.), 1969 ICJ Rep. 3, 44 (Feb. 20)
[8] Opinio iuris [opinio iuris sive necessitatis; эрх буюу үүргээ мэдэх]. Олон улсын заншлын эрх зүйд хамаарах terminus technicus (мэргэжлийн үг) олон улсын эрх зүйн этгээдүүдийн тодорхой асуудал, хэргүүд дээр туулж өнгөрөсөн туршлагууд нь заавал дагаж мөрдөх хүчин чадалтай болж хувирсан хэмээх итгэл. Эрх зүйн толь. Р.Батхүүгийн тайлбар. http://asuult.net/erkhzui/toli.html-аас ишлэв. (хамгийн сүүлд 2005 оны 12 сарын 11-нд зочилсон).
[9] Х.Виктор Кондэ "Хүний эрхийн олон улсын нэр томъёоны гарын авлага", УБ., 2002, 118 дахь тал
[10] Restatement (Third) of the Foreign Relations Law of the United States, Article 102(2) (ALI 1987)

хоёрдугаарт, талууд тэгш эрхтэй байх, гуравдугаарт, хэнд ч, ямар ч үед тохиолдож болохоор, өөрөөр хэлбэл, өнөөдөр чи уг харилцаанд орсноор чамд хохиролтой байж болох ч, маргааш чамд ашигтай байх шударга ёсны зарчимд тулгуурласан байдаг"[1].


Заншлын эрх зүй нь улс хоорондын харилцаанд өргөнөөр мөрдөгдөх ба тэдний практикаас бүрдэнэ. Улс орнууд тухайн заншлыг хууль зүйн хувьд хүчин чадалтай хэмээн итгэж байх үед оршдог[2]. Зарим тодорхойлолтод зөвхөн олон улсын гэрээнд заншлын хэм хэмжээг хоёрдагч эх сурвалж болгох маягаар хэрэглэдэг гэж бичсэн байна[3].

Заншлын эрх зүйн тухай тодорхойлолтуудыг ерөнхийд нь нэгтгэн дүгнэвэл обьектив талаасаа практик, байнгын давтамжтай байх ёстой бол субьектив талаасаа түүний хүчин чадлыг нь хүлээн зөвшөөрсөн итгэл байх ёстой юм. Өөрөөр хэлбэл, Олон Улсын шүүхийн дүрэмд заасан нөхцлүүд заншлыг тодорхойлох ерөнхий нөхцлүүдийг эмхэтгэн тодорхойлжээ гэж хэлж болно.

Олон улсын заншлын эрх зүйн судалгаагаар мэргэшсэн профессор Д'Амато[4]: "Олон улсын эрх зүйчид өөрсдийн байр сууриа хамгаалахын тулд бараг тааралдсан бүх эх сурвалжаа эрх зүйн эх сурвалжид тооцох боллоо. Энэ байдлыг шүүмжлэгчид төдийлөн үл ойшоож, хоосон гоё үг мэт хүлээн авч байна... Олон улсын эрх зүйгээс бусад салбарт ажиллаж буй бидний хамтран зүтгэгчид хууль, шүүхийн жишигт үндэслэн үйл ажиллагаагаа явуулдаг. Заншил гэдэг бол тэдний хувьд маш хачин, этгээд зүйл мэт харагддаг..."[5] гэж хэлсэн байдаг. Түүний хэлснээс үзэхэд олон улсын эрх зүйн бүх харилцааг гэрээгээр зохицуулж чаддаггүй ба ихэнх тохиолдолд олон улсын заншлын эрх зүй нь зохицуулалтын хэрэгсэл болдгийг харж болно. Мөн олон улсын эрх зүйчид өөрийн байр суурийг хамгаалахын тулд төдийлөн олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөөгүй номлол, зарчмуудыг заншлын эрх зүй мэтээр батлахыг оролдох тохиолдол байдаг аж.

Харин Монгол Улсын хувьд өдийг болтол заншил хэмээх ойлголтыг тодорхойлсон тодорхойлолт алга байна. Иймээс хууль тогтоогч түүнийг тодорхойлсон хууль, Дээд шүүх заншлын эрх зүйг тодорхойлсон практик зөвлөмж мөн гаргах шаардлагатай юм.

Дүгнэлт. Олон улсын гэрээг үндэсний шүүхэд хэрэглэх асуудлыг авч үзэхдээ зөвхөн Монгол Улсын олон улсын гэрээний тухай ярих бус мөн олон нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, заншил, шүүхийн жишгийг бүхэлд нь судлах шаардлагатай юм. Мөн Монгол Улсын дээд шүүх Олон Улсын гэрээг үндэсний шүүхэд хэрэглэх талаар зөвлөмж гаргахдаа тухайн олон улсын гэрээнүүдийг чухал, чухал бус буюу нэгдүгээрт нэн түрүүн хэрэглэх, хоёрдугаарт харгалзан үзэх гэх мэтээр ангилах боломжгүй учраас ерөнхийд нь зөвлөсөн шинжтэй зөвлөмж гаргах хэрэгтэй гэж үзэж байна. Ингэхдээ дээр өгүүлсэнчлэн заншил, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, олон улсын гэрээг шүүхэд хэрэглэсэн олон улсын практик, жишгийн талаар дурдах нь зүйтэй юм. ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн адил тухайн олон улсын гэрээг хэрэгжүүлж байгаа шүүх байгууллагын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, үндэсний шүүхэд шууд хэрэглэх хүчин чадалтай болгон хэм хэмжээ тогтоож ч болох юм.



[1] Bruce Benson's The Enterprise of Law, Extracted by Mark Sulkowski, The Enterprise of Law: Justice Without the State by Bruce Benson. pp 12-15 http://jim.com/custom.htm -аас ишлэв. (хамгийн сүүлд 2005 оны 12 сарын 11-нд зочилсон).

[2] http://www.saskschools.ca/curr_content/law30/international/internationalvocab/vocab.html -аас ишлэв. (хамгийн сүүлд 2005 оны 12 сарын 11-нд зочилсон).

[3] http://www.hfienberg.com/irtheory/intlawdefinitions.html-аас ишлэв. (хамгийн сүүлд 2005 оны 12 сарын 11-нд зочилсон).

[4] Норфвестерний Их Сургуулийн профессор. 1988 оны 4 сарын 22-нд болсон "Олон Улсын Заншлын эрх зүйн онол" сэдэвт семинарт удирдагчаар оролцсон.

[5] THE THEORY OF CUSTOMARY INTERNATIONAL LAW, 82 American Society of International Law Proceedings 242 (1988) (Code A88f) p 1.

Олон улсын эрх зүйн зохицуулалтад Монгол Улсын оролцоог өргөтгөх нь

ГХЯ-ны Гэрээ, эрх зүйн газрын зөвлөх,
олон улсын эрх зүйч Г.Сэсээр

Монгол Улс Эзэн богд Чингисын үеэс хууль, эрх зүйг хүндэтгэн дээдэлж, олон улсын эрх зүйн үндсийг тавьсан төрт ёсны түүхэн уламжлалтай билээ. Нэг намын тогтолцоо ноёрхож байсан он жилүүдэд намын шийдвэрийг бишрэн шүтэж, олон улсын эрх зүйн зарим үндсэн хэм хэмжээг "хөрөнгөтний үзэл суртал" хэмээн шүүмжилж, хэрэгжүүлэх ажлыг хойш тавьж байснаар олон улсын эрх зүйн хөгжилд зарим ухралт гарсан нь бас л түүхэн үнэн юм.

Монгол Улс ардчилал, эх зээлийн замыг сонгож, шинэ ардчилсан Үндсэн хууль баталснаар олон улсын эрх зүйн зохицуулалтад оролцох Монгол Улсын оролцоог шинээр нээж, хуульчлан баталгаажуулсан билээ.

Монгол Улсын бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөө, төрийн байгуулал, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага, Үндсэн хуулийн хяналтын тогтолцоог олон улсын эрх зүйд бүрнээ нийцүүлэн хуульчилсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд олон улсын эрх зүйн нийтээр зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх, олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх тухай заалтууд тусгагдсан.

Үндсэн хуульд харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй гэдгээ ч хуульчлан баталгаажуулсан.

Үндсэн хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд баталж гаргасан анхны хуулиудын нэгэнд Гэрээний эрх зүйн тухай Монгол Улсын хуулийг баталсан. Өөрөөр хэлбэл, олон улсын эрх зүйн зохицуулалтад оролцох Монгол Улсын эрх зүйн үндэс бүрдэж, боломж нээгдсэн гэсэн үг.

Аливаа улс, бүс нутгийн олон улсын эрх зүйн зохицуулалтад амжилттай оролцохын үндэс нь өөрийн орны эрх ашиг, тодруулж хэлбэл хэрэгцээ, шаардлагаа зөв тогтоож, тэдгээрт нийцсэн бодлого, үйл ажиллагаа явуулах ёстой.

Эрх зүйн үндэс бүрдэж, боломж нээгдсэн ч бодит байдалд дүгнэлт хийж, эрх ашиг, хэрэгцээ, шаардлагаа зөв тодорхойлж, тэдгээрт нийцсэн үйл ажиллагаа явуулах нь монголын хуульчид, ялангуяа олон улсын хуульчдын эн тэргүүний зорилт юм.

Дайн, энх, улс гүрний аюулгүй байдал, зэвсэг хураах, цөмийн зэвсгийг хорогдуулах, олон улсын худалдааны дэг журам тогтоох, хүрээлэн буй орчныг хамгаалах, далайн эрх зүй зэрэг даяаршлын шинжтэй улс төрийн яриа хэлэлцээгээр шийдэгдэх асуудлуудыг НҮБ, олон улсын бусад байгууллагын хүрээнд шийдсээр ирсэн билээ.

Цөмийн зэвсэгтэй хоёр том гүрний дунд оршдог, цөмийн зэвсэггүй жижиг улсын хувьд Монгол Улс цөмийн зэвсгээс ангид байх статусаа хоёр хөрш, цөмийн зэвсэгтэй гүрнүүдээр хүлээн зөвшөөрүүлсэн нь өөрийн орны аюулгүй байдлын амин чухал эрх ашгийг олон улсын эрх зүйгээр хамгаалах чиглэлд хийсэн томоохон ажил болсон билээ. Одоо холбогдох талуудтай олон улсын гэрээ байгуулж, хуульчлан баталгаажуулах ёстой.

Монгол Улсын санаачилгаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 52 дугаар чуулганаар эдийн засаг, нийгэм, улс төрийн болон бусад хүчин зүйлээс үл хамааран бүх улс гүрний тусгаар тогтносон бүрэн эрхийг хамгаалах, бусдын дотоод хэрэгт үл оролцох нөхцөлийг бүрдүүлэх, улс бүр олон улсын эрх зүйгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх боломжийг дээшлүүлэх, аливаа улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улс төрийн тусгаар тогтнолд аюул занал учруулах, ийнхүү аюул занал учруулахаар айлган сүрдүүлэхээс татгалзах, олон улсын эрх зүйн зарчмыг зөрчин хүч хэрэглэх буюу хэрэглэхээр сүрдүүлэх замаар байгуулсан аливаа хэлэлцээр хүчингүй байх, улс орнуудын хамтын ажиллагааны боломжийг дээшлүүлэх, маргааныг эв зүйгээр шийдвэрлэх зэрэг олон улсын хэлэлцээ явуулах зарчим, чиглэлийг тусгасан тогтоол баталсан нь Монгол Улсын олон улсын эрх зүйн хөгжилд оруулсан томоохон хувь нэмэр болсон билээ.

Монгол Улсын олон улсын эрх зүйн салбарт хийгдсэн ийм наашгай үр дүн олныг дурдаж болох боловч өнөөгийн байдлаар 200 орчим олон талт гэрээ, конвенцийн оролцогч болж, 2000 гаруй хоёр талын хэлэлцээр байгуулаад байгаа манай улс байгуулсан гэрээ, хэлэлцээрээ өөртөө ашигтайгаар хэрэгжүүлэх, нэг ёсондоо "чулуу болгох" талаар учир дутагдалтай байгаад өнөөдөр та бид анхаарлаа хандуулж, ярилцан тодорхой арга хэмжээний санал дэвшүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Далайд гарцгүй улсуудын дамжин өнгөрөх худалдааны тухай конвенц 1965 онд хүчин төгөлдөр болж, Далайн эрхийн болон ТИР-ийн конвенцуудаар баталгаажсан боловч Монгол Улсын далайд гарцгүй, газар зүйн тааламжгүй байршлын улмаас гарах нэмэлт зардал бусад сөрөг үр дагаврыг арилгахын тулд дамжин өнгөрөх хөрш ОХУ, БНХАУ-тай дамжин өнгөрөх тээврийн тухай хэлэлцээр байгуулах хэлэлцээ олон жил явагдаж, хэлэлцээрийн хавсралтаа тохирч чадахгүй байгаа нь далайд гарцтай, их гүрнүүдийн эрх ашигт хөтлөгдсөөр буйн нэг жишээ юм.

Дэлхий нийтийн анхаарлын төвд байгаа нийтлэг асуудлаар идэвхтэй байр суурь баримталж, хөгжлийн төвшин, газар зүйн

байршил, байгаль цаг уурын ижил төстэй улсуудад дэмжлэг үзүүлж, эрх ашгаа нэгтгэн хамгаалах, жин нэмэх талаар үргэлжлүүлэн ажиллах нь тодорхой.

Монгол Улсын хоёр болон олон талт гэрээ, хэлэлцээрт төрийн, төрийн бус байгууллагууд, иргэний нийгэм, хуулийн болон хувь этгээд, иргэдийн эрх ашгийг хамгаалсан олон сайхан заалт бий.

Олон улсын эрх зүйн зохицуулалтад Монгол Улсын оролцоог өргөтгөх асуудлын хүрээнд өнөөдөр миний бие нэгэнт нэгдэн орж, байгуулаад байгаа Монгол Улсын гэрээний манай улс, байгууллага, иргэдийн эрх ашгийг хамгаалсан хэм хэмжээг хэрхэн үр дүнтэй ашиглаж болох талаар зарим нэг санааг Та бүхний сонорт хүргэх зорилт тавилаа.

Олон улсын харилцаанд жин багатай жижиг улсын хувьд олон улсын эрх зүйн оролцоогоо нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлсэн шинэ гэрээ, хэлэлцээр байгуулах хэрэгцээ, шаардлагыг бүтээлчээр судлахын зэрэгцээ нэгэнт нэгдэж орсон олон талт хэлэлцээр, байгуулсан хоёр талт хэлэлцээрээсээ эрэлхийлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

Монголын төрийн байгууллагууд, иргэний нийгэм, хувийн хэвшил, мэргэжлийн байгууллага, мэрэгжилтнүүдийн зүгээс байгууллага, иргэдийн олон улсын эрх зүйн хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангахад бодитойгоор тусалж чадаж байна уу гэдэг асуулт зүй ёсоор гарч, үгүй, яагаад гэсэн хариулт аяндаа дагалдана.

Монгол Улсын олон улсын гэрээний тухай хуульд хэвлэн нийтэлж, нийтийн хүртээл болгож байх тухай заалт орсны дагуу Улсын Их Хурлын Тамгын газар, Гадаад хэргийн яамнаас хамтран олон улсын гэрээний эмхтгэл гаргаж байгаа ч хэрэгтэй байгууллага, хүндээ хүрэх, түүнийг бүрэн хэмжээгээр олох, ойлгож хэрэглэхэд хүндрэл гарсаар байна.

Өөрөөр хэлбэл, олон улсын эрх зүйн тодорхой хэм хэмжээг сурталчлан таниулах ажил хэрэгцээ, шаардлагатай шатанд хүрч, бодитой, үр дүнтэй хийгдэж чадахгүй байгаа билээ.

Олон улсын эрх зүйн хэм хэмжээг түүвэрлэх, судлах, хэрэгтэй эзэнд нь ойлгуулах сурталчлан таниулах, цаашид байгуулах, нэгдэн орох гэрээ, хэлэлцээрийн шаардлага, хэрэгцээг оновчтой тодорхойлохын тулд дараах чиглэлээр ажиллах боломжтой гэж үзэж байна:

1. Ямар байгууллага, иргэнд ямар заалт хэрэгтэй, түүнийг хэрхэн зөв ашиглах талаар сурталчилгаа, зааварчлага дутагдаж байна. Гадаад орнуудад олон улсын эрх зүй, олон улсын эрх зүйн тодорхой хэм хэмжээг сурталчлан таниулах төрийн үүргийг хяналтын үндсэн дээр хувийн хэвшилд шилжүүлсэн туршлага элбэг байдаг. Үүнийг өргөнөөр ашиглах боломж манайд ч бий.

Жишээлэхэд, хувь хүний улс төр, эдийн засаг, бизнес, хувийн эрх, эрх чөлөөний талаар олон улсын эрх зүйн ямар хэмжээ байгаа, түүнийг хэрхэн ашиглаж болох талаар мэргэжлийн өндөр төвшинд тайлбарлан таниулсан лавлагаа, гарын авлага шаардлагатай гэсэн үг.

Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний төв зэрэг мэргэжлийн байгууллагууд материалаар ханган, эрх зүйн орчныг нь бүрдүүлэх, ерөнхий чиглэл өгөхөөс хэтэрч чадахгүй нь тодорхой. Олон улсын эрх зүйн хичээл заадаг, сургалт, судалгаа явуулдаг их сургуулиуд маш том хүч юм. Тэдний хүчийг оновчтой, үр бүтээлтэй ажиллах хэрэгтэй.

2. Олон улсын эрх зүйн тодорхой салбар, хэм хэмжээг сурталчлан таниулах талаар жижиг төсөл хэрэгжүүлж болох юм. Гэхдээ төсөлд дулдуйдах үе өнгөрч байгаа учир олон улсын эрх зүйг сурталчлан таниулах, Монгол Улсын олон улсын эрх зүйн оролцоог нэмэгдүүлэх, олон улсын эрх зүйгээс "ихийг олж" авахад цаашдаа хувийн хэвшлийн хүчийг зөв зохистой ашиглахад онцгой анхаарах цаг болсон.

3. Олон улсын эрх зүйг сурталчлан таниулахад шүүх, арбитрын практик, өмгөөлөгчид, хувийн хэвшилд ажиллаж буй олон улсын хуульчдын хүчийг ашиглах, тэдэнд төрийн болон мэргэжлийн байгууллагаас туслах ажлыг зохистой хэлбэрээр зохион байгуулахад анхаарах нь зүйтэй.

4. Тодорхой хэм хэмжээний лавлагаа, тайлбар, гарын авлагын талаар мэргэжлийн хүмүүсийн дунд уралдаан зарлаж, шалгаруулан худалдаж авдаг гадаад орнуудын туршлагыг хэрэглэх боломжтой.

5. Төр засгийн болон төрийн бус байгууллагууд өөрийн төлөвлөгөө, төсөвт олон улсын эрх зүйн холбогдох хэм хэмжээг сурталчлах арга хэмжээг тусгах боломжтой.

6. Монгол Улсын олон улсын гэрээний шаардлага, хэрэгцээний талаар төрийн, төрийн бус байгууллага, аймаг, орон нутаг, иргэний нийгмийн тодорхой төлөөлөл, хувийн хэвшил, ард иргэдийн дунд судалгаа хийж, түүний үр дүнг үндэслэн олон улсын гэрээний бодлогыг тодорхойлж, хэлэлцээ хийж, хэлэлцээр байгуулдаг туршлага ч байдгийг хэрэглэх боломжтой.

7. Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хууль олон улсын эрх зүйн хэм хэмжээг сурталчлан таниулах, хэрэгцээ, шаардлагыг судлах, мониторинг хийх чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага зүй ёсоор гарч байгааг анхаарах хэрэгтэй.

Миний дэвшүүлж буй дээрх саналуудыг Та бүхэн шүүн тунгааж, авах, гээхийн ухаанаар хандана гэж найдаж байна.

ХЯТАД УЛСЫН ГАЗРЫН ЭРХИЙН ДҮРМИЙН ОДООГИЙН БАЙДАЛ ХИЙГЭЭД ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛ

Нэг. Хятад улсын хэрэгжүүлж байгаа газрын эрхийн үндсэн тогтолцоо

Хятад улс газрыг нийтэд өмчлүүлэх дүрмийг хэрэгжүүлж, газрыг хувьдаа өмчлөхийг эрс цаазлаж байдаг. Энэ талаар дэлхийн улс гүрэн өөр өөр бодлого баримталдаг. "Үндсэн хууль"-ийн 10 дугаар зүйлийн тогтоолд: "Хятадын газар нь улсад өмчлөгдөнө, хөдөө тосгон хийгээд хотын дүүргийн газар нь хуульд улсад өмчлүүлэхээр ашид заасныг гаргавал бүр хамт нийтэд өмчлөгдөнө. Орон сууцны газар хийгээд хувьдаа үлдээсэн газар, хувьдаа үлдээсэн уул нь ч хамтад өмчлөгдөнө". "Газрын хамааралтын хууль"-ийн 2 дугаар зүйлийн тогтоолоор, "Бүгд Найрамдах Хятад Ард Улс нь газрын нийгэм журамт нийтийн өмчлөлийг хэрэгжүүлнэ. Даруй ард нийтийн өмчлөлийн дүрэм хийгээд хөдөлмөрчин түмний хамтын өмчлөлийг хэрэгжүүлнэ" гэж заасан.

Газрын нийтийн өмчлөлийн суурин дээр, улсын газар өмчлөх эрх хийгээд хамт нийтийн газар өмчлөх эрх нь зэрэгцэн оршиж байдаг. Нийтийн өмчлөлийн шинж чанартай газар өмчлөх эрхийг зах зээл дээр чөлөөтэй гүйлгээнд оруулж болдоггүй. Нийгэм журамт зах, дэлгүүрийн аж ахуйн байгууламжийг алгуур аажмаар бүрэлдүүлэхийг дагалдан, хувь цогцос газар ашиглах байдал бүрэлдэж, үүнээс болж олон зүйлийн газар хэрэглэх эрх үүссэн байна. Газар хэрэглэх эрх бол нэгэн зүйлийн хувь эрх мөн. Үүнээс нь хятад улсын газар ашиглах ба газар арилжаалах эрхийн суурь , газрын эрхийн үндсэн тогтолцоо бүрэлдсэн байна.

(Нэг) Газар өмчлөх дүрэм

Хятад улсын газар өмчлөх дүрэм нь улсын газар өмчлөх эрх хийгээд хамт нийтийн газар өмчлөх эрх зэрэгцэн оршихоор илэрч байдаг.



Хятад улсын Өвөрмонголын Их сургуулийн Хууль судлалын дээд сургуулийн дэд профессор Хайтан

1. Улсын газар өмчлөх эрх: Хятад улсын "Газрын хамааралтын хууль"-ийн 2 дугаар зүйлийн тогтоолоор: "Улсын газрыг бүх иргэдэд өмчлүүлнэ, даруй улсын газрын өмчлөх эрхийг төрийн явдлын хүрээнээс улсыг төлөөлөн хэрэгжүүлнэ." Гэвч бодит үйлдэл дунд, төрийн явдлын хороо нь газар өмчлөх эрх ба шууд хэрэгжүүлэхийн аргагүй тул эл шатны орон нутгийн ардын засгийн ордон голдуу хот, Саюуны ардын засгийн ордныг ч түүний газрын хамааралтыг салаа мөчрөөс тухай эрхийг баттай хэрэгжүүлж хууль ёсоор дээд шатны ардын засгийн ордонд зөвшөөрүүлж түүнд зохих хэмжээний газрын ашиг шимийг тушаадаг.

2. Хамт нийтийн газар өмчлөх эрх: "Газрын хамааралтын хууль"-ийн 10 дугаар зүйлийн тогтоолоор, хөдөө тосгоны тариачдын хамт нийтэд өмчлөгдөх газар нь ердөө тосгоны тариачдын хамт нийтэд өмчлөгдөж, тосгоны хамт нийтийн аж ахуйн зохион байгуулалт буюу тосгоны ардын зөвлөлөөс хамаардаг.

(Хоёр) Газар эрхлэх дүрэм

1. Улсын газрыг эрхлэх эрх

1980-аад оны сүүлч, 1990-ээд оны эхээр Хятад улсын гадагш нээлттэй төрийн бодлого хэрэгжүүлэхийг дагалдан шинэ газар эрхлэх дүрэм бүрэлдсэн байна. Тэр нь Хятад улсад газрыг төлбөртэй эрхлэх дүрэм бий болгосныг илтгэж, газар хангах дүрэмд үндсэн хувиралт гарсны шинж тэмдэг болсон байна.

Төлөвлөгөөт аж ахуйн байгууламжид, улсын өмчлөл бүхий газрыг төрийн байгууллага, аж ахуй, ажил үйлсийн нэгжээс засаг захиргааны хуваарилалтын хэлбэрээр өнө удаан үнэ төлбөргүй хэрэглэсээр ирсэн байна. Үүний үр дүнд улсын өмчлөл бүхий газар нь үр бүтээмжгүй ашиглагдах буюу газар шороо эх баялаг хүнд ноцтой бүрэлгэн суйтгэгдсэн байдал илэрсэн байна. Ийм байдлын дор, 1990-ээд оноос улсын өмчлөл бүхий газрыг төлбертэй хэрэглэж эхэлсэн нь Хятад улсын газрын дүрэм дэх нэгэн том чухал өөрчлөлт болсон.

Улсын газар эрхлэх эрхийг олох зорилго нь голдуу гэр орон сууцыг бүтээн байгуулахад оршино. Энэ эрхийг олох арга замд засаг захиргааны хуваарилалт эрхийг гаргаж өгөх болон шилжүүлэн өгөх гурван зүйлийн хэлбэр байдаг. **Засаг захиргааны хуваарилалт** гэдэг нь үнэ төлбөргүйгээр улсын өмчлөл дэх газрыг эрхлэхийг зааж буй. Голдуу цэргийн явдал, төрийн байгууллага, сурган хүмүүжил зэрэг зорилтоор энэхүү газрыг эрхэлдэг. Засаг захиргааны хуваарилалтын хэлбэрээр олсон улсын өмчлөл дэх газрыг эрхлэх эрхийг зарчим дээрээ дахин шилжүүлж болохгүй. Хэрэв шилжүүлэхэд хүрвэл, эрхбиш зөвшөөрлийн эрх бүхий ардын засгийн ордоноор зөвшөөрүүлж, шилжүүлэн авсан этгээдээс хууль ёсоор газар эрхлэх эрхийг гаргаж авах төлбөр мөнгийг улсад тушаах хэрэгтэй.

Одоо улсын өмчлөл дэх газар өмчлөх эрхийг олох хэлбэрт төлбөртэй гаргаж өгөх болон шилжүүлэн өгөх нь зонхилох тоог эзлэж байна. **Газар эрхлэх эрхийг гаргаж авах** гэдэг нь улсаас улсын өмчлөл дэх газар эрхлэх эрх ба зохих хугацаагаар газар эрхлэх этгээдэд өгч, газар хэрэглэгчээс улсад газар эрхлэх эрхийн төлбөр мөнгө өгөх хэлбэрийг зааж байна. Газар эрхлэх эрхийг гаргаж өгөхөөс болж нэгдүгээр тэсийн газрын зах дэлгүүр бий болсон байна. Гаргаж өгөх хэлбэрт ердөө хэлэлцээрээр гаргаж өгөх, зарлан худалдахаар гаргаж өгөх болон үнэ хаялцуулан гаргаж өгөх зэрэг гурван зүйл байдаг. Хэлэлцээрээр гаргаж өгөхөөс болсон улсын өмчлөл дэх хүнд ноцтой алдаж сүйтгэх үзэгдлээс сэргийлэхийн төлөө, хуулинд хэрэв улсын өмчлөл дэх газар эрхлэх нь худалдаа, зугаа цэнгэлийн зориулалттай бол эрх биш үнэ хаялцуулах, зарлан худалдах хэлбэрийг тохируулан хэрэглэх хэрэгтэй гэж тогтоожээ.

Газар эрхлэх эрхийг шилжүүлэн өгөх гэдэг нь газар хэрэглэгч нь өөрийн газар эрхлэх эрхээ дахин гуравдагч этгээдэд шилжүүлэн өгөхийг зааж байна. Үүнд, худалдаалах, солилцох болон бэлэглэхийг багтаана. Ердөө газар эрхлэх эрхийг гаргаж өгснөөс болж бүрэлдсэн газрын зах дэлгүүрийг газрын нэгдүгээр тэсийн зах дэлгүүр хэмээн нэрийдэж, улсаас ганцаар эзэмшин эзэгнэдэг. Газрын нэгдүгээр тэсийн зах, дэлгүүрийг дамжин олсон газар эрхлэх эрх ба дахин шилжүүлэн өгснөөс болж бүрэлдсэн газрын зах дэлгүүрийг газрын хоёрдугаар тэсийн зах, дэлгүүр гэдэг. Хуулиас газар эрхлэх эрхийг шилжүүлэн өгөхэд тун чанга хязгаарлалттай байдаг. Тухайлбал, газар эрхлэх эрхийг гаргаж өгөх хэрд тогтоосон хугацаа болон нөхцөлөөр газрыг нээн ашиглахгүй. Бэлэн оруулахгүй байсан бол газар хэрэглэх эрхийг шилжүүлэн өгч болохгүй. Одоо хуулийн тогтоолоор газар хэрэглэх эрхийг шилжүүлэн өгөхөд эрх биш доорхи нөхцөлийг хангах ёстой. 1. Газар хэрэглэх эрхийг шилжүүлэн өгөхдөө эрх биш уул газар эрхлэх эрхийг гаргаж өгөх үед тогтоосон эрх үүргийн хэмжээнд байх ёстой. Иргэн дээрх газар хэрэглэх эрхийг гаргаж өгөх хэрд тогтоосон газрын зориулалтыг өөрчилж болохгүй. 2. Газар хэрэглэх эрхийг гаргаж өгөх үед тогтоосон ёсоор, газар хэрэглэгч нь нэгэнт газар хэрэглэх эрхийг гаргаж өгөх бүхий төлбөр мөнгийг төлж барсан мөртлөө газар хэрэглэх эрхийн гэрч бичгийг гардаж авсан байх ёстой. 3. Газар хэрэглэх эрхийг гаргаж өгөх үед тохиролцсоноор, газар нь барилга байшин барих зориулалттай байвал, бэл оруулан нээн ашиглах мөртлөө бэл оруулалтын хэмжээ нь бүх бэл оруулалтын 25 хувиас дээш байх хэрэгтэй. Хэрэв газрыг зохих хэмжээнд хэвшсэн маягаар нээн ашиглахад хүрвэл газрыг заавал аж үйлдвэрийн зориулалттай газар буюу бусад барилга байгууламжийн зориулалтын газрын нөхцөлийг бүрэлдүүлсэн байх ёстой. Газар хэрэглэх эрхийг шилжүүлэн өгөхийг зохих хэмжээгээр хязгаарлах нь гэр газар хөрөнгийн зах, дэлгүүрийг тогтворжуулж, улсын өмчлөл дэх хөрөнгийн алдагдал гээгдэж, гэр газар хөрөнгийн зах зээлийн хөрслөг байдлыг сэргийлэхэд чухал ач холбогдолтой юм.

2. Орон сууцны газар эрхлэх эрх

Орон сууцны газар хэрэглэх эрх олохын зорилго нь иргэн гэр байшин барьж, өмчлөлийн эрх эдлэхэд оршино. Тэр нь улсын өмчлөл дэх газар буюу хамт нийтийн өмчлөл дэх газар дээр өргөдөл гаргаж хянан зөвшөөрүүлэх журмаар олгогддог. Орон сууцны газар эрхлэх эрх нь шилжүүлэх, барьцаалахыг зөвшөөрөхгүй боловч өв залгамжлахыг зөвшөөрдөг.

3. Газрыг дагаажилан эзэгнэх эрх

Газрыг дагаажилан эзэгнэх эрх гэдэг нь хөдөө тосгоны хамт нийтийн зохион байгуулалтын гишүүн нь хамт нийтийн зохион байгуулалттай ба дагаажилан эзэгнэх үед тогтоосноор олсон, тариа тарих, мал маллах, мод тарих зэрэг тариалан, мал аж ахуйн зориулалттайгаар газрыг эзэмшиж, хэрэглэж, ашиглах эрхийг заадаг. Иргэд хүмүүс газрыг дагаажилан эзэгнэх эрх ба хууль ёсоор шилжүүлэн дагаажилуулах, түрээслүүлэх, солилцох, шилжүүлэн өгөх буюу бусад хэлбэрээр гүйлгээнд оруулж болдог. Гэвч шилжүүлэн өгөхдөө эрх биш дагаажилуулагчийн зөвшөөрлийг олох хэрэгтэй. Үүнээс гадна "дөрвөн атар"-ын дагаажилан эзэгнэх эрхийг хууль ёсоор шилжүүлэн өгөх, түрээслүүлэх, хувь оруулах, барьцаалах буюу бусад хэлбэрээр гүйлгээнд оруулж болно.

Хоёр. Хятад улсын газрын эрхийн дүрэмд оршиж байгаа гол асуудлууд

Нэг. Улсын газрын өмчлөх эрх болон хамт нийтийн газар өмчлөх эрхийн байр суурь нь эрх тэгш бус байдаг.

Хятад улсад улсын газар өмчлөх эрх болон хамт нийтийн газар өмчлөх эрх зэрэгцэн орших дүрмийг хэрэгжүүлдэг. Улсаас хамт нийтэд өмчлөгдөх газрыг татварлан хэрэглэх дүрмээр дамжин улсын өмчлөлд оруулж болдог. Гэвч хамт нийт нь улсын өмчлөл дэх газрыг хамт нийтийн өмчлөлд оруулж болохгүй. Хоёр зүйлийн өмчлөлийн эрхийн байр суурийн эрх тэгш бус байдал нь газар татварлан хэрэглэх дүрэмд томбойн илэрч байдаг. Газар татварлан эрхлэх дүрмийг үндэслэн, улсаас газар татварлан эрхлэхээр дамжин хамт нийтийн өмчлөлийн эрхийг үгүйсгэж, үүний зэрэгцээгээр бас улсын газар хэрэглэх эрх нь хамт нийтийн газар хэрэглэх эрхийг үгүйсгэсэн үр дүн авчирсан байна. Өөрөөр хэлбэл, улсаас хамт нийтийн өмчлөгдөх газрыг татварлан хэрэглэсний дараа хотын газар хэрэглэгчид тушаан өгч, үүний зэрэгцээгээр хөдөө тосгоны хамт нийтийн зохион байгуулалт болон тариачдын газраа алдах байдал зөндөө илэрдэг. Үүний үр дүнд, хөдөө тосгоны газрын эх сурвалж нь хотын гэр газар хөрөнгийн зах дэлгүүрт шилжин орж, засгийн ордон хийгээд хотын аж үйлдвэр худалдаачдын ашиг шимийг нь хүртээгээд тариачдын эрх ашиг үрэгддэг.

Хоёр. Улсын хамт нийтийн газрыг татварлан хэрэглэх үндэслэлийн зааг хязгаар нь тодорхой бус байна. "Газрын хамааралтын хууль"-ийн 2 дугаар зүйлийн тогтоолоор "Улсаас нийгэм нийтийн ашиг тусын хэрэгцээнээс болж хууль ёсоор хамт нийтийн өмчлөлд байгаа газрыг татварлан хэрэглэж болно". Гэвч "Нийгэм нийтийн ашиг тус" нь чухам ямар вэ? Түүний хэмжээ болон зааг хязгаар

нь хэр зэрэг гэснийг тодорхой бодит болгоогүй. Иймээс бодит үйлдлийн дунд их хэмжээний худалдааны ажил үйлс нь нийгэм нийтийн ашиг тусын нэрийг зүүж газрыг татварлан хэрэглэх үзэгдэл найдвартай оршиж байдаг.

Гурав. Газар татварлан хэрэглэх дүрэмд газар татварлан хэрэглэхээс болсон татварын нөхвөр мөнгөний баримжаа нь хэтэрхий доор байж, газрын үнэнхүү өртөгийг тусгаж дийлэхгүй байдал оршиж байна.

Газар татварлан хэрэглэснээс болсон татварын нөхвөр мөнгийг тухайн газрыг татварлан хэрэглэхээс өмнөх 3 жилийн тариалангийн гаралтын дундаж тоогоор боддог. Гэвч засгийн ордноос газрыг татварласны дараа, тэр газар нь барилга байгууламжийн хэрэглээний газар болон хувирч газрын үнэ нь хэд дахин цаашилбал хэдэн арван дахинаар нэмэгддэг. Газрын үнэ нэмэгдсэнээс олсон ашиг шим нь бүр засгийн ордон болон гэр газар хөрөнгийг нээн ашигласан худалдаачдын гарт орж, тариачид ямар ч ашиг хүртэж дийлэхгүй байдаг. Газар татварлан хэрэглэсний явцад тариачид зөвхөн нүдний өмнөх тариалангийн ашиг шимээ алдахаас гадна бас ирээдүй дэх оршин тогтнох үндсэн бодлогоо алдаж байдаг. Иймээс газраа алдсан тариачид хот орж ажил эрж байгаа үзэгдэл олширч байна. Тариачдын эрх ашгийг батлахын тулд улсаас "Шинэ хөдөө тосгоны бүтээн байгуулалт"-ын төрийн бодлогыг эхлэн хэрэгжүүлж, хөдөө тосгоны тариачдын эм эмнэлэгийн тогтоолын дүрэм байгуулах идэвхитэй арга хэмжээг түүний гол агуулгын нэг болгоно. Үүний дагуул газар татварлан хэрэглэх дүрэмд өөрчлөлт хийхийг зарим газар оронд нэгэнт туршин хийж эхэлсэн байна.

Дөрөв. Хамт нийтийн газар өмчлөх эрхийн өмчлөгчийн баянч цогц нь тодорхой байж, тосгоны эрх баригч нь бодит дээрээ газар өмчлөгч болсон байдал оршиж байна. Үүний үр дүнд, цөөхөн тооны тосгоны эрх баригч нь эрхээ ашиглан, дураар газар шийдвэрлэж, тарианы газар алдагдан гээгдэж, тариачдын үндсэн эрх ашгийг хохируулж байгаа үзэгдэл цөөхөн биш оршиж байна.

Тав. Тариачдын газар дагаажилан эзэгнэх эрх нь бодит үйлдэл дунд цөөхөн тооны тосгоны эрх баригчийн хадлагад орж, үүний зэрэгцээгээр газар дагаажилан эзэгнэх эрхийг гүйлгээнд оруулах хэлбэр болон хүрээ хэмжээ хэтэрхий явцуу байна. Хэдийгээр 2003 оноос эхлэн хэрэгжүүлсэн "Хөдөө тосгоны газар дагаажилах хууль"-д тариачдын газар дагаажилан эзэгнэх эрхэд бодисын эрхийн шинж чанарыг олгож, тухайн эрхийг хамгаалах бүтээмжтэй арга хэмжээ авсан боловч, бодит үйлдэл дунд дээр ярьсанчлан хамт нийтийн газар өмчлөх эрхийн тус бие нь өмчлөгч нь тодорхой бус шалтгаанаас шалтгаалан цөөхөн тооны тосгоны эрх баригч нь дураар газар дагаажилах гэрийг огцруулж газар дагаажилан эзэгнэх эрхэд халдаж байгаа байдал бодитой оршиж байна.

Газар дагаажилан эзэгнэх эрхийг гүйлгээнд оруулах хэлбэр, арга зам, хүрээ хэмжээний тухай хязгаарлал нь хэтэрхий чанга мөртлөө явцуу байна. Тухайлбал эрхэд: Гүйлгээнд оруулах хэлбэрийн талаар хязгаарлал оршиж байна. Тариачид газар дагаажилан эзэгнэх эрхээ зөвхөн шилжүүлэн дагаажилуулах, түрээслүүлэх, солилцох, шилжүүлэн өгөх болон бусад хэлбэр (голдуу хувь оруулах хэлбэр)-ээр гүйлгээнд оруулж болдог. Шилжүүлэн өгөхдөө эрх биш дагаажилуулагчийн зөвшөөрлийг олох хэрэгтэй. Одоо хуулийн тогтоолыг үндэслэвэл, тариачид дагаажилан эзэгнэх эрхээ барьцаалж болохгүй. Эзэн мэдэж шилжүүлж болохгүй. Хоёрт, гүйлгээний баянч цогцын талаар хязгаарлал оршиж байна. Тариачдын тус хамт нийтийн зохион байгуулалтын гаднах гишүүнд газар дагаажилан эзэгнэх эрхээ шилжүүлэхэд эрх биш балгас, сумын засгийн ордноор зөвшөөрүүлэх хэрэгтэй байдаг. Энэ нь газар дагаажилан эзэгнэх эрхийн арилжаалах этгээдийн хүрээ хэмжээ болон газар хэрэглэх эрхийн арилжааны хүрээ хэмжээг ихээр багасгасан байна.

Газар дагаажилан эзэгнэх эрхийн тухай хэтэрхий чанга хязгаарлал нь тариачид гар дээрх газраа ашиглан хөрөнгө нийлүүлэх, бэл оруулахад ашиггүй байж, мөн тариачдын дагаажилан авсан газар дээрээ бэл оруулах идэвхижил ч нөлөөлж, үүний улмаас газрыг төвлөрүүлэн хэрэглэх хэмжээнд аж ахуйгаа бүрэлдүүлэх болон хөдөө тосгоны аж ахуйлалын бүтцийг зохион байгуулахад ашиггүй байж тариалан аж ахуйн хөгжилтийг зохих хэмжээнд харшилсан байна.

Зургаа. Хөдөө тосгоны газар ашиглах эрхийн тухайн тогтоол хараахан үгүй байсаар. Хятад улсын одоогийн хуульд зөвхөн хөрсийн эрхийн тухай тогтоол байж, газар ашиглах эрхийн тухай тогтоол хараахан үгүй байсаар. Хөрсийн эрх болон газар ашиглах эрх нь хууль зүйлийн адил биш газрын эрх байж, өөр өөрийнхөө үйлдлийг бадруулж байдгаас харилцан орлуулж болохгүй юм. Газар ашиглах эрхийн тухай тогтоолгүйгээс болж газрыг өндөр бүтээмжтэй ашиглахад харшилж байдаг.

Гурав. Хятад улсын газрын эрхийн дүрмийн шинэтгэл

Хятад улсын хүн амын 60 хувиас дээш нь хөдөө тосгонд оршиж байдаг. Тариачин бол хятад улсын хамгийн том нийгмийн давхарга байж, тариачдын асуудал нь Хятад улсын одоохчлолтын явц дахь үндсэн асуудал болж байдаг. Газар нь тариалан үйлдвэрлэлийн дунд оруулж болшгүй онцгой байр суурийг эзэлдэгээс тариачин болон газар шороо нь байгууллага, харилцаа холбоотой байдаг. Газрын дүрэм бол нэг улсын үндсэн аж ахуйн дүрэм байж, хөдөө тосгоны газрын дүрмийн зохистой эсэх нь тариалан үйлдвэрлэл, хөдөө тосгоны одоохчлолтын суурь болж байдаг. Иймээс хятад улсын газрын эрхийн дүрмийн шинэтгэл нь одоохондоо голдуу хөдөө тосгоны газрын эрхийн өөрчлөлтөд гол анхаарлаа хандуулж байна.

Нэг. Хөдөө тосгоны хамт нийтийн газар өмчлөх эрхийг төгөлдөржүүлж жинхэнэ утга агуулга дээрх хамт нийтийн газар өмчлөх эрхийг буй болгох хэрэгтэй.

Хөдөө тосгоны хамт нийтийн газар өмчлөх эрхийн талд оршиж байгаа асуудалд чиглүүлэн эрдэмтдээс аль олон талын өөрчлөх

сэтгэмжийг дурдсан байдаг. Түүний дотор төлөөлүүлэх чанартай дөрвөн зүйлийн үзэл байдаг. Нэг. Хамт нийтийн газар өмчлөх эрхийг устгаж хөдөө тосгоны газрыг улсад өмчлүүлэх. Хоёр. Хамт нийтийн газар өмчлөх эрхийг устгаж, хөдөө тосгоны газрыг тариачдад, хувь хүнд өмчлүүлэх. Гурав. Хэсэг хамт нийтийн газрыг өмчлүүлэх эрхийг устгаж, хөдөө тосгоны газрыг адил бус газар орны бодит байдлыг үндэслэн улс, хамт нийтийн буюу хувь хүнд өмчлүүлэх. Дөрөв. Одоо хамт нийтийн газар өмчлөх эрхийг төгөлдөржүүлж, жинхэнэ утга агуулга дээрх хамт нийтийн газар өмчлөх эрхийг буй болгоно.

Хятад улсын бодит байдал болон дүрмийн үргэлжлэн хөгжих шалтгаанаас үүсэж, миний бие дөрөвдүгээр зүйлийн өөрчлөлтийн арга хэмжээг зөвшөөрөн дэмжиж байна. Доор бусад хэдэн зүйлийн өөрчлөлтийн сэтгэмжийг дөхөм судлая.

Хамт нийтийн газар өмчлөх эрхийг устгаж, хөдөө тосгоны газрыг тариачин, хувь хүнд өмчлүүлэхийг зөвшөөрөн дэмжиж байгаа үзэл нь Хятад улсад нилээд хүчтэй урсгал болж байна. Иймэрхүү үзэл нь мөн ихээхэн тооны тариачдын хүрээллийг олсон байдаг. Гэвч энэхүү үзлийг баримталж байгаа эрдэмтэд нь хөдөө тосгоны газрыг тариачин хувь хүнд өмчлүүлэхээс үүссэн дутагдал болон харш саадыг бодолхийлснээр дутмаг. Хөдөө тосгоны газрыг тариачин хувь хүнд өмчлүүлэх дүрмийг хэрэгжүүлэхийг харшилж байгаа хамгийн их хүч нь улс төрийн байгууламжийн асуудал болно. Хятад улс бол нийгэм журамт улс байж, нийгэм журамт нийтийн өмчлөлийг эрс хэрэгжүүлж байдаг. Нийгэм журмын замыг баримтлахад эрхбиш газар шорооны нийтийн өмчлөлийг баримтлах хэрэгтэй. Газрын дүрэмд шинэтгэл хийхдээ хүмүүсийн оюун санааны дотор нэгэнт хоногшиж хадагдсан үзэл, танилтыг бодолхийлэхгүй байхын аргагүй юм. Өмчлөлийн эрх нь зөвхөн нэг зүйлийн эд хөрөнгийн эрхийн хэлбэр биш, тэр нь түн баялаг аж ахуйн болон улс төрийн утга агуулгатай байдаг. Иймээс Хятад улс нь өөрийн үндсэн хуулиа өөрчлөхөөс өмнө энэхүү зүйлийн үзэл нь хууль ёсны чанар болон хэрэгжүүлэлтийн чанараа олж чадахгүй юм.

Газрыг улсад өмчлүүлэх үзлийн хамгийн их харш саад нь даруй тариачдын үзэл санаандаа хүлээн авч зөвшөөрч дийлэхгүй байх асуудал болно. Иймээс, Хятад улсад газрыг улсад өмчлүүлэх нөхцөл ба орчин тойрон хараахан үгүй байсаар.

Хэсэг хамт нийтийн газар өмчлөх эрхийг устгаж, улс, хамт нийт, тариачин хувь хүнд тус бүр өмчлүүлэх үзэл нь Хятад улсын зүүн, баруун, дунд хэсгийн аж ахуйн хөгжилт нь ихтэй, бодит байдлыг үндэслэн дурдан гаргасан байна. Гэвч энэхүү үзэл нь хуулийн дөхмөл чанарт нийцэхгүй мөртлөө газрыг улс буюу хувь хүнд өмчлүүлэхээс болсон эмзэг талыг сэргийлж дийлэхгүй байдгаас болж мөн олон эрдэмтэд зөвшөөрөгдөхгүй байсаар.

Иймээс одоо хэрэгжүүлж байгаа хамт нийтийн газар өмчлөх эрхийг цаашид төгөлдөржүүлэх нь их зүйлийн бүтээмжтэй мөртлөө хэрэгжүүлэх боломцоотой сэтгэмж болно. Асуудлын зангилаа нь хамт нийтийн өмчлөлийн эрхийн баянч цогц тодорхой бус, хагас байгаа байдлыг тодорхой болгож, хамт нийтийн өмчлөлийн эрхийг чангатгах явдал болно. Хуулиас хамт нийтийн өмчлөх эрхийн баянч цогцыг тодорхой тогтоож, чанга хэрэгжүүлэлтийн чанартай байлгавал таарна.

Миний үзэхээр, одоогийн баянч цогц тодорхой бус байдал дахь хамтаар, олноор өмчлөх дүрмийг хувьдаа хамтаар өмчлөх дүрэм даруй хамт нийтийн газрыг хувьчлуулах дүрмээр орлуулбал зохино. Хамт нийтийн өмчлөлийн эрхийг хэрэгжүүлэхдээ хувьцаатны их хурлаар дамжин шийдвэр гаргаж, түүний ашиг шимийн зохих журмаар нь эл хувьцаатанд хуваж, эцсийн шийдвэрлэх эрхийг бүх хувьцаатанд өгөх хэрэгтэй. Хятад улсын зарим газар оронд иймэрхүү газрыг хувьцаажуулах дүрмийг туршин хэрэглэж үр бүтээмжтэй байгаа нь тун сайн юм. Газрыг хувьцаажуулах дүрэм нь Хятад улсад газрыг өрхөд дагаажилуулан эзэгнэх дүрмийг хэрэгжүүлснээс хойших бас нэг удаагийн хөдөө тосгоны газар тарианы хувьсал болох юм. Энэхүү хувьсалын харалт нь бүх тариачдын нэр нэдэрдээ нийцсэн газрын өмчлөгч болоход оршино.

Хоёр. Улсын газар татварлан хэрэглэх эрхийг чанга хязгаарлан газар татварласнаас болсон татварын төлбөр мөнгийн баримжааг дээшлүүлнэ. Хуульд улсаас газар татварлах хүрээ хэмжээ даруй "Нийгэм нийтийн ашиг тус"-д хэрэглэгдэх хэмжээнд тодорхой чанга хязгаарлал хийх хэрэгтэй. Одоогийн хууль дахь газрын татварын төлбөр мөнгөний баримжааг дээшлүүлж тариачдад төв голч төлбөр мөнгө олговол зохино. Эрх тэгш хэлэлцэн тохиролцох байр суурийг батлах хуулийн журмыг тогтоож, тариачдын оролцох эрх болон хамаа бүхий байдлыг мэдэх эрхийг батална.

Гурав. Тариачдын газар дагаажилан эрхлэх эрхийг чангатгаж газар дагаажилан эзэгнэх эрхийн гүйлгээнд орох хэлбэр болон хэмжээг өргөтгөнө. Хуульд тариачдын өөрийн газар дагаажилан эзэгнэх эрхээ барьцаалахыг зөвшөөрөхийн зэрэгцээгээр барьцаалсан байдалд тарианы газрын зориулалтыг өөрчилж болохгүй байхыг тодорхой тогтоовол зохино.

Дөрөв. Хуульд газар ашиглах эрхийн дүрмийг өөрчөрлөн тогтоож газрын эрхийн системийг нээн бүрэлдүүлнэ. "Хятад улсын бодисын эрхийн төсөв"-д нэгэнт газар ашиглах эрхийг тогтоож, газар ашиглах эрхийг олох арга зам, хуулийн үр дүн, дуусах эрхийн тухай нарийвчлан тогтоосон байна.



Үндэсний эрх зүйн тогтолцоонд нотариатын эзлэх байр суурийг тодорхойлох асуудалд



Хууль зүйн магистр,
нотариатч Ч.Баянжаргал

Монгол Улсад нотариатын байгууллага анх Шүүх Явдлын Яамны ерөнхий хэлтэст гэрээ, хэлцлийг батлах хэргийг эрхлэх салаа гэсэн нэртэйгээр байгуулагдаж байжээ[1] (1925 оны 10 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан Шүүх Явдлын Яамны дүрэм).

Нотариатын байгууллага 1925 оноос үйл ажиллагаагаа явуулсан 81 жилийн түүхтэй юм.

Нотариатын үйл ажиллагаа нь социализмын үед гол төлөв ахуйн болон гэр бүлийн, төрийн байгууллагын салбарыг хамарч явагддаг байсан бол орчин үед дээрх салбарыг хамрахаас гадна бизнесийн салбарт шинэ орон зайг эзэлж, аливаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхтэй холбоотой бүхий л асуудлыг хамарсан өргөн хүрээнд эрх зүйн үйлчилгээ үзүүлж байна.

Нотариатын гэрчлүүлсэн бичиг баримт, хууль зүйн үйл явдал хүлээн зөвшөөрегдөж, нотлох баримтын хийгээд гүйцэтгүүлэх хууль зүйн хүчин чадлыг агуулж, нийтийн итгэл хүлээх болсон нь уг байгууллагын хууль хамгаалах байгууллагын тогтолцоонд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргийг тодорхойлно.

Нотариат гэж гэрээ, гэрээслэл, бичиг баримтын хуулбар хийгээд тухайн хүний гарын үсэг мөн болохыг эзэн этгээдийн хүсэлтээр гэрчлэн батлах түүнчлэн эд хөрөнгийг зохих эзэнд нь шилжүүлж өгөхөөр хүлээн авах, эзэн нь тогтоогдоогүй өвд улсын хамгаалалт тогтоох зэрэг хууль зүйн ач холбогдолтой үйлдэл хийж, үйлчилгээ үзүүлдэг улсын албан байгууллагын сүлжээ мөн.[2]

Нотариатын мэргэжил нь эртний Ромд үүссэн түүхтэй[3].

Нотариат *гэдэг нэр томъёо нь:* "note", "notary" бичиж тэмдэглэх гэсэн утгатай латин үгнээс гаралтай бөгөөд үүнээс үндэслэн нотариат гэдгийг баталгаажуулагч, батлагч, гэрчлэгч гэх зэргээр ойлгож иржээ. Мөн notarius-*Латины* ***бичээч***[4] ***бичигч, тэмдэглэгч, нарийн бичгийн дарга*** гэсэн үгнээс гаралтай[5] гэж үзсэн байна.

Манай улсын хувьд нотариат гэсэн нэр томъёог хэл зүйн хувьд ***гэрээ гэрчлэх газар***[6], хууль зүйн нэр томьёонд ***магадлан гэрчлэх газар***[7] хэмээн тодорхойлсон байна.

Аливаа үйлдэл, үйл явдал, баримт бичгийг албан ёсоор хууль зүйн талаар гэрчилж, эрх зүйн зарим үйлдэл хийж, түүний гэрчилсэн баримт бичиг нотлох баримтын хийгээд гүйцэтгүүлэх хүчин чадлыг агуулдаг, хувийн статустай, төрийн тодорхой хууль хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлдэг албан тушаалтныг нотариатч гэж ойлгож болно. Гэхдээ Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан төрийн бус байгууллагын албан тушаалтан гэдэгт удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан гэж тодорхойлсноос үзвэл нотариатчийг оруулаагүй байна.[8]

Монгол Улсын үндэсний эрх зүйн тогтолцоог бүрдүүлж буй аль нэг салбар эрх зүйд нотариатын эрх зүйн асуудлыг хамааруулан судлаагүй байна.

Нотариат гэдгийг зөвхөн нотариатын байгууллага (хууль хамгаалах байгууллагын нэг салаа мөчир болох талаас нь), нотариатч (хуульчийн нэг бие даасан мэргэшил болох талаас нь) гэдгээр явцуурууллан өөрөөсгөл байдлаар судлагдсан байна.

Гэтэл уг үйл ажиллагааны үндсэн эх сурвалж болох хууль нь "Нотариатын тухай" гэж томъёологдож, нотариатын байгууллага, нотариатчийн эрх зүйн асуудлаас гадна нотариатын үйлдэл хийх журмыг агуулсан байна. Нотариатын үйлдэл хийхтэй холбоотой бусад асуудлыг олон улсын гэрээ, хууль, хуульчилсан актаар (эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ, иргэний хууль, нотариатын үйлдэл эрхлэн хийх заавар, үйлчилгээний хөлс зардлын жишиг... гэх мэт) зохицуулдаг.

Иймээс нотариатын Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд эзлэх байр суурийг тодорхойлохын тулд:

- ямар эрх зүйн салбарт хамаарах;
- эсхүл бие даасан салбар эрх зүй мөн эсэхэд хариулт өгөх шаардлага урган гарч байна.

Ихэнхи судлаач, эрдэмтэд эрх зүйн онолын хувьд өөрийн зохицуулах зүйл, зохицуулалтын аргатай байх шалгуурыг хангаж байвал бие даасан салбар эрх зүй гэж үздэг.

[1] Б.Гомбосүрэн "БНМАУ-ын Нотариат", УБ., 1972 он, 6 дахь тал
[2] Монголын нэвтэрхий хууль. УБ., 2000 он, 639 дэх тал
[3] Ж.П. Пиепу, Ж.Ягр "Профессиональное нотариальное право", Мк., 2001 г, с. 37
[4] Словарь иностранных слов. Мк., 1989 г
[5] Т. Сэнгэдорж "Хуульчийн мэргэжил", УБ., 1998 он, 33 дахь тал
[6] Я. Цэвэл "Монгол хэлний товч тайлбар толь", УБ., 1966 он, 382 дахь тал
[7] Улсын нэр томъёоны комиссын мэдээ. № 107, 108, Хууль зүйн нэр томьёо. УБ., 1978 он, 124 дэх тал
[8] Тодруулга: нотариатч нь Монголын нотариатчдын танхимын гишүүний эрх, үүргийг эдэлдэг бөгөөд гишүүнийхээ хувьд ямар нэг албан тушаал эрхэлдэггүй. /МНТ-ын дүрэм 1997он/

ХЗШУ-ны доктор, академич Т.Сэнгэдорж бие даасан салбар эрх зүйн шалгуурыг арай өөр байдлаар авч үзсэн байдаг. Өөрөөр хэлбэл, өөрийн зохицуулах зүйл, зохицуулалтын аргаас гадна өөрийн тусгай зарчим, тогтолцоо, хууль тогтоомжийн бааз суурь, хууль зүйн шинжлэх ухааны бусад салбаруудын харилцан хамаарал зэрэг шалгууруар экологийн эрх зүйг авч үзжээ.

Ер нь аливаа эрх зүй бий болох уг үндэс нь нийгэм, эдийн засгийн материаллаг хөрс суурьтай байх ёстой. Тухайлбал, Монгол Улсад Үндсэн хуулийн цэц байгуулагдсанаар үндсэн хуулийн процесс, зах зээлийн эдийн засагт шилжиж, хувийн аж ахуй эрхлэхийг хүлээн зөвшөөрч хөгжүүлэхтэй холбогдон бизнесийн эрх зүй үүсэн бий болох эх үндэс нь тавигдсан.

Аливаа үндэсний эрх зүйн тогтолцоог бүрдүүлж буй эрх зүйн салбаруудыг гүйцэтгэж буй үүргээр нь материаллаг ба процессын эрх зүй гэж ангилж үздэг. Иймээс нотариат аль эрх зүйн ангилалд хамаарахыг тогтоох нь зүйтэй юм. Нотариатыг гүйцэтгэж буй чиг үүргээр нь авч үзвэл дараах дүгнэлтийг хийж болно.

Нотариатын тухай хуульд зааснаар...нотариатын үйлдэл хийх замаар иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах...[1] хэмээн нотариатын үйлдэл нь ямар хууль зүйн ач холбогдол, үүрэг гүйцэтгэхийг хуульчилсан байна.

Асуудлыг илүү тодотгохын тулд нотариатын үйл ажиллагааны үндсэн зохицуулалтыг агуулсан иргэний эрх зүйн үүднээс үнэлэлт өгвөл уг эрх зүйн хамгаалалтын асуудалтай холбогдож байна.

Иргэний эрх зүйн хамгаалалт гэдгийг Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч субъектийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо хэвийн байдлаар хэрэгжүүлэх боломж олгох төдийгүй, эрхийн хэвийн хэрэгжилтийг хангадаг хууль зүйн арга хэрэгсэл гэж үздэг.[2]

Нотариат бол хүний эрх, эрх чөлөөний хууль зүйн баталгааны нэг хэсэг мөн.

Иргэний эрх зүйн хамгаалалтыг шүүхийн ба шүүхийн бус замаар хэрэгжинэ гэж үзээд, шүүхийн бус хэлбэрт[3] зөвхөн арбитрыг хамааруулж үздэг.

Нотариат нь түүний гүйцэтгэж буй чиг үүрэг[4], нотариатын тухай хуулийг үндэслэвэл иргэний эрх зүйн шүүхийн бус хамгаалалтын нэг хэлбэр юм.

Нотариатын үйл ажиллагааны агуулгаас авч үзвэл, хууль тогтоомжид заасан нотариатаар гэрчлүүлнэ гэсэн материаллаг эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлж буй хууль зүйн хэлбэр учир хууль зүйн процессын нэгэн төрөл гэж үзэж болно.

Өнөөгийн эрх зүйн тогтолцоонд үндсэн хуулийн, захиргааны, иргэний, эрүүгийн, арбитрын зэрэг процессын эрх зүй байна. Нотариатын үйл ажиллагааг дээрх процессын эрх зүйн аль нэгэнд нь хамааруулах боломжгүй юм.

Социалист эрх зүйн тогтолцооны үед нотариат нь захиргааны процессын нэг хэсэг болж байсан гэж үзэж болно.

Учир нь, нотариатын үйл ажиллагааг захиргааны байгууллага эрхэлдэг байсантай холбоотой.

Үүнээс үндэслэвэл, нотариатын эрх зүйн асуудлыг процессын эрх зүй гэж үзэж болно.

Нотариат бие даасан процессын эрх зүй болох шалгуур нь:

1. Аль нэг салбар эрх зүйд хамааруулаагүй байна.

Өөрөөр хэлбэл, нотариатыг аль нэг салбар эрх зүй болон эрх зүйн институт гэж үзээгүй байна.

2. Өөрийн гүйцэтгэх тусгай чиг үүрэгтэй.

- Гэрчлэх замаар нотлох баримтыг бий болгох;
- Эрх олгох;
- Гэрээний гүйцэтгэлийг хангуулах;
- Үүрэг дуусгавар болгох;
- Өвлөгчийн эрх ашгийг хамгаалах;
- Өмчлөх эрхийг баталгаажуулах гэх мэт.

3. Зохицуулах зүйл

Нотариатын хуулийг иш үндэс болговол нотариатын эрх зүйн зохицуулах зүйлийг дараах байдлаар тодорхойлж болно:

- Нотариатын зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим, нотариатчийн эрх зүйн байдлыг тодорхойлохтой холбогдож үүссэн нийгмийн харилцаа;
- Нотариатаас хэлцэл, өмчлөх эрх, хуулийн этгээд үүсгэн байгуулах бичиг баримт гэрчлэх зэрэг нотариатын үйлдэл хийх замаар иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангахтай холбогдож үүссэн нийгмийн харилцаа;
- Нотариатын үйл ажиллагаанд хяналт тавих харилцаа (хяналт шалгалт хийх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох).

Нотариатын талаархи хууль зүйн тодорхойлолтуудыг[5] иш үндэс болговол: Нотариатаас иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн гэрээ, гэрээслэл болон бусад хууль зүйн ач холбогдол бүхий бичиг баримтыг гэрчлэх болон бусад нотариатын үйлдэл хийхтэй холбогдсон нийгмийн харилцаа юм.

4. Зохицуулалтын арга

- Зөвшөөрөх (үйлчлүүлэгч өөрийнхөө хүсэлтээр нотариатын үйлдэл хийлгэж

[1] Нотариатын тухай хууль. 1997 он, 1 дүгээр зүйл

[2] Д.Бат-Өлзий "Иргэний эрх зүй", УБ., 2003 он, 37 дахь тал, Б.Баттөмөр "Иргэний эрх зүйн зарим асуудал", УБ., 2004 он, 89 дэх тал

[3] Иргэн, хуулийн этгээд өөрсдөө хэрэгжүүлж буй өөртөө туслах зэрэг хамгаалалтын онцгой хэлбэр бий.

[4] "БНМАУ-ын төр эрхийн үндэс". Ред Э.Авирмэд, Б.Чимид. УБ., 1978 он, 48 дахь тал, "Монгол Улсын төр эрх зүйн үндэс". Ред Т.Сэнгэдорж. УБ., 1998 он, 33 дахь тал, Ч.Баянжаргал "Нотариат". УБ., 2005 он, 11 дэх тал

[5] Эрх зүйн мэдлэгийн товч толь. УБ., 1986 он 90 дэх тал, Монголын нэвтэрхий толь. УБ., 2000 он. 639 дэх тал, Хууль зүйн тайлбар толь. УБ., 2003 он. Хянан тохиолдуулсан С.Нарангэрэл, Г.Совд, Большой юридический словарь. М., 2000 он, с. 374, Ч.Баянжаргал "Нотариат", УБ., 2005 он 30 дахь тал

болно. Жишээ нь, зээлийн гэрээ);

- Үүрэг болгох (хуульд заасан тохиолдолд нотариатын үйлдлийг заавал хийлгэх. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ гэх мэт);
- Зөвлөх (нотариатын хууль тогтоомж, нотариатын үйлдэлтэй холбогдсон асуудлаар зөвлөгөө өгөх);
- Хориглох (хуульд заасан тохиолдолд хориг тогтоох. Үйлчлүүлэгч нь эрх зүйн чадамжгүй буюу төлөөлөх эрхгүй байвал нотариатын үйлдэл хийхээс татгалзана);
- Хариуцлага тооцох (Хууль зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх).

5. Тусгай зарчим

- Хууль дээдлэх;
- Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах;
- Өмчлөх эрхийг хамгаалах;
- Хэлний зарчим;
- Нотариатын үйл ажиллагааг хуулиар эрх олгогдсон этгээд эрхлэх;
- Нотариатч тогтоосон тойрогт үйл ажиллагаа явуулах;
- Үйл ажиллагаагаа явуулахдаа хараат бус байх;
- Нотолгоонд тулгуурлах;
- Нууц хадгалах;
- Өөрийн бууртай үйл ажиллагаанаас учруулсан хохирлыг бүрэн хариуцах;
- Үйлчлүүлэгчийн бууртай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг нотариатч хариуцахгүй байх;
- Нотариатын үйлчилгээ төлбөртэй байх.

6. Нийгэм, эдийн засгийн шаардлага бүрдсэн

Ардчилсан нийгмийг төлөвшүүлж, хөгжүүлэхэд хууль хамгаалах байгууллагуудын эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагааг нь боловсронгуй болгож, хэрэгжүүлэх асуудал чухал ач холбогдолтой.

Нэг талаас хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдэлж, хүн эрхээ баталгаатай эдэлж, хэрэгжүүлэх эрх зүйн таатай орчинг бүрдүүлэхэд аливаа үйл явдал, бичиг баримтыг гэрчилж, түүнийг хууль ёсны болгох үндсэн үүргийг нотариатч хэрэгжүүлж байна.

Иргэд нотариатад итгэх итгэл өндөр, өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаална хэмээн үздэг учраас өөрт тохиолдсон эрх зүйн аливаа үйлдэл, үйл явдлыг нотариатаар гэрчлүүлэх хүсэл сонирхол давамгайлах болжээ. Тухайлбал, найз нөхөддөө мөнгө хэрэгтэй үед нь тусалж, мөнгө зээлэхдээ хүү тооцохгүй ч, нотариатаар мөнгө зээлдүүлсэн тухай зээлийн гэрээгээ гэрчлүүлдэг болжээ.

Нөгөө талаас зах зээлийн харилцаанд шилжиж, энэ чиг хандлагыг баримтлан эдийн засгийн харилцаа өргөжихийн хэрээр нотариатчаар үйлчлүүлэх үйлчлүүлэгчдийн тоо эрс өсөн нэмэгдэж, зөвхөн үйлчлүүлэгч төдийгүй хууль хэрэглэгчдийн анхаарлыг ихэд татах боллоо.

ХУУЛЬ ЗҮЙН ХЭРЭЭЛ
www.legal.mn



Даатгалын хэлцэл



Монгол Өмгөөлөгчдийн Холбооны гишүүн, өмгөөлөгч Ч.Уянга

Даатгалын хамгаалалт авах эрх болон хамгаалалт өгөх үүрэг үүсгэх зорилгоор даатгагч, даатгуулагчийн хооронд хэлцэл хийгдэнэ.

Жишээ нь:

А өөрийн байшингаа Б-д бүх нөхцөл байдлаас үүсэх галын эрсдлийн даатгалд даатгуулжээ. Хэрвээ А-гийн байшинд ямарваа нэгэн нөхцөл байдлаас гал гаран байшингийн тодорхой хэсэг юмуу байшин бүхлээрээ шатаж А-гийн гэр бүлд хохирол учрах бол Б гэрээнд заасан нөхцөлийн дагуу А-д учирсан хохирлыг бүрэн барагдуулна. Хохирол үүсэхээс өмнө хэрвээ үүсвэл гэсэн байдлаар харилцан тохиролцож гэрээ байгуулан хэлцэл хийсэн байна. Учир нь ямарваа нэгэн хохирол бий болоход нөхөн төлүүлэх зорилготой байсан ба хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээж байна.

Даатгагч, даатгуулагч өөрөө сайн дураар хүсэл зоригоо илэрхийлэн даатгалын хамгаалалт өгөх ба авах зорилгоор хэлцэл хийж байгаа бөгөөд түүгээр нь ямар хэлбэрээр хэлцэл хийхээ харилцан тохиролцоно (Иргэний хуулийн тайлбар 42.1 дэх хэсэг). Хэлцлийг даатгагч, даатгуулагчийн харилцан тохиролцсноор тухайн харилцаанд хэрэглэн заншсан даатгалын гэрээт баталгаа бичин олгох буюу аман хэлбэрээр хийж болно. Мөн гэрээ байгуулан бичгэн хэлбээр хийнэ. Даатгалын хамгаалалт авах ба өгөх хэлцэл ихэвчлэн бичгэн хэлбэрээр хийгдсэн байдаг. Даатгалын бичгээр хийх хэлцэл нь даатгагч, даатгуулагч нар гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болдог бөгөөд хэдэн хувь үйлдэн талуудад үлдэх хувь дээр харилцан гарын үсэг зурсан байвал хэлцэл хийсэн гэж үзнэ.

Даатгалын хамгаалалт авах болон өгөх хэлцлүүд нь дараахь тохиолдолд хүчин төгөлдөр бус байна. Үүнд:

- Хууль зөрчсөн буюу нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан хэлцэл;
- Дүр үзүүлэн хийсэн хэлцэл;
- Өөр хэлцлийг халхавчлах зорилгоор хийсэн хэлцэл;
- Үнэн сананаасаа бус, хөнгөмсгөөр хандаж, түүнийгээ илэрнэ гэж урьдаас тооцож, тодорхой хүсэл зориг илэрхийлэн хийсэн хэлцэл;
- Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон иргэн эрх зүйн бүрэн чадамжгүй гэж албан ёсоор тооцогдоогүй байхдаа хийсэн хэлцэл;
- Эрх зүйн бүрэн чадамжтай этгээд үйлдлийнхээ учир холбогдлыг ойлгох чадваргүй болсон буюу сэтгэцийн түр зуурын сааталд орсон үедээ хийсэн хэлцэл;
- Хуулиар тогтоосон хэлбэрийг зөрчсөн, хуульд заасан тохиолдолд зохих этгээдийн зөвшөөрөлгүй хийсэн хэлцэл;
- Хуулийн этгээд үйл ажиллагааныхаа үндсэн зорилгыг зөрчиж хийсэн хэлцэл.

Даатгалын хамгаалалтын хүчин төгөлдөр бус хэлцэл хийсэн талууд нь уг хэлцлээр шилжүүлсэн бүх зүйлсээ харилцан буцааж өгдөг ба боломжгүй бол үнийг нь төлдөг (Иргэний хууль 56.5 дахь хэсэг). Тухайн хэлцлийг хийхдээ даатгагч болон даатгуулагч нь хүсэл зоригоо бичгээр илэрхийлэх буюу тооцоо хийхдээ алдаа гаргавал хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэлгүй бөгөөд алдаагаа засаж болно (Иргэний хууль 57.4 дэх хэсэг)

Мөн даатгалын хамгаалалт авах ба өгөх хэлцлүүд нь дараахь тохиолдолд хүчин төгөлдөр бус гэж тооцогдож болно (Иргэний хууль 57 дугаар зүйл). Үүнд:

- Шүүх хуульд заасан үндэслэл, журмын дагуу сонирхогч этгээдийн нэхэмжлэлээр хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцож болно. Энэ хэлцэл нь хийсэн үеэсээ хүчин төгөлдөр бус байна;
- Гэрээгээр тохирсон хэлбэрийг зөрчсөн хэлцлийг шүүх сонирхогч этгээдийн нэхэмжлэлээр хүчин төгөлдөр бус гэж тооцож болно;
- Төлөөлөгч буюу зуучлагч нь төлөөлүүлэгч буюу үйлчлүүлэгчийнхээ хүсэл зоригийн илэрхийллийг буруу ташаа мэдээлсний үндсэн дээр хийсэн хэлцлийг ноцтой төөрөгдсөн гэж үзэж хүчин төгөлдөр бусаар тооцож болно;
- Ноцтой төөрөгдлийн үндсэн дээр хүсэл зоригоо илэрхийлэн хийсэн хэлцлийг шүүх хүчин төгөлдөр бус гэж тооцож болно.

Дараахь тохиолдолд ноцтой төөрөгдсөн гэж үзнэ (Иргэний хууль 58.2 дахь хэсэг):

- Хэлцэл хийгч этгээд хэлцэл хийхдээ хүссэн хэлцлээсээ өөр хэлцлийг зөвшөөрөн хийсэн;
- Хэлцэл хийгч этгээд хүссэн хэлцлийнхээ агуулгыг эндүүрсэн.

Харин дараахь тохиолдолд ноцтой төөрөгдсөн гэж үзэж болно (Иргэний хууль 58.3 дахь хэсэг). Үүнд:

- Хэлцэл хийгч нөгөө тал болох этгээд, түүний хувийн шинж байдал нь хэлцэл хийх гол үндэслэл болсон бөгөөд энэ

талаар төөрөгдсөн;

- Хэлцэл хийх гол үндэслэл болсон эрхийн талаар төөрөгдсөн;
- Хэлцлийн зүйлийн үнийг тодорхойлоход ач холбогдол бүхий эд зүйлийн шинжийн талаар төөрөгдсөн;
- Тохиролцооны зүйл байсан сэдэлтийн талаар төөрөгдсөн.

Тодорхойгүй байгаа ямар нэгэн гэнэтийн эрсдэл учирснаар хохирол үүсэхэд хохирлыг нөхөн төлөх үүрэг үүсэх нөхцөлд хэлцлийг хэрэгжүүлэх, эсхүл хэлцлийг дуусгавар болгохоор тохиролцож хийснийг болзол тавьж хийсэн хэлцэл гэнэ (Иргэний хууль 44.1 дэх хэсэг).

Жишээ:

А өөрийн автомашинаа Б-д нэг жилийн хугацаатай даатгуулжээ. Даатгалын хугацаанд даатгалын тохиолдол бий болж А-д тодорхой хохирол учиржээ. Б учирсан хохирлыг гэрээнд заасны дагуу хэн бүрэн хэмжээгээр буюу хэсэгчлэн нөхөн төлөх үүрэгтэй эсэхийг тодруулахаар А-г дуудсан байна.

Даатгагч, даатгуулагч харилцан тохиролцож бий болж болзошгүй эрсдлийн үр дагавар хохирлыг нөхөн төлөх үүргээ биелүүлж хэлцлийг дуусгавар болгохоор тохирсон бол өөрчлөгдөх болзлоор хийсэн хэлцэл гэнэ (Иргэний хууль 44.3 дахь хэсэг).

Жишээ:

А өөрийгөө жолоочийн хариуцлагын даатгалд 1 сая төгрөгийн даатгалын үнэлгээтэйгээр Б-д даатгуулжээ. А замын хөдөлгөөнд оролцох явцдаа гурадагч этгээд болох иргэн Г-д 2 сая төгрөгийн хохирол учруулжээ. Б өөрийн гэрээгээр хүлээх үүргийн хязгаар буюу даатгалын үнэлгээ болох 1 сая төгрөгийг хохирогч Г-д нөхөн төлснөөр болзол бүрэн биелсэнд тооцон гэрээний хугацаа дуусгавар болно.

Хохирлыг нөхөн төлөх болзол нь хуулийн шаардлагад нийцээгүй буюу нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харш эсвэл илтэд биелэгдэх боломжгүй бол хэлцэл хүчин төгөлдөр бус байна (Иргэний хууль 45.1 дэх хэсэг).

Хохирлыг нөхөн төлөх, төлүүлэх болзол тавьж хэлцэл хийсэн талууд даатгалын эрсдэл учирахаас өмнө эсрэг талдаа гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь саад болох эрхгүй (Иргэний хууль 48.1 дэх хэсэг).

Хохирлыг нөхөн төлөх болон төлүүлснээр өөрт нь ашиггүй байх хэлцэлд оролцогч тал нь болзолд шударга бусаар саад болвол хохирол учирсанд тооцдог (Иргэний хууль 48.2 дахь хэсэг).

Харин ашигтай байх хэлцэлд оролцогч тал нь болзолд шударга бусаар нөлөөлсөн бол хохирол учраагүйд тооцно.

Хохирлыг нөхөн төлөх, төлүүлэх болзол тодорхой хугацаанд бий болоход гэрээнд оролцогч аль нэг тал нөгөө талдаа гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ биелүүлэхэд нь нэгэнт саад болчихсон байвал түүнээс болж эсрэг талдаа учирах гэм хорыг арилгах үүрэгтэй байдаг.

Даатгалын харилцаанд оролцогчид

Даатгалын хамгаалалт өгөх ба авах хэлцлийг талууд төлөөлөгчөөр дамжуулан хийж болно. Талуудыг төлөөлөх төлөөлөгч нь иргэнийн эрх зүйн бүрэн, бүрэн бус, эсвэл хязгаарлагдмал чадамжтай иргэн болон хуулийн этгээд байна. Төлөөлөгч төлөөлүүлэгчээс олгосон бүрэн эрхийн хүрээнд, түүний нэрийн өмнөөс даатгалын хамгаалалт авах ба өгөх хэлцэл хийх бөгөөд уг хэлцлээс үүсэх эрх, үүрэг нь төлөөлүүлэгчид бий болдог.

Даатгалын үйл ажиллагаанд даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагч, хохирол үнэлээч гэсэн даатгалын харилцааны субъекүүд оролцдог бөгөөд тэдний эрх зүйн байдлыг Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиар зохицуулна.

Даатгалын гэрээний тухай ойлголт

Даатгалын гэрээ гэдэг нь даатгагч даатгалын тохиолдол бий болоход даатгуулагчид учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх, даатгуулагч нь даатгалын хураамж төлөх үүргийг тус тус хүлээсэн даатгалын бичгээр хийгдсэн хэлцэл юм.

Даатгалын хамгаалалт өгөх ба авах бичгээр хийгдсэн хэлцэл буюу гэрээг талууд хуулийн хүрээнд чөлөөтэй байгуулж, түүний агуулагыг өөрсдөө тодорхойлно (Иргэний хууль 189.1 дэх хэсэг). Даатгалын хамгаалалтын гэрээний гол нөхцөл, түүнийг тодорхойлох журмыг заасан гэрээ байгуулах саналыг хүлээн зөвшөөрснөөр гэрээ байгуулагдана.

Талууд нэг баримт бичиг үйлдэн хүлээн зөвшөөрч гарын үсэг зурснаар даатгалын гэрээ байгуулсанд тооцно. Даатгалын гэрээний зарим үг хэллэг салбарын болон мэргэжлийн онцлогоос шалтгаалан ойлгомжгүй бол гэрээнд тайлбар оруулдаг.

Жишээ:

- ***Даатгалын мэдүүлэг*** *- Даатгуулагчийн зүгээс эсвэл түүний нэрийн өмнөөс даатгуулахаар бүрдүүлсэн төрөл бүрийн баримт материал, нарийн мэдээлэл;*
- ***Даатгалын хураамж*** *- Даатгуулагч даатгуулсны төлөө Даатгагчид төлөх төлбөр;*
- ***Даатгалын тохиолдол*** *– Даатгуулсан зүйлд учирсан хохирол, тохиролцсон болзол бүрдэхийг;*
- ***Даатгалын үнэлгээ*** *- Даатгуулагчийн даатгуулахаар мэдүүлсэн үнэ буюу нөхөн олговрын дээд хэмжээ;*
- ***Нөхөн олговор*** *- Гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд Даатгагчаас Даатгуулагчид олгох төлбөр.*

Харин гэрээний аль нэг нөхцөлийн утга ойлгомжгүй бол түүний агуулгыг бусад нөхцөлийн болон гэрээний ерөнхий агуулгатай харьцуулах замаар тодорхойлж болно. Нэгэнт байгуулагдсан даатгалын гэрээгээр тохирсон даатгалын хураамж буюу мөнгөн төлбөрийг даатгагчид даатгуулагч төлснөөр гэрээ хүчин төгөлдөр болсонд тооцогддог. Талууд харилцан тохиролцож даатгалын хураамж төлөгдөх хугацааг тохирч болно. Даатгуулагч даатгалын хураамжийг хугацаанд нь төлөөгүй бол даатгагч хураамж төлөх 15 хоногийн нэмэлт хугацаа тогтоож болох бөгөөд энэ хугацааг дахин хэтрүүлбэл үүсэх үр дагаврыг даатгагч даатгуулагчид бичгээр мэдэгдэнэ (Иргэний хууль 437.1 дэх хэсэг). Даатгагч даатгалын хураамжийг хугацаанд нь төлөөгүй байхад даатгалын тохиолдол бий болсон бол даатгагч гэрээнд заасан үүрэг хүлээхгүй (Иргэний хууль 437.2 дахь хэсэг). Даатгалын тохиолдол бий болохоос өмнө даатгуулагч даатгалын гэрээнээс татгалзсан бол даатгагч эрсдлийг өөртөө хүлээж байсан хугацаанд тохирох даатгалын хураамж болон гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээнийхээ хөлсийг даатгуулагчаас шаардах эрхтэй (Иргэний хууль 437.3 дахь хэсэг).

Даатгуулагч этгээдэд даатгалын хамгаалалтыг авахад байгуулсан даатгалын гэрээ нь бүрэн утга болон чанараараа хийгдсэнд тооцогддог.

Даатгалын гэрээнд гэрээ байгуулагч талуудын эрх үүрэг, даатгалын зүйл, даатгалын үнэлгээний хэмжээ, даатгалын эрсдлүүд, даатгалын хураамж болон түүнийг төлөх хугацаа, даатгалын гэрээний хугацаа болон түүний нөхцөл, гэрээнд өөрчлөлт оруулах нөхцөл, маргаан шийдвэрлэх журам гэх мэт нөхцлүүдийг тусгадаг. Түүнээс гадна даатгагч даатгуулагч хоёр нэмэгдэл эрх, үүрэг, хариуцлагынхаа талаар тусгайлсан тохиролцоогоо гэрээндээ тусгаж болно.

Даатгалын гэрээнд тавигдах шаардлага

Даатгалын гэрээг бичгээр хийх бөгөөд энэ шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна (Иргэний хууль 431.3 дахь хэсэг). Даатгалын гэрээнд дараахь нөхцөлийг тусгана.

Даатгалын гэрээний гол буюу туслах нөхцөл

Даатгалын гэрээний гол нөхцөл нь хуульд заасан буюу гэрээнд зайлшгүй тусгавал зохих, түүнчлэн нэг талын хүссэний дагуу нөгөө тал нь зөвшөөрсөн нөхцөлийг хэлнэ.

Гэрээний гол нөхцөл:

- Даатгалын зүйл;
- Даатгалын эрсдлийн төрөл;
- Даатгалын үнэлгээний хэмжээ;
- Даатгалын хугацаа, түүнийг дахин сунгах нөхцөл;
- Даатгалын хураамжийн хэмжээ түүнийг төлөх хугацаа;
- Даатгагч, даатгуулагчийн эрх, үүрэг, хариуцлага;
- Гэрээг дүгнэх, цуцлах, түүнд өөрчлөлт оруулах нөхцөл.

Гэрээний туслах нөхцөл:

- Даатгалын нөхөн төлбөр;
- Даатгалын нөхөн төлбөр авахад бүрдүүлэх материал;
- Даатгалын нөхөн төлбөр авах эрхээ алдах.

Даатгалын гэрээний стандарт нөхцөл

Гэрээний нэг тал нь нөгөөдөө санал болгож байгаа, хуулиар тодорхойлоогүй буюу хуулийн заалтыг тодотгосон журам тогтоосон, байнга хэрэглэгдэх, урьдчилан тогтоосон нөхцөлийг гэрээний стандарт нөхцөл гэнэ (Иргэний хууль 200.1 дэх хэсэг). Даатгалын харилцаанд ихэвчлэн санал болгож гэрээний стандарт нөхцөлийг нөгөө талдаа урьдчилж явуулдаг бөгөөд хэрэв нөгөө тал стандарт нөхцөлийг зөвшөөрвөл гэрээ байгуулдаг. Нөгөө тал стандарт нөхцөлөөс өөрсдийн үйл ажиллагаанд тохирох байдлаар өөрчлөх санал гарган харилцан тохиролцож гэрээ байгуулбал гэрээний стандарт нөхцөл алдагдана.

Дараахь нөхцөл бүрдсэн тохиолдолд стандарт нөхцөл нь талуудын хооронд байгуулсан гэрээний салшгүй хэсэг болно (Иргэний хууль 200.3 дахь хэсэг).

- Санал гаргагч тал нь гэрээ байгуулж байгаа газарт стандарт нөхцөлийг ил тод харагдахаар бичиж энэ нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн этгээдтэй гэрээ байгуулахаар заасан бол;
- Нөгөө тал нь дээрх нөхцөлтэй танилцах боломжтой байсан бөгөөд уг нөхцөлийг зөвшөөрсөн бол.

Санал хүлээн авагч тал нь аж ахуй эрхлэгч этгээд бөгөөд ажил хэргийн онцлогоос хамаарч стандарт нөхцөлийг урьдчилан мэдэх ёстой, мэдэх боломжтой байсан бол стандарт нөхцөл нь гэрээний салшгүй хэсэг болно (Иргэний хууль 200.4 дэх хэсэг). Хэрэв стандарт нөхцөлийг илэрхийлсэн гадаад нөхцөл нь хэвшсэн хэлбэрээс өөр байсан учир нөгөө тал нь түүнийг урьдчилан мэдэх боломжгүй байсан бол стандарт нөхцөл гэрээний салшгүй хэсэг болохгүй (Иргэний хууль 200.5 дахь хэсэг).

Стандарт нөхцөлийг гэрээнд тусгасан ч тэр нь харилцан итгэлцэл, шударга ёсны зарчимд харш, уг нөхцөлийг хүлээн зөвшөөрөгч нөгөө талдаа хохиролтой бол уг нөхцөл хүчин төгөлдөр бус байна. Энэ тохиолдолд стандарт нөхцөлийг гэрээнд тусгах болсон нөхцөл байдал, талуудын ашиг сонирхол болон бусад нөхцөл байдлыг харгалзан үзнэ (Иргэний хууль 202.1 дэх хэсэг). Аж ахуй эрхэлдэггүй иргэнтэй гэрээ байгуулахаар санал гаргаж байгаа тал нь дараахь нөхцөлүүдийг гэрээний стандарт нөхцөлд тусгасан бол тэдгээр нь хүчин төгөлдөр бус байна (Иргэний хууль 202.2 дахь хэсэг). Үүнд:

- Саналыг хүлээн авах, түүнээс татгалзах зэрэгт хэт урт буюу тодорхой бус хугацаа тогтоосон;
- Үүргээ гүйцэтгэхэд хэт урт буюу тодорхой бус, хуульд үл нийцэх хугацаа тогтоосон;
- Гэрээнд заагаагүй бөгөөд тодорхой үндэслэлгүйгээр гэрээг цуцлах эрхтэй байхаар заасан;
- Гэрээгээр нэгэнт тогтоосон үүргээ нөгөө талын хууль ёсны ашиг сонирхолд үл нийцэх байдлаар өөрчлөх буюу татгалзах эрхтэй байхаар заасан;

- Гаргасан зардлыг хэт өндрөөр буюу нэмэгдүүлэн тооцож шаардах эрхийг өөртөө олгосон;
- Онцгой ач холбогдол бүхий тайлбарыг нөгөө талд гаргасанд тооцохоор заасан;
- Урт хугацаатай үүргийн харилцаанд үнийг үндэслэлгүйгээр хэт богино хугацаанд огцом өсгөхөөр заасан;
- Нөгөө талын үүргээ гүйцэтгэх, эрхээ хэрэгжүүлэхээс татгалзах хуулиар олгогдсон эрхийг хязгаарласан буюу үгүйсгэсэн;
- Нөгөө талдаа үүргээ гүйцэтгэхийг урьдчилан сануулах буюу үүргээ гүйцэтгэх боломжийн хугацаа олгох хуулиар тогтоосон үүргээс санал гаргагч талыг чөлөөлсөн;
- Санал гаргагч тал нь өөрт учирсан бодит хохирлоос хэт давсан хэмжээний нөхөн төлбөр шаардахаар тогтоосон;
- Санал гаргагч, хууль ёсны төлөөлөгч зэрэг этгээдийн санаатай буюу хэт болгоомжгүй үйлдлийн улмаас учирсан хохирлыг хариуцахыг үгүйсгэсэн буюу хязгаарласан;
- Үүргээ зөрчсөнөөс учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах нөгөө талын эрхийг хязгаарласан;
- Санал гаргагч тал нь үүргээ хэсэгчлэн гүйцэтгэсэнээс нөгөө талын хууль ёсны ашиг сонирхол хохирох тохиолдолд гэрээнээс татгалзах, гэрээгээ цуцлах, үүргээ гүйцэтгээгүйгээс учирсан хохирлыг шаардах эрхийг үгүйсгэсэн;
- Санал гаргагч талын бэлтгэн нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний дутагдлын талаар хүлээх хариуцлагыг хуульд зааснаас бага хэмжээгээр тогтоосон;
- Санал гаргагч тал хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйгээс нөгөө тал гэрээг цуцалсан бол санал гаргагч талд анз төлөхөөр заасан.

Бараа бүтээгдэхүүн тогтмол нийлүүлэх буюу ажил үйлчилгээ тогтмол явуулах тухай гэрээний стандарт нөхцөлд дараахь нөхцөлийг тусгасан бол тэдгээр нөхцөл нь хүчин төгөлдөр бус байна (Иргэний хууль 202.3 дахь хэсэг). Үүнд:

- Нөгөө талд хоёроос илүү жилийн хугацаагаар үүрэг хүлээлгэж байгаа;
- Аль нэг тал нь гэрээг цуцлах санал гаргаагүй тохиолдолд гэрээг тухай бүр нь нэг жилээс доошгүй хугацаагаар сунгасанд тооцохоор тогтоосон;
- Гэрээг цуцлах хугацаа нь гэрээг сунгасан хугацаанаас гурван сараас илүү байхаар заасан нь нөгөө талын хууль ёсны ашиг сонирхолд үл нийцэхээр бол.

Дор дурдсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээд санал гаргагч талын оронд түүнтэй адил эрхтэйгээр тухайн гэрээний харилцаанд оролцохоор заасан буюу оролцох бололцоотой байхаар тогтоосон бол стандарт нөхцөл хүчин төгөлдөр бус байна (Иргэний хууль 202.4 дэх хэсэг). Үүнд:

- Гуравдагч этгээдийг нэрээр нь заасан;
- Нөгөө талд дангаар гэрээг цуцлах эрх олгосон.

Гэрээний стандарт нөхцөлд хамаарах хэсгүүдийн аль нэг нь хүчин төгөлдөр бус байх, эсвэл гэрээний гол бус нөхцөл болсон тохиолдолд гэрээ бүхэлдээ хүчин төгөлдөр байна.

Даатгалын гэрээний эрх, үүргийн талаархи ойлголт

Даатгалын гэрээгээр даатгагч нь даатгалын тохиолдол бий болоход даатгуулагчид учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тус тус хүлээнэ.

Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ гэсэн зарчмын дагуу даатгалын гэрээний хохирол нөхөн төлөх үүргийг талуудын гэрээнд тохирсон хугацаанд, гэрээнд заасан хохирол нөхөн төлөх нөхцөлийн дагуу даатгагч гүйцэтгэдэг. Даатгалын хохирол нөхөн төлөх үүрэг гүйцэтгэх газрыг даатгагчийн оршин суугаа газраар, нөхөн төлөх үүргийг мөнгөн төлбөрөөр эсвэл сэргээн засварлах, орлуулах зэргээр гэрээнд харилцан тохирсон хэлбэрээр гүйцэтгэнэ.

Даатгалын гэрээний үндсэн ба нэмэлт эрх, үүрэг

Түүнээс гадна даатгагч даатгуулагч хоёр нэмэгдэл эрх, үүрэг, хариуцлагынхаа талаар тусгайлсан тохиролцоогоо гэрээндээ тусгаж болно.

Жишээ:

А өвөрийн автомашинаа Б-д даатгуулжээ. Даатгалын гэрээгээр тохирох даатгагчийн гол үүрэг учирсан хохирлыг нөхөн төлөхийг тохирсон бөгөөд түүн дээр нэмэлт үйлчилгээ болох ослын газраас чирч холдуулах зардлыг төлөх, хохирлын үнэлгээ тогтоох зардлыг төлөх, засварын газар байх хугацааны зардлыг төлөхөөр даатгагч үүрэг хүлээн тохиролцлоо.

Даатгалын гуравдагч этгээдэд ашигтай гэрээ

Мөн даатгалын гэрээг даатгуулагч гуравдагч этгээдэд ашигтайгаар байгуулах боломжтой. Энэ төрлийн гэрээнд хариуцлагын даатгалын гэрээнүүд ордог. Хэрвээ гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгуулагч, гуравдагч этгээдийн аль аль нь даатгалын тохиолдол үүсэхэд даатгагчаас үүргийн гүйцэтгэлийг шаардаж болно.



Эрх зүйн иж бүрэн үйлчилгээний цогцолбор

Хуульч Б.Цогнам

Улс орон хөгжих тусам төрөл бүрийн эрэлт хэрэгцээ, шаардлага нэмэгдэж байгаатай уялдуулан аливаа үйлчилгээг үзүүлэхдээ аль болох чирэгдэл багатай, цаг хэмнэсэн, нэг цэгийн үйлчилгээний шинэ дэвшилтэт арга барил бий болжээ. Энэ жишгээр манай оронд гааль, татвар зэрэг газар нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлээд тодорхой туршлага хуримтлуулсны дээр үйлчлүүлэгч нарын талархал хүлээж байна. Харин өмгөөллийн байгууллагын чиглэлээр ийм төв байгуулах нь зүйтэй юм.

Монгол Улсад хуулийн этгээд болон иргэдэд үзүүлдэг эрх зүйн иж бүрэн нэг цэгийн үйлчилгээ илт үгүйлэгдэж байна. Эрх зүйн иж бүрэн үйлчилгээний цогцолбор нь эрх зүйч мэргэжлийн хүмүүс нэгд, хуулийн зөвлөгөө өгөх, хоёрт, өмгөөллийн үйл ажиллагаа явуулах, гуравдугаарт, нотариатын үйлчилгээ үзүүлэх, дөрөвдүгээрт, хуулийн орчуулга хийх, тавдугаарт, хуулийн лавлагаа өгөх ажилбарын хэлбэр нь томсгосон буюу бичил багаар хамтын хөдөлмөрийн хосолмол аргачлалаар ажиллах юм.

Хуулийн зөвлөгөө өгөх алба нь үйлчлүүлэгчийн хүсэлтийн товч гол агуулгыг сонсоод нарийн мэргэшсэн хуульчидтай холбон өгч гэрээг хийхэд нь туслах, нэхэмжлэл, өргөдөл, гомдлыг бичих, нотлох баримт цуглуулах зэргээр техникийн чанартай ажлыг гүйцэтгэх бөгөөд энэ ажилд залуусыг дадлагажуулахад чухал хувь нэмэр болно.

Харин өмгөөлөх үйл ажиллагааг нарийн мэргэшүүлэн эрүүгийн, түүнийгээ дотор нь онц хүнд, хүнд, хүндэвтэр, хөнгөн, эрх зүйн зөрчлийн гэж ангилахаас гадна иргэний хэрэг, маргааны өмгөөлөгч нарыг банк, санхүү, худалдаа арилжааны, гэр бүлийн хөдөлмөрийн, татвар, хил гааль, барилга, уул уурхай гэх мэтээр ангилах юм. Шаардлагатай бичиг баримтыг тухайн газар дээр нь баталгаажуулах үйлчилгээг үзүүлдэг, энэ нь өмгөөлөгч оролцохгүй учраас өөрийнхөө өөрийнхөө үйлчлүүлэгчийн бичиг баримтыг буруу, зөв баталсан гэх хэл аманд өртөхгүй, үйлчлүүлэгч нотариат хайж гадагш явж цаг заваа үрэхгүй сайн талтай. Хуулийн орчуулгыг хийхдээ орос, хятад, англи, солонгос гэх мэт хэд хэдэн хэлнээс хөрвүүлэх чадвартай, тусгай зөвшөөрөлтэй бичил баг байх ба шаардлагатай үед хуулийн байгууллагад хэлний орчуулагч хийсдэг, мөн хараагүй, хэлгүй зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэлмэрч хийж тусалдаг нарийн мэргэжлийн хүн байх юм. Эцэст нь, кодификаторчтай байх энэ үндсэн дээр өөрийн багийнханд үе үе шинэ мэдээлэл өгөх, лавлагаагаар хангах, ер хүссэн хүн ирж тухайн хууль хүчинтэй эсэх талаар лавлагаа авах боломжоор хангагдах болно. Энэ бүх нүсэр ажлыг тухайн эрх зүйн иж бүрэн үйлчилгээний цогцолборын диспедчер холбоо техник хэрэгсэл ашиглан арын албыг залгуулах учиртай.

Эрх зүйн үйлчилгээг байнгын тогтмол 24 цагийн ажиллагаатай болгон, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэхэд байнгын бэлэн байдалд байх аваас цагдаа, прокурор, шүүхийн хойшлуулшгүй ажилд ч тустай, хувь хүнд ч хэрэгцээтэй зүйл юм. Үүний тулд гагцхүү шийдвэрлэх шаардлагатай нэг асуудал бол барилга, техник, тоног төхөөрөмж, машин унааны товчхондоо эдийн засгийн бэрхшээлтэй тулгарна. Энэхүү бэрхшээлээс гарах арга зам бол хуульчдын нэгдмэл санаа, нэг зорилго, хамтын оюуны хүч чармайлтын үр дүнд санхүүгийн эх үүсвэрийг бий болгох, "таван эх үүсвэр байгаа" зарчмаар тулгамдсан асуудлыг эрэгээр шийдвэхэд бүрэн боломж байгаа юм. Гагцхүү энэ алтан боломжийг алдахгүй байхыг эрхэм хуульч таны оюуны мэлмийд өргөн барьж байна.



Үргэлжлэл. (түрүүч нь 2005 оны №3, №4, 2006 оны №1, №2, №3-т)

Латин нэр томъёо

Clientela –	үйлчлүүлэгчдийн нэгдэл
Coactus	албадан
Coactus tamen volui, sed per praetorem restituendus sum	албадлаганд байсан ч би өөрийнхөө санааг илэрхийлсэн
Coarto	товчлох
Codex	хууль; ном
Codicillus	гэрээслэлийн нэмэлт
Coemptio	худалдан авах
Coeo	тохирох
Coepi	эхлэх
Coerceo	барих; шийтгэл хүлээлгэх
Coercitio	шийтгэл; номхотгох
Coetus	цуглаан
Cogente necessitate	зайлшгүй шаардлагаар явуулсан үйл ажиллагаа
Cogitatio	санаа, зорилго; шүүмжлэн хэлэлцэх
Cogitationis poenam nemo patitur	үзэл санааныхаа төлөө хэн ч шийтгэл хүлээдэггүй
Cogito	бодох
Cognati	эхийн талын цусан төрөл ба эхийн талын садан
Cognatio	ураг төрөл, цусан төрөл
Cognatus	төрлийн, хамаатны
Cognitio	хэрэг мөрдөх, хэрэг хүлээлгэх
Cognitor	хууль хамгаалагч
Cognitus	олж мэдэх; таних
Cognomen	хоч, хоч нэр
Cognovit actionem	шударга ёс болон нэхэмжлэлийн үндэслэлийг татгалзахын оронд хүлээн зөшөөрөх
Cognovit actionem relicta verificatione	өөрийгөө хамгаалах үүднээс буюу нэхэмжлэлийн эсрэг гаргасан хариуцагчийн татгалзал
Cogo	албадах
Cohabito	хамт амьдрах, хамт оршин суух
Cohaeredes una persona censentur, propter unitatem juris quod habent	өв хөрөнгийг хамтарч эзэмшдэг учраас хамтран өв залгамжлагчдыг нэг этгээд гэж авч үзнэ
Coheres	удам залгамжлагч

хууль зүйн мэдээний хүрээлэн www.nli.gov.mn


Coincidentia	тохиолдлоор
Coiudices	шүүхийн туслахууд
Collatio	жишиж үзэх, харьцуулах
Collatio bonorum	тэнцүү хуваарилагдах асуудал тавигдсан, хэд хэдэн этгээдэд харьяалагдах өмч хөрөнгийн нэгтгэл
Collatio signorum	тамгануудын ижил эсэхийг харьцуулах
Colleco	саатуулах
Collega	нөхөр
Collegatarius	гэрээслэлд өөр этгээдтэй эсвэл бусад этгээдүүдтэй хамт бичигдсэн ашиг хүртэгч
Collegium	хамт олон; хуулийн этгээд
Colligendum bona defuncti	нас барсан этгээдийн эд хөрөнгийг цуглуулж эмхлэх
Colligo	хамтад нь холбох; цуглуулах
Collisio	тулгарах
Collistrigium	шившгийн багана
Colloquium	ярилцлага
Collybista	санхүүгийн зуучлагч
Collybus	мөнгөний солилцоо; валютын ханш; валютын арилжаа
Colo	заншуулах; нөлөөлөх
Colonus	колон; хамжлагын тариачин
Color	будаг
Colore officii	албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах
Columbarium	нас барагчдын чандрыг хадгалахад зориулсан байр
Combustio domorum	байшинд түймэр тавих; түймэр тавих
Comes	дагуул
Cominus	гардан; гардан байлдаанд
Comitas	харилцаа
Comitas gentium	олон улсын таатай харилцаа
Comitas inter communitates	улс хоорондын найрсаг харилцаа; улс орнууд хоорондоо хууль ба ёс заншлаа харилцан хүлээн зөвшөөрөх
Comitia	магистратуудыг сонгох болон хууль гаргах эрхтэй ардын хурал
Comitia centuriata	центур ба зуутуудаас сонгогдогчид оролцсон Ромын хурал
Comitia curiata	гучин патрици оролцсон Ромын хурал
Comitia tributa	триб эсвэл дүүргээс сонгогдсон сонгогдогчид оролцсон Ромын хурал
Comitor	дагалдах
Commeatus	амралт чөлөө

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

Commemoro	сануулах
Commendatio	тайлбар; зөвлөгөө
Commendo	даалгах
Commentarius	тайлбарлах; тайлбар, тодорхойлолт
Commercia belli	дайтаж байгаа орнуудын иргэд хоорондын хэлэлцээр
Commercium	худалдаа, худалдааны эргэлт
Commissarii lex	худалдан авагч үүргээ биелүүлээгүй тохиолдолд зээл олгох хэлэлцээгээ хүчингүй болгож болох худалдагчийн эрх
Commilito	цэргийн найз, хамсаатан
Committo	үйлдэх; нэгтгэх; харьцуулах
Commodatum	зээл
Commodo	тус хүргэх; зээл олгох
Commodum	ашиг; ашиг сонирхол
Commodum ejus esse debet cujus periculum est	аз туршиж байгаа хүн ашиг олох ёстой
Commodum ex injuria non oritur	хууль зөрчих замаар ашиг болон давуу талыг олж болохгүй
Commodum ex injuria sua non habere debet	хэн ч хууль бус үйлдлээрээ ашиг олох ёсгүй
Commodus	тохиромжтой; ашигтай
Commonia(communia)turbariae	түрээслүүлэгчийн газраас хүлэр олборлох түрээслэгчийн эрх
Commotus	тайван бус
Commune bonum	нийтийн баялаг, нийгмийн баялаг
Commune consilium regni	хаант засгийн ерөнхий зөвлөл
Commune placitum (communia placita)	иргэний нэхэмжлэл
Commune vinculum	ерөнхий үүрэг буюу нийтлэг холбоо; ижил цусан гаралтай
Communi dividundo	хамтын эзэмшилд байгаа хөрөнгөө хуваах тухай нэхэмжлэл
Communi observantia non est recedendum	ердийн буюу нийтийн ажил хэргээс хойш суух хэрэггүй
Communia pasturae	бусдын өмчийн газар дээр өөрийн малыг хариулах эрх
Communia piscariae	түрээслүүлэгчийн усан сангаас загас барих түрээслэгчийн эрх
Communicatio	харилцаа; нэгдэл
Communico	оролцох; хэлэлцэж тохирох
Communio	бэхжүүлэх
Communio bonorum	хөрөнгө хамтарч эзэмших

/үргэлжлэл дараагийн дугаарт/

“АНУ-ын шүүхийн тогтолцоо, онцлогийн талаархи сургалт зохиов”



АНУ-ын Техас мужийн Уислэн Их сургуулийн Хуулийн дээд сургууль, Азийн шүүх эрх мэдлийн хүрээлэн, Хууль зүйн үндэсний төвтэй хамтран “Эрх зүйн боловсрол ба хуульчдын дипломын дараах сургалт”, “Шүүхийн мэтгэлцэх зарчим” сэдэвт сургалтыг 10 дугаар сарын 9-өөс 10-ны өдөр зохион байгууллаа. Өнөөгийн АНУ-ын Үндсэн хууль болон шүүхийн тогтолцоо, түүний онцлог, шүүхийн хараат бус байдлын тухай, шүүхийн мэтгэлцээний зарчим зэрэг олон мэдээллийг сургалтад оролцогсдод өгсөн юм. Сургалтыг Уислэн их сургуулийн Хуулийн дээд сургуулийн профессор Жое Спурлок, тус сургуулийн профессор Г.Ганзориг нар удирдав.

Сургалтын гол зорилго нь Монголын шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад шүүгчдийн гүйцэтгэх үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх асуудалд шүүгч, хуульчдын анхаарлыг хандуулах байв.

Сургалтад өмгөөлөгч, шүүгч, прокурор, нотариатч нийт 40 хүнийг хамруулсан бөгөөд энэ үеэр АНУ-ын шүүхийн тогтолцоог Монгол Улсын шүүхийн тогтолцоотой харьцуулан хэлэлцэж, чөлөөт ярилцлага өрнүүлсэн юм. Мөн АНУ-ын шүүхийн тогтолцооны онцлогтой талууд болох хоёр тал зуучлалын журмаар хэргийг хэрхэн шийддэг, нотлох баримтын хуулийн талаар, хэргийг ямар тохиолдолд хэрэгсэхгүй болгодог, “БАР”-ын холбоо, хууль зүйн сургалтын тогтолцоо, тавигдах шалгуур зэрэг асуудал сургалтад оролцогсдын анхаарлыг ихэд татаж байлаа.

У.Болд

“ Энэ оны байдлаар 113 Монгол хүн ногоон карт хожжээ”

Бидний мэддэг “Цахим өртөө” веб сайт нь “Цахим өртөө” холбоо нэртэйгээр үйл ажиллагаа явуулдаг болоод удаагүй байна. Тус холбоо тодорхой сэдвээр жил бүр уулзалт, ярилцлага зохион байгуулдаг уламжлалтай. Энэ удаагийн уулзалт, ярилцлага тус холбооны гишүүн “Ганзориг консултинг” компанийн захирал Г.Ганзоригийн “Цагаачлалын тухай хууль” сэдвээр 10 дугаар сарын 16–ны өдөр Монголын хэвлэлийн хүрээлэнгийн мэдээллийн төвд боллоо. Уулзалт, ярилцлага нь хэрхэн хууль ёсоор АНУ-д оршин суух вэ, хэдэн төрлийн визийг ямар журмаар авах вэ, ногоон картын талаар зэрэг асуултад хариу өгөхөд чиглэгдсэн юм. Энэ удаагийн



уулзалт, ярилцлагад оролцогсод эдгээр асуудлаар сонирхсон олон асуултдаа хариулт авсан юм.

АНУ-ын цагаачлалын шинэтгэлийн хууль 2006 онд багтан батлагдахгүй нь тодорхой болжээ. Уг хуулийн төсөлд “хууль бусаар оршин сууж байгаа хүмүүст ажиллах зөвшөөрөл, ногоон карт авахаар өргөдөл гаргах эрхтэй” болгоно гэж заасан байгаа аж. Түүнчлэн энэ оны 7 дугаар сарын 19-ний өдөр АНУ-ын Төрийн департаментийн мэдээлснээр, АНУ-д цагаачлах эрхийн ногоон картыг 113 монгол хүн хожжээ.

Б.Ундармаа

www.nli.gov.mn

Эрх зүйн шинэтгэл: Өчигдөр, өнөөдөр,



Зүүн гар талаас гурав дахь нь Г.Эрдэнэбат



Зүүн гар талаас: Б.Даваажав, Х.Номингэрэл, М.Номинцэцэг, Б.Энхболд

Хууль зүйн алба үүсгэн байгуулагдсаны 85 жилийн ойд зориулан Хууль зүй дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний төв, Нээлттэй Академи хамтран "Эрх зүйн шинэтгэл: Өчигдөр, өнөөдөр, маргааш" сэдвийн хүрээнд Монголын хууль зүйн салбарын хуульч, эрдэмтэн, судлаачдын "Алтан" үеийнхний төлөөллийн онол практикийн Бага Хурлыг 11 дүгээр сарын 28-нд Хууль зүйн Үндэсний төвд зохион байгууллаа.

Энэхүү онол практикийн Бага Хурлыг ХЗДХЯ-ны сайд Д. Одбаяр нээж, Хууль зүйн алба үүсгэн байгуулагдсаны 85 жилийн ойд зориулан дээрх сэдвийн хүрээнд гурван үеийн төлөөллийн эрдэм шинжилгээ, онол практикийн Бага хурлыг зохион байгуулж байгаагаар онцолсон юм. Тус хурлаар "Хууль тогтоох үйл ажиллагааны шинэтгэлийн тухайд" сэдвээр гавьяат хуульч, доктор, профессор Б. Чимид "Хууль зүйн боловсрол" сэдвээр Монгол Улсын гавьяат хуульч, Академич, Ж.Амарсанаа, "Шүүх эрх мэдэл" сэдвээр МУИС-ийн ХЗС-ийн багш, доктор, профессор Н.Лүндэндорж, "Эрх зүйн соёл" сэдвээр УИХ-ын дэд дарга, доктор, профессор Д.Лүндээжанцан, "Хууль зүйн шинжлэх ухаан" сэдвээр академич С.Нарангэрэл нар тус тусилтгэл тавьж, тус сэдвийн хүрээнд оролцогчидын дунд хэлэлцүүлэг өрнүүлж, сонирхсон асуултанд хариулж, үнэт санал бодлоо солилцсон юм.

Уг арга хэмжээний "Дунд" үеийн төлөөлөл болох хууль зүйн залуу багш, судлаачдын Эрдэм шинжилгээний бага хурал 11 дүгээр сарын 23 нд ХЗҮТ-д болсон бөгөөд хурлыг ХЗҮТ-ийн захирал, академич Ж. Амарсанаа нээсэн юм. Бага хурлаар нийт арван илтгэл тавигдснаас МУИС-ийн ХЗС-ийн багш Г. Эрдэнэбат "Nullum crimen sine lege" зарчим ба социалист хувилбарын өв уршиг сэдэвт илтгэлээрээ шилдэгийн шилдэгээр шалгарч, оны залуу судлаач өргөмжлөлийн эзэн болсон юм. .

Харин залуу үеийн төлөөлөл болох оюутнуудын шилдэг илтгэлийн уралдаан 11 дүгээр сарын 13 хооронд болсон юм. Тус уралдаанаар Цагдаагийн Академийн сонсогч Б. Энхболдын "Эрүүгийн хэрэг үүсгэх шатан дахь өмгөөлүүлэх эрхийг хангах зарчмын хэрэгжилт, өнөөгийн байдал" сэдэвт илтгэл шилдэгээр шалгарсан бол удаах байруудад Х. Номингэрэлийн "Эрх зүйн шинэтгэлийн туслалцаа: сургамж, шүүмж ", М.Номинцэцэгийн "Шинэ барааны тэмдэг: Sound mark" сэдэвт илтгэлүүд тус тус шалгарсан юм.

Б.Ундармаа

"ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС" СЭТГҮҮЛ НИЙТЛЭЛИЙН ЖАГСААЛТ

№	Сэдвийн нэр	Зохиогчийн нэр, эрхэлсэн ажил	Нийтлэгдсэн дугаар

Төрийн байгууллалтын хууль тогтоомж

1.	**Хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх арга зам**	**Ж.Дашдорж** /Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн/	**2003 он №1(01)**
2.	**Үндсэн хуулийн хяналтын механизм**	**Э.Лхагвасүрэн** /Үндсэн хуулийн цэцийн ажилтан/	**2003 он №1(01)**
3.	**Зохистой захиргааны ерөнхий зарчим**	**Филипп М.Лэнгброек** /орчуулсан С.Гэрэлмаа, ХЗҮТ/	**2003 он №1(01)**
4.	**Монгол улсад захиргааны хэргийн шүүх байгуулах асуудал**	**Н.Тунгалаг** /УИХ-ын Тамгын газрын хуулийн хэлтсийн зөвлөх/	**2003 он №2(02)**
5.	**Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа**	**Н.Отгончимэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2003 он №2(02)**
6.	**Монгол улсын эрх зүйн шинэтгэл**	**Иммануэль Гебхардт** /ХБНГУ, өмгөөлөгч/	**2003 он №2(02)**
7.	**ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх зөвхөн Үндсэн хуульдаа захирагдана**	**Э.Лхагвасүрэн** /Үндсэн хуулийн цэцийн ажилтан/	**2003 он №2(02)**
8.	**Бүгд найрамдах Казакстан улсын Үндсэн хуулийн зөвлөл яаж ажилладаг вэ?**	**Э.Лхагвасүрэн** /Үндсэн хуулийн цэцийн ажилтан/	**2003 он №3(03)**
9.	**Захиргааны байгууллага, албан тушаалтны хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан гэм хорыг арилгах**	**Н.Отгончимэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2003 он №3(03)**
10.	**Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс**	**Б. Чимид** /ХЗҮТ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, гавьяат хуульч, доктор, профессор/	**2004 он №1(04)**
11.	**Дэлхийн зарим орны Үндсэн хууль дахь спортын зохицуулалт**	**Б.Бат-Эрдэнэ** /"Аварга" дээд сургуулийн захирал, докторант/	**2004 он №1(04)**
12.	**Украйны үндсэн хуулийн шүүх**	**Э.Лхагвасүрэн** /Үндсэн хуулийн цэцийн ажилтан/	**2004 он №1(04)**
13.	**Хууль зүйн нэр томьёог оновчтой болгох, зөв хэрэглэх асуудал**	**С.Гэрэлмаа** /ХЗҮТ-ийн Төрийн байгууллалтын хууль тогтоом-жийн секторын эрхлэгч/	**2004 он №1(04)**
14.	**ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх-Шүүх эрх мэдлийн хамгийн дээд зэргэмжийн шүүх болох нь**	**Э. Лхагвасүрэн** /Үндсэн хуулийн цэцийн ажилтан/	**2004 он №1(04)**
15.	**Үндсэн хуулийн хөгжлийг судлахад шинэ хандлага нэн чухал**	**Б. Чимид** /ХЗҮТ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, гавьяат хуульч, доктор, профессор/	**2004 он №2(05)**
16.	**Монгол Улсын эрх зүйн тогтолцоо: Өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага**	**С.Төмөр** /УИХ-ын гишүүн асан, Хууль зүйн доктор, профессор/	**2004 он №3(06)**

17.	**Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэхэд анхаарах нь**	**Б. Цогням** /Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн шүүхийн сургагч багш/	**2004 он №3(06)**
18.	**Хууль зүйн нэр томьёоны талаархи зарим асуудал**	**Д. Баянбилэг** /ХЗҮТ-ийн мэдээлэл, сурталчилгааны төвийн дарга/	**2004 он №3(06)**
19.	**Захиргааны шүүх нь хүний нэгдсэн эрхийг хамгаалах үндсэн баталгаа болох нь**	**Г.Банзрагч** /ХБНГУ-ын Байротын Их сургуулийн докторант/	**2004 он №3(06)**
20.	**Ардчилсан нийгэм, улс төрийн плюрализм**	**Ш. Цогтоо** /МУИС-ийн ХЗС-ийн багш, доктор, дэд профессор/	**2004 он №4(07)**
21.	**Бидний сонгох, сонгогдох эрх**	**С.Гэрэлмаа** /ХЗҮТ-ийн Төрийн байгуулалтын хууль тогтоомжийн секторын эрхлэгч/	**2004 он №4(07)**
22.	**Бүгд Найрамдах Беларусь улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай**	**Э.Лхагвасүрэн** /Үндсэн хуулийн цэцийн ажилтан/	**2004 он №4(07)**
23.	**Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар**	**С.Гэрэлмаа** /ХЗҮТ-ийн Төрийн байгуулалтын хууль тогтоом-жийн секторын эрхлэгч/	**2005 он №1(08)**
24.	**Гүрж улсын Үндсэн хуулийн шүүх: зохион байгуулалт, үйл ажиллагаа**	**Э.Лхагвасүрэн** /Үндсэн хуулийн цэцийн ажилтан/	**2005 он №1(08)**
25.	**Иргэдийн шилжин суурьших хөдөлгөөнд хяналт тавих нь**	**Ц.Ганзориг** /ИБМУТ-ийн Бүртгэл, мэдээллийн хэлтсийн мэргэжилтэн/	**2005 он №1(08)**
26.	**Хууль зүйн алдаатай нэр томъёо Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нь**	**Э.Ариунаа** /ТЕГ-ын Дээд сургуулийн багш/	**2005 он №2(09)**
27.	**Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын асуудалд**	**У.Мөнхбат** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2005 он №2(09)**
28.	**Литвийн Үндсэн хуулийн шүүхийн тухай**	**Э.Лхагвасүрэн** /Үндсэн хуулийн цэцийн ажилтан/	**2005 он №2(09)**
29.	**Хүний нэр төр, алдар хүнд ба Үндсэн хуулийн эрх зүйн хамгаалалт**	**Ш.Сүхбаатар** /МУИС-ийн докторант/	**2005 он №3(10)**
30.	**Ерөнхийлөгчийн институтэд эрх зүйт ёсны үүднээс хандах нь**	**Ч.Өнөрбаяр** /МУИС-ийн докторант/	**2005 он №3(10)**
31.	**Монгол Улс дахь хууль дээдлэх ёсны төлөвшил-өнгөрсөн, одоо, ирээдүй**	**Э.Ганболд** /УИХ-ын Тамгын газрын ажилтан/	**2005 он №3(10)**
32.	**Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх**	**Д.Оросоо** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2005 он №3(10)**
33.	**Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад анхаарах зарим асуудалд**	**Ж.Жавзандулам** /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, докторант/	**2005 он №3(10)**
34.	**Хуулийн тайлбар**	**Танабэ Масанори** /Жайка-ийн эрх зүйн шинэтгэл, туслалцаа төслийн мэргэжилтэн/	**2005 он №3(10)**
35.	**Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө ба олон нийтийн хэвлэл мэдээлэл**	**М.Батсуурь** /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, докторант/	**2005 он №3(10)**
36.	**Башкиртостан улсын Үндсэн хуулийн шүүхийн онцлог**	**Э.Лхагвасүрэн** /Үндсэн хуулийн цэцийн ажилтан/	**2005 он №4(11)**
37.	**Нийтийн эрх зүйн гэрээ**	**Н.Тунгалаг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2005 он №4(11)**
38.	**Цагдаагийн байгууллагын менежмент**	**Б.Ванган** /ЦЕГ-ын Тамгын газрын шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа/	**2005 он №4(11)**

39.	**Монгол Улсын үндэсний эрх зүйн соёлын төлөвшилт**	**Д.Таванжин** /Цагдаагийн академийн багш, доктор/	**2005 он №4(11)**
40.	**Үндсэн хууль ба хүний эрхийн зарим асуудал (хураангуй)**	**Д.Баянбилэг** /ХЗҮТ-ийн Хууль зүйн мэдээлэл, сурталчилгааны төвийн захирал/	**2006 он №1(12)**
41.	**Францын Үндсэн хуулийн зөвлөлийн онцлог**	**Э.Лхагвасүрэн** /Үндсэн хуулийн цэцийн ажилтан/	**2006 он №1(12)**
42.	**Оршин суух газраа сонгох эрх, түүний эрх зүйн үндсийг шинэтгэх асуудал**	**Ц.Цэрэнням** /МУИС-ийн магистрант/	**2006 он №1(12)**
43.	**Үндэсний эв нэгдлийг хангахад эрх зүйн үүрэг, ач холбогдол**	**Б. Чимид** /ХЗҮТ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, гавьяат хуульч,доктор, профессор/	**2006 он №2(13)**
44.	**Латви Улсын Үндсэн хуулийн шүүхийн онцлог**	**Э.Лхагвасүрэн** /Үндсэн хуулийн цэцийн ажилтан/	**2006 он №2(13)**
45.	**Эрх зүй, хуулийн тухай өгүүлэх нь**	**А.Энхбат** /МӨХ-ны гишүүн, өмгөөлөгч, доктор/	**2006 он №2(13)**
46.	**Эрх зүйн шинэтгэлийн үйл явц ба хүний эрх**	**Д.Баянбилэг** /ХЗҮТ-ийн Хууль зүйн мэдээлэл, сурталчилгааны төвийн захирал/	**2006 он №2(13)**
47.	**Төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын агуулга, чиг үүрэг**	**С.Гэрэлмаа** /РЗҮТ-ийн ТБХТ-ийн секторын эрхлэгч/	**2006 он №3(14)**
48.	**Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн баталгаажилт**	**Ш.Үнэнтөгс** /ХЗДХЯ-ны мэргэжилтэн/	**2006 он №3(14)**
49.	**Армен улсын Үндсэн хуулийн шүүхийн онцлог**	**Б.Лхагвасүрэн** /ҮХЦ-ийн Тамгын газрын ажилтан/	**2006 он №4(15)**
50.	**Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн баталгаажилт**	**Ш.Үнэнтөгс** /ХЗДХЯ-ны мэргэжилтэн/	**2006 он №4(15)**
51.	**Өрнөдийн шашин номлогчдын Монголчуудтай холбогдох нь**	**Т.Төмөрхүлэг** /МУИС-ийн НУС-ийн дэргэдэх Түүхийн судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор/	**2006 он №4(15)**
52.	**Ард түмэн төрийн хэрэгт шууд оролцох эрх буюу ард нийтийн санал асуулга**	**С.Эрдэнэболор** /Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш/	**2006 он №4(15)**

Иргэний хууль тогтоомж

1.	**Газрын эзэн, эрх зүйн асуудал**	**Т.Сэнгэдорж** /доктор, профессор/	**2003 он №1(01)**
2.	**Оюуны өмчийн түүхэн хөгжлийн тойм**	**Д.Цолмон** /ХЗҮТ-ийн иргэний хууль тогтоомжийн секторын эрхлэгч/	**2003 он №1(01)**
3.	**Англи-Саксоны эрх зүй дэх хөрөнгийн барьцааны ойлголт, төрөл, баталгаажуулалт**	**Ж.Баттуяа** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2003 он №2(02)**
4.	**2002 оны Иргэний хууль ба зөрчилдөөний хэм хэмжээ**	**Т.Мэндсайхан** /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн профессор, доктор/	**2003 он №3(03)**
5.	**Лизингийн гэрээний ойлголт, түүний төрөл: Эрх зүйн зохицуулалтын асуудалд**	**У.Мөнхбат** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2003 он №3(03)**
6.	**Үл хөдлөх хөрөнгийг хуулиар хамгаалдаг**	**О.Цэвэлмаа** /Отгонтэнгэр их сургуулийн магистрант/	**2003 он №3(03)**
7.	**Гэр бүлийн хууль тогтоомжийн түүхэн хөгжил**	**А.Дугармаа** /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш/	**2003 он №3(03)**

8.	**Арбитрын тухай шинэ хуулийн талаар өгүүлэх нь**	**Б.Дашдондог** /Хуульч/	**2003 он №3(03)**
9.	**Хөршийн эрх**	**Б. Гэрэл** /МУИС-ийн магистрант/	**2004 он №1(04)**
10.	**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хугацааны эрх зүйн зохицуулалт**	**П. Баттогтох** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2004 он №1(04)**
11.	**Гэрлэлтийн харьцаанаас үүссэн маргаантай хэргийг шийдвэрлэхэд анхаарах асуудал**	**Л. Бямбаа** /Нийслэлийн шүүхийн шүүгч/	**2004 он №1(04)**
12.	**Хамтран ажиллах гэрээ**	**Ч. Нарантуяа** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2004 он №1(04)**
13.	**Монгол Улсын газрын хууль тогтоомжийн түүхэн хөгжил**	**Н. Отгончимэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант/	**2004 он №2(05)**
14.	**Зохиогчийн эрхийн тэмдэглэгээ**	**Д.Цолмон** /ХЗҮТ-ийн секторын эрхлэгч, Удирдлагын академийн ахлах багш/	**2004 он №2(05)**
15.	**Өөртөө туслах эрхийн мөн чанар, онцлог**	**Т.Мэндсайхан** /ХЗҮТ-ийн Хууль зүйн сургалтын төвийн эрхлэгч, доктор/	**2004 он №2(05)**
16.	**Бусдын газар дээр барилга байгууламж барих эрх**	**Д. Отгончимэг** /ХЗДХЯ-ны ахлах мэргэжилтэн/	**2004 он №2(05)**
17.	**"Нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийн хэргийг шүүхээр шийдвэрлэж байгаа нь**	**Л.Бямбаа** /Нийслэлийн шүүхийн шүүгч/	**2004 он №2(05)**
18.	**Төлөөлөл**	**Ч.Амгалан** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2004 он №3(06)**
19.	**Иргэний хэргийг давж заалдах шатаар хянах ажиллагаа**	**Д.Хуяг** /МУИС-ийн ХЗС-ийн багш, докторант/	**2004 он №4(07)**
20.	**Татварын хуулийг хэрэглэж буй практикийн зарим асуудал**	**А.Доржготов** /Улсын дээд шүүхийн шүүгч/	**2004 он №4(07)**
21.	**Газрын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал**	**Х.Оюунцэцэг** /Удирдлагын академийн ахлах багш/	**2005 он №1(08)**
22.	**Сервитут, түүний хөгжил**	**Б.Энхмаа** /МУИС-ийн магистрант/	**2005 он №1(08)**
23.	**ИХШХША дахь төлөөлөлтийн зарим асуудал**	**А.Түвшинтулга** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтны туслах/	**2005 он №1(08)**
24.	**Барьцааны эрх-Эдийн эрх болох тухай асуудалд**	**Д.Бат-Өлзий** /ТЕГ-ын Дээд сургуулийн багш, дэд профессор/	**2005 он №1(08)**
25.	**Давж заалдах шатны шүүхээс иргэний хэргийг хянан шийдвэрлэх хэмжээ, хязгаар**	**Д.Хуяг** /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, докторант/	**2005 он №1(08)**
26.	**Хөөн хэлэлцэх хугацаа нь завсарлаагүй гэж үзсэн байна**	Японы шүүхийн шийдвэрийн "Цаг үе, мэдээлэл" сэтгүүлээс	**2005 он №1(08)**
27.	**Иргэний хэргийг шүүгч дангаар ба бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэх зарим асуудал**	**Д.Хуяг** /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, докторант/	**2005 он №2(09)**
28.	**Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн ач холбогдол**	**Д.Янжмаа** /ИБМУТ-ийн мэргэжилтэн/	**2005 он №2(09)**
29.	**ГТХАН-Монгол улсын хууль зүйн салбарт-10 жил**	**Л.Заяа** /ГТХАН-ийн зохицуулагч/	**2005 он №2(09)**
30.	**Иргэний хуулийг тайлбарлах нь**	Цуврал	**2005 он №2(09)**
31.	**Өөртөө туслах нь өөрийн хамгаалалтын арга болох тухай асуудалд**	**Д.Бат-Өлзий** /ТЕГ-ын Дээд сургуулийн багш, дэд профессор/	**2005 он №3(10)**
32.	**Арбитрын ажиллагааны нууцлалын зарим асуудал**	**Д.Цолмон** /ХЗҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын эрхлэгч/	**2005 он №3(10)**

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.mn.gov.mn

33.	**Иргэний хуулийг тайлбарлах нь**	Цуврал	**2005 он №3(10)**
34.	**Шударга өрсөлдөөн-бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлнэ**	**Б.Жаргалсайхан** /Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газрын дарга/	**2005 он №3(10)**
35.	**Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх, түүнтэй холбоотой маргааныг шийдвэрлэх нь**	**А.Доржготов** /УДШ-ийн шүүгч/, **Д.Цэнд-Аюуш** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний дэд ажилтан/	**2005 он №4(11)**
36.	**Эрх зүйн зарим бүл дэх компанийн асуудал**	**Т.Жаргалсайхан** /ХЗҮТ-ийн сургалтын төвийн багш, магистр/	**2005 он №4(11)**
37.	**Иргэний хуулийг тайлбарлах нь**	Цуврал	**2005 он №4(11)**
38.	**Иргэний хэргийн хөдөлгөөний менежмент, хууль зүйн зохицуулалт**	**У.Мөнхбат** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2006 он №1(12)**
39.	**Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, заалтад дүн шинжилгээ хийх нь**	**С.Ганцэцэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний дэд ажилтан/	**2006 он №1(12)**
40.	**Уламжлалт мэдлэгийг оюуны өмчийн эрх зүйгээр хамгаалах нь**	**Д.Эрдэнэчимэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, Отгонтэнгэр их сургуулийн багш/	**2006 он №1(12)**
41.	**Анхан шатны шүүхийн практикийг судалсан судалгааны тайлан**	**Д.Цолмон** /ХЗҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын эрхлэгч/	**2006 он №1(12)**
42.	**Иргэний хэргийг хяналтын шатаар хянан шийдвэрлэх ажиллагаа**	**Д.Хуяг** /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, докторант/	**2006 он №1(12)**
43.	**Иргэний хуулийг тайлбарлах нь**	Цуврал	**2006 он №1(12)**
44.	**Иргэний хэргийг хяналтын журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох нь**	**Д.Хуяг** /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, докторант/	**2006 он №2(13)**
45.	**"Know-how" эзэмшигчийн эрхийг хамгаалах арга**	**Д.Эрдэнэчимэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, Отгонтэнгэр их сургуулийн багш/	**2006 он №2(13)**
46.	**Хөдөлмөрийн эрх зүй дэх цалин хөлс, олговор**	**С.Болормаа** /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш/	**2006 он №2(13)**
47.	**Газрын харилцаанаас үүссэн маргаан, түүнийг шийдвэрлэх нь**	**Д.Цэнд-Аюуш** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний дэд ажилтан/	**2006 он №2(13)**
48.	**Хөдөлмөрийн эрх зүй дэх үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний төлөв байдал**	**С.Ганцэцэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний дэд ажилтан/	**2006 он №2(13)**
49.	**Хамтран амьдрагсдын тогоо руу өнгийхөд ...**	**Р.Энхтүвшин** /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш/, **Г.Батчимэг** /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан/	**2006 он №2(13)**
50.	**Иргэний хуулийн тайлбар**	Цуврал	**2006 он №2(13)**
51.	**Франчайзийн гэрээ, түүний онцлог**	**Г.Мөнхболд** /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант/	**2006 он №3(14)**
52.	**Шилжилтийн үеийн нийгмийн халамжийн эрх зүй**	**Д.Эрдэнэчимэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, Отгонтэнгэр их сургуулийн багш/	**2006 он №3(14)**
53.	**Иргэний хуулийн тайлбар**	Цуврал	**2006 он №3(14)**
54.	**Хөдөлмөрийн гэрээ цуцалсан маргаан шийдвэрлэх зарим асуудал**	**Л.Баасан** /Отгонтэнгэр их сургуулийн дэд захирал, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор/	**2006 он №4(15)**
55.	**Санхүүгийн түрээс, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал**	А.Доржготов /Улсын дээд шүүхийн шүүгч/	**2006 он №4(15)**

56.	**Ажлын байран дахь бэлгийн дарамтлалын эсрэг хууль тогтоомжийн хэрэгцээ**	Д.Эрдэнэцэцэг /Отгонтэнгэр их сургуулийн багш, ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2006 он №4(15)**
57.	**Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын зарим конвенцийн хэрэгжилтийн талаар цухас авч үзэх нь**	С.Ганцэцэг /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний дэд ажилтан/	**2006 он №4(15)**
58.	**Аккредитивийн төлбөр тооцоо, түүнийг хэрэгжүүлэх журам**	Г.Батчимэг /Хуульч/	**2006 он №4(15)**
59.	**Иргэний хуулийн тайлбар**	Цуврал	**2006 он №4(15)**

Шүүх эрх мэдэл

1.	**Монгол улсын шүүх эрх мэдлийн тогтолцоо ба шүүхийн эрх зүйн үзэл баримтлалын зарим асуудал**	**Ц.Амарсайхан** /Улсын Дээд шүүхийн шүүгч/	**2003 он №3(03)**
2.	**Ази, номхон далайн зарим орны хорих байгууллага: Өнөөгийн байдал, чиг хандлага**	**Р.Оюунбадам** /Эмэгтэйчүүдийн хорих ангийн дарга, гавъяат хуульч, хурандаа/	**2003 он №3(03)**
3.	**Шүүгчийн ёс зүй**	**Ж.Амарсанаа** /ХЗҮТ-ийн захирал, академич/	**2004 он №1(04)**
4.	**Шүүхийн шийтгэх тогтоолын үндэслэл ба шүүхээс гарах дүгнэлт**	**Д.Баярсайхан** /Улсын дээд шүүхийн шүүгч/	**2004 он №1(04)**
5.	**Гаалийн хууль тогтоомжийг зөв хэрэглэх асуудал**	**О.Зандраа** /Улсын дээд шүүхийн шүүгч/	**2004 он №2(05)**
6.	**Фидуцийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал**	**П.Цэцгээ** /Улсын дээд шүүхийн судалгааны төвийн захирал/	**2004 он №2(05)**
7.	**Захиргааны хэргийн шүүх: харьцуулсан судалгаа**	**Н.Отгончимэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант/	**2004 он № 2(05)**
8.	**Шүүгчийн ёс зүйн байдлын судалгаа**	**Д.Золзаяа** /ШУА –ийн философи социологийн эрх зүйн хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан /	**2004 он №2(05)**
9.	**Шүүхийн эрх зүй дэх үнэний асуудал**	**Ц.Амарсайхан** /Улсын дээд шүүхийн шүүгч/	**2004 он №3(06)**
10.	**Шүүх засаглал: онол практикийн зарим асуудал**	**Ц.Амарсайхан** /Улсын дээд шүүхийн шүүгч/	**2004 он №4(07)**
11.	**Үндсэн хуулийн цэц ба захиргааны хэргийн шүүх**	**Ж.Амарсанаа** /Үндсэн хуулийн цэцийн гишүүн, академич/	**2005 он №1(08)**
12.	**Шүүгчийн нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэж буй үүрэг, хараат бус байдлыг хангах нь**	**Л.Бямбаа** /Нийслэлийн шүүхийн шүүгч/	**2005 он №2(09)**
13.	**Хуулийн уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй**	**Ёоахим Кают** /ХБНГУ-ын Ньюренберг хотын дээд шүүхийн иргэний тэнхимийн тэргүүн/	**2005 он №2(09)**
14.	**Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт шийдвэр гүйцэтгэх арга, журмын асуудалд**	**Д.Оросоо** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2005 он №2(09)**
15.	**Шүүхийн алдаа**	**Ц.Амарсайхан** /УДШ-ийн Иргэний хэргийн танхимын тэргүүн/	**2005 он №4(11)**
16.	**Шүүгчийн ёс зүйг үнэлэх асуудал**	**Ц.Одончимэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2005 он №4(11)**
17.	**Шүүх эрх мэдэл ба шүүхийн бие даасан байдал**	**Л.Бямбаа** /УДШ-ийн шүүгч, докторант/	**2005 он №4(11)**

Хууль зүйн хүрээлэн www.legal.mn

18.	**Хуулийн хэм хэмжээг тайлбарлан хэрэглэх, төсөөтэй хэрэглэх асуудал засаглалын хууль тогтоох ба шүүх эрх мэдлийн эмзэг зааг болох нь**	**Л.Заяа** /ГТХАН-ийн "Хуульчдын сургалт ба давтан сургалт" төслийн удирдагч/	**2005 он №4(11)**
19.	**Захиргааны шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрөл, тэдгээрийн зүйлийг тодорхойлох нь**	**Г.Банзрагч** /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, ХБНГУ-ын Байротын их сургуулийн докторант/	**2005 он №4(11)**
20.	**Шүүгч хараат бус байх зарчим, түүний шалгуурын талаарх онолын асуудал**	**Л.Бямбаа** /УДШ-ийн шүүгч, докторант/	**2006 он №1(12)**
21.	**Шүүхэд гомдол гаргах зарим үндэслэл**	**Д.Янжинхорлоо** /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш/	**2006 он №1(12)**
22.	**Шүүхийн бие даасан байдал төлөвших үйл явц**	**Л.Бямбаа** /УДШ-ийн шүүгч, докторант/	**2006 он №2(13)**
23.	**Хууль хэрэглэх арга ажиллагаа**	**Иммануэль Гебхардт** /ХБНГУ-ын өмгөөлөгч/	**2006 он №2(13)**
24.	**Арбитрын ажиллагаа, шүүхийн оролцоо**	**А.Доржготов** /УДШ-ийн шүүгч/	**2006 он №2(13)**
25.	**Шүүхийн прецедент эрх зүйн эх сурвалж болох нь**	**М.Ариунаа** /Отгонтэнгэр их сургуулийн багш/	**2006 он №2(13)**
26.	**Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын тухай Үндсэн хуулийн эрх зүйн үндэслэл**	**Л.Бямбаа** /УДШ-ийн шүүгч, докторант/	**2006 он №3(14)**
27.	**Захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, харьцуулалт**	**Д.Дэлгэрбат** /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан/	**2006 он №3(14)**
28.	**Шүүхийн менежментийг боловсронгуй болгох үзэл баримтлал**	**Н.Дагва** /Нийслэлийн шүүхийн Тамгын хэлтсийн дарга/	**2006 он №4(15)**
29.	**Захиргааны хэргийн үйл ажиллагааны төлөвшил**	**О.Зандраа** /Улсын дээд шүүхийн шүүгч/	**2006 он №4(15)**
30.	**Шүүх эрх мэдлийн тухайд**	**Ц.Баярмаа** /Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн нарийн бичгийн дарга, хууль зүйн магистр/	**2006 он №4(15)**

Прокурорын хяналт

1.	**Прокурорын чиг үүргийг хэрэгжүүлэх зарим асуудал**	**Б.Цэрэгбалтав** /УЕП-ын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх/	**2003 он №1(01)**
2.	**Шүүн таслах ажиллагаанд прокурор яллах үүрэгтэй оролцдог**	**Ё.Сагсай** /Нийслэлийн прокурорын хяналтын прокурор/	**2003 он №2(02)**
3.	**АНУ-д прокурор ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?**	**Ж.Эрдэнэбаатар** /Нийслэлийн прокурорын туслах, хэлтсийн дарга/	**2003 он №3(03)**
4.	**Мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналтын зарим асуудал**	**Ё.Сагсай** /Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор/	**2004 он №1(04)**
5.	**Олон улсын эрүүгийн шүүхийн үйл ажиллагаанд прокурорын гүйцэтгэх үүрэг**	**Б.Цэрэнбалтав** /Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх/	**2004 он №1(04)**
6.	**Мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналтын чиг үүрэг, бүрэн эрх**	**Т.Сүхбаатар** /Улсын ерөнхий прокурорын газрын туслах, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга/	**2004 он №2(05)**
7.	**Хуульчийн ба прокурорын ёс зүй**	**Б.Цэрэнбалтав** /Улсын ерөнхий прокурорын орлогч/	**2004 он №3(06)**
8.	**Хэргийн газрын үзлэгт прокурор оролцох чиг үүрэг**	**Т.Сүхбаатар** /УЕП-ын туслах/	**2005 он №2(09)**

9.	**Хорих ял эдлүүлэх зарим тулгамдсан асуудал**	**Ц.Мөнхбат** /УЕПГ-ын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор/	**2005 он №3(10)**
10.	**Хүний эрх, прокурорын хяналт**	**Е.Сагсай** /Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор/	**2006 он №1(12)**
11.	**Хорих ялын хэрэгжилт, өнөөгийн байдал**	**Ц.Мөнхбат** /УЕПГ-ын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор/	**2006 он №2(13)**
12.	**Баривчлах ба хорих ялын харилцан хамаарал, эрх зүйн орчин**	**Ц.Мөнхбат** /УЕПГ-ын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор/	**2006 он №3(14)**
13.	**Гэр бүлийн хүчирхийлэл: Хорих ял ба эмэгтэйчүүд**	**Ц.Мөнхбат** /УЕПГ-ын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурор, прокурор/	**2006 он №4(15)**

Олон улсын эрх зүй, Харьцуулсан эрх зүй

1.	**Дэлхийн худалдааны байгууллагын гол хэлэлцээрийн тухай**	**Б.Отгонбаяр** /ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрхлэгч/	**2003 он №1(01)**
2.	**Олон улсын харилцаа-Ази, Номхон далайн орнуудын хэтийн төлөв, Монгол улсын эзлэх байр суурь**	**Ш.Үнэнтөгс** /Хууль зүйн магистр/	**2003 он №1(01)**
3.	**Чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал**	**А.Энх-Амгалан** /Олон улсын эрх зүйч/	**2003 он №2(02)**
4.	**Харьцуулсан эрх зүйн хөгжлийн чиг хандлага ба конвергенци**	**Б.Гүнбилэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2003 он №2(02)**
5.	**Англиин шүүхийн шийдвэрийн эмхтгэл ба эрх зүйн эх сурвалжид тооцогдох ном зохиолын ач холбогдол**	**Б.Гүнбилэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2003 он №3(03)**
6.	**Олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжил, хандлага, Монгол улсын оролцоо**	**Ж.Энхсайхан** /Олон улсын эрүүгийн шүүхийг дэмжих үндэсний эвслийн зөвлөх, хууль зүйн доктор/	**2004 он №1(04)**
7.	**Олон улсын шинжтэй иргэний хэргийг шүүхээр шийдвэрлэх нь**	**Т.Мэндсайхан** /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн дэд профессор, хууль зүйн доктор/	**2004 он №1(04)**
8.	**Консулын хийх Нотариатын үйлдэл**	**А.Төмөр** /Гадаад хэргийн яамны мэргэжилтэн/	**2004 он №1(04)**
9.	**Гадаадын хөрөнгө оруулалтын тухай олон улсын эрх зүй ба гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол улсын хууль**	**Ч.Нарантуяа** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2004 он №2(05)**
10.	**Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенц ба "Монгол улсын олон улсын гэрээний тухай хууль"**	**С.Должин** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан /	**2004 он №2(05)**
11.	**Жишиг эрх зүйн тухай ойлголт**	**Б.Гүнбилэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2004 он №3(06)**
12.	**Эвтанаци буюу өвчтөн хүсэлтээрээ үхэх эрхийн тухай**	**П.Баяр** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2004 он №3(06)**
13.	**Хууль зүйн шинжлэх ухаанд харьцуулсан эрх зүйн эзлэх байр, гүйцэтгэх үүрэг**	**Н.Отгончимэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2004 он №4(07)**
14.	**Оролмаанууд төрөлх эх орон казахстандаа эргэж ирсэн нь**	**Галия Сармурзина** /Казахстаны Кайнерийн их сургуулийн доцент/	**2004 он №4(07)**
15.	**Иракийн дайн ба Олон улсын нийтийн эрх зүйн асуудал**	**Т.Заяа** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2005 он №1(08)**
16.	**Нийтийн ба хувийн эрх зүйн тухайд**	**З.Сүхбаатар** /"Хасагт хайрхан" дээд сургуулийн багш, докторант/	**2005 он №1(08)**

"Хууль дээдлэх ёс", 2006 он, №4

17.	**Арбитрын ажиллагааны олон улсын эрх зүйн зохицуулалт**	**Ч.Сарангэрэл** /"Отгонтэнгэр" их сургуулийн багш/	**2005 он №1(08)**
18.	**Худалдааны эрх зүй-"Lex mercatoria"-ийн тухай ойлголт, түүний үүсэл хөгжил**	**Б.Тамир** /ХЗҮТ-ийн багш/	**2005 он №1(08)**
19.	**Бернийн конвенцийн материаллаг хэм хэмжээ**	**Д.Уянга** /ХБНГУ-ын Фрайбургийн их сургуулийн докторант/	**2005 он №1(08)**
20.	**Интернетийн зохицуулалт, бүтцийн асуудал**	**Вольфанг Килиан** /ХБНГУ-ын Ханноверийн их сургуулийн доктор, профессор/	**2005 он №2(09)**
21.	**Монгол ба Болгар улсын эрх зүйн тогтолцоо**	**П.Баяр** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2005 он №2(09)**
22.	**Олон улсын эдийн засгийн харилцаан дахь үндэстэн дамнасан корпораци**	**Н.Мөнхтуяа** /ХЗҮТ-ийн багш/	**2005 он №2(09)**
23.	**Экстеризм, түүний хэлбэрийн тухай**	**О.Пунцагдаш** /Монгол улсаас БНКазУ-д суугаа ЭСЯ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга, доктор/	**2005 он №2(09)**
24.	**БНХАУ дахь хүний эрхийн төлөв байдал**	**Б.Энх-Амгалан** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2005 он №3(10)**
25.	**ОХУ-ын хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал**	**Т.Жаргалсайхан** /ХЗҮТ-ийн сургалтын төвийн багш, магистр/	**2005 он №3(10)**
26.	**Авилгалын эсрэг НҮБ-ын конвенц ба Монгол Улсын үндэсний хууль тогтоомж**	**Ж.Амарсанаа** /Академич, доктор, профессор/ **Д.Зүмбэрэллхам** /доктор, профессор/ **Ч.Нарантуяа** /магистр/	**2005 он №3(10)**
27.	**Үндэсний шүүхэд олон улсын эрх зүйг хэрэглэх асуудал**	**М.Мөнхбат** /ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрхлэгч/	**2005 он №4(11)**
28.	**Шударга бус өрсөлдөөнийг хориглох эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа**	**Т.Заяа** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2005 он №4(11)**
29.	**Австри улсын нотариатын системийн харьцуулсан судалгаа**	**Д.Янжинхорлоо** /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш/	**2005 он №4(11)**
30.	**Монгол, Казахстаны хоёрдмол харьяаллыг шийдвэрлэх асуудалд**	**О.Пунцагдаш** /Гадаад хэргийн яамны Хөрш орнуудын газрын зөвлөх, доктор/	**2005 он №4(11)**
31.	**Дорно ба өрнийн эрх зүйн томъёоллын түүхэн хандлага, ялгаа**	**Т.Заяа** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/, **А.Серик** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтны туслах/	**2005 он №4(11)**
32.	**Гадаад улсын эрх зүйг хэрэглэх үед үндэстний ашиг сонирхлыг харгалзах нь**	**Д.Бат-Өлзий** /ТЕГ-ын Дээд сургуулийн багш, дэд профессор/	**2005 он №4(11)**
33.	**Дэлхийн эрх зүйн тогтолцоог харьцуулсан эрх зүйн үүднээс ангилах нь**	**Б.Гүнбилэг** /МУИС-ийн докторант/	**2006 он №1(12)**
34.	**Дүрвэгчдийн эрх зүйн байдал**	**А.Төмөр** /Гадаад хэргийн яамны Гэрээ, эрх зүйн газрын атташе/	**2006 он №1(12)**
35.	**Өрсөлдөөний эрх зүй нь үндэстэн дамнасан корпорацийг зохицуулах хамгийн шилдэг арга болж чадах уу?**	**Н.Цогт** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2006 он №1(12)**
36.	**Маргааныг шүүхээс гадуур шийдвэрлэх арга: Зуучлал**	**Ч.Нарантуяа** /Хууль зүйн магистр/, **Ц.Одончимэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2006 он №1(12)**
37.	**Дэлхийн улс гүрнүүдийн хүн ам зүйн бодлого**	**О.Пунцагдаш** /Гадаад хэргийн яамны Хөрш орнуудын газрын зөвлөх, доктор/	**2006 он №1(12)**
38.	**Олон улсын эрх зүйн болон үндэсний эрх зүйн харилцан хамаарал**	**М.Мөнхбат** /ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрхлэгч/	**2006 он №2(13)**

39.	**Эмгэнэлт хэргүүд ба эрүүгийн эрх зүйн гарцаагүй байдлыг эрх зүйн харьцуулсан төлөвт авч үзэх нь**	**Эрик Хилгэндорф** /ХБНГУ-ын Вюрцбургийн их сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, профессор/	**2006 он №2(13)**
40.	**Монгол Улс дахь харьцуулсан эрх зүйн судалгаа**	**Ж.Амарсанаа** /ШУА-ийн ФСЭХ-ийн Хууль зүйн судалгааны төвийн захирал, Олон улсын эрх, эрх зүйн харьцуулсан судалгааны төвийн захирал, академич/	**2006 он №2(13)**
41.	**Газар өмчлөх эрх ба газрын хэвлийн баялгийг ашиглах эрх: Германы эрх зүй дэх ашиг сонирхлын зөрчил**	**Л.Л.Чантурия** /доктор, профессор/	**2006 он №2(13)**
42.	**Ажил гүйцэтгэх гэрээ, түүний үндсэн нөхцөл**	**М.Доржханд** /ХЗҮТ-ийн ажилтан, хууль зүйн магистр/	**2006 он №2(13)**
43.	**Гүтгэлэг тойрсон маргаантай асуудлууд**	**П.Өнөрмаа** /БНЭУ-ын Дэлигийн их сургуулийн Хуулийн сургуулийн магистрант/	**2006 он №2(13)**
44.	**Монгол Улсын Дээд шүүхийн тайлбарын эрх зүйн орчинг үнэлж дүгнэх нь**	**Б.Гүнбилэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2006 он №2(13)**
45.	**Legal system of Mongolia**	**Gunbileg Boldbaatar**	**2006 он №2(13)**
46.	**Олон улсын эрүүгийн шүүх ба Үндсэн хуулийн асуудал**	**М.Мөнхбат** /ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрхлэгч/	**2006 он №4(15)**
47.	**Олон улсын гэрээг үндэсний шүүхэд хэрэглэх асуудалд (хэрэгцээ, олон улсын практик, заншил, жишиг)**	**Б.Гүнбилэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2006 он №4(15)**
48.	**Олон улсын эрх зүйн зохицуулалтад Монгол Улсын оролцоог өргөтөх нь**	**Г.Сэсээр** /ГХЯ-ны Гэрээ, эрх зүйн газрын зөвлөх, олон улсын эрх зүйч/	**2006 он №4(15)**
49.	**Хятад улсын газрын эрхийн дүрмийн одоогийн байдал хийгээд шинэчлэлийн асуудал**	**Хайтан** /Хятад лсын Өвөрмонголын их сургуулийн Хууль судлалын дээд сургуулийн дэд профессор/	**2006 он №4(15)**

Криминологи

1.	**Авилгын эсрэг: тэмцэл, боловсронгуй болгох нь**	**Д.Зүмбэрэллхам** /ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын эрхлэгч/	**2003 он №1(01)**
2.	**Мансууруулах бодис ба хууль бус үйл ажиллагаа**	**О.Пунцагдаш** /Монгол улсаас БНКазУ-д суугаа ЭСЯ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга, доктор/	**2003 он №1(01)**
3.	**Криминологийн судалгааны найдвартай байдал, түүнийг дээшлүүлэх арга зам**	**Г.Эрдэнэбат** /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш/	**2003 он №2(02)**
4.	**Монгол улсад терроризмтэй тэмцэх эрх зүйн орчин бүрдүүлэх зарим асуудал**	**Л.Батдолгор** /Хууль зүйн магистр/	**2003 он №2(02)**
5.	**Нийгмийн үйлчилгээ үзүүлэх ял Эрүүгийн хуульд тусгагдсан байдал, түүнийг боловсронгуй болгох асуудал**	**Б.Билэгсайхан** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2003 он №3(03)**
6.	**Албадан ажил хийлгэх ялыг эдлүүлж байгаа практик**	**Б.Билэгсайхан** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2003 он №3(06)**
7.	**Эрүүгийн ба Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хэрэгжилт**	**С.Жанцан** /ШУА-ийн Бага чуулганы гишүүн, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор/	**2004 он №1(04)**
8.	**Гэмт хэргийн улмаас учрах оюун санааны гэм хорын асуудал**	**Ц.Одгэрэл** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2004 он №1(04)**
9.	**Хүүхэд эмэгтэйчүүдийг хил дамжуулан худалдах асуудал ба хүний эрх**	**Г.Уранцоож** /Хүний эрх, хөгжил төвийн тэргүүн/	**2004 он №1(04)**

10.	**Монгол улсын Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн шинэтгэлийн зарим асуудал**	**Д.Зүмбэрэллхам** /ХЗҮТ-ийн секторын эрхлэгч, доктор, профессор/	**2004 он №2(05)**
11.	**Албадан ажил хийлгэх ялыг эдлүүлж байгаа практик**	**Б.Билэгсайхан** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2004 он №3(06)**
12.	**Хууль бусаар ан агнах гэмт хэргийн шалтгаан ,нөхцөл, тэмцэх арга зам**	**Ц.Цэлмэг** /"Шихихутаг" Хууль зүйн дээд сургуулийн багш/	**2004 он №4(07)**
13.	**Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зарим хугацаа,түүний тухай ойлголт**	**Ц.Одончимэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2004 он №4(07)**
14.	**Полиграфийн түүхэн хөгжил, түүнийг гэмт хэрэг илрүүлэхэд ашиглах арга зам**	**Г.Батчимэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтны туслах/	**2004 он №4(07)**
15.	**Баривчлах ялын хэрэгжилт, эрх зүйн зохицуулалт**	**Ц.Одончимэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2005 он №1(08)**
16.	**Гэмт хэргийн статистикт хийх регрессийн шинжилгээ**	**Г.Батчимэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтны туслах/	**2005 он №1(08)**
17.	**Цагдаагийн ажилтны нэр хүнд**	**З.Батсүх** /ЦЕГ-ын Тамгын газрын ажилтан/	**2005 он №1(08)**
18.	**Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд холбогдох зарим асуудал**	**Л.Билгээ** /ЦЕГ-ын хэвлэл мэдээллийн ажилтан/	**2005 он №2(09)**
19.	**Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлын нэхэмжлэлийг шийдвэрлэх аргыг тодорхойлох нь**	**Ц.Одончимэг** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2005 он №2(09)**
20.	**Гэр бүлийн хүчирхийллийн зарим асуудал**	**Б.Буян-Амгалан** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2005 он №2(09)**
21.	**Шилжилтийн үеийн Монгол улс дахь гэмт хэргийн чиг хандлага**	**Д.Зүмбэрэллхам** /ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын эрхлэгч/	**2005 он №3(10)**
22.	**Гэмт зан төлөв ба удамшлын зарим хүчин зүйл**	**Б.Буян-Амгалан** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2005 он №4(11)**
23.	**Албадан ажил хийлгэх ялыг эдлүүлж буй өнөөгийн практик**	**Г.Туулхүү** /ШШГЕГ-ын дэд дарга/	**2006 он №1(12)**
24.	**Насанд хүрээгүй хүмүүст хамаарах эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт**	**Л.Уянга** /ХЗҮТ-ийн Сургалтын төвийн багш/	**2006 он №2(13)**
25.	**Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад иргэний нэхэмжлэгчийн эрхийг хангах нь**	**Т.Бямбажав** /Дундговь аймгийн шүүхийн шүүгч/	**2006 он №2(13)**
26.	**Компьютерийн гэмт хэрэг**	**Ц.Хүрэл-Очир** /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, докторант/	**2006 он №2(13)**
27.	**Хорих байгууллагын үйлдвэрлэл, түүний үр дүн**	**О.Шагдарсүрэн** /ШШГЕГ-ын СҮБТЗГ-ын дарга/	**2006 он №2(13)**
28.	**Монгол Улс дахь эрүүгийн хэргийн нөхцөл байдал, гэмт хэргийн шалтгаан**	**Л.Билгээ** /ЦЕГ-ын ажилтан, цагдаагийн хурандаа/	**2006 он №2(13)**
29.	**"Гэмт хэргийн" нийгэм**	**Г.Түмэннаст** /МУИС-ийн Социологийн тэнхимийн багш/	**2006 он №2(13)**
30.	**Цээрлүүлэх "Цэвэр гар" буюу Монгол "Катани"**	**Ч.Нямсүрэн** /МӨХ-ны гишүүн, өмгөөлөгч/	**2006 он №2(13)**
31.	**Өнөөгийн нийгэм ба ял шийтгэл**	**Р.Оюунбадам** /ШШГЕГ-ын харьяа Хорих 407 дугаар ангийн дарга, хурандаа, гавьяат хуульч/	**2006 он №3(14)**
32.	**"Ганц худаг" буюу цагдан хорих төвийн эрт, эдүгээгийн асуудал**	**Р.Оюунбадам** /ШШГЕГ-ын харьяа Хорих 407 дугаар ангийн дарга, хурандаа, гавьяат хуульч/	**2006 он №3(14)**

Хуульчийн мэдээллийн сан www.legalinfo.mn

33.	**Компьютерийн гэмт хэрэг** /үргэлжлэл/	**Ц.Хүрэл-Очир** /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, докторант/	**2006 он №3(14)**
34.	**Ял эдэлж буй хэрэгтний бусдад учруулсан хохирлыг төлүүлэх ажиллагаа**	**Ч.Өнөрцэцэг** /ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих тасгийн хяналт, шалгалтын байцаагч, ахлах дэслэгч/	**2006 он №4(15)**

Эрх зүйн үйлчилгээ

1.	**Өмгөөллийн нууцын тухай**	**Б.Эрдэнэцогт** /МӨХ-ны гишүүн, өмгөөлөгч/	**2003 он №1(01)**
2.	**Нотариатч ямар үйл ажиллагаа эрхэлдэг вэ?**	**И.Гебхардт** /ХБНГУ, өмгөөлөгч/	**2003 он №1(01)**
3.	**Бар-ын Нэгдсэн Холбооны үндсэн шинж /Монголын хуульчдад загвар болгох нь/**	**Жой Спурлок** /АНУ-ын Азийн эрх зүйн институтын захирал/	**2003 он №2(02)**
4.	**Нотариат иргэний эрхийг хамгаалдаг**	**П.Отгонжаргал** /Монголын Нотариатчдын танхимийн мэдээллийн албаны ажилтан/	**2003 он №2(02)**
5.	**Хуульчдаас өндөр түвшинд сонгон шалгаруулна**	**Т.Төгсжаргал** /ХЗДХЯ-ны мэргэжилтэн, магистр/	**2003 он №3(03)**
6.	**Нотариат аливаа баримтын үнэн зөвийг гэрчилдэг**	**П.Уянга** /Монголын Нотариатчдын танхимийн мэдээллийн албаны ажилтан/	**2003 он №3(03)**
7.	**Мэдүүлэг авах арга /Мөрдөн байцаагчид өгөх сэтгэл зүйн зөвлөмж/**	**Игорь Олегович Вагин** /ОХУ-ын Аж үйлдвэр, шинжлэх ухаан, технологийн яамны сэтгэл судлалын шинжээч/	**2003 он №3(03)**
8.	**Оюуны өмчийн эрхийн нэр томъёоны дагалга**	**Ю.Энхтөвшин** /"Евромаркпат-Монгол" ХХК-ийн захирал/	**2003 он №3(03)**
9.	**Ардчилсан нийгэмд өмгөөллийн эзлэх байр суурь**	**Б.Ганбаатар** /Монголын өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн,өмгөөлөгч/	**2004 он №1(04)**
10.	**Нотариатчдад өгөх зөвлөмж**	**Н.Отгонжаргал** /Монголын Нотариатчдын танхимийн мэдээллийн албаны ажилтан/	**2004 он №1(04)**
11.	**Оюуны өмчийн эрхийн нэр томьёоны дагалга**	**Ю.Энхтүвшин** /Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч/	**2004 он №1(04)**
12.	**Эрүүгийн шүүн таслах ажиллагаанд өмгөөлөгч мэтгэлцээний нэг тал болох нь**	**Я.Нямжав** /МӨХ-ны гишүүн, өмгөөлөгч/	**2004 он №2(05)**
13.	**Хуулийн зөвлөгчийн эрх зүйн байдлын зарим асуудал**	**П.Баттогтох** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2004 он №2(05)**
14.	**Нотариатчдад өгөх зөвлөмж**	**П.Уянга** /Монголын Нотариатчдын танхимийн ажилтан/	**2004 он №2(05)**
15.	**Оюуны өмчийн эрхийн нэр**	**Ю.Энхтүвшин** /Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч/	**2004 он №2(05)**
16.	**Өмгөөлөгчийн ёс зүйн зарчим**	**Н.Сосорбарам** /МӨХ-ны Сахилгын хорооны дарга/	**2004 он №3(06)**
17.	**Тайван жагсаал, цуглаан хийх эрх, түүний эрх зүйн үндсийг шинэтгэх асуудал**	**Д.Оросоо** /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	**2004 он №3(06)**
18.	**Гарын үзүүрийн ажил биш**	**Н.Алтанцэцэг** /Монголын Нотариатчдын танхимийн удирдах зөвлөлийн гишүүн/	**2004 он №3(06)**
19.	**Санаж бодсоноо л хэлье**	**Д.Тогтохжаргал** /Ахмад өмгөөлөгч/	**2004 он №4(07)**
20.	**Иргэд газраа өмчилж авахад бүрдүүлэх баримт бичиг**	**С.Наранцэцэг** /Нийслэлийн Хан-Уул дүүргийн нотариатч/	**2004 он №4(07)**

Хууль зүйн үндэсний сургууль www.lawschool.mn

21.	**Өмгөөлөгч байна гэдэг миний бодлоор...**	**А.Энхбат** /"Эрх" хууль зүйн товчооны захирал, өмгөөлөгч/	**2005 он №1(08)**
22.	**Гэрээслэл**	**Р.Онончимэг** /Сүхбаатар дүүргийн нотариатч/	**2005 он №1(08)**
23.	**Нотариатчийн мэргэжил, нийгэмд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол**	**Д.Дуламцоо** /Баянгол дүүргийн нотариатч/	**2005 он №2(09)**
24.	**Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн талаарх ойлголт, нотариатын үйлдэл**	**Г.Бадамсүрэн** /Монголын Нотариатчдын танхимийн мэдээллийн албаны ажилтан/	**2005 он №2(09)**
25.	**Гэрчилж буй гэрээслэлээ сар бүр бүртгүүлж байх ёстой**	**П.Отгонжаргал** /Монголын Нотариатчдын танхимийн мэдээллийн албаны ажилтан/	**2005 он №3(10)**
26.	**Мэргэжлийн нотариатын эрх зүй**	**В.В.Ярков** /Свердловск мужийн нотариатын танхимын ерөнхийлөгч/	**2005 он №3(10)**
27.	**Иргэний баримт бичгийн төв архив**	**Д.Дэмбэрэл** /ИБМУТ-ийн ахлах мэргэжилтэн/	**2005 он №4(11)**
28.	**Нотариатын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал**	**Р.Онончимэг** /Сүхбаатар дүүргийн нотариатч/	**2005 он №4(11)**
29.	**Үл хөдлөх эд хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулахад нотариатын гүйцэтгэх үүрэг**	**Ч.Баянжаргал** /Баянгол дүүргийн нотариатч/, Ш.Сүнжидмаа **/Сүхбаатар дүүргийн нотариатч/**	**2005 он №4(11)**
30.	**Даатгалын эрх зүйн орчин**	**Ч.Уянга** /МӨХ-ны гишүүн, өмгөөлөгч/	**2006 он №1(12)**
31.	**Нотариатчийн үйл ажиллагаа**	**Ч.Баянжаргал** /Баянгол дүүргийн нотариатч/	**2006 он №1(12)**
32.	**Эрх зүйн сурталчилгааны үр нөлөөг сайжруулах нь**	**Д.Уянга** /ХЗҮТ-ийн хэвлэл мэдээллийн ажилтан/	**2006 он №1(12)**
33.	**Эрүүгийн хэргийг шалгаж, шийдвэрлэхэд өмгөөлөгчийн оролцоо**	**Б.Ганчулуун** /МӨХ-ны гишүүн, өмгөөлөгч/	**2006 он №2(13)**
34.	**Иргэний үнэмлэх бүртгэлийн явцад иргэдээс анхаарах зарим асуудал**	**М.Сэлэнгэмөрөн** /ИБМУТ-ийн мэргэжилтэн/	**2006 он №2(13)**
35.	**Иргэний баримт бичгийн зөрчлийг арилгахад анхаарах зарим асуудал**	**С.Сайханцэцэг** /ИБМУТ-ийн Хяналтын улсын ахлах байцаагч/	**2006 он №2(13)**
36.	**Иргэний талаарх лавлагаа, мэдээлэл**	**С.Очирбат** /ИБМУТ-ийн туслах мэргэжилтэн/	**2006 он №2(13)**
37.	**Эрх зүйн албаг боловсролын хэрэгцээ, шаардлага**	**Б.Тамир** /ХЗҮТ-ийн Сургалтын төвийн багш/	**2006 он №2(13)**
38.	**Хууль ёсоор өв залгамжлах нь**	**Ч.Эрдэнэбаяр** /Баянгол дүүргийн нотариатч/	**2006 он №2(13)**
39.	**Нотариатчийн ёс зүйн асуудалд**	**Ч.Баянжаргал** /Баянгол дүүргийн нотариатч/	**2006 он №3(14)**
40.	**Үндэсний эрх зүйн зохицуулалт нотариатын эзлэх байр суурийг тодорхойлох асуудалд**	**Ч.Баянжаргал** /нотариатч, магистр/	**2006 он №3(14)**
41.	**Даатгалын хэлтэс**	**Ч.Уянга** /МӨХ-ны гишүүн, өмгөөлөгч/	**2006 он №3(14)**

Нотариатын 80 жилийн ойд

1.	**Нотариатын байгууллагын үүсч хөгжсөний 80 жилийн ойн баярын хурал**	**2006 он №1(12)**
2.	**"Нотариатын нийгэмд гүйцэтгэх үүрэг, цаашдын чиг хандлага" онол-практикийн бага хурал**	**2006 он №1(12)**

"Хууль дээдлэх ёс", 2006 он, №4

Цагдаагийн байгууллагын 85 жилийн ойд

1.	Цагдаагийн байгууллагын түүхэн замналаас	2006 он №3(14)

Эврика – 2006

1.	Эрх зүйт ёс ба хуульчийн ёс зүй	М.Батсуурь /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, докторант/	2006 он №3(14)
2.	Торгох ялын биелэлт, түүний үр нөлөөг дээшлүүлэх нь	Р.Мөнхзул /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан/	2006 он №3(14)
3.	Захиргааны хэргийн шүүхээс Засгийн газрын шийдвэрийг хянах нь	Д.Энхчимэг /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан/	2006 он №3(14)
4.	Эрх зүйт ёс (эрх зүйг бүтээх ажиллагаа)	О.Мөнхсайхан /МУИС-ийн Хууль зүйн магистрант/	2006 он №3(14)

Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол

1.	Дугаар 26-28	2006 он №3(14)

Нэр томъёо

1.	Латин нэр томъёоны тайлбар (цуврал)	2005 он №3(10)
2.	Латин нэр томъёоны тайлбар (цуврал)	2005 он №4(11)
3.	Латин нэр томъёоны тайлбар (цуврал)	2006 он №1(12)
4.	Латин нэр томъёоны тайлбар (цуврал)	2006 он №2(13)
5.	Латин нэр томъёоны тайлбар (цуврал)	2006 он №3(14)

Мэдээ, мэдээлэл

1.	Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал	2004 он №2(05)
2.	Америкийн Баарын холбооны "Азийн эрх зүйн санаачлага төсөл"	2004 он №2(05)
3.	Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээ ба Хууль зүйн үндэсний төв (Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээг бий болгох болон удирдан явуулах түр хэлэлцээр)	2004 он №4(07)
4.	Норвегичууд Монголын өмгөөлөгчдөд оюуны хөрөнгө оруулалт хийнэ.	2004 он №4(07)
5.	Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээний (ALIN) үйл ажиллагаа	2005 он №1(08)
6.	Газрын эрх зүйн зохицуулалт эрдэмтдийн анхаарлыг татав	2006 он №3(14)
7.	"АНУ-ын шүүхийн тогтолцоо, онцлогийн талаархи сургалт зохиов"	2006 он №4(15)
8.	"Энэ оны байдлаар 113 Монгол хүн ногоон карт хожжээ"	2006 он №4(15)
9.	Эрх зүйн шинэтгэл: Өчигдөр, өнөөдөр, маргааш	2006 он №4(15)

хууль дээдлэх ёсны хүрээлэн www.nli.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ



Үндсэн хуулийг тухайн улсын төрийн нэрийн хуудас гэдэг. Манай улсын төрийн нэрийн хуудас болсон Үндсэн хуулийг Хууль зүйн үндэсний төвөөс долоон хэл /монгол, орос, англи, франц, герман, япон, хятад, солонгос/-ээр орчуулан, нэгтгэж эмхтгээд иргэд, байгууллагын эрэлт хэрэгцээнд өргөн барьж байна.

Эмхтгэлд орсон орчуулгад 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тусгасан болно.

Монгол Улсын Үндсэн хууль, түүний орчуулгын эмхтгэл нь манай улсын гадаад харилцаанд болон харьцуулсан эрх зүй судлалд өчүүхэн боловч хувь нэмэр болох буй за.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn



ӨНӨӨГИЙН УЛС ТӨР ХУУЛЬЧИЙН НҮДЭЭР

Гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид “Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр” гэсэн бүтээлээ гаргалаа. Монголын улс төрийн тогтолцооны шинэтгэл, түүний эрх зүйн үндэс (тойм), Монголын улс төрийн тогтолцоон дахь тулгамдсан асуудлууд, Үндэсний эв нэгдлийг хангахад эрх зүйн ач холбогдол, “Governance” нь “Засаглал” уу, удирдлага уу? гэсэн дөрвөн бүлэг, бүлэг нь зүйл, хэсгээс бүрдэх эл бүтээл нь агуулга, цар хүрээний хувьд эрхэм таныг мэдээллээс гадна мэдлэг олж авах, мэдлэгээс мэргэн ухаанд хүргэх буй за, Уг номд Монголын улс төрийн тогтолцооны шинэтгэл, өнөөгийн төлөв байдлыг хурц бөгөөд оновчтой, энгийн бөгөөд үндэслэлтэй, эргэцүүлэн шүүмжилж саналаа уншиж, бодож, боловсруулан буулгасан нь зарим нэгэнд нь таатай бус байх авч зайлшгүй Монгол Улсад хэрэгтэйг Та уншаад ойлгох буюу.

Ингээд эцэст нь хэлэхэд агуулгыг нь биш эзнийг нь хэн болохоос хамааран тухайн ном, бүтээлийг худалдаж авдаг зуршлаасаа түр хагацаж, бичсэн “эзэн”-ийг нь үл тоон бичигдсэн “зүйл, агуулга”-ыг нь уншаад үзэхийг Та бүхэнд зөвлөж байна.